



Konrad
Adenauer
Stiftung



ОРОН НУТГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ



УЛААНБААТАР ХОТ
2015 он

ОРОН НУТГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Хянасан: Г.Маналжав

Хэвлэлд бэлтгэсэн: М.Сайнбилэг

Хэвлэлийн хуудас: 18,8хх

Хэвлэсэн тоо: 500ш

Хэвлэсэн газар: ЭКИМТО ХХК

Утас: 11320001

АГУУЛГА

1. Эрхэм уншигчиддаа учирлах ануу. /Өмнөтгөл/ 5

НЭГДҮЭЭР БҮЛЭГ

2. УИХ-ын гишүүн, УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Монголын нутгийн удирдлагын холбооны Тэргүүн Су.Батболд
“Төвлөрлийг сааруулах нь өөрөө удирдах ёсны хөгжлийн чухал нөхцөл мөн” 12
3. УИХ-ын гишүүн, УИХ-ын Нутгийн удирдлагын дэд хорооны дарга Н.Батцэрэг
“Орон нутгийн биеэ даасан байдлыг бэхжүүлэх, эрх зүйн орчныг шинэчлэх нь” 17
4. УИХ-ын гишүүн, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт
“Иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, хүндрэл, бэрхшээл, гарах арга зам” 29
5. УИХ-ын гишүүн, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга, доктор Ж.Батсуурь
“Орон нутгийн бие даасан байдалд юу саад болж байна вэ?” 35
6. Монгол банкны хяналтын зөвлөлийн дарга, Доктор профессор Ж.Ядамсүрэн
“Орон нутгийн эдийн засаг, санхүү, төсвийн эрх мэдэл, цаашдын хандлага” 47
7. ЭТҮГЭН Их Сургуулийн Проректор, Доктор, Профессор А.Цанжид
“Орон нутгийн бие даасан байдал, түүний шалгуур” 63
8. Орхон аймгийн ИТХ-ын дарга Б.Мягмарсүрэн
“ИТХ-ын үйл ажиллагааг чанаржуулж сайжруулах арга зам” 82
9. Монголын нутгийн удирдлагын холбооны дэд Тэргүүн Удирдахуйн ухааны магистр Г.Маналжав
“Төлөөлөгч бүрэн эрхээ зөв ойлгож чанартай хэрэгжүүлэх нь” 97
10. Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч, Ш.Ганбат
“Нутгийн өөрийн удирдлага ба инноваци” 119

ХОЁРДУГААР БҮЛЭГ

“Нутгийн удирдалагын эрх зүйн шинэчлэл” сэдэвт ЭССЭ, илтгэл бичих уралдааны өндөр оноо авсан сэдвүүд

1. *Удирдлагын академийн тэнхэмийн эрхлэгч, доктор Я.Бямбаяр*
“Тэргүүлэгчид” социализмаас уламжилсан гажиг уу? 132
2. *Төв аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга А.Идэрпүрэв*
“Нутгийн удирдлагын эрх зүйн орчны шинэчлэл”
3. *Хөгжлийн түүчээ сангийн санхүүч П.Баасандулам*
“Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төсвийн үйл явцад иргэдийг оролцуулж буй байдалд хийсэн шинжилгээ” 141
4. *Батлан хамгаалах Их сургуулийн багш, М.Батдорж*
“Монгол улсад Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлсэн төвлөрлийг сааруулах нь” 172
5. *Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын ажилтан А.Жаргалдаваа*
“Нутгийн удирдлагын эрх зүйн шинэчлэл” 182
6. *Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Номин*
“Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, арга барил, үр өгөөж, иргэд олон нийтийг дагуулж манлайлах чадварыг хөгжүүлэх өөрчлөх арга” 189
7. *Монгол улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутан Н.Батчимэг, Б.Баялагмаа*
“Орон нутгийн сонгуулийн тогтолцоо ба улс төрийн нам” 202
8. *Москва хотын Санхүү, эдийн засгийн их сургуулийн оюутан Г.Амаржаргал*
“Нутгийн удирдах байгууллагын хөгжилд иргэн миний үзүүлэх хувь нэмэр” 214
9. *Батлан хамгаалахын Их сургуулийн оюутан Г.Булгантамир, Б.Сүхбаяр*
“Төсвийн шинэчлэлийн зарим асуудал” 221

ЭРХЭМ УНШИГЧИДДАА УЧИРЛАХ АНУУ



Монголын нутгийн удирдлагын холбоо, ХБНГУ-ын “Конрад-Аденауэр”-Сангийн Суурин төлөөлөгчийн газар хамтран 2010-2015 онуудад олон арга хэмжээ зохион байгуулж нутгийн өөрөө удирдах ёсныболон нутгийн захиргааны байгууллагын сонгуультаан ажилтнуудтай нүүр тулан уулзаж ярилцлага, хэлэлцүүлэг, онол практикийн бага хурал, сургалт семинар зохион байгуулж ирсэн билээ.

Эдгээр арга хэмжээний үндсэн зорилго нь Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг өөрчилж, шинэчлэх, чиг үүрэг, эрх мэдэл, нутаг дэвсгэр, хүн амынхаа эзэн нь байх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн юм.

2010 онд Дорноговь аймгийн Сайншанд суманд **“Нутгийн удирдлагын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал”** Үндэсний зөвлөгөөн, 2011 онд бүх аймгийн сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын сургалт, 2012 онд **“Нутгийн удирдлагын өнөөгийн байдал, цаашдын хандлага”** сэдвээр хийсэн онол практикийн бага хурал, 2013 онд **“Иргэддээ тулгуурласан чадвартай, хариуцлагатай нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлж хөгжүүлье”** Үндэсний зөвлөлөгөөн, 2014 онд **“Монгол улсад төвлөрлийг сааруулж орон нутагт эрх мэдэл олгох, иргэдийн оролцоог хангах нь”** сэдэвт зөвлөлдөх уулзалт, мөн 2014 онд Монголын нутгийн удирдлагын холбоо байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан **“Ухаалаг төрлүү**

шилжих хүрээнд Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь”сэдэвт зөвлөгөөн, 2015 онд 21 аймгийн бүх сумдын ИТХ-ын дарга нарыг хамруулсан сургалт хэлэлцүүлэг нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Сонгуулийн тухай зэрэг олон хуулиудыг улам боловсронгуй болгоход чиглэгдсэн юм. Мөн аймаг орон нутгийн бүсийн уулзалт зөвлөлгөөн ч олон болов. Эдгээр арга хэмжээнд оролцогсодоос нутгийн удирдлагын эрх зүйн орчныг өөрчилж шинэчлэхэд чиглэгдсэн олон зуун санал гарлаа.

Мөн УИХ, Засгийн газарт энэ чиглэлээр удаа дараа саналаа хүргүүлж байсан бөгөөд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Нутгийн удирдлагын дэд хороо, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, эдгээр арга хэмжээнүүдэд оролцож, санал бодлоо солилцож байсныг талархалтайгаар дурдъя.

Монгол улс Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуваагддаг. Өөрөөр хэлбэл төр засгийн бодлого шийдвэр орон нутагт амьдарч буй айл өрх, иргэн бүрт хүрч, төрийн үйлчилгээг сайжруулах, ажлын үр өгөөжийг дээшлүүлэх нөхцөл бүрддэг. Тиймээс ч нутгийн удирдлагын асуудал, орон нутгийн биеэ даасан байдлыг зөв төлөвшүүлж хөгжүүлэх ажил нь засгийн газрын төдийгүй засаг захиргааны нэгж бүрийн эрхэмлэх зорилго, баримтлах зарчим, анхаарах бодлого, уялдуулан зохицуулах зорилтыг дэвшүүлж байдаг юм. Үүний үндэс нь хууль зүйн хүрээнд хийх өөрчлөлт шинэчлэлт мөн. Иймд “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг бид бүхэн орон нутгийн өөрөө удирдах байгууллагатайгаа хамтран боловсруулаад байна.

МНУХ, КАС-гийн зүгээс санаачлан Төр засгийн төлөөлөл, эрдэмтэн судлаач, энэ чиглэлээр ажиллаж буй хүмүүсийн оюунаа чилээж, цаг хүчээ гарган бичсэн сэдвүүд болон эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр зарласан уралдаанд байр эзэлж, шалгарсан Илтгэл-ЭССЭ-г нэгтгэн энэхүү номыг бүтээж танд өргөн барьж байна.

Нутгийн удирдлагын сонгуультан, ажилтнуудыг сургаж төлөвшүүлэх, хөгжүүлж бэлтгэхэд ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сан оюуны үнэлж баршгүй хөрөнгө оруулалт хийдэг юм.

Нутгийн удирдлага, түүний дотор нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг хөгжүүлэхэд сүүлийн жилүүдэд Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгчийн газрын хамт олны идэвх чармайлт, өгөөж үр ашиг, сэтгэл зүрхэнд шингэсэн зүтгэл, санаачлагыг үе үеийн нутгийн удирдлагын хамт олон талархаж, бахархаж баярлаж байдаг юм.

ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн үе үеийн Суурин төлөөлөгч П. Глуховский, Др. Т. Шрапел, Д. Рай, Др. Д. Шмюкинг нартаа баярласнаа илэрхийлье.

Энэхүү номыг бүтээхэд хамтран ажилласан КАС-гийн Суурин төлөөлөгч Др. Даниел Шмюкинг, төслийн менежер хатагтай С. Ганзаяа нартаа баяр талархалаа дэвшүүлж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



**ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч
Др. Даниел Шмюкинг**



**ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Төслийн менежер
хатагтай С.Ганзаяа**

Энэ ном Таны ширээний ном, танай хамт олны лавлах болж, цаашдын үйл ажиллагаанд тань санаа нэмж, сэдэл өдөөж шинэ шинэ санал санаачлага өрнүүлэхэд нь тус дэм үзүүлэх болтугай гэж ерөөж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛЫН НУТГИЙН УДИРДЛАГЫН ХОЛБООНЫ
ТЭРГҮҮН, ДОКТОР (Ph.D.)

СУ.БАТБОЛД



Мэндийн хадгал

ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сан нь Монгол Улсын Засгийн газрын урилгаар 1993 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн билээ. Бид хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа нэгэн чухал зорилт болох нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг сайжруулах, төвлөрлийг сааруулах чиглэлээр Монголын Нутгийн Удирдлагын Холбоотой олон жилийн туршид үр дүнтэй хамтран ажиллаж байна. Бидний энэхүү хамтын ажиллагааны зорилго нь орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлж, чадавхижуулах мөн төвлөрлийг сааруулахад хувь нэмрээ оруулахад чиглэглэгддэг.

Монголын Нутгийн Удирдлагын Холбоо нь Монгол улсын ууган ТББ-уудын нэг төдийгүй 1994 онд албан ёсоор үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөг хүртэлх хугацаанд орон нутагт тулгарч буй олон арван асуудлыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, жинхэнэ утгаараа орон нутгийн дуу хоолой болж байгаа хамт олон юм.

Хоёр байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд 2015 онд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг бүх аймгийн төлөөллийг оролцуулан санал асуулга зохион байгуулж, мэргэжлийн баг бүрэлдэхүүнтэйгээр боловсруулан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 32 зүйлийн 60 гаруй заалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар тогтож, бие даасан хуулийн төсөл болгохоор шийдвэрлэлээ. Түүнчлэн “Монгол улсын Үндсэн хууль”, “Сонгуулийн тухай хууль”-уудад холбогдох саналаа өгөхөөр хэлэлцэж тохирсон билээ. Мөн энэ онд “Нутгийн удирдлагын эрх зүйн орчны шинэчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний уралдааныг орон даяар зарлан үндэсний хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж шилдгүүдийг шалгуурласан юм.

Энэхүү төсөл, хөтөлбөрийг санаачлан ажил хэрэг болгож буй УИХ-ын гишүүн, Монголын Нутгийн Удирдлагын Холбооны Тэргүүн Су.Батболд, дэд тэргүүн Г.Маналжав, тус төслийг хариуцан ажиллаж буй М.Сайнбилэг нарт талархлаа илэрхийлэхийн зэрэгцээ бидний хамтын ажиллагааны хугацаанд сайн түншлэлийг бий болгож чадсан Монголын Нутгийн Удирдлагын Холбооны үе үеийн хамт олонд ажлын өндөр амжилт хүсье.

Манай хоёр байгууллагын хамтын ажиллагааны үр дүнгийн нэгээхэн хэсэг болох энэхүү номоо уншигч таны оюуны мэлмийд өргөн барьж байгаадаа баяртай байна. Та таалан соёрхоно уу.

Др.Даниел Шмюкинг
Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч



Konrad
Adenauer
Stiftung

Нэгдүгээр бүлэг



ЭРДЭМТЭН СУДЛААЧДЫН САНАЛ БОДОЛ





СУНДУЙН БАТБОЛД

Монгол Улсын Их Хурлын гишүүн УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, Монголын нутгийн удирдлагын холбооны Тэргүүн

Эрх зүйч, инженер-багш, Удирдахуйн ухааны доктор

ТӨВЛӨРӨЛИЙГ СААРУУЛАХ НЬ ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ХӨГЖЛИЙН ЧУХАЛ НӨХЦӨЛ МӨН

Орон нутгийн бие даасан байдал ямар нэг хэмжээнд байхгүйгээр нутгийн өөрөө удирдах ёс боломжгүй юм. Бие даасан байдлыг бэхжүүлэх гол арга нь төвлөрлийг сааруулах, эрхжүүлэх, эрх эдлэх-хариуцлага хүлээх чадварыг орон нутагт бүрдүүлэх байдаг.

Төвлөрлийг сааруулах буюу бидний дээр өгүүлснээр төвлөрөлийг задлах хөдөлгөөн нь анх хөдөө аж ахуйг дэмжих бодлогын хүрээнд үүссэн боловсорсон үзэл баримтлал юм. Төвлөрөл буюу эрх мэдлийг төвлөрүүлэх нь улс орны нэгдмэл байдлыг бэхжүүлэхэд ач холбогдолтой гэж үздэг. Харин төвлөрлийг задлах нь олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр улс орныг нэгдмэл байлгах арга юм. Тэхээр

төвлөрөл, төвлөрлийг задлах зэрэг нь удирдлагын үр нөлөө, ардчилал зэргээс гадна улс төрийн үр дагавартай үзэгдлүүд юм. Засаглалын үр нөлөө, ардчиллын шаардлага, улс төрийн үр дагаварын аль ч талаас авч үзсэн хэт төвлөрөл юмуу хэт тархай бутархай байх хоёрын аль аль нь сөрөг үр дагавартай ажээ. Тухайн үеийн болон улс орны онцлогоос шалтгаалан энэ хоёр хандлагын харьцаа янз бүр байх нь мэдээж юм. Хөгжиж буй орнуудын хувьд гарааны нөхцөл нь дотоодын дайн самуун, салан тусгаарлах хөдөлгөөн эрчимтэй байхаас бусад тохиолдолд ихэвчлэн эрх мэдлийн төвлөрөл ихтэй байдаг. Социалист байсан орнуудын хувьд энэ дүгнэлт бүр ч бодитой гэж хэлж болно.

Төвлөрлийг сааруулах гэдгийг ерөнхий байдлаар тодорхойлбол эрх мэдлийг төрийн төв байгууллагаас (ялангуяа гүйцэтгэх эрх мэдлийн) бүс нутгийн юмуу анхан шатны нэгжид шилжүүлэн өгөхийг хэлдэг байна. Нэгдмэл байгууламжтай оронд хууль тогтоох эрх мэдэл бүхэлдээ парламентад байдаг. Түүнээс орон нутагт эрх мэдэл шилжүүлэх (бүр мөсөн) асуудал бараг байхгүй гэж хэлж болно. Шүүхүүд төвшин бүртээ хуулиар тодорхойлсон эрх мэдэлтэй. Тэхээр эрх мэдэл төвлөрүүлэх-задлах асуудал голлож гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд дээр яригдана.

Төвлөрлийг сааруулснаар:

- Орон нутгийн өвөрмөц нөхцөл, оршин суугчдын сонирхол, эрх ашгийг илүү мэддэг орон нутгийн удирдлага илүү зөв шийдвэр гаргаж чадна.
- Тэрчлэн гаргасан шийдвэрийг илүү сайн хэрэгжүүлнэ.
- Ардчиллын хөгжилд бодитой хувь нэмэр болно. Хүмүүс санаа бодлоо илэрхийлэхэд хамгийн ойр байгаа эрх мэдэлт байгууллагад дөт байх ба уг байгууллага хүмүүсийн санал, шаардлагыг хүлээн авч шийдвэрлэх чадвар их байх тусам ардчилсан ороцооны зарчим илүү үр дүнтэй хэрэгжих болно.
- Хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд түлхэц үзүүлнэ.
- Орон нутаг дахь ядуурлыг багасгахад нөлөө үзүүлнэ.
- Бүс нутаг, манай орны нөхцөлд бол аймгууд хоорондын, сумд хоорондын хөгжлийн ялгааг багасгахад нөлөө үзүүлнэ.

Төвлөрлийн сааралт нь зөвхөн орон нутгийн удирдлагад төдийгүй иргэний нийгэмд бүхэлд нь боломж нээж байгаа хэрэг юм.

Төвлөрлийг сааруулах буюу децентрализацийн зэрэгцээ төвөөс шилжүүлэх гэж нэрлэж болмоор өөр нэг үйл явц бол деконцентраци юм. Энэ нь төвийн байгууллагаас өөрийн орон нутаг дахь байгууллагад зарим эрх мэдлийг шилжүүлэх юмуу төвд гаргасан шийдвэрийг нарийвчлан хэрэгжүүлэх эрх өгөх явдал юм. Зарим тохиолдолд төв байгууллага зарим хэсгээ орон нутаг руу шилжүүлэн байрлуулах явдал ч гардаг. Деконцентрацийг зарим үед децентрализацийн нэг хэлбэр гэж үздэг. Гэвч децентрализацийг нарийн утгаар нь тодорхойлох юм бол энэ нь эрх мэдлийг төвийн байгууллагаас орон нутгийн иргэдийн төлөөллийн, иргэд өөрсдөө сонгож байгуулдаг байгууллагад юмуу түүнээс томилогдсон байгууллагад шилжүүлэх явдал юм. Чухам ийм үед л эрх мэдэл орон нутаг, тэнд оршин суугаа иргэдэд шилжиж байна хэмээн үзэж болно. Тиймээс дезентрализац, деконцентрац хоёр хоёр өөр үйл явц хэмээн үзэж болно. Деконцентрац нь дээр цухас тэмдэглэсэнчлэн захиргааны хүрээн дэх эрх шилжүүлэлт юм. Захиргааны төв байгууллага орон нутгийнхаа нэгж, салбарт эрх өгч байгаа хэрэг. Тиймээс түүнийг захиргааны төвлөрөл сааруулалт гэж нэрлэдэг эндээс деконцентрацийг децентрализацийн хэлбэр гэж үзэх үзэл гаргасан байна. Гэтэл төвлөрөл сааруулах буюу децентрализаци нь улс төрийн хүрээн дэх эрх мэдлийн шилжилт юм. Эрх мэдэл шилжүүлэн авч буй орон нутгийн субъект нь иргэдийн сонгосон байгууллага, албан тушаалтан байх ба ихэвчлэн төсвийн хувьд ч бие даасан байдалтай байна. Харин захиргааны хүрээнд эрх шилжлээ гэхэд захиргааны орон нутгийн байгууллага нь төв байгууллагынхаа хяналт, удирдлагад байнга байх ба удирдлагыг томилоход дээд байгууллага нь шууд ба шууд бусаар оролцоно. Ийм учраас зарим үед эрх шилжсэний үр дүн бага байх тохиолдол бий. Тэхдээ деконцентрац нь эрх мэдлийг хэт төвлөрүүлсэн байдлыг сааруулахад тодорхой нөлөөтэй юм. Тийм ч учраас төвлөрлийг жинхэнэ утгаар нь сааруулах үйл явцын эхлэл нь деконцентрац байх нь элбэг тохиолддог байна.

Тиймээс төвлөрлийг сааруулах үндсэн хэлбэр нь деволюц буюу улс төрийн эрх шилжүүлэх явдал юм. Улс төрийн эрх

шилжүүлэх нь дан ганц эерэг үр дүнтэй байдаг гэж болохгүй. Эрх мэдлийн хуваарилалт, төрийн байгууллагын төвшин хоорондын харилцааг зөв зүйтэй томъёолсон байлаа ч гэсэн орон нутгийн элит эрх мэдлийг гартаа төвлөрүүлэх аюул байнга байдаг. Тийм учраас төвлөрлийг сааруулах үйл явц нь нутгийн удирдлагад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхтэй хослох хэрэгтэй байдаг байна. Тэхдээ асуудлыг зөвхөн иргэд орон нутгийн хурлыг сонгох, сонгогдсон байгууллага иргэдийн нэрийн өмнөөс эрх хэрэгжүүлэх явдлаар хязгаарлаж болохгүй юм. Орчин үед иргэдийн ороцооны шинэ хэлбэрүүдийг эрэлхийлэх, хэрэглэх нь өргөжиж байна. Энэ хүрээнд түншлэл хэмээх шинэ ойлголт буй болж улам бүр анхаарал татах болов. Энэ нь орон нутгийн засаглалд иргэд, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, хувийн хэвшил болон төрийн бус олон төрлийн бусад байгууллагын идэвхтэй оролцоог илэрхийлж буй нэр томъёо юм.

Түншлэгч байгууллагуудын зорилго нь орон нутгийнхаа хөгжлийн төлөө хамтран ажиллах явдал юм. Хамтын ажиллагааны хэлбэр нь түншлэгч байгууллагууд шийдвэр гаргах үйл явцад оролцох, хариуцан тайлагналд хяналт тавих, янз бүрийн хэлбэрийн яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, тодорхой зорилгыг хэрэгжүүлэх үүднээс харилцан тохиролцож гэрээ байгуулах зэрэг олон янз байна.

Дэлхийн улсуудын туршлагаас үзэхэд орон нутаг нь өөрийн нутгийн эдийн засгийн хөгжлийн асуудлууд, орон нутгийн төлөвлөлт, байгалийн баялагийг ашиглах болон тогтвортой хөгжлийн асуудлаар үр нөлөөтэй ажиллаж чаддаг байна.

Төвлөрлийг сааруулах нь нарийн бодож төлөвлөсөн эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй өөрчлөлтийг шаардана. Үүнд:

- Бүс нутгийн болон анхан шатны нэгжид эрх хэмжээ бүхий байгууллагыг байгуулах,
- Засаг захиргааны бүх төвшинд сонгууль явуулдаг болох,
- Нэгэнт байгуулагдсан бүс нутгийн болон анхан шатны байгууллагуудад зохих хэмжээний эрх, түүнээс үүдэн гарах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шилжүүлэн өгөх,
- Дээрээс тавьдаг элдэв хяналтыг болиулах, багасгах,

- Орон нутагт эрх эдлэх, хариуцлага хүлээх чадавхийг бүрдүүлэх зэрэг болно.

Эл үйл ажиллагаа нь хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинээр хууль, дүрэм гаргах шаардлагыг буй болгоно. Үүнд:

- Үндсэн хуулийн хэмжээний өөрчлөлт. Төрийн янз бүрийн төвшний байгууллагын эрх хэмжээг тодорхойлсон заалтууд зэрэг төвлөрөлгүй систем ажиллах тулгуур зарчмуудыг тодорхойлох, уг системийн талаар органик хуулиудыг гаргах, өөрчлөх суурь заалтууд г.м
- Төвлөрөлгүй системийн гол гол байгууллагуудын талаарх нарийвчилсан заалт бүхий хуулиуд, үүний дотор санхүүгийн эрх хэмжээг хуваарилах асуудлыг зохицуулсан хуулиуд,
- Янз бүрийн төвшний байгууллагууд хоорондын харилцааг тодорхойлсон хууль тогтоомж зэрэг болно.

Төвлөрөлгүй системийн ерөнхий бүтэц зарчмыг тогтоох (дизайныг хийх), өөрөөр хэлбэл асуудлыг бүхэлд авч үзэж ерөнхий зургийг нь гаргаж гол гол элементүүдийг нь тодорхойлох асуудал чухал юм. Ийм ажил нь тийм ч амаргүй байдаг нь олон улсын туршлагаас харагддаг. Төвлөрөлгүй системийн дизайн нь ихэвчлэн олон янзын оролцогчдыг хамарсан хүнд хэцүү яриа хэлэлцээ, тэмцлийн үр дүн байдаг байна. Төвлөрөлгүй системийн дизайныг тодорхойлоход дээр нэгэнт яригдсан ерөнхий зарчмуудаас гадна харгалзах ёстой хоёр хүчин зүйл байдаг. Үүнд:

- Тухайн орны нөхцөл байдал, өвөрмөц онцлогт нийцүүлэх,
- Орон нутгийн чадавхийг харгалзах

Орон нутгийн чадавх хангалтгүй байгаа үед төвлөрлийг сааруулах оролдлого нь бодлогын хэрэгжилтийг үр дүнгүй болгохоос гадна үзэл санааны өөрийн нь нэр хүндийг бууруулан, ийм бодлогод итгэх итгэлийг алдагдуулна. Тийм учраас төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө орон нутагт чадавхи бүрэлдүүлэх нь чухал юм. Энэ нь юуны өмнө хүний нөөцөд хамааралтай байдаг. Мэргэжлийн өндөр ур чадвартай албан хаагчидгүйгээр уг ажлыг хийх бололцоогүй юм. Энэ нь хөгжиж буй орнуудад нийтлэг ажиглагддаг хүчин зүйл байдаг.



НАМДАГИЙН БАТЦЭРЭГ

Монгол Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын
Нутгийн удирдлагын дэд хорооны дарга
Металлург инженер, Эдийн засагч, судлаач

ОРОН НУТГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧЛЭХ НЬ

УДИРТГАЛ

“Хүн ам нийслэл орчимд төвлөрч, төв, орон нутгийн хөгжил жигд биш, шилжилт хөдөлгөөний дийлэнхийг хөдөлмөрийн насны залуучууд бүрдүүлж, орон нутагт үйлдвэрлэл, бизнес эрхлэх боломж хумигдаж байна¹. Мөн хүн амын 57 хувь нь орон нутагт суурьшиж байгаа ч цаашид буурах хандлагатай байна. Жишээлбэл: 1990-2001 онд 123 сумын хүн ам механик өссөн бол 2001-2012 онд 254 сумын хүн ам буурч, нийт 330 сумаас 192-т 2 км² тутамд 1 хүн ноогдож байна².”

1 Монгол Улсын Их Хурлын ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн хүрээлэн. судалгааны эмхтгэл. Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого /төсөл/. УБ., (2015), 21 дэх тал.

2 Мөн тэнд. 169 дэх тал.

Хот хөдөөгийн хөгжлийн түвшиний ялгааг бууруулах нь орон нутагт ядуурал, ажилгүйдлийг бууруулах, өрхийн сарын дундаж орлогыг өсгөх, бараа бүтээгдэхүүний үнийн ялгааг арилгах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого /төсөл/-д тусгажээ.

Энэ нь гурван сая хүн амтай, 15 сая км² газар нутагтай, асар их байгалийн баялагтай, эх газрын хөгжиж байгаа жижиг орны дүр төрх юм.

Тиймээс бид энэ хурдацтайгаар төв рүү чиглэсэн их нүүдлийн хөдөлгөөнийг саармагжуулж, төвд цугларсан төвлөрлийг сааруулж, төрийн зөв бодлогыг боловсруулах нь зүйн хэрэг юм.

Иймд орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлж, өөрөө удирдах ёсыг хөгжүүлж, түүний эдийн засаг, санхүүгийн үндсийг бэхжүүлэх явдал ямар үүрэг ач холбогдолтойг судалж, эрх зүйн орчныг шинэчлэх талаар тусгахыг зорив.

НУТГИЙН УДИРДЛАГЫН БИЕ ДААСАН БАЙДАЛ³

Сонгодог утгын «орон нутгийн засгийн газар» буюу орон нутгийн бие даасан захиргааны шинжийг дараах байдлаар тодорхойлдог байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн дагуу тухайн нутаг дэвсгэртээ эрх барих чиг үүргийг хэрэгжүүлж, орон нутгийн үйлчилгээний талаар хариуцлага хүлээдэг байх;
2. Санхүү, төсвийн хувьд бие даасан, орлогоо өөрөө бүрдүүлэх эрх мэдэлтэй байх;
3. Боловсон хүчнийг томилох, ажлаас халах, дэвшүүлэх эрх мэдэлтэй байх;
4. Олонхийн намаас сонгогдсон хурлын байгууллага орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, дотооддоо мөрдөх дүрэм гаргаж хэрэгжүүлдэг байх;

3 Монгол Улсын Үндсэн хуулийн тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт «Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн» хэмээн заасан байдаг. Үүнийг нутгийн удирдлагын Үндсэн хуулийн үндсэн баталгаа болсон заалт хэмээн тайлбарладаг. Гэхдээ “эдийн засаг, нийгмийн цогцолбор” гэдэгт юуг ойлгох вэ гэдэг нь тодорхойгүй явж ирсэн.

5. Төрийн захиргааны төв байгууллагуудын албан тушаалтнууд зөвхөн зөвлөгөө өгөх, мэргэжлийн хяналт хийх үүрэгтэй болохоос биш орон нутгийн бүрэн эрхэд хамаарах асуудалд оролцдоггүй байхаар тодорхойлжээ⁴.

Эндээс харахад Монгол Улсын нутгийн удирдлага нь 2 ба 3 дахь үзүүлэлтийн хувьд эрх мэдэлгүй, 5 дахь үзүүлэлтийн хувьд хагас эрх мэдэлтэй гэж дүгнэж болохоор байна.

Шилжилтийн эдийн засагтай олон оронд 1990-ээд оноос хойш төвлөрлийг сааруулахад чиглэгдсэн захиргааны шинэтгэлийн хүрээнд засаг захиргааны чухам хэдэн түвшинтэй байх, аль түвшинд ямар нэгжтэй байх зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ оновчтой бүтэц бий болгоход чиглэсэн эдийн засгийн загварт тулгуурлахаас илүү түүхэн уламжлалд даатган орхижээ⁵. Сүүлийн 20 жилд хөгжингүй орнуудад хэрэгжсэн шинэтгэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг томсгох чиглэлтэй байсан бол шилжилтийн эдийн засагтай Зүүн Европын орнууд, тухайлбал, Польш, Чех, Унгарт 1990-ээд оны эхээр төвийн хүчтэй хяналтыг халах зорилгоор хийсэн шинэтгэлийн үр дүнд орон нутгийн засаг захиргааны маш олон тооны нэгж бий болжээ. Үүний сөрөг үр дагавар нь эдгээр жижиг нэгж хуулиар олгосон бүх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Энэ нь Монгол Улсын нөхцөл байдалтай төстэй юм.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу нутгийн удирдлагын тогтолцоо өмнөх үеийнхнээс эрс өөрчлөгдсөн⁶. Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ”* хэмээн заасан. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь иргэдээс сонгогддог

4 Марк Тойнэр ба Давид Хулме. Засаглал, захиргаа ба хөгжил: Төрийг ажиллагаатай болгох нь. Macmillan Press, (1997), 160 дахь тал.

5 Хайми Боэкс, Хорхе Мартинез Вазкез, Андрей Тимифеев. Орон нутгийн засаг захиргааны бүтэц ба төв, орон нутгийн төсвийн харилцаа: Төвлөрлийг сааруулах бодлогод орхигдсон асуудал, Жоржиа муж Улсын их сургууль. (2004)

6 Хөдөөд аймаг-сум-баг гэсэн үндсэн бүтэцтэй байхаар тогтсон нь үндсэндээ Монгол Улс 1932 оноос хойш мөрдөж ирсэн бүтэц бөгөөд 1960 оны Үндсэн хуулиас ялгаатай нь нийслэлд районуудыг дүүрэг болгон нэршлийг нь өөрчилж, хороодыг байгуулжээ. Эдүгээ Монгол Улс засаг захиргааны хувьд 21 аймаг, аймгууд нь 330 сум, 1575 багт, нийслэл хот нь 9 дүүрэг, 135 хороонд хуваагдаж байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байхаар аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал болгосноор Ерөнхий сайд, доод шатны нэгжүүдэд Засаг даргыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал санал болгосноор дээд шатны Засаг дарга томилохоор зохицуулжээ. Орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь дээд шатны захиргаанд ажлаа тайлагнаж, харин Хурлууд доод шатны Хурлын үйл ажиллагаанд оролцохгүй байх зарчмыг тусгасан байна.

Мөн 1992 онд сонгосон нутгийн удирдлагын тогтолцоонд хэд хэдэн асуудал байна. Жишээлбэл: Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт *“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амыг байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ”* гэсэн нь ихээн шүүмжлэл, маргаан дагуулсан нь 2000-аад оны эхэн үеэр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах үе, мөн Үндсэн хуулийн Цэц дээр үүссэн маргаануудаас⁷ харагддаг. Үүний зэрэгцээ эдийн засгийн хувьд амьдрах чадваргүй сумдыг нэгтгэх санаачлагыг Засгийн газрын зүгээс хэд хэдэн удаа гаргасан боловч тэдгээр нь тэгсхийгээд дарагдаж байсан талаарх судалгаа байна⁸.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээс харахад 330 сумын 62.9 хувь нь 3000 хүртэл хүн амтай, 30.4 хувь нь 2000 хүртэл амтай байна. Үүний эсрэгээр нийслэлийн хүн амын тоо 1990 онтой харьцуулахад 2.4 дахин өсч 2014 онд 1.372.000 буюу нийт хүн амын бараг тал хувь нь нийслэл хотод оршин сууж төвлөрлийг маш ихээр үүсгэж байна⁹. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ гэсэн нь хэт хатуу заалт юм. Үндсэн хуулийн

7 “Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай» Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоолыг Үндсэн хууль зөрчсөн гэсэн гомдлыг Үндсэн хуулийн цэц хянаж үзээд тухайн орон нутгийн иргэдтэй зөвлөлдөөгүй гэсэн үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргаж байсан жишээ байна.

8 Хамтын бүтээл. Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ. УБ., (2015), 65 дахь тал.

9 Нийслэлийн Статистикийн газрын мэдээгээр 1990 онд Улаанбаатар хотод оршин суугчдын тоо 560,600 буюу нийт хүн амын 26.7 хувийг эзэлж байсан бол 2014 оны байдлаар 1.372.000 болж нийт хүн амын 46.8 хувийг эзэлж байна. <http://www.ubstat.mn/StatTable=11>

Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийг «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршил, тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал шийдвэрлэнэ» хэмээн өөрчилж болох юм¹⁰.

Ийнхүү Улаанбаатар хотод төвлөрөл ихээр үүсч байгаа ч түүнийг бууруулах арга замыг судалж, гарч олох нь нэн чухал зүйлийн нэг юм.

Тэгвэл төвлөрлийг сааруулах гэдгийг ерөнхий байдлаар тодорхойлбол эрх мэдлийг төрийн төв байгууллагаас /ялангуяа гүйцэтгэх эрх мэдлийн/ бус нутгийн юмуу анхан шатны нэгжид шилжүүлэн өгөхийг хэлнэ. Нэгдмэл байгууламжтай оронд хууль тогтоох эрх мэдэл бүхэлдээ парламентад байдаг. Түүнээс орон нутагт эрх мэдэл шилжүүлэх асуудал бараг байхгүй гэж болно.

Төвлөрлийг сааруулснаар¹¹:

1. Орон нутгийн өвөрмөц нөхцөл, оршин суугчдын сонирхол, эрх ашгийг мэддэг орон нутгийн удирдлага нь зөв шийдвэр гаргаж, гаргасан шийдвэрийг илүү сайн хэрэгжүүлэх;
2. Хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд түлхэц үзүүлэх;
3. Орон нутаг дахь ядуурлыг багасгахад нөлөө үзүүлэх;
4. Бүс нутаг, манай орны нөхцөлд бол аймаг, сумд хоорондын хөгжлийн ялгааг багасгахад нөлөө үзүүлнэ.

Төвлөрлийн сааралт нь зөвхөн орон нутгийн удирдлагад төдийгүй иргэний нийгэмд бүхэлд нь боломж нээж байгаа хэрэг юм¹².

10 Хамтын бүтээл. Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ. УБ., (2015), 66 дахь тал.

Судлаач дээрх судлаачдын дэвшүүлж буй байр суурьтай адил байгаа болно. Б.Т Мөн одоогийн тогтолцоо нь илүүц давхардал, засаглалын нүсэр бүтцийг бий болгосон гэж үзэх үндэстэй. Тухайлбал, Улаанбаатар хотын дүүрэг бүр Хуралтай бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа, зорилго нь бүрхэгдүү байна. Иймд эдгээр Хурлыг татан буулгах, эсхүл нэгтгэж болох юм.

11 Б.Чимид, төвлөрөл сааруулах нь ардчиллын нэгэн гол хандлага бөгөөд зөвхөн сайн санааны лоозон, үзэмжийн сонголт биш билээ. Энэ бол улс орны эдийн засаг, улс төр, нийгэм-соёлын амьдрал, юуны өмнө улс төрийн дэглэмийг ардчилан төв, хөдөөд ард түмний засгийг хэрэг дээр тогтоон хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээнээс ургаж гардаг жам ёсны үйл явц юм. Уг үйл явц XX ба XXI зууны заагаас эхлэн дэлхий нийтэд тархсан буюу газар сайгүй өрнөсөн түгээмэл үзэгдэл болов.

12 С.Батболд, Төвлөрлийг сааруулж нутгийн өөрөө удирдах ёс хөгжих нөхцлийг хангах нь. / докторын зэрэг горилсон бүтээл/, Нутгийн удирдлага сэтгүүл. УБ., (2012), 33 дахь тал.

Мөн ардчилалд суурилсан төвлөрлийг сааруулах гэдэг бол төв засгийн дангаар ноёрхор эрх хэмжээг¹³ задалж:

- **Босоо чиглэлээр:** тухайлбал засаг захиргаа нутаг дэвсгэрийн бүх шатны нэгжүүдийн өөрийн удирдлагад доош доош нь шилжүүлж, тэдгээрийн бие даасан байдлыг бэхжүүлэх;
- **Хэвтээ чиглэлээр гэвэл:** засаг төрийн дээд, төв байгууллагын эрх хэмжээг задалж иргэний нийгэм, хувийн хэвшил, бизнесийн зэрэг хажуугийн орчинд шилжүүлж, төрийн ачааг хөнгөлөн иргэний чирэгдлийг нимгэлэн бүтээлч санаачлагыг хөгжүүлэх явдал¹⁴ юм.

Төвлөрлийг сааруулах нь улс төр, захиргаа, төсвийн талаар шийдвэр гаргах эрх мэдлийг төв засгийн газраас орон нутгийн засаг захиргаа, байгууллагад шилжүүлэх үйл явц юм¹⁵. Энэ бүхнээс дүгнэн үзвэл орон нутгийнхаа асуудлыг тэндэхийн иргэд өөрсдөө шийдвэрлэх гэсэн агуулга бүхий нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх нь төвлөрлийг сааруулах үндсэн арга зам, гол сувгийн нэг юм.

Монгол Улсын хувьд нутгийн удирдлагын бие даасан байдлыг хангах оролдлогуудыг Үндсэн хууль батлагдсанаас хойш хийж ирсэн. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг 2002 онд баталснаар 1990-ээд оны дундуур эхлүүлсэн төвлөрлийг сааруулах шинэтгэлд цэг тавигдсан. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төсвийн зарлагын хариуцлагыг яамдад шилжүүлснээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн зарлагад эзлэх орон нутгийн төсвийн зарлага 30% (ДНБ-д 13%) байсан бол тус хууль хүчин төгөлдөр үйлчилсэн 2003-2011 онд дундажаар 10% болж буурчээ (ДНБ-д 3%)¹⁶.

13 Эрх хэмжээг (компетенция, competence) нь байгууллага, албан тушаалтны эрхлэх ажил, эрх үүрэг түүнийгээ хэрэгжүүлэх орон зайг илэрхийлдэгээр нь эрх мэдэл (власть-power) гэдгээс ялгаж баймаар атал манайхан гагцхүү эрх мэдэл гэж чадавхи талаас нь өөрөөсгөл дүгнэх нь элбэг болж, дам ишлэв.

14 Б.Чимид. Төвлөрлийг сааруулахад нутгийн өөрийн удирдлагын санхүүгийн үндсийг бэхжүүлэхийн ач холбогдол. Хариуцлагатай төр: Санхүүгийн төвлөрөл нутгийн өөрөө удирдах ёс форумд тавьсан илтгэлээс.

15 Жейм Которобо. Төвлөрлийг сааруулах үйл явц ба оролцоот ардчилалд орон нутгийн өөрөө засаглах эрх нөлөөлөх нь. илтгэлээс.

16 Хамтын бүтээл. Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ. УБ., (2015), 65 дахь тал.

Харин орон нутгийн төсвийн орлого, зарлагын ангиллын дээрх тогтолцоог боловсронгуй болгон 2011 оны 11 дүгээр сар Төсвийн шинэ хуулийг баталсан нь төв-орон нутгийн төсвийн харилцаанд чухал шинэтгэлийг эхлүүлээд байна.

Төсвийн шинэ хууль нь хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилгыг харгалзсан томъёоны дагуу хуваарилах санхүүгийн ерөнхий шилжүүлэг буюу орон нутаг мэдэж зарцуулах Орон нутгийн хөгжлийн санг бий болгосон¹⁷ билээ. Энэ нь Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцоонд томоохон өөрчлөлт шинэчлэл болсон хэмээн тооцогдож байгаа бөгөөд бодлого боловсруулахад орон нутгийн иргэдийн оролцоог хангахад ихээхэн ач холбогдол өгч байгаа юм.

2013 оноос хэрэгжиж эхэлсэн Төсвийн тухай хуулийн хамгийн чухал ач холбогдол нь Орон нутгийн хөгжлийн сангийн үлэмж хэмжээний хөрөнгийг захиран зарцуулах эрх мэдлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн захиргаанд шилжүүлсэн явдал юм. Ингэснээр орон нутгийн захиран зарцуулах хөрөнгийн хэмжээ урд өмнөхөөс зуу гаруй дахин нэмэгдэж байгаа юм. Монголын нэг хүнд ногдох Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хөгжиж буй орнуудтай харьцуулахад хамгийн өндөр биш юмаа гэхэд нэлээд дээгүүр орох байх гэж бодож байна. Иймээс Орон нутгийн хөгжлийн сангийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн нь Монгол улсад орон нутгийг хөгжүүлэхэд ихээхэн боломж нээж өгч байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн нэр төрөл, орон нутгийн хөгжилд үзүүлэх үр нөлөө ямар байгаа талаарх судалгаа сонирхвол:

Орон нутгийн хэмжээ, хүн амын тоо, хөгжлийн дүртөрхөөрөө харилцан адилгүй сумдууд бүгд л гудамжны гэрэлтүүлэг, хогийн хаягдал цэвэрлэх/ ачиж зайлуулах, хүүхдийн цэцэрлэг, нийтийн халуун ус зэрэг цөөн хэдэн төрлийн төслүүдийг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батласан байна. Эдгээр төслүүд нь тухайн орон нутагт шаардлагатай гэдэг нь эргэлзээгүй ч урт хугацааны хөгжлийн байр сууринаас авч үзэхэд эдгээр

¹⁷ Төсвийн тухай хуулийн Есдүгээр бүлэгт: Орон нутгийн төсвийн харилцаа бүлгээр зохицуулсан байна.

нь хамгийн үр ашигтай төслүүд биш байгаа юм. Сумын төв, гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулах эсвэл сумын оршин суугчдын таашаалд нийцэхүйц төслүүдийг санхүүжүүлэх нь буруу биш хэдий ч ОНХС-гаас санхүүжүүлэх төслүүдийг эрэмбэлэн сонгохдоо тухайн орон нутгийг хөгжүүлэхэд нэн тэргүүний ач холбогдолтой эсэх эсвэл хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар зарцуулж байгаа эсэхийг шалгуур болгосон эсэх нь эргэлзээтэй байгаа юм.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц төслүүдийг тодорхойлж чадавхи хөдөөд, ялангуяа алслагдсан сумдад хомс байна. ОНХС-гаар хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг тодорхойлж эрэмбэлэхдээ мэдээлэл судалганд суурилсан шийдвэр гаргаж хараахан чадахгүй байна.

Орон нутгийн засаг захиргаа болон ИТХ-ын тэргүүлэгчид нь иргэдийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргаж байгаа тул тухайн сумын хөгжил дэвшилд хамгийн их хувь нэмэр оруулах төслүүд шалгарах ёстой гэж тооцож болохгүй юм. Төсвийн тухай хууль, ОНХС-ийн одоогийн тогтолцооны хүрээнд “сайн” төслүүдийг шалгаруулдаг нөхцлийг бүрдүүлэхийн тулд:

- алслагдсан сумдын удирдлагад сургалт явуулж бодит төлөвлөлт хийх чадвартай болгох;

- орон нутгийн хөгжилд үр нөлөө үзүүлэхүйц загвар төслүүдийг санаачилж хэрэгжүүлсэн сумдыг дэмжиж урамшуулах;

- “сайн” төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн сумдын шилдэг туршлагыг орон даяар түгээж бусдад үлгэр дууриалал болгох зэрэг арга хэмжээг авч болох юм.

Харьцуулсан судалгаа:

Нийгэм оршин буйн илэрхийлэл болсон хүн, хүний жам ёсны эрхийн талаар олон улсын тунхагийн үзэл санаа, гадаадын болон үндэсний судлаачид, зарим улс орны үйл ажиллагааг харьцуулан судлах явцад дээрх асуултын хариуг нийгмийн харилцааны ардчилсан тогтолцооны суурь зарчмаас хайх нь зүй ёсны гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Тодруулж хэлбэл тодорхой нутаг дэвсгэрийн оршин сууугчид амьдрал ахуйнхаа

өөрсдөөс шалтгаалах асуудлыг бие даан шийдвэрлэж, эрсдэл, хариуцлагаа хүлээдэг зарим бүхий нутгийн өөрийн удирдлагыг төлөвшүүлэх тухай асуудал юм¹⁸.

Нийгмийн харилцааны ардчилсан тогтолцооны үнэлэмж нь хүн бүр жам ёсны эрхээ аль болохуйц бүрэн дүүрэн эдлэх боломжийг бүрдүүлэх, иргэд амьдрал ахуйн өөрсдөөс хамаарах асуудлыг тодорхой нутаг дэвсгэрийн хамт олны хүрээнд хараат бусаар, бие даан хэрэгжүүлэх чадамжаар илэрхийлэгддэг байна¹⁹.

Улс орнуудын төрийн байгууламжийн хэлбэрээс үл хамааран нутгийн өөрөө удирдах байгууллага бие даан оршин тогтнох чадамжтай байх нь тухайн орны хөгжлийн үндэс суурь болдог бол нутгийн удирдлагын байгууллагын бие даасан, хараат бус байдлын гол цөм нь санхүүгийн бие даасан байдал юм. Тиймээс хэрэгжүүлж буй шинэтгэлийн гол зорилго нь нутгийн удирдлагын байгууллагуудын эрх мэдэл, чиг үүргийг нэмэгдүүлэхэд түлхүү чиглэгдэж байна.

Ихэнх улс оронд нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх хэмжээ, бие даасан байдлыг Үндсэн хуулиараа зохицуулсан байх бөгөөд Нутгийн удирдлагын тухай хууль, түүний санхүүгийн бие даасан байдлын тухай хуулиудыг батлан гаргасан байх боловч тэдгээрийн хоорондын зөрчилтэй байдал, Иргэдийн сонгуульт төлөөллийн эрх ашгийн сонирхлын нөлөөлөл зэргээс хамаарч бодит амьдрал дээр төдийлөн үр дүнтэй хэрэгждэггүй тал хандлага бий гэж судлаачид үзсэн байна. /Тухайлбал: БНСУ/

Улс орнуудын нутгийн удирдлагын байгууллагуудын санхүүгийн хараат бус байдлыг орон нутгийн өөрийн орлого бүрдүүлэлт болон орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ гэсэн 2 үзүүлэлтүүдийг харьцуулан дараах 4 ангилалд хуваав:

18 С.Нармандах. Иргэний ардчилсан нийгмийн нутгийн өөрийн удирдлага. «Төрийн захиргаа» сэтгүүл. 2014 он. №02, 59 дэх тал.

19 Судлаачид иргэний ардчилсан нийгмийн талаарх цөөнгүй тодорхойлолт дотроос Аврам Линкольны «Ардчилал гэдэг ард түмний тусын тулд, ард түмнээр удирдуулсан, ард түмний засаглал юм. /Charity for All to Of the People, by the People, For the People/ хэмээснийг хамгийн оновчтой нь гэж үздэг. Ийнхүү ардчилал /демократ/ хэмээх ойлголт нь үгийн уг сурвалжийн хувьд ч, хамгийн оновчтой гэх тодорхойлолтын хувьд ч «ард түмний засаглал» гэсэн ойлголт ухагдахууныг илэрхийлдэг байна.»

1. Орон нутгийн өөрийн орлого болон орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь өндөр: Энэ нь орон нутгийн захиргаа нь нутгийн иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангалттай хангахуйц хэмжээний санхүүгийн чадавх бүхий тогтолцоотой учир нутгийн удирдлагын байгууллагууд нь хүчтэй байдаг. /АНУ/

2. Орон нутгийн өөрийн орлогын хэмжээ нь өндөр, орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь бага: Энэ нь санхүүгийн хараат бус байдла нь өндөр хэдий ч, орон нутгийн үзүүлэх үйлчилгээ, хариуцлага нь бага байдаг. Харин захиргааны хувьд бие даасан, хараат бус байдал нь сул, орон нутгийн үзүүлэх үйлчилгээ, хариуцлага нь бага, төв Засгийн газраас хамаарал ихтэй. /Франц, Польш/

3. Орон нутгийн өөрийн орлогын хэмжээ нь бага, орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь өндөр: Энэ нь орон нутгийн үйлчилгээ, хариуцлага өндөр, санхүүгийн хараат бус байдал сул тогтолцоо юм. Эдгээр нь орон нутгийн удирдлага нь сул ба төв Засгийн газраас хараат орон нутгийн үйлчилгээ үзүүлнэ. Захиргааны хараат бус байдал сул. /Их Британи/

4. Орон нутгийн өөрийн орлогын хэмжээ болон орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь бага: Санхүүгийн болон захиргааны бие даасан, хараат бус байдал нь сул байна. /Турк, Унгар, Словени/

Дараах хүснэгтээр Европын зарим орон болон АНУ-ын орон нутгийн санхүүгийн хараат бус байдлыг тоймлон харуулав. Хүснэгт-1

	Бага	Өндөр	
Орон нутгийн орлого	Франц, Польш	АНУ	Өндөр
	Словени, Унгар, Турк	Их Британи	Бага
	Орон нутгийн төсвийн зарлага		

Орон нутгийн төсвийн орлого /дэмжлэг/, төсвийн зарлага:
Хүснэгт-2

	Төвлөрсөн төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг, хувиар	Орон нутгийн татвар, хураамж хувиар	(Харьцаа) Орон нутгийн төсөв, төвлөрсөн төсөв	Орон нутгийн төсвийн зарлага /ДНБ, хувиар/	Төвлөрсөн төсвийн зарлага /ДНБ, хувиар/
УНГАР	68.00	19.00	-	-	-
ПОЛЬШ	45.00	44.00	15/85	-	-
ФРАНЦ	-	-	18/82	8.00	48.00
АНУ	20.50	-	23/77	9.00	37.00
ИХ БРИТАНИ	48.00	31.00	28/72	13.00	46.00
СЛОВЕНИ	79.30	20.70	12/01/00	5.00	43.00

САНАЛ

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын Хөгжлийн агентлаг, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй «Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь» төслийн хүрээнд Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчинд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан ажиллаж байна.

Энэхүү хуулийн төслийн хүрээнд одоогоор зарчмын дараах асуудлуудыг тусгана.

1. Засаг захиргааны нэгжийн хуваарийг өөрчлөхтэй холбоотой харилцааг гүнзгийрүүлэн судалж, Үндсэн хуулийн үзэл санаа, тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт нийцүүлэн органик хуулийн холбогдох зохицуулалтыг тодорхой болгон, нарийвчлан тусгах;
2. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын эрх хэмжээг хуульчилж, үйл ажиллагаа нь тогтмолжих, баг, хороо нь асуудлаа бие даан шийдвэрлэх боломжтой байх зохицуулалтуудыг нэмж оруулах;

3. Нутгийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нь хуулийн хяналтад орж, шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог зайлшгүй хангах талаар зохицуулна;
4. Хурал чиг үүргээ ямар арга хэрэгслээр, хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана;
5. Төсвийн холбогдох хууль тогтоомжийг судалж төвлөрлийг сааруулах, эрх мэдлийг шилжүүлэх, орон нутгийн төсвийг бодитой төлөвлөх зэрэг чиглэлээр шаардлагатай зохицуулалтыг тусгана.
6. Засаг даргаас нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, төлөвшүүлэх талаар хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлж хуульчилж өгнө.

Гарц: Орон нутагт зах зээлийг ойртуулах, хөдөө орон нутагт ажлын байр бий болгох, орон нутгийн онцлог, байгаль орчны нөхцөлд нийцсэн уламжлалт технологийг хөгжүүлэх, орон нутагт технологи түгээх замаар хөдөө орон нутгийн хүн амын амьжиргааг сайжруулах нь төвлөрлийг сааруулах үндсэн арга механизм байна.

Орон нутагт сэргээгдэх эрчим хүч ашиглах, амьжиргааг сайжруулах замаар Улаанбаатарын хүн амын тоог өнөөгийн түвшнээс хорин хувиас хэтрүүлэхгүй.

Томоохон ашигт малтмалын ордыг ашиглахдаа орон нутгийн хөгжилд үр нөлөөтэйгээр төлөвлөж, үйлдвэрлэл, уул уурхайн орд дагасан хот, тосгоныг бусад дагалдах үйлдвэрлэл, үйлчилгээ, цэцэрлэг, сургууль, эмнэлгийн хамт байгуулах бодлого баримтлах шаардлагатай.



ДОГСОМЫН БАТЦОГТ

Монгол Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга

Усны инженер, Банк санхүүч, эдийн засагч

ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БАЙГАА ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, ГАРАХ АРГА ЗАМ

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад төрийн үйлчилгээ жинхэнэ утгаараа хөгжиж, өндөр түвшинд хүрсэн байдаг. Ийм орны иргэд нь тэгтлээ бухимдаж, улс төрждөггүй. Иргэн нь ажлаа хийж, төлөх ёстой татвараа төрдөө төлсөн болохоор төрийн байгууллага нь өөрийн хууль, журмын дагуу иргэддээ яг л “хаан” шиг үйлчлэх үүрэгтэйг сайн мэднэ. Харин төрийн үйлчилгээний ажилтнууд нь ард иргэдийн татвараар цалинжиж, санхүүждэг болохоор, үйлчлүүлэгч ямар хүн байхаас үл хамааран байнга инээмсэглэж, хүндэтгэлтэйгээр үйлчлэх учиртайг сайн мэднэ. Ийм л тогтолцоотой учраас үйлчлэгч, үйлчлүүлэгч аль аль нь бие биедээ сэтгэл хангалуун байдаг байна. Ер нь аливаа улсын төр, засгийн байгууллагын бодлого,

үйл ажиллагаа нь иргэдээ ажиллах, амьдрах нөхцлөөр хангаж, бүх төрлийн үйлчилгээг хүргэхэд чиглэгддэг.

Манай улс ч Үндсэн Нуулийнхаа 16-р зүйлийн 2-т “Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалын тэнцэл алдагдлаас хамгаалуулах эрхтэй” гэж хуульчилж өгсөн байгаа.

Иргэн сурч боловсрох, эрүүл амьдрах, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, нийгмийн халамж, үйлчилгээ авахаас эхлээд сонгох, сонгогдох улс төрийн эрх чөлөөгөө эдлэх хүртэл нийгмийн төрөл бүрийн үйлчилгээг өдөр тутам авдаг. Энэ үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, иргэн бүрт хүргэх нь төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг мөн. Иргэн хүний хүсэл, санал, хэрэгцээ шаардлагыг сэтгэл ханамжийн зохих түвшинд хангах ажлыг үйлчилгээ гэдэг байна. Үйлчилгээ нь орон зай, цаг хугацаа харгалзалгүй иргэн бүрдээ тэгш шуурхай хүрч байх учиртай. Нийгмийн үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- | | |
|--|------------------------|
| -тодорхой байх; | -ил тод нээлттэй байх; |
| -чирэгдэлгүй байх; | -ялгаваргүй байх; |
| -шат дамжлагагүй байх; | -хүртээмжтэй байх; |
| -соёлтой байх; | -чанартай байх; |
| -үйлчилгээ авсан иргэн нь сэтгэл ханамжтай байх. | |

Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг тогтмол авах, чанартай, хөнгөн шуурхай, соёлтой байхыг шаардах, бас хяналт тавих эрх нь иргэн хүнд бий. Иргэн хүн ажил, амьдралынхаа явцад өөрийн зохицуулж чадахгүй байгаа үйлчилгээг л төр засгаас шаарддаг.

Бидний тоймлон судалснаар иргэн хүн 11 багцийн 30 гаруй төрлийн үйлчилгээг төрөөс авч байна. Иргэн хүнд үйлчлэх үйлчилгээг салбараар ангилан төрөлжүүлж хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлснээр боловсрол, эрүүл мэнд, соёл, нийгмийн халамж гээд 30 шахам хуулиар үйлчилгээний бодлогыг тодорхойлж байна. Нөгөө талаар үйлчилгээг хүнд ойртуулах, хүртээмжтэй чанартай болгоход улсын төсвийн хөрөнгийн нилээд хэсэг нь зориулагдаж байна. Зөвхөн боловсролын салбарт 2010 оны байдлаар улсын төсвийн нийт орлогын 33,6 хувь буюу 486,3 тэрбум төгрөг зарцуулагджээ.

Төрийн үйлчилгээг шат дараалалгүй, чирэгдэл, хүнд сурталгүй, шуурхай хүргэдэг “Нэг цонхны үйлчилгээ”, “Цахим бүртгэл”, “Нээлттэй хаалганы өдөр”, “Угтах үйлчилгээ” төрийн үйлчилгээний цахим машин буюу “ТҮЦ” машин зэрэг үр ашигтай шинэ үйлчилгээний хэлбэрүүд бий болж шат дамжлага, чирэгдлийг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Гэсэн хэдий ч иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээ нь чирэгдэл ихтэй, шат дамжлага олонтой байгаагаас иргэн бүр хангалттай үйлчилгээ авч чадахгүй байна. Сум бүрт их эмч ажиллаж байгаа ч малчин өрх сумын төвөөс 50-иас дээш км хол амьдарч, эмнэлгийн тусламж, үйлчилгээг тэр бүр хүртээмжтэй авч чаддаггүй, нийгмийн бусад олон үйлчилгээнээс хол байна. Төв суурин газарт байгаа иргэд төрийн зарим үйлчилгээг авахын тулд олон хоног төрийн байгууллагаар явж, шат дамжлага бүрт саатаж, чирэгддэг байна. Жишээ нь: Нийслэлийн нэг иргэн газраа хувьчилж авахаар 10 шахам газраар орж 14-21 хоногийн хугацаа зарцуулж байна. Ийм хүндрэл банкнаас зээл авах, тэтгэвэр, тэтгэмжээ тогтоолгох, сургууль, цэцэрлэгт хүүхэд бүртгүүлэх, газар авах, хувьцааны ноогдол ашгаа тооцуулах зэрэг олон үйлчилгээнд тохиолдож байна. Мөн гааль, татвар, хуулийн байгууллагууд ч иргэдийг ихээхэн чирэгдүүлдэг. Бид аливаа асуудлыг чирэгдэлгүй, шуурхай шийдвэрлэдэг тогтолцоонд шилжихийн тулд олон төрлийн арга хэмжээ авах шаардлага байна.

Хүний хэрэгцээ хязгааргүй, хэрэгцээ бүр нь шинэ шинэ үйлчилгээг бий болгохыг шаардаж байгаа өнөө үед төрийн үйлчилгээг боловсронгуй болгох, иргэдэд хүндрэлгүйгээр хүргэхийн тулд олон арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд нь:

Нэгдүгээрт:

Улс орнуудын төрийн байгууламжийн хэлбэрээс үл хамааран нутгийн удирдлага бие даан оршин тогтнох чадамжтай байх нь тухайн орны хөгжлийн үндэс болдог бол нутгийн удирдлагын бие даасан хараат бус байдлын гол цөм нь тэдгээрийн санхүүгийн бие даасан байдал юм. Иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг чанартай, хүртээмжтэй болгохын тулд төрийн байгууллагын шатлал бүрийн чиг, үүргийн судалгааг нарийн гаргаж, ажлын давхардал, хийдэл, ажилтнуудын

ажлын ачаалалтай дүйцэхүйц цалин, хангамжийг тогтоох зэрэг олон асуудал яригдах болно. Одоогийн байдлаар дээд болон дунд шатны байгууллагад ажиллагсдын тоо олон, авч байгаа цалин нь өндөр, чиг, үүргийн давхардал ихтэй байгаа бол төрийн захиргааны байгууллагын анхан шатны нэгж болох баг, хороонд ажиллагсдын ажлын ачаалал маш их, цалин нь хамгийн бага түвшинд байгаа нь шударга ёсонд нийцэхгүй байгаа юм. Хүн амын төвлөрлийг харгалзан бүтэц, орон тоогоо төсөвтэй багтаан тухайн засаг захиргааны нэгжийн удирдлага өөрсдөө тогтоох эрхийг шилжүүлж өгөх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт санхүүжилт, өмчийн харьяаллын асуудлыг нарийвчлан судалж, төвлөрлийг сааруулах шаардлагатай. Тухайн засаг захиргааны нэгжид байгаа сургууль, эмнэлэг, соёлын төв, цэцэрлэг, мал эмнэлэг, татвар, улсын бүртгэл, халамжийн үйлчилгээний санхүү, боловсон хүчний асуудлыг орон нутгийн мэдэлд шилжүүлэх, дээд шатны байгууллага нь мэргэжлийн удирдлагаар хангадаг тогтолцоонд шилжих хэрэгтэй гэж үзэж байна.

Хоёрдугаарт:

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, таруу байршилтай амьдардаг иргэдэд төрийн үйлчилгээг оновчтой, хүртээмжтэй хүргэхийн тулд хийж хэрэгжүүлэх нэг чухал ажил бол засаг захиргааны нэгжийг өөрчлөн зохион байгуулах явдал юм. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж орон нутагт харилцан адилгүй, үр өгөөж нь хангалтгүй учраас хөдөөгийн иргэд төв суурин газар руу шилжиж, аймгийн төв, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг хотуудад хүн амын төвлөрлийг бий болгож байна. Хүн амын шилжилт хөдөлгөөн нь төрийн үйлчилгээтэй холбоотой асуудал юм. Хүн амын төвлөрөл бий болсноор сургуулийн анги, танхимын тоо хүрэлцэхгүй, нэг ангид хамрагдах хүүхдүүд хэт олон болох, зам, тээврийн түгжрэл, агаарын бохирдол үүсэх, ажлын байр олдохгүй байх зэргээр олон үйлчилгээг хүндрүүлж, сөрөг нөлөөллийг бий болгон чирэгдэл үүсэх нөхцлийг бүрдүүлж байна.

Иймээс засаг захиргааны нэгжийг өөрчлөн зохион байгуулах замаар аймаг, сумыг нэгтгэх, бүсийн төвүүдийг иж

бүрэн үйлчилгээ үзүүлдэг нэгж болгосноор нийслэл болон бусад том хотуудын ачаалал багасаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээ ойртож, айл өрхийн амьжиргаанд сайнаар нөлөөлөх болно.

Гуравдугаарт:

Монгол Улсын Үндсэн Хуулийн 59 дүгээр зүйлийн 2-т зааснаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга гэсэн нутгийн удирдлага нь төрөөс иргэдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай байлгах, иргэдийнхээ онцлогыг харгалзан үйлчилгээг төлөвлөж, хүргэх, хянаж ажиллах үүрэгтэй. Нутгийн удирдлагаас төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр нөлөөлөх нөлөө, авах арга хэмжээ, хүлээх үүрэг ерөнхий, хомс учраас бие даасан ажиллагаа, идэвх, санаачлага, хариуцах чадвар суларч байна. Тиймээс төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа орон нутгийн боловсон хүчнийг чадавжуулах, хариуцлагажуулах арга хэмжээг Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталж, хэрэгжүүлэх ажлаас эхлэх хэрэгтэй.

Дөрөвдүгээрт:

Төрийн албаны үйлчилгээний стандартыг нэгж бүрт бий болгож, иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх үүрэг хүлээсэн төрийн албан хаагчдын хүнд суртлыг арилгах, иргэдийг чирэгдүүлэх гох дэгээ болсон дүрэм, журмыг цэгцлэх, үйлчилгээний ажлыг цахимжуулахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

ЭДГЭЭР ДУТАГДАЛ, БЭРХШЭЭЛИЙГ АРИЛГАХЫН ТУЛД:

- Төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний давхардал, шат дамжлага, чирэгдлийг яам, агентлаг болон орон нутгийн түвшинд судалж, түүний үндсэн дээр эрх зүйн орчныг шинэчлэх замаар бүтэц, тогтолцоог нь өөрчлөн, үйлчилгээг хүн амд ойртуулах;

- Орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлж үйлчилгээний байгууллагуудын төсөв, өмч, хүний нөөцийн асуудлыг яам, агентлагаас нутгийн удирдлага руу шилжүүлж, нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг шууд хариуцуулах;

- Салбарын яамдын удирдлагын хэт төвлөрлийг задалж орон нутгийн нэгж бүрийг биеэ даан ажилладаг, чадварлаг боловсон хүчнийг өөрсдөө томилдог, тэдний ажилд хяналт тавьдаг эрхтэй болгосноор нийгмийн бүх төрлийн үйлчилгээ иргэндээ ойртож, чанар үр нөлөөг дээшлүүлэх;

- Гадаадын зарим оронд төрийн үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор төрийн зарим чиг үүргийг улсын бус секторт шилжүүлэн гүйцэтгүүлж, концессийн болон тендерийн гэрээ, мэргэжлийн холбоод, аутсорсингийн хэлбэрийг ашиглан үр дүнд хүрч байгаа туршлагаас суралцаж хэрэгжүүлэх;

- Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, цаг хугацаа алдахгүйгээр төрийн үйлчилгээний байгууллагуудын барилгын болон засварын ажлыг хийж гүйцэтгэх, бусад бараа, үйлчилгээг шуурхай шийдвэрлэдэг, иргэдийн зүгээс тендерийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

- Төрийн үйлчилгээний стандартыг бүх түвшинд бий болгож мөрдөх, цахим үйлчилгээг өргөжүүлэхийг бодлогоор дэмжиж, энэ арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж ажиллах;

- Үйлчилгээг шуурхай, чанартай, үр ашигтай болгохын тулд иргэдийн идэвхтэй оролцоо, хяналтыг сайжруулах, түүний тулд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид бусад сонгуультаан, нутгийн захиргааны байгууллагын ажилтан, иргэдийг сургах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа, холбоог сайжруулах, төрийн бүх төрлийн үйлчилгээг хөнгөвчлөх, нэмэгдүүлэх талаар тодорхой бодлого, чиглэл гарган хэрэгжүүлэх шаардлагатай байна.



ЖАМЪЯНСҮРЭНГИЙН БАТСУURЬ

УИХ-ын гишүүн, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга
Барилгын инженер- эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор

Нэг. ОРОН НУТГИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛД ЮУ СААД БОЛЖ БАЙНА ВЭ?

Монгол Улс, Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, унитар орон. Манай улсын төрийн тогтолцоонд нутгийн удирдлагын тогтолцоо өвөрмөц байр суурь эзэлдэг. Түүнийг Үндсэн хуулиараа зохицуулсан байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд “Аймаг сум хоёрыг “хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор болгоно”, “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээний эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэнэ” /58,62 дугаар зүйл/ гэсэн байгаа. Харамсалтай нь энэ заалт хэрэгжээгүй. Хэрэгжихэд нь юу саад болж байна вэ? түүнийг арилгаж, залруулах ямар боломж байна вэ? гэдэг талаар хэлэлцүүлэгт оролцогчийн хувиар товч санал хэлье.

Юуны өмнө энэ заалтыг хэрэгжүүлэхээр гаргасан хууль, тогтоол шийдвэрүүд дутуу, муу зарим талаар Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалаас зөрж гарсантай холбоотой. Тухайлбал, Орон нутгийг бие даасан тогтолцоотой болгон хөгжүүлэхэд төвлөрлийг сааруулах бодлого амин сүнс болдог. Гэтэл төвлөрөл саараагүй, харин ч эргэж төвлөрүүлэх бодлого явсан, одоо ч хэвээрээ байна. 2003 оноос Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр төвлөрөл гаарч, нутгийн удирдлагын тогтолцоо дампуурч эхэлсэн. Одоо төсвийн тухай хуулиар зарим нэг залруулга хийсэн ч үндсэн том алдаа огт засагдаагүй байна. Үүнийг концепцийнх нь хэмжээнд эргэн харж өөрчлөхгүйгээр нутгийн удирдлагад буй болсон хүнд байдал илааршихгүй. Хөрөнгө, хүн хоёрынхоо талаар ямар ч эрх мэдэлгүй орон нутгийн удирдлагын байгууллага бол нэрийн төдий зүйл. Сүүлийн жилүүдэд орон нутагт төсвөө бие даан зарцуулах эрх мэдлийг нэлээд өргөн хэмжээгээр өгч байгаа.

Харамсалтай нь орон нутаг өөрөө төсвөө боловсруулах, хуваарилах, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах гэсэн төсвийн циклийг хэрэгжүүлэх туршлага, чадавх, бас эрх зүйн боломж ч хангалтгүй байна. Ийм болохоор одоогийн төсвийн хуулийн хүрээнд орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн нэлээд нарийвчилсан зохицуулалт хийх шаардлага байгаа юм.

Хоёрдугаарт, “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэсэн Үндсэн хуулийн 58.2 дахь заалтыг хэрэгжүүлэх ажил эрх зүйн болоод улс төрийн саад бэрхшээлтэй учирдаг. Гол бэрхшээл нь нэг талаас намын бодлогоор сонгуулийн үр дүнд томилогддог Засаг дарга, Ерөнхий сайд, нөгөө талаас Орон нутгийн сонгуулиар бүрддэг ИТХ-ын хооронд улс төрийн шинжтэй зөрчил үүсдэг явдал мөн. Үнэндээ сонгууль болгоны дараа шат шатны засаг даргыг томилох гэж бөөн маргаан болсоор ирлээ. Энд маш олон баримт жагсааж болно.

Энэ бол орон нутгийн бие даасан байдлыг хангахад хамгийн том саад болж байгаа зүйл.

Энэ том саадыг арилгахын тулд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулахаас өөр арга зам одоогоор харагдахгүй байна. Үүнийг ч судлаач, мэрэгжилтнүүд орон нутгийн удирдлагууд хүлээн зөвшөөрч байна. Энд сонголтын хувилбарууд ч бий. Тухайлбал, ИТХ-аас нэрийг нь дэвшүүлсэн хүнийг тухайн шатны Засаг даргаар томилох үүргийг Ерөнхий сайд, эсвэл дээд шатны Засаг дарга нь буцаах эрхгүйгээр шууд томилох /ёсчлох/ үүрэгтэй байхаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд Засаг дарга засаг төрийн төлөөлөл байх тухай заалтын хүрээнд зарим нэг нарийвчилсан зохицуулалт хийх шаардлага гарч болох. Бас улс төрийн намын оролцоог зохистой хэмжээнд зааж хязгаарласан байх ёстой. Одоогийнх шиг намын дарга Засаг дарга байж боломгүй санагдана. Орон нутагт улс төржих гээч өвчнийг хязгаарлах тодорхой бодлого, зохицуулалт хийсэн нөхцөлд энэ боломжийн сонголт байж болно.

Сонголтын нөгөө нэг хувилбар нь Засаг дарга нэгэнт л орон нутаг дахь засаг төрийн төлөөлөл гэдэг үзэл баримтлал хэвээр байгаа нөхцөлд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарыг шат дараалан шууд томилдог байж болно. Ийм нөхцөлд ИТХ-уудыг Улс төрийн намаас хамааралгүй, оролцоогүй цэвэр иргэдийн байгууллага байхаар зохицуулж болно. Засаг дарга Засгийн газрын Мөрийн хөтөлбөрийг орон нутагт яаж хэрэгжүүлэх, талаар тусгасан хөтөлбөрийг боловсруулж ИТХ-аар батлуулан тухайн орон нутагт хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. ИТХ-ын гол үүрэг нь Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавихад оршино. Шийдэх асуудал нь орон нутагт Гүйцэтгэх удирдлагын зэрэгцсэн бүтэц буй болж нэмэлт зохицуулалт шаардана. Бас улсын болон орон нутгийн төсөв их тодорхой заагтай, уялдсан байхаас эхлээд зохицуулах асуудлууд цөөнгүй үүснэ.

Гуравдугаарт, Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, түүний бие даасан хараат бус байдлыг хамгаалах асуудал туйлын чухал юм. Европын болон даян дэлхийн нутгийн өөрөө удирдах ёсны харти, бусад баримт бичгүүдэд орон нутгийн бие даасан байдалд хор учруулахаас сэргийлэх талаар гаргасан зөвлөмжүүдийг бүтээлчээр судлан хэрэгжүүлэх ёстой.

Эхлээд **эрх зүйн шинжтэй баталгааг** хангах ёстой. Үүнийг өмнө товч хэлсэн. Энд зөвхөн зөвлөмжийн шинжтэй зүйлийг товч хэлье.

- Орон нутгийн эрх мэдэлд хуваарилсан асуудлыг хуулиар тодорхой заах. Эдгээр асуудал нь байнгын шинжтэй байх ба түр эрх, түр даалгавар гэх мэтийн зүйлийг эрх өгсөн байгууллага хүссэн үедээ эргүүлэн авч болох учраас ийм арга хэрэглэхээс татгалзах,
- Орон нутаг нь төвийн мэдэлд байгаа нийтлэг асуудлыг орон нутагт эрхэлж болох ба ийм тохиолдолд уг эрх нь хуулиар заагдсан байх,
- Орон нутаг ба төвийн хамтран хариуцах асуудлын хувьд хэн нь юуг хариуцахыг хуулиар заах,
- Дээд байгууллагаас орон нутагт эрх шилжүүлж болно. Тэхдээ нийтлэг асуудлыг хариуцуулах, эрх шилжүүлэх зэргээр дээд байгууллагаас орон нутагтай харилцахдаа уг асуудлаар дамжуулан орон нутгийн бие даасан байдалд халдах, хараат болгох оролдлогоос урьдчилан сэргийлэх,
- Орон нутгийн эрх мэдлээс гадуур боловч орон нутгийн бие даасан байдалд нөлөөлж болзошгүй асуудлаар шийдвэр гаргахдаа орон нутагтай зөвлөлдөх ,

Санхүүгийн шинжтэй баталгаагүй бол ямар ч сайн хууль хэрэгжихгүй гэдгийг үндэс болгож тэр баталгааг бүрдүүлэх ёстой.

- Орон нутгийн хүлээх үүрэг санхүүгийн нөөц хоёр зохицож байх,
- Үүргээ гүйцэтгэхэд хангалттай бус санхүүгийн нөөцтэй байсан тохиолдолд орон нутгийн эсрэг шүүх ажиллагааг зохистой биш гэж үзэх,
- Орон нутаг төсвөөс хөрөнгө зарах тэргүүлэх зорилтыг өөрөө бие даан тодорхойлох эрхтэй байх,
- Орон нутгийн татвар төлөгчийн төлж буй татвартай харьцуулахад авч буй үйлчилгээний нь үр өгөөж илүү байх зарчмыг хэрэгжүүлэх нь сонгогдсон төлөөлөгчийн гол үүрэг байх,

- Орон нутгийн татварыг төрөөс хязгаарлаж болох боловч бие даасан байдал, үүргээ биелүүлэхэд нь нөлөөлөхгүй байхаар шийдвэрлэх,
- Орон нутгийн татвар нь инфляц зэрэг эдийн засгийн өөрчлөлтийг тусгадаггүй учраас санхүүгийн хүндрэл гарч болохыг дээд байгууллага анхаарч байх,
- Орон нутаг зээл авах эрхтэй байх,
- Орон нутагт янз бүрийн төрлийн грант олгох зэргийг санхүүгийн баталгаа хангах гол хүчин зүйлс гэж үзэж байгаа юм.

Хяналт, зохицуулалтын шинжтэй баталгааг нутгийн иргэд, олон нийтийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор бүрдүүлэх шаардлагатай.

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага өөрийн харьяа захиргааны (гүйцэтгэх) байгууллага байгуулах, тэдгээрт ажиллах хүмүүсийг шилж сонгох, төрийн бусад байгууллагын ажилтнуудтай ижил хэмжээнд нийгмийн хамгаалал, халамжид хамруулах, ажиллах нөхцөл, цалин хөлсөөр хангах,
- Дээрээс тавих захиргааны хяналтын гол нь орон нутгийн байгууллага хуулийн хүрээнд ажиллаж байгаа эсэхэд чиглэх,
- Дээрээс эрх шилжүүлсний дагуу орон нутгийн байгууллагаас хийж байгаа ажлыг хянаж болох боловч орон нутаг нөхцөл байдалдаа нийцүүлэн өвөрмөц хандлага гаргаж болохыг үгүйсгэхгүй байх,
- Дээд газрын хяналтын ерөнхий зарчим нь ажлын үр дүнг аль болохоор өндөр байлгахад чиглэхийн зэрэгцээ орон нутгийн бие даасан байдлыг хөндөхгүй байх,
- Орон нутгийн байгууллагууд ижил төвшний гадаад, дотоодын байгууллагатай шууд харилцах хамтран ажиллах,

Энд дурдсан төрөл бүрийн баталгаа нь чухамдаа төв орон нутгийн харилцааны агуулгыг илэрхийлж байгаа юм. Нутгийн өөрөө удирдах ёс аль болохоор бүрэн дүүрэн хэрэгжиж байх нь эл харилцаанд дээр дурдсан хүчин зүйлсийг хэрхэн

харгалзаж хууль тогтоомжоор баталгаажуулахын зэрэгцээ үйл ажиллагааны арга барил болгон тогтмолжуулахаас хамаардаг.

Хоёр. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ИРГЭДИЙН ОРОЛЦОО ЯМАР БАЙНА ВЭ? ОРОЛЦООНЫ ЯМАР ХЭЛБЭРҮҮД ӨНӨӨДӨР ЧУХАЛ ГЭЖ ТА ҮЗЭЖ БАЙНА ВЭ?

Орон нутаг бол иргэдэд хамгийн ойр байж, шууд харьцаж байдаг төрийн болон бусад үйлчилгээний гол орчин юм. Тийм болохоор нутаг орноо хөгжүүлэхэд иргэд хамгийн өргөн хүрээтэй, хамгийн идэвхтэй оролцох шаардлагатай байдаг. Өнөөдөр иргэдийн оролцооны олон хэлбэр бий. Тэр бүрийг ихээхэн үр нөлөөтэй ашиглах шаардлагатай гэж үзэж байна.

Иргэдийн оролцооны хамгийн түгээмэл хэлбэр бол тэд **олон нийтийн хурал, цуглаанд оролцох**. Үүнд ихэнх хүмүүсийн сайн мэддэг баг, хорооны зүгээс зохион байгуулдаг хурал, уулзалтуудыг ойлгож болно. 2014 онд Ерөнхийлөгчийн тамгын газраас сум, дүүрэг бүрт **Иргэний Танхим** байгуулахыг зөвлөмж болгосон байдаг. Энэ дагуу орон нутгийн төвшинд олон тооны иргэний танхимууд байгуулагдан ажиллаж буй. Иргэний танхим нь сум, дүүргийн төв хэсэгт байрлах бөгөөд иргэд үзэл бодлоо илэрхийлэх, аливаа асуудлаар хэлэлцүүлэг, яриа өрнүүлэх, уулзалт зохион байгуулах уулзалтын гол газар байх ёстой. Эдгээр уулзалтуудын үеэр засгийн газрын төсөл, хөтөлбөрийн талаарх чухал мэдээ, мэдээлэл, бэлчээрийн менежмент, газрын гэрчилгээ олгох арга хэмжээ эсвэл сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг иргэд, олон нийтийн амьдралд нөлөө үзүүлэх зэрэг олон асуудлаар иргэдийнхээ санаа бодлыг сонсож, шийдвэр гаргахдаа шууд оролцоог нь хангах боломжтой.

Өнөөгийн нөхцөлд орон нутагт иргэдийн оролцоог дэмжин зохион байгуулах нэг чухал хэлбэр бол **төсвийн үйл явцын судалгаанд идэвхтэй оролцох** явдал мөн. 2013 онд хүчин төгөлдөр болсон Төсвийн тухай хуулинд бүх өрх, оршин суугаа орон нутагтаа нэн тэргүүнд хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа хөгжлийн төсөл, хөтөлбөрийн (Орон нутгийн хөгжлийн сан гэж нэрлэдэг) талаар судалгаа явуулж, түүнд иргэдээ өргөн хүрээтэй хамруулахыг шаарддаг болсон. Энэхүү судалгааны маягтыг

жил бүрийн хавар буюу 3-5 дугаар сарын хооронд баг, хорооны засаг дарга тарааж, судалгаа авч байх ёстой. Судалгаанд идэвхитэй хариулж холбогдох газарт нь мэдээлэл, саналаа хүргүүлэх нь тухайн орон нутагт нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөтөлбөр, ажлууд тодорхойлоход нэн чухал. 6, 7 дугаар сард зохион байгуулагддаг баг, хорооны олон нийтийн уулзалтуудаар төсвийн тодорхой асуудлууд шийдэгдэхэд иргэдийг бас сайн оролцуулах шаардлагатай.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх бага хэмжээний төсөл хөтөлбөрүүдийг шалгаруулах **худалдан авах үйл ажиллагаанд оролцох нь** иргэдийн оролцооны бас нэг гол хэлбэр юм. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх харьцангуй жижиг хэмжээтэй ажлуудын хувьд орон нутгийн иргэд бүлэг, баг болон нэгдэж тус ажлыг гүйцэтгэх боломжтой. Тухайн гүйцэтгэх ажлын нийт төсөв 20 сая төгрөгөөс бага тохиолдолд засгийн газар иргэдийн бүлэг, багтай шууд гэрээ хийж болдог. Ийм учраас уг ажлыг хэрэгжүүлэхэд иргэдийн идэвх, санаачилга юу юунаас чухал байх болно.

Бас Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын тендер болон төслүүдийн гүйцэтгэлд **хяналт-үнэлгээ \мониторинг\ хийхэд** иргэд оролцох боломж их өргөжиж байгаа. Сангийн яамнаас гаргасан шинэ чиглэлийн дагуу иргэд засгийн газрын худалдан авах үйл ажиллагаа болон ОНХС-гийн төслүүдэд мониторинг хийх баг бүрдүүлж болно. Түүнчлэн шинээр батлагдсан хуулиар иргэд засгийн газрын төсвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах эрхтэй болсон бөгөөд төсвийн талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлдэг болсон байгаа.

Иргэд орон нутагтаа ажиллаж буй **төрийн байгууллага, албан тушаалтны үйлчилгээний чанарт мониторинг хийх хэлбэрээр** орон нутгаа хөгжүүлэхэд оролцох өргөн боломж бий. Жишээ нь, иргэдийн дунд цэцэрлэг, сургууль, эмнэлэг, тээвэр зэрэг орон нутагт төрөөс үзүүлж буй үйлчилгээний чанарт сэтгэл дундуур хүн олон байдаг. Тиймээс энэ асуудлыг шийдэхэд дөхөмтэй нэг арга бол тухайн үйлчилгээг хүргэж буй байгууллага, хувь хүнтэй ойр дотно хамтран ажиллаж, дутагдалтай талууд юу байгааг зөв тодорхойлж, амьдралд

ойр шийдэл олох явдал юм. Энэ арга барилыг хэд хэдэн хувилбараар хэрэгжүүлж болох боловч Монгол улсад тохирох, илүү түгээмэл хэрэглэгддэг арга бол тухайн үйлчилгээг авч буй иргэдийн дунд судалгаа явуулж, “тайлангийн хуудас” буюу “онооны хуудас”-тай болгох арга байдаг. Жишээ нь бид үүнийг хэрэглээд үзэх боломжтой.

Сүүлийн үед ихээхэн өргөжиж буй иргэдийн оролцооны нэг хэлбэр бол **иргэд сайн дураараа нэгдэж** нутаг орноо хөгжүүлэх төрөл бүрийн санаачилга гарган төрийн болон бизнесийн байгууллагуудтай хамтран ажилладаг болсон явдал мөн. Хэдийгээр засгийн газар иргэдэд төрийн үйлчилгээг аль болох хамгийн сайн түвшинд хүргэх үүрэг хүлээдэг ч засгийн газрын төсөв, хүн хүчний чадавхи хязгаарлагдмал учир бүх зүйлийг дангаар хариуцан ажиллаж чадахгүй. Тиймээс тухайн орон нутагт байгаа аливаа төрлийн үйлчилгээ иргэдийн сэтгэлд хүрэх түвшинд байж чадахгүй байгаа тохиолдолд энэ үйлчилгээний чанарыг сайжруулахад иргэдийн сайн дурын саннаачилгын үйл ажиллагаа их чухал. Энд заавал аль нэг том бодлогын асуудал байх албагүй. Хог хаягдлыг багасгах, цэцэрлэг, сургуулийн орчны тохижилтыг сайжруулах, гээд ямарч асуудлаар иргэд нэгдэж үр дүнтэй үйл ажиллагаа явуулах боломжтой. Гол нь үүнийг нь нутгийн удимрдлагын байгууллагууд анхааран дэмждэг байх нь л чухал.

Гурав. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД УЛС ТӨРИЙН НАМЫН ОРОЛЦОО ХЭРЭГТЭЙ ЮУ?

Орон нутагт улс төржилт хэрээс хэтэрсэн учраас иргэд, хамт олон орон нутгийн сонгуульд улс төрийн намын оролцоог аль болох бага байлгах, болж өгвөл бүрэн хязгаарлах нь зүйтэй гэсэн санаа бодол сүүлийн жилүүдэд маш их яригдах боллоо. Иргэд төдийгүй судлаачид, улс төрчид, орон нутгийн удирдах ажилтнууд ч үүнийг ажил хэрэгчээр ярилцаж эхэллээ. Одоо парламентад яригдаж буй Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд энэ асуудал онцгой анхаарал татаж байгаа болно.

Эхлээд өөрийн туршлагаа судлах хэрэгтэй. 1996 оны орон нутгийн сонгуулийн хуулиас өмнө хуралд нэр дэвшүүлэхэд намууд оролцдоггүй байсан. Тэнд сайн муу тал байсан л байх. Харин 1996 оноос эхлэн аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-д улс төрийн нам нэр дэвшүүлдэг болсон. Гол үр дүн нь орон нутагт хавтгай улс төржилтийг дэврээсэн, одоо энэ бүр тэвчиж болох хязгаараас аль эрт хэтэрч нутаг орныг бусниулсан дампуу явдал болжээ.

Тэгэхлээр энд ярих гол асуудал нь орон нутгийн хурлын сонгуульд улс төрийн намуудын оролцоо ямар байхыг шийдэх. Зүй нь орчин үеийн сонгодог утгаараа бол улс төрийн нам чинь төрд иргэдийн өмнөөс хяналт тавьдаг иргэний ниймийн шинж давамгайлсан байх ёстой шүү дээ. Гэтэл манайд улс төрийн тогтолцооны бүх эд эсд улс төрийн намууд голлох үүрэг гүйцэтгэх болчихоод байгааг эргэн харж, концепцийн хэмжээнд нягталмаар байна. Ингэхийн тулд өөрийнхөө орны 20 гаруй жилийн туршлагыг сайн судлах ёстой.

Хоёрдугаарт, сонгож авсан ардчиллын зам, түүний плюраль загвартай холбож бодмоор байгаа юм. Нутгийн удирдлагын тогтолцооны хөгжил, ялангуяа өөрөө удирдах ёсны хэрэгжилт ардчилалтай салшгүй холбоотой. Орон нутгийн оршин суугчид асуудлыг шууд өөрсдөө хэлэлцэх, шийдвэрлэх боломж бүхий газар бүрт, асуудал бүрт эл боломжийг ашиглана.

Шууд ардчиллын аргыг хэрэгжүүлэх боломжгүй, төлөөллийн байгууллагаар шийдвэр гаргах үед ч олон нийтийг аль болох өргөн оролцуулан санал авах, хэлэлцүүлэг хийх зэрэг аргыг хэрэглэдэг. Ялангуяа мэдээлэл, холбооны технологи амьдралд өргөн хэрэглэгдэж буй өнөө үед олон нийттэй зөвлөлдөх эл аргыг өргөн хэрэглэх боломж нээлттэй байгаа юм. Сүүлийн жилүүдэд **“Шууд ардчилал”-ыг** хөгжүүлэх үйл ажиллагаа эрчимтэй өрнөж байгаа ч манайд эрх зүйн бие даасан зохицуулалт дутмаг байгаа нь үйл явц бодит үр дүнд хүрч чадахгүй байна.

Гуравдугаарт, Хүний нөөцийн менежменттэй холбож улс төрийн намын оролцоог хязгаарлах тухай бодох ёстой.

Нутгийн удирдлагын тогтолцоог тамирдуулж, олон түмэнд нэргүй, үнэгүй болгож байгаа хамгийн гол шалтгаан бол яах аргагүй орон нутаг дахь улс төрийн харилцааны дампуурал, мэргэжлийн удирдлагын хомсдол мөн. Улс төрийн харилцааны дампуурал нь юуны өмнө орон нутгийн сонгуультай холбогддог. Энд мэргэжлийн удирдлага, төрийн удирдлага, улс төрийн удирдлагын харилцан хамаарлыг хангах асуудал яригдана. Эхний хоёр буюу мэргэжлийн болоод төрийн удирдлагад улс төрийн намын оролцоог бүрэн хаах ёстой. Энэ хоёр улс төртэй хутгалдаад ирэхлээр орон нутгийн хүний нөөцийн бодлогоч алдагдана, чадавхи ч алга болно. Харин улс төрийн удирдлагын тухайд бол цэвэр намын асуудал. Ийм л логикоор орон нутгийн сонгуулийн хуулийг боловсруулж удирдлагын салбар, чиглэлүүдийг өөрийнх нь байр сууринд тавих хэрэгтэй.

Дөрөвдүгээрт, нэгэнт намын шинжээр сонгууль явуулж орон нутгийн хурлыг бүрдүүлж байгаа нөхцөлд орон нутгийн улс төрийн нөөцийг зөв ашиглах ёстой.

Нутгийн удирдлагын төвшин дэх улс төрийн нөөц гэдэг бол тэнд байгаа улс төрийн нам төдий биш ээ. Үүнд эрх чөлөөтэй иргэн, ТББ, янз бүрийн бүлэг, холбоо, малчдын нөхөрлөл гээд иргэний нийгмийн байгууллагууд гол нөөц нь юм. Энд улс төрийн нам дээр гарч томрохын оронд иргэний нийгмийн бүтцийн хувьд нэг эгнээнд орж, хамтран засаг, захиргааны удирдлагад хяналт тавьдаг байх ёстой. Ингэж хуульчлах шаардлага бий болоод удаж байна. Үүнийг одоо л цаг алдалгүй шийдэж авахгүй бол дахиад л сонгуулийн цикл ороод ирнэ.

Эцэст нь яг одоогийн нөхцөлд орон нутгийн сонгуульд улс төрийн намуудын оролцоо ямар байвал зохистой тухайд санал хэлье. Өнгөрсөн туршлага, олон улсын жишиг хандлагыг эрэгцүүлж бодоод дараах тодорхой санааг хэлэлцүүлэгт оруулж байна. Үүнд:

- Баг, хорооны ИНХ-ын тэргүүлэгчид, Засаг даргыг сонгох томилох бүх үйл ажиллагаанд улс төрийн намын оролцоог бүрэн хориглож, харин тухайн орон нутаг дахь улс төрийн бусад нөөц, иргэд, иргэний нийгмийн бүрдлүүдийн оролцоог өргөтгөж хуульчлах, Чингэхдээ баг, хорооны Засаг даргыг иргэд өөрсдөө ИНХ-аараа

эцэслэн сонгодог, огцруулдаг байх, энд дээд шатны Засаг даргын оролцоо байж болохгүй.

- Сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг тухайн нутаг дэвсгэр дэх улс төрийн нөөц, тухайлбал, улс төрийн нам, иргэний хөлөлгөөн, ТББ, иргэдийн зохион байгуулагдсан бүлэг хамтлагууд хамтарсан болон дангаараа тодруулдаг болгож хуульчлах,
- Аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчийн тухайн орон нутгийн иргэдийн тодорхой төлөөллийг хангасан иргэний нийгмийн байгууллагатай хамтран улс төрийн намаас нэрийг нь дэвшүүлдэг байхаар хуульчлах,
- Аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг УИХ-ын сонгуульд ялалт байгуулж эрх баригч болсон намаас томилогдсон Ерөнхий сайд шууд томилдог, Тэр Засаг дарга нь сум, дүүргийнхнийг шууд томилдог харин сум, дүүргийн Засаг дарга нь ИНХ-ын шийдвэрээр сонгогдсон баг, хорооны засаг даргыг шууд батламжилдаг байх.
- Төрийн захиргааны болон мэрэгжлийн удирдлагын босоо тогтолцоооны хүний нөөцийн томилгоонд улс төрийн намын оролцоог бүрэн хааж, харин ИТХ-тай зөвшилцөх механизмыг хуульд суулгаж болох талтай.
- Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлж оролцох улс төрийн нам иргэд, аж ахуйн нэгжээс сонгуулийн зардлын хандив авах явдлыг хязгаарлах, эсвэл бүрэн хориглож төрийн захиргааны байгууллага, сонгуулийн байгууллага хяналт тавихаар хуульчилж болмоор мэт санагдана.

Дөрөв. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙН ХАНДЛАГЫН ТУХАЙ ТАНЫ БОДОЛ?

Орон нутгийн хөгжлийн ирээдүйн хандлагын тухайд олон хүчин зүйлээс шалтгаалах учраас нарийвчилсан тодорхой зүйл хэлэх боломж хязгаарлагдмал. Харин ерөнхий хандлага хийгээд бодлогын хувьд зарим зүйлийг хэлж болно.

Юуны өмнө Монголын орон нутаг маш сайн хөгжих өргөн боломжтой. Учир нь эрх зүйн орчны хувьд, газар нутаг, байгалийн баялгийн хувьд, хөдөө аж ахуйд суурилсан аж ахуйн

өвөрмөц цогцолборын хувьд бүх талаар бие даан хөгжих боломж буй. Энэ утгаар нь би ирээдүйн хандлагыг маш өөдрөг төсөөлж явдаг хүний нэг. Үндсэн хуульд заасан тэр л ерөнхий хандлагын дагуу хөгжих учиртай. Өөрөөр хэлбэл, нутаг орныхоо хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх санхүүгийн болон эрх зүйн чадавхитай нийгэм- эдийн засгийн цогцолборууд болж хөгжинө гэсэн үг. Одоо ч энэ л чиглэлээр явж байгаа. Энэ замд бэрхшээл, хүндрэл учруулж буй зарим зүйлийн талаар би өмнө ярьчихлаа.

Орон нутаг гэдэг бол бас ерөнхий ойлголт. Энд Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал бодлогоос эхлээд баг хороо хүртэл шаталсан суварган бүтэц бий. Дашрамд тэмдэглэхэд Монгол улс цаашдаа хэдэн бүстэй, бүсүүд нь ямар үзэл баримтлал, бодлогоор хөгжих вэ? гэдэг асуудал анхаарал татаж байгаа. Ер нь бол Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүс нутгийн удирдлага зохицуулалтын тухай хууль гээд батлагдаад гарчихсан зүйлүүд бий. Бүсийн тулгуур төвүүд гээд зарлачихсан юм ч бий. Харамсалтай нь энэ бодлого, хөтөлбөр одоо хүртэл олигтой явахгүй, олон асуудал нь ойлгомжгүй, бүрхэл хэвээр байгаа нь орон нутгийн цаашдын хөгжлийн хандлагад сайнаар нөлөөлөхгүй байна. Наад зах нь зам харгуй, дэд бүтэц, зах зээлийн татах, түлхэх хүчний харьцаа гээд орон нутгийн хөгжлийн цаашдын төлөвлөлтөд харгалзах ёстой олон зүйл бүдэг бүрхэг байгааг аль болох тодорхой болгох шаардлагатай.

Монгол Улсын ХХ1 тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Аймгуудын ХХ1 зууны тогтвортой хөтөлбөрүүдийг баталж гаргасан. Тэдгээр орон нутгийн хөгжлийн ирээдүйн хандлагыг нэлээд нарийн тусгасан байдаг. Харамсалтай нь одоо тэр хөтөлбөр, баримт бичгүүдийг эргэж харж, хэрэглэж байгаа байдал туйлын хангалтгүй, бараг мартагдах шахам болсон. Ер нь манайханд салан баавгайн үлгэр шиг хандлага их газар авчихлаа. Зүй нь хийсэн бүтээсэн зүйлийнхээ залгамж холбоон дээр л аливаа юм хөгждөг жам ёс шүү дээ. Орон нутгийн хөгжлийн ирээдүй ч гэсэн ялгаагүй урьд хийсэн, одоо хийж байгаа, бас ирээдүйд хийхээр төлөвлөж байгаа зүйлийн залгамж холбоон дээр л тодорхойлогдоно.



ЖИГЖИДСҮРЭНГИЙН ЯДАМСҮРЭН

Монгол банкны хяналтын зөвлөлийн дарга,
Дээд боловсролтой эдийн засагч, Доктор профессор

ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ЭРХ МЭДЭЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Асуудлын чухал болох нь. Монгол орон бүрэн төвлөрсөн удирдлагатай социалист тогтолцооноос ардчилсан чөлөөт тогтолцоонд шилжин орж хөгжих хүнд бэрх замыг туулж байна. Үүнтэй уялдаад шилжин орж буй нийгмийг танин мэдэх, эрх зүйн шинэчлэл хийж байх шаардлага өссөөр байна. Нийгмийг танин мэдэхүйн энэхүү шаардлага нутгийн өөрөө удирдах байгууллагын болон төрийн бүх шатны удирдах ажилтан нарт нэн түрүүнд хамааралтай юм.

Анх 1992 онд бидний оролцоотойгоор төслийг нь боловсруулан УИХ-д хүргүүлж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлан гаргаж, зохих байгууллагаас орон нутгийн бүх шатны хурлыг сонгон байгуулж, Засаг даргыг томилон түүний ажлын

албадыг байгуулж, албан хаагчдыг бүрдүүлэх чухал ажлыг хэрэгжүүлсэн билээ. Энэ ажлын үр дүнд 21 аймаг, нийслэлийн болон 350 орчим сум, дүүрэг, хороодыг зохион байгуулж удирдах байгууллагуудыг нь сонгож, томилсон юм. Энэ бол анхны алхам байлаа.

Монголын нийгмийн ардчилсан өөрчлөлт шинэчлэлтийн хамрах нэг үндсэн хүрээ нь төрийн байгуулал байсан юм. Энэ явцад төр бүх шатанд сууриараа солигдож, мөн чанар нь үндсээрээ өөрчлөгдөж эхэлсэн. Төрийн хуучин байгууллага, аппаратыг шинэ агуулгад нийцүүлэхийг зорьсон. Энэ шинэчлэлийн нэг хэсэг нь Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн томъёоллоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын шинэ тогтолцоог бүрдүүлэх товчоор хэлбэл, нутгийн хуучин төвлөрсөн удирдлагын тогтолцоог халж, шинэ тогтолцоог үүсгэн бүрдүүлж, зөв төлөвшүүлэх явдал байсан. Шинэчлэл нь төрийн болон нутгийн удирдлагын олон талыг тухайлбал, Монгол төрийн байгууламжаас эхлээд орон нутгийн удирдлага, зохицуулалтыг бүхэлд нь хамарсан. Орон нутагт амьдрал үүрлэдэг учраас тэнд шинэчлэлийг илүү ихээр шаардсан.

Энэ явцад орон нутгийн тогтолцоог шинэчлэх хууль эрх зүйн үндсийг бүрдүүлсээр ирсэн. Амьдралын өөрчлөлтийг тусган олон хууль гаргасан, үүний зэрэгцээгээр бас хуулиудад холбогдох өөрчлөлтийг хийхийн тулд олон заалтыг дайвар болгон хавчуулах замаар нэмсээр өдий хүрч, 20 гаруй жилийг өнгөрөөлөө. Энэ арга өдгөө хүчээ шавхжээ. Тиймийн учир орон нутгийн хүрээн дэх шинэчлэл өөрчлөлт удаашран зорьсон зорилгодоо хүрээгүй байна. Эхлэл төдий үндсийг тавьж, зогссон байна. Энэ нь олон шалтгаантай. Түүнийг жинхэнэ ёсоор залгуулан төлөвшүүлж эрч хүч авахуулан эцсийн зорилгод нь хүргэх асуудал тулгамдаж байна. Энд шийдвэрлээгүй, бэрхшээлтэй цөөнгүй асуудал хуримтлагдсаны нэг нь **орон нутагт эдийн засаг, санхүү, төсвийн эрх мэдлийг** бүрэн өгөх явдал мөн. Үүнийг цаг алдалгүй зөвөөр шийдвэрлэх нь Монгол орны эдийн засаг, улс төр, нийгэм, оюун санааны хүрээнд хийх шинэтгэлийг хурдасгах, нийгмийн амьдралыг тогтворжуулах нэг гол хүчин зүйл болох билээ.

Өнөөгийн байдлаас гарч зорьсон зорилгоо гүйцэд хэрэгжүүлэхэд энэ салбарын өөрчлөлт шинэчлэлийн байдлыг бүхэлд нь нэг дүгнэж, тулгарсан зорилтыг холбогдох хуулийн энэ тэнд зүйл заалт маягаар нэмэлт оруулж, шийдвэрлэхийг оролддог арга барилаа эргэн харж, шинээр асуудлыг цогц байдлаар зохицуулах шаардлага гарч буйг ухааран ухамсарлаж, орон нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх асуудлыг цоо шинэ хөрс суурьт бус өнөөгийн үүсч бүрдсэн дэвсгэр суурь дээр нь цогц байдлаар шинэ хуулиар шийдвэрлэхийг оролдох нь зүйтэй болсон бус уу. Уг салбарыг зохицуулахад хууль зүйн хувьд реформ хийх цаг аль хэдүйн болжээ. Ингэхгүйгээр орон нутгийн бие даасан байдлыг хангах тухай ярих нь утгагүй зүйл болсон байж магад. Бидэнд ингэж авч үзэх бололцоог олгох шинэ зарчим, шинэ үндэслэл, үзэл баримтлалыг томъёолсон суурь хууль байна.

Үндсэн хуулийн зарчим, үзэл санаа. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэгт орон нутгийн удирдлагыг өөрчлөх үндэслэл, зарчмыг тодорхойлж оруулсан юм. Эдгээр үндэслэл, зарчмыг янз бүрээр тайлбарлаж өдий хүрлээ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагыг нэг хэсэг нь өмнөх үеийнх шиг ойлгож байлаа, нөгөө хэсэг нь олон нийтийн удирдлагын шинж байдлаар авч үзэх нь байлаа. Бас Үндсэн хуулийн энэ бүлгийг өөрчлөхгүйгээр орон нутгийн удирдлагын бие даасан байдлыг жинхэнэ ёсоор төлөвшүүлж чадахгүй гэж үзэх, бичих явдал ч гарсан. Аль аль нь уг асуудалд гоомой хандаж байгаа явдал бөлгөө.

Монголчууд асуудлаа цааш гүйцээн хэрэгжүүлж болох эрх зүйн шинэчлэлийн хангалттай үндэслэлийг Үндсэн хууль тавьсан байна. Хэрэг дээрээ Үндсэн хуульд шинэ нөхцөлд бидний төгс хэрэгжүүлэхээр зорьсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн *нэгжийн удирдлага, өөрөө удирдах ёс, төрийн удирдлага* гэсэн энэ салбарын шинэчлэлийн чухал гурван ойлголт хоорондоо уялдаа холбоотой хуульчлагдсан байна.

Эндээс нэг чухал асуудлыг анхаарвал зүйтэй санагдана. Энд эхлээд дурьдсан нэгжийн удирдлага хэмээх нь босоо болон хэвтээ удирдлагын огтолцол дээр үндэслэн хэрэгжих учиртай юм. Үүнийг мартаж болохгүй. *Өөрөө удирдах ёс*

гэдгийг улс төрийн үүднээс бус авч үзвэл тэр нь *тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил хэргийг тэндэхийн иргэд, хамт олон шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан бие даан шийдвэрлэх, эрхлэн хөтлөх, хариуцах ёс юм*. Эдгээр шинж нь “нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх” Үндсэн хуулийн томъёоллоор илэрч байгаа билээ. Үүнийг өнгөцхөн тайлбарлах, авч үзэх явдал удирдлагын бүх төвшинд гарч ургашаа ахихгүй байгаа юм. Ингэх нь өөрөө удирдах ёсыг жинхэнэ ёсоор бэхжүүлэн төлөвшүүлэхэд саад тотгор болж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нутаг дэвсгэрийн нэгжүүд хөгжих чөлөөт байдлын эрх зүйн үндсийг бүрдүүлж, “аймаг, сум, нийслэл, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж тодорхойлсон. Энэ нь төрийн байгууламжийн хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүрэг бол өөрийгээ тэтгэх тал бүрийн чадавхтай бие даасан субъект байна гэдгийг баталгаажуулсан хэрэг юм. Эл цогцолборт *нутаг дэвсгэрийн, засаг захиргааны, эдийн засгийн, нийгмийн / нийгэмшлийн/* гэсэн дөрвөн шинж хадгалагдана. Эндээс эдийн засгийн болон нийгмийн цогцолбор гэдэг бол аймаг сум, нийслэл дүүрэг гэх хос нэгжийн эдийн засаг санхүүгийн үндэс, тэдгээрийн нийгэмшлийн үндсийг хамарсан ойлголт болж байна.

Эдийн засгийн үндэс гэх нь чухам юу вэ, Монгол Улсын Иргэний хуульд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс нь хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, байгалийн нөөц, баялаг, өөрийн мэдлийн аж ахуй, бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос бий болсон ашгийн хуримтлал, албан татвар, хураамжаас бүрдэнэ” гэж заажээ. Эндээс эдийн засгийн үндэс гэдэг бол тухайн нэгжийн оршин байх, хөгжихөд зайлшгүй шаардлагатай агаад бие даан эзэмшиж, ашиглах, хууль ёсоор татан оруулж буюу захиран зарцуулж болох эдийн болон эдийн бус бүх баялгийг, юуны өмнө эд хөрөнгийн нийт нийлбэрийг, тэдгээрийн эх нөөцийг хамарч байна.

Харин нийгмийн /нийгэмшлийн/ үндэс гэдэг нь сумын нийт хүн амын тоо, тэдний соёл боловсрол, эрүүл мэндийн байдал болон нийгмийн хамгааллын тогтолцоо, бусад нийтлэг үйлчилгээ, ерөнхийдээ хүний хөгжлийг хамруулсан ойлголт юм. Тухайн нэгжийн хүний тоо, хүний нөөцийн хөгжлийн үзүүлэлт нь нэгжийн бие дааж оршин цэцэглэхийн үндэс билээ. Эзэнгүй нутаг дэвсгэрийн нэгж гэж байхгүй, энд нийгэмшлийн асуудлыг оруулахгүй бол тэр нь утгагүй зүйл болно.

Бас Үндсэн хуульд төрийн байгууллага болон орон нутгийн эрх барих байгууллага өөр өөрийн эрх хэмжээний асуудлыг бие даан шийдвэрлэх зарчмыг хэрэгжүүлэхээр заасан байна. “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” хэмээн баталгаажуулжээ.

Ийнхүү зах зээлийн эдийн засагтай, ардчилсан дэглэмтэй, нийгмийн чиг баримжаатай шинэ монгол орны шинэ төр засаг нь улсынхаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хөгжлийг хэт төвлөрийг багасгах, аймаг, сум зэрэг нутаг дэвсгэрийн завсарын нэгжийг бие далган эдийн засгийн хувьд аль болохоор өөрийгөө тэтгэн хөгжиж чадахуйцаар зохион байгуулахыг Үндсэн хууль гол зарчим, үзэл санаа баримтлалаа болгожээ.

Орон нутагт өөрөө удирдах ёс, төрийн удирдлагыг хослохуй. 1992 оны Үндсэн хуульд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэсэн зарчмыг тунхагласан. Тэгээд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага бол Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн хурал, хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн гэж хуульчилсан юм. Ингэхлээр, нутгийн өөрөө удирдах ёсны хууль зүйн гол онцлог бол тухайн нэгжийн амьдралын үндсэн асуудлыг тэр нэгжийн иргэд шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан шийдвэрлэх явдал болж буй.

Хамгийн түгээмэл шалгуурыг баримтлан авч үзвэл нэгжийн өөрөө удирдах ёс бол тухайн нэгжийн хүн ам хуулийн хүрээнд өөрсдийн ажил амьдралын үндсэн асуудлыг гаднын дарамт шахалтад автахгүйгээр өөрсдөө бие даан шийдвэрлэж, хариуцаж байна гэсэн үг.

Харин хослуулан хэрэгжүүлэх төрийн удирдлага бол тус бүрдээ онцлог байдалтай, харилцан адилгүй нөхцөл дэх /эдийн засаг, газар зүйн байрлалын хувьд/ аливаа нэгжийн дотоод асуудал, өвөрмөц зорилтыг бус, харин Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс байх язгуур эрх ашиг, ашиг сонирхлыг илэрхийлсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Зах зээлийн харилцаа гүнзгийрэх тутам төрөөс аж ахуйг эрхлэх, удирдах үүрэг сулран харин улс нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах, хууль ёс, нийгмийн хэв журмыг сахиулах, улсын санхүүг бэхжүүлэх, татварын хэргийг эрхлэх, нийгмийн хэмжээгээр орлого, зарлагыг хуваарилах, дэд бүтцийг хөгжүүлэх, нийт иргэнд хамааралтай нийтлэг үйлчилгээг хүн амд үзүүлэх, нийгмийн халамж, хамгааллыг зохион байгуулах чиг үүрэг голлох шинжтэй болж үлддэг.

Орон нутагт буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх төрийн удирдлага нь аль ч утгаараа Засгийн газрын шугмаар хэрэгжүүлдэг төвлөрсөн удирдлага мөн. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төрийн удирдлагыг УИХ хууль тогтоох замаар эрх зүйн хувьд зохицуулах, хянан шалгах чиг үүргийг гүйцэтгэх үндсэн дээр Засгийн газар, түүний орон нутгийн удирдах байгуулага болох Засаг даргын шугмаар дэс дараалан хэрэгжүүлдэг.

Эрх мэдлийн хуваарилалтын хэмжээ, төвшингээс хамааран дэлхийн улс орнууд хатуу төвлөрсөн, бага төвлөрсөн удирдлагатай гэх хоёр хэсэгт хуваагддаг юм. Үндсэн хуульд зааснаар Монгол Улс нэгдмэл улс мөний хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийнхээ нэгжийг төр засаг нь улсынхаа ашиг сонирхлын үүднээс дээш нь ямар нэг хэмжээгээр төвлөрүүлж зохицуулах, хянан удирдах явдал зайлшгүй гардаг билээ. Гэхдээ манайх орон нутгийн бүх шатны нэгжийг өөрөө удирдах ёсонд хамааруулснаар төвлөрлийг үлэмж хэмжээгээр сааруулахыг зорьсон улс оронд хамаарна. Харин орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дээд шатныхыг /манайхаар бол аймаг, нийслэлийг/ дан ганц төрийн удирдлагатай болгож, зөвхөн доод шатны нэгжийг өөрийн удирдлагатай байхаар тогтоож хэрэгжүүлдэг улс орон бас бий. Үүнийг нэлээд хатуу төвлөрсөн удирдлагатай улс оронд тооцдог. Бас Холбооны улс гэх онцгой удирдлагатай улс орон буй. Тэгэхээр улс орнууд

өөрсдийн төрийн байгууламжаа харгалзан түүнээс үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаа тогтоож хэрэгжүүлдэг билээ. Ерөнхийдээ улс орнуудын төв засаг нь улсынхаа нутаг дэвсгэрийг засаг захиргааны хувьд хэрхэн яаж хуваарилж, хүн амаа харъяалуулан орон нутгаа удирдах, тэндэхийн эрх барих газруудтай эрх зүйн ямар байдалтай харилцахыг төрийн байгууламжаасаа хамаарч тогтоож явуулдаг юм. Энэ үүднээс ямар ч улс гүрэн төрийн байгууламжийнхаа хувьд холбооны улс, нэгдмэл улс гэсэн хоёр янз билээ. Өдгөө манайд Монгол Улсынхаа дээрх онцлогыг харгалзалгүй, улс оронуудын төрийн байгууламж ямар болохыг анзааралгүй өөрт тааралдсан аль нэг талын улс орны нутгийн удирдлагын тогтолцоог үлгэр болгон түүний туршлагыг авах нь зүйтэй гэж нэг тал руу хадууран хазайх явдал гардаг билээ. Нэгдмэл улсын хувьд манайх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагаа түүнд тохируулан авч үзэж төвлөрлийг сааруулах тухай ярих нь зүйтэй юм.

Өөрөө удирдах ёс хэрэгжих үндсэн гол шинжүүд. Харин өөрөө удирдах ёс нийтлэг шинжтэй. Нутаг дэвсгэрийнхээ буюу хамт олныхоо амьдрал, хөгжлийн аливаа асуудлыг хуулийн хүрээнд бие дааж шийдвэрлэх, тэрхүү шийдвэр нь тухайн нутаг дэвсгэрийн хамт олны заавал дагаж биелүүлэх, тухайлбал заавал хэрэгжүүлэх хүчин төгөлдөр байх, эрхлэх аливаа асуудлаа шийдвэрлэн хэрэгжүүлэхэд гаднын ямар ч дарамт шахалтад өртөхгүйгээр бие даасан байх учиртай. Үндсэн хуульд “нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэсэн заалтад дээрх шинжүүд тусгагдсан байна. Энэ нь нэгжийн удирдлагын бие дааж ажлаа явуулах эрх зүйн хангалттай үндэслэл мөн.

Орон нутгийн эдийн засаг, санхүүгийн бааз. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тусын нутаг дэвсгэрийнхээ цогцолбор хөгжил, хүн амынхаа ашиг сонирхлыг хангах зорилгод нийцсэн өөрийн эдийн засгийн үндэс, бааз суурьтай байх, тэрхүү үндэс бааз суурь нь төвөөс шууд хамааралтай бус байхыг бас

хуульчилсан байна. Үүгээрээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудал өмнөх төвлөрсөн удирдлагын үеийнхээс ялгаатай. Өдгөө энэ нь бодитой хэрэгжихэд олон бэрхшээл байна. Шинэ Үндсэн хуулиас хойшхи өнөө хүртэлх үед орон нутгийн бие даасан байдлыг хангаж буй мэтээр ярих явдал бас байна. Орон нутгийн бие даасан байдлыг хангаж байгаа тухай лоозон өдгөө цааш явахаа больжээ. Ий мд энэ салбарт эрх зүйн бодитой цогц шинэчлэл хэрэгтэй болсон байна. Энэхүү шинэчлэлд өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэн хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн механизмыг шинээр бүрдүүлэх, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн ажлын арга барилыг өөрчлөх, хүн амын сэтгэл зүйг шинэчлэн өөрчлөх асуудал чухлаар тавигдаж байна. Үүнийг хэрэгжүүлэхгүйгээр нутгийн өөрөө удирдах ёс нь цааш хэрэгжихэд бодитой түвэг учирч байна. Үүнээс болж өдгөө манай улсад нутгийн өөрөө удирдах ёс хэлбэрээрээ тогтсон ч, агуулгаараа төдийлэн төлөвшихгүй байгааг хэлэх хэрэгтэй.

Өөрөө удирдах ёсны эдийн засгийн үндэс бааз суурийг бүрдүүлэхэд дээрх бодит бэрхшээлээс гадна энэ асуудалд төвөөс хандах албан ёсны хандлага өрөөсгөл, үзэл бодлын зөрүүтэй, түүнээс хамаарч хугацаа алдах явдал бас гарч байна. 1990-ээд оны эхээр авсан арга хэмжээгээр орон нутагт өөрөө удирдах ёсыг нэгэнт бий болгочихсон мэт өнгөц хандах, тайвшрах явдал байна. Хурлын ач холбогдлыг үгүйсгэх, дутуу үнэлэх, аппаратын хүчийг хэтрүүлэн үнэлэх явдал бат бөх оршсоор байна. Төр засгийн ийм үнэлэмжийн дагуу аймаг, нийслэлийн ИТХ-ын ажлын албаны орон тоо, бүтэц сүрхий нэмэгдсэн. Нөгөө талаар ИТХ-ын Төлөөлөгчдийн оролцоо, иргэд иргэд сонгогчийнхоо төлөө зүтгэсэн цаг, хүчийг үнэлэх, аппаратын хүчээр биш, сонгуульт хүмүүсийн идэвхтэй бүтээлч ажиллагааг урамшуулах асуудлыг дорвитой шийдвэрлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн хоёр дох заалтыг шат шатны хуралд нь эрхийг өгөх, төсөв зардлыг нь бий болгоход анхаарах цаг ирсэн байна.

Орон нутгийн хүн ам өөрсдийнхээ амьдралын асуудлыг өөрсдөө шийдвэрлэж, эрх ашгаа өөрсдөө хамгаалж, нутаг дэвсгэрээ өөрийгээ тэтгэх аж ахуй, нийгмийн цогцолбор

болгон авч явах эрх мэдэл, боломжийг тэдэнд бодит байдал дээр олгохгүй байна. Төв засаг нь улсын хэмжээний асуудлаа, нутгийн засаг нь нэгжийнхээ асуудлыг шийдвэрлэдэг, хариуцдаг байх нь эл нийгмийг цэгцтэй болгохын үндэс билээ. Орон нутаг тус бүрийн эдийн засаг, санхүүгийн бодитой үндэс, бааз суурь бүрдээгүй байна. Энэ тухайд дараах асуудал манайд үгүйлэгдэж байна.

Цаашид хэрхвэл зохилтой вэ. Нутгийн өөрөө удирдах ёсны гол асуудал болох эдийн засаг, санхүү, төсвийн эрх мэдлийг орон нутагт жинхэнэ ёсоор олгох эх үндэс нь Монгол Улсын төрийн байгууламжийг бүрдүүлж байгаа *засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зөв, зүй зохистой хуваарийг бий болгох явдал мөн*. Цаашид барих гол чиглэл бол засаг захиргааны анхан шатны байгууллагыг хүн амд аль болохоор ойртуулах, нэгжүүдийн бие дааж хөгжих байгаль, эдийн засаг, нийгмийн нөхцөл бололцоог өргөтгөх агаад аппаратыг багасган хэмнэх, чадваржуулах, нэгжийг томруулж жигдрүүлэх явдал билээ. Өдгөө хуучин тогтолцооны нутаг дэвсгэрийн хуваарийн зохион байгуулалтын дутагдлыг арилгах асуудал ерөөс хөндөгдөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан завсрын тогтолцоо болох аймаг сум нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн цогцолбор болох заалтыг хэрэгжүүлэхэд нутаг дэвсгэрийн өнөөгийн хуучин хуваарь саад болж байна. Нутаг дэвсгэрийн нэгжийн хил хязгаарыг өөрийгээ тэтгэж авч явах боломж бүхий эдийн засагтай байх шаардлагын хэмжээнд тогтоох, тухайн нутаг дэвсгэр дэх эдэлбэр газрыг сумын хурлуудад хуваарилан эзэмшүүлэх шаардлага бодитойгоор гарч байна.

Өдгөө өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулах материаллаг нөхцөл болох эдийн засгийн үндсийг бүрдүүлэх ажил үнэн чанартаа хуулийн тунхаглалаас хэтрээгүй байгаа юм. Тухайлбал бүх шатны хурал эдийн засгийн хувьд нэгэн ижил суурьтай байна гэж хэлж болно. Өөр өөрийн ялгаж эзэмшсэн, тус тусдаа өмчилсөн, түүнээ өөрөө мэдэж өсгөж үржүүлдэг, орлогыг нь хүртэж нийтийн тусын тулд зарцуулдаг, үржүүлэн өсгөдөг

эдийн засгийн суурьгүйгээр өөрөө удирдах ёсны байгууллагын нутаг дэвсгэртээ бие даах нөхцлийг хангаж чадахгүй юм. Энэ үүднээс Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг төсөвтэй харилцах байдлаар нь аймаг, сумын хуралд хуваарилан хариуцуулах, төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага, байгалийн баялаг зэргийг тэдэнд хуулиар хуваарилж өгөх замаар орон нутгийн өмчийг төлөвшүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. Энэхүү арга хэмжээг Монголын нийгмийн удирдлагыг шат шатанд нь зааглаж, засаглалын хомсдолыг арилган, хариуцлагыг тодорхой болгоход чиглүүлмээр байна.

Өөрөө удирдах байгууллагын бие дааж ажиллах, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд чухал үндэс нь түүний санхүүгийн бааз юм. Энэ бол өнөө үед үнэхээр бэрхшээлтэй, түвэгтэй, ургашаа ахихгүй байгаа асуудал болой. Эдийн засаг унаж, үйлдвэрлэлийн хэмжээ буурч, мөнгө төгрөгийн ханш доошилж, төсвийн алдагдал ихсэж, өрийн хэмжээ нэмэгдсэн, түүнийг төлж эхлэх хугацаа хаяанд ирсэн өдгөө ярихад ч бэрхшээлтэй боловч энэ тухайд зарчмын шийд гаргаж, шинэ үзэл санааг нэвтрүүлэн алсдаа суурь ирээдүй болох чиглэлээр ажиллаж эхлэх хэрэгтэй байна. Төсвийн хуульд шинэлэг санаанууд байгаа ч нарийвчилсан механизм тогтоогоогүйгээс өдгөө Хурал нутаг дэвсгэрийнхээ төсвийг жинхэнэ эзэн шиг мэдэж, бие даан төлөвлөн хянаж, зарцуулах бодит эрхгүй байна. Бодит байдал дээр Хурал төсвийнхээ орлогыг бүрдүүлэх эх үүсвэрийг олох нь бололцоо муутай, хүнд хэцүү байна. Үүнийг нотлоход ямарч судалгаа шинжилгээ хэрэггүй билээ.

Өөрөө удирдах ёсны хууль, эрх зүйн баазыг өвч бүрдүүлэхэд хууль тогтоох дээд байгууллага онцгой анхаарах учиртай цаг үед бид амьдарч байна. Юуны өмнө төв, орон нутгийн хийгээд өөрөө удирдах бүх шатны байгууллага хооронд эрх хэмжээг улам тодорхой зааглах, тэгэхдээ уялдуулах, шийдвэрлэх асуудлынх нь төрөл зүйл, төвшинг зөв зохистой байдлаар тогтоох хэрэгтэй байна.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг суурь

үндэс болгон одоогийн хүрсэн шинэ нөхцөлд тэдгээрийн бие даах эрх мэдлийг жинхэнэ нэмэгдүүлэхийн тулд *аймгийн тухай хууль, сумын тухай хууль, нийслэлийн тухай хууль, дүүргийн тухай хуулийг* тус тусад нь боловсруулан баталж мөрдөх хэрэгтэй байна. Эдгээр хуульд нэгж бүрийн статус, онцлог, эрхэм зорилго, чиг үүрэг, сум болон аймгийн нийтийн эрх зүйн субъект болох шалгуур, шинж, дүрмийн агуулга, аймаг, сумыг байгуулах, татан буулгах үндэслэл журам, сум, аймгийн нутаг дэвсгэрийн хилийг хэрхэн тогтоох, өөрчлөх үндэслэл журам, үйлдвэрлэл, мал аж ахуй эрхлэх, байгалийн баялаг ашиглах зэрэг байгаль, эдийн засгийн нөхцөл, зам харилцаа, дэд бүтэц, хүн амын бүрэлдэхүүн, аюулгүй амьдрах нөхцөл, сум, аймгийн эдийн засгийн үндэс, өмч, санхүүгийн бааз, төсөв, нөөц баялаг ашиглах эрх, удирдлагаа сонгон байгуулах, томилох журам, тэдгээрийн эрх зүйн байдал, зохион байгуулалт, өөрөө удирдах ёсны эрхийг хангах баталгаа зэргийг нгарийвчлан оруулах учиртай. Хууль тогтоохдоо орон нутаг өөрийн онцлогт тохирсон шийдвэр гаргах орон зайг үлдээж хуульчлах, хуульд тусгайлан заах шаардлагагүй асуудлыг нэгжийн дотоод дүрэм журмаар зохицуулахыг бататгах хэрэгтэй юм.

Аймгийн хуулийг сумын хуулиас тусад нь гаргахын учир нь аймаг бол завсарын нэгж, сум бол амьдрал буцалж байдаг жинхэнэ хамт олны өөрийн удирдлагын нэгж, өөрөө удирдах ёсны гол цөм учир хүн амд үзүүлэх үйлчилгээ тэнд төвлөрөхөөр, харин аймгийн удирдлага хүн амд бус сумдад үйлчлэх чиглэлтэй байх учиртай. Бас жижиг 2-3 аймгийг нэгтгэн томруулж болно. Аймгийн өнөөгийн чиг үүргээс нь суманд шилжүүлж болно. Аймгийн хуульд хуулийн биелэлтийг хангаж шалгах, засаг захиргааны ажилд хяналт тавих, их урлаг, нарийн мэргэжлийн эмнэлэг, коллежийн сургалт, сумдыг дагнасан бизнесийг хөгжүүлэх, төрийн өмчийн төлөөллийн болон аюулгүй байдал, цэрэг, иргэний хамгаалалт, хууль зүйн зэрэг сумаас дээхнүүр мэргэжлийн үйлчилгээгээр хангах цөөн чиг үүргийг өгч болох билээ.

Монголын Нутгийн Удирдлагын Холбооны Мөрийн хөтөлбөр болох Тунхаг бичигт нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын бүрэн эрхийг хангах асуудлыг нэлээд үндэслэлтэй тусгасан байна. Эдгээрийг нэг бүрчлэн хуульчлах хэрэгтэй билээ.

Эдийн засаг, санхүү, төсвийн талаарх орон нутгийн эрхийг нэмэгдүүлэх тухайд. Нутгийн өмчийн тухай хуулийг тусад нь гаргах шаардлага гарч байна. Орон нутгийн өмчийг хуульд хавсарга байдалтай оруулж дурьдах төдийхэн хуулиар зохицуулахыг оролдох нь өөрсдийгээ хуурч суугаа хэрэг гэхээс өөрөөр үзэх үндэсгүй. Нутгийн өмчийн эд хөрөнгийг олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, өмчлөх эрхээ хамгаалуулах зэрэг асуудал төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй тусгагдсан байгаа юм. Энэ хуульд өмчийн нийтийн болон өөрийн эд хөрөнгийн ангилал хийх, ИТХ, түүний Тэргүүлэгчид, Засаг даргын эрх үүргийн зааг ялгааг тодорхой тусгах, сумын хамт олны бүрэн эрх юу болохыг тодорхойлох, нутгийн өмчийн болон түүний оролцоотой аж ахуйн нэгжийн статус, хэлбэр болон холбогдох заалтыг хамруулан хуульчлах шаардлагатай юм. Энэ хуульд бас дараах асуудлыг тусгамаар байгаа юм. Орон нутагт өдгөө ахуйн үйлчилгээ ихээр үгүйлэгдэж байна. Энэ орон зайг нөхөхийн тулд холимог болон хэсгээр өмчлөх дундын өмчийн аж ахуйн нэгж бий болгож ажиллуулах эрхийг орон нутгийн хуралд олгох, нутгийн өмчид эд хөрөнгө олж авахад тохиолддог элдэв хаалт хязгаарлалтыг аль болохоор багасгах, чөлөөтэй ажиллах боломж олгох, онцгой тохиолдлоос бусад янз бүрийн зөвшөөрөл лиценз ологодог байдлыг цөөлөх, газар, газрын хэвлийн баялаг, ой мод, усны сан зэрэг төрийн өмчийн объектыг орон нутгийн эрх ашгийн үүднээс аймаг, сум хэрхэн эзэмших, ашиглах үндэслэл журмыг төрийн удирдлага, өөрөө удирдах ёсны харьцаанд тодорхой болгох, либеральчлан аль болохоор чөлөөтэй байлгах, нутгийн өмчийн эд хөрөнгийг бий болгох, хувьд шилжүүлэх, эргүүлэн авах, захиран зарцуулах, үнэлэх, бүртгэх, данслах, хамгаалах талаар ИТХ, Засаг даргын эрхийг тодорхой зааглах, төлөөлөх журмыг тогтоох, сумдын хүн амын үйлчилгээнд зориулсан бүх объектыг сумын өмчлөлд шууд шилжүүлж, хяналтын зөв зүйтэй тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг нутгийн өмчийн хуульд тусган оруулмаар байна.

Орон нутгийн төсвийн эрхийг хангах болон орон нутгийн санхүүгийн тухайд тусгай хуулиуд бас хэрэгтэй байна. Ингэхгүйгээр одоогийн байдлаар байвал эрх нь хангагдахгүй гэдгийг бид харлаа. Бүр багц хууль боловсруулан хэрэгжүүлж

өнөөгийн хэт төвлөрлийг шууд арилгах нь чухал. Сумын төсвийг юуны өмнө өөрийн үндсэн орлогын хүрэлцэхүйц тогтвортой эх үүсвэртэй болгох, түүнээ өсгөн нэмэгдүүлэхэд санаачлагатай ажиллах эрхийг олгож, тэгж ажиллах боломжоор хангах учиртай. Аймаг, сум нь тус тусдаа орлогыг дахин хуваарилах баталгаагаар хангагдах ёстой. Бас татаас, тусламж, зээл авах, зээллэгийн облигац гаргах эрхтэй байх, эх үүсвэрийг нь хэнээс ч хамаарахгүй эзэмших, ашиглах эрх олгох, энэ бүхний үндэслэл журмыг хуулиар тогтоож өгөх хэрэгтэй. Энд олон хууль хэрэгтэй, тус бүрдээ хуультай байх шаардлагатай асуудал юм.

Бас орон нутагт татвар, хураамжийн эрх олгох, сан хөмрөг бүрдүүлэх, валютын эрх олгох, тэдгээрийн зарцуулалтын дэглэмийг хуулиар тогтоож хэрэгжүүлэх шаардлагатай болжээ. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 8 дахь заалтаар сумын татварын орлогын эх үүсвэрийг тогтоосон боловч бас л оромдож хэлбэрдсэн, орлого нь бараг орох, үгүй нь тодорхойгүй хэдэн зүйл заасан нь сумдын ИТХ-ын санхүүгийн чадамжийг сулруулсан хэвээр байна. Харин сумын хөгжлийн сангийн талаарх хуулийн заалт хэрэгтэй байгааг үгүйсгэх учиргүй юм. Энэ мэтчилэн Төсвийн хуулийн талаар дорвитой өөрчлөлт хийхгүй бол болохгүй болж. Сумын ажилчин албан хаагчдын орлогын албан татвар сумдаа үлддэг байсныг аймагт төвлөрүүлсэн зэрэг дутагдлыг хэлж болно.

Өдгөө бараг бүх сумдын төсөв дахин хуваарилалтын татаастай байна. Энэхүү дахин хуваарилалтын орлогыг төвлөрсөн төсвөөр дамжуулахгүйгээр сумын төсөвт шууд өгдөг болгох, дахин хуваарилалтын татаасыг болж өгвөл хурлын бүрэн эрхийн хугацаагаар сум бүрт тогтоон олговол жинхэнэ бие даах боломж бүрдэх билээ. Одоо ихэнх сумын төсвийн орлогын хэдхэн хувийг /дундажаар 15/ өөрийн орлого эзэлж байна. Сум бүрийн төсвийн орлогын дийлэнх олонх хэсэг /75-аас дээш хувь/ өөрийн үндсэн орлого болон дахин хуваарилалтын орлогоос бүрдвэл сум сая бие дааж байна гэж хэлэх үндэс бүрдэх бөлгөө. Энэ бүхнийг хуулиар зохицуулах хэрэгтэй болно.

Орон нутагт тухайлбал, аймгууд өөрсдийн арилжааны банкуудыг үүсгэн ажиллуулбал нэн тустайсан. Ийм банк зөвхөн аймгийн хэмжээний байна. Аймаг, сумын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг шуурхай болгох, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангахад тустай байх болно. Энэ нөхцөлд төсвийн үйл явцын эрх хангагдах бололцоо бас бий болно. Сумын ИТХ төсвөө боловсруулах, батлах, орлогоо төлөвлөх, олох, зарлагаа нэг бүрчлэн хуваарилах, санхүүжүүлэхэд дээд байгууллагын оролцоо багасч хязгаарлагдах болно. Харин дээр өгүүлсэн дахин хуваарилалтын орлого тодорхой болсон байх нь чухал.

Газар, газрын хэвлий дэх баялгийг ашиглах тухайд өөрчилмөөр зүйл нэлээд байгаа юм. Газар зөвхөн улсын өмч гэх хийсвэр ойлголтыг бага ч гэсэн бодитой болгомгоор байна. Энэ нь орон нутгийн бие дааж хөгжихөд ихээхэн хамааралтай асуудал билээ. Яагаад тэр билээ гэж асуух биз. *Газар бол үл хөдлөх хөрөнгө талаасаа эдийн засаг өмчийн харилцаа, хүрээлэн буй орчин талаасаа байгаль экологийн харилцаа, нутаг дэвсгэрийн талаасаа улс, аймаг /нийслэл, дүүрэг/, сум, багийн холбогдох эрх зүйн харилцаа билээ.* Ингэхлээр, газрын асуудал бол эдийн засаг өмчийн, байгаль экологийн, улс төр эрх зүйн харилцааг хамарсан нарийн ойлголт. Энэ харилцаанд аймаг, сум ямар эрх үүрэгтэй байх, ямар орлого олох асуудал үүснэ. Монгол Улсын бүх газар нь нутаг дэвсгэрийн хувьд улс, нийслэл, аймаг, дүүрэг, сумын хил хязгаартай учир түүнийг бас хэрхэн ашиглах, орлогоо хэрхэн хуваарилах нь тодорхой хязгаартай байх учиртай. Юуны өмнө бүх эдэлбэр газраа улсын, аймгийн, сумын хэмээн ангилж, эзэмших, хамгаалах тогтолцоог тодорхой болгох хэрэгтэй. Эдэлбэр газрыг түрээсэлдэг журамд шилжих хэрэгтэй. Энэ нь газрыг бизнесийн эргэлтэд оруулах санаа юм. Одоогийнх шиг газрыг лиценз гэх хээл хахуулийн өдөөгүүр болгож болохгүй. Сумын ИТХ-ыг өөрийн нутгийн газраа хуваарилах, эзэмшүүлэх, аж ахуйн эргэлтэд оруулах, хөрсөө хамгаалах, цөлжилтийн эсрэг тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх, нөхөн сэргээх асуудлыг жил бүр хэлэлцэж хөтөлбөржүүлдэг, балансжуулдаг, нөхөн сэргээдэг, ойжуулдаг, хамгаалдаг болгох нь тулгамдаж байна. Тухайлбал, хөдөөгийн сумдын малчид өвөлжөө, хаваржаа,

намаржаа, зуслангийн газраа түрээслэх, тэрч бүү хэл худалдах замаар хуулийн зохицуулалтаас өмнө зохих харилцааг үүсгэх болжээ. Газар нутаг эзэнтэй мөртлөө эзгүй юм шиг орхигдож, хөрс муудаж цөлжиж байгаа нь аймшгийг дагуулж байна.

Газрын хэвлий түүний доорх баялаг гагцхүү төрийн өмч гэдгийг газраас нь ялгамжтай авч үзэн газрыг орон нутагт эзэмших, ашиглах эрх олгох, зөвшөөрөл, төлбөрийн талаас нь тухайн орон нутаг аймаг, суманд нь орлого оруулахыг тооцоолсон хууль журам хэрэгжүүлэх шаардлага урган гарч байгаа юм.

Эцэст нь тэмдэглэхэд Монголын Нутгийн Удирдлагын Холбооны Тунхаг бичигт дээрх асуудалд ихээхэн чухал санаа бүхий зүйлийг зааж оруулсан байна. Тухайлбал, 2 дугаар зүйл, 9-д нутаг дэвсгэрийн нэгж бүрт газар, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, цэвэр ус, цахилгаан эрчим хүч, дулааны болон бохир усны шугам сүлжээ гэх мэт тоноглол, үйлдвэрлэлийн хэрэгслийн өмчтэй болгох, өмч хөрөнгийг шинээр бий болгох, төсвийн орлогын тодорхой эх булагтай болгох, улмаар төсвөө төлөвлөх, бүрдүүлэх, захиран зарцуулах бүрэн эрх эдлүүлэхийг гол зорилт болгон тавьжээ. Бас тэр Тунхаг бичгийн нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв, санхүүгийн бие даасан байдлыг хангах дэд бүлэгт өнөөгийн тулгамдаад байгаа асуудлыг тоочин оруулсан байна. Энэ бүхнийг хуульчилж өгвөл орон нутгийн эдийн засаг, санхүү, төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд чухал алхам болох билээ.

Ж.ЯДАМСҮРЭНГИЙН БИЕ ДААСАН ЗАРИМ БҮТЭЭЛЭЭС

1. БНМАУ дахь үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх нийгмийн өмчийн үүсэл хөгжлийн зарим асуудал – УБ., УХГ, 1985, 184 хууд;
2. Зах зээл судлал. Их, дээд сургуульд үзэх сурах бичиг. /Н.Бүрэнтэй хамтран/ – УБ., УХГ, 1986, 206 хууд;
3. БНМАУ-ын хөгжлийн улс төрийн эдийн засгийн ухааны зарим асуудал. /У.Камбартай хамтран/ – УБ., УХГ, 1987, 174 хууд;
4. Социалист үйлдвэрлэлийн харилцаа, түүнийг төгөлдөржүүлэх зарим асуудал – УБ., УХГ, 1988, 234 хууд;

5. Эдийн засгийн хуулиуд – УБ., УХГ, 1990, 145 хууд;
6. Монгол Улсын үнэт цаасны зах зээл – УБ., T&U printing, 1998, 212 хууд;
7. Үнэт цаасны зах зээлийн нэр томъёоны толь, товч тайлбар. /Б.Дашцэрэнтэй хамтран/ – УБ., T&U printing, 1999, 131 хууд;
8. Үнэт цаасны хөгжингүй зах зээл: үүсэл, хөгжил, дэд бүтэц, хандлага, туршлага – УБ., T&U printing, 1999, 248 хууд;
9. Үнэт цаас: мөн чанар, үндсэн шинж, чиг үүрэг, төрөл, үнэ, орлого - УБ., T&U printing, 2000, 140 хууд;
10. Үнэт цаасны зах зээл: онол, практик – УБ., T&U printing, 2001, 268 хууд;
11. Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт – УБ., Admon, 2003, 126 хууд;
12. Сонгуулийн тухай зарим ойлголт, товч тайлбар - УБ., Жиком пресс, 2008, 210 хууд;
13. Капиталист биш хөгжлийн замын тухай онол, Монголд судлагдсан байдал. Ред. Б.Даш-Ёндон – УБ., Selengepress, 2012, 86 хууд.
14. Эдийн засгийн онолын түүхийн шим шүүсийн тойм. /Б.Даш-Ёндонтой хамтран/ - УБ., “Экимто”, 2014, 154 хууд.



ХАРАНУД АЮУРЗАНА ЦАНЖИД

Цахилгааны инженер мэргэжилтэй, Түүхийн ухааны дэд доктор зэрэг хамгаалсан. Профессор цолтой.

ОРОН НУТГИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ, ТҮҮНИЙ ШАЛГУУР

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээ, төв орон нутгийн харилцааны эрхзүйн зохицуулалт нь судлаачид болон төрийн бодлоготон, ажилтны анхаарлыг татсан асуудал билээ. Дурдсан асуудалтай холбогдох, түүнийг шийдэхэд нөлөө бүхий өөр нэг асуудал бол орон нутгийн бие даасан байдал юм. Энд орон нутгийн бие даасан байдал хэмээх ойлголтыг бид улстөрийн эрх мэдэл талаас нь бус гол нь менежментийн талаас нь авч үзэж байна. Орон нутгийн бие даасан байдлын талаар ул үндэстэй авч үзэхийн тулд нэгд, тухайн ойлголтыг тодорхойлох, хоёрт, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тогтоох хэрэгтэй. Эл хоёр зорилтыг шийдвэрлэхийн тулд юуны өмнө уг асуудлыг судласан хүмүүсийн санал, үзэл бодлыг мөшгин үзэх нь зүйтэй.

Манай оронд хэдийгээр орон нутгийн бие даасан байдал, төвлөрлийг сааруулах гэх мэт асуудлын талаар их ярьдаг боловч чухамдаа орон нутгийн бие даасан байдал гэж юу вэ гэдгийг, түүний дотор нэгдмэл байгууламжтай улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие даасан байдал гэж юу вэ гэдэг талаар онолын шинжтэй тодорхойлолт гаргах оролдлого хийсэнгүй өдий хүрчээ. Тиймээс бид арга зүйн хувьд ач холбогдолтой гэж үзэн гадаадын судлаачдын бүтээлийг шүүрдэн үзэхэд хүрч байгаа юм. Тэгэхдээ тэд орон нутгийн бие даасан байдал гэдгийг шатлалын чухам аль төвшинд авч үзэж байгааг анхаарах нь зүйн хэрэг. Хэрвээ шатлалын доод төвшинд авч үзэж байгаа бол ийм эрэгцүүлэл холбооны улсын тухайд ч, нэгдмэл улсын тухайд ч адилхан ач холбогдолтой юм. Харин холбооны улсын муж улс-төв засгийн газрын хоорондын харилцааны тухайд авч үзэж байгаа бол түүнд болгоомжтой хандах ёстой.

Орон нутгийн бие даасан байдлын талаарх судалгаанд анхны /орчин үед/ чухал санааг дэвшүүлсэн хүн бол Чарльз Тиебот гэж үздэг боловч түүний үзэл санааг орон нутгийн бие даасан байдлыг тодорхойлох бус уг байдлыг буй болгох чадавхийг бүрдүүлэх арга зам юмуу бодлоготой холбоотой гэж үзвэл оновчтой юм. Тэрбээр орон нутаг нь оршин суугчдад тодорхой хэмжээний үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ тэднээс татвар авдаг. Оршин суугчид үзүүлж буй үйлчилгээний чанар, хэмжээ болон татварын их багаас хамааран орон нутгийн нэгжийн хооронд шилжин суурьшина гэж үзсэн байна. Ингэснээр нэгжүүдийн хооронд оршин суугчдын төлөөх тодорхой хэмжээний өрсөлдөөн гарах аж. Нэлээд сонирхол татах санал дэвшүүлсэн хүн бол Гордон Кларк юм. Кларк орон нутгийн засаг захиргаа бол тодорхой зорилго бүхий, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эрх мэдлээ өсгөх эрмэлзэлтэй рационал тоглогчид мөн гэж үзээд түүнийг тодорхойлогч зарчим /шинж- А.Ц./ бол нэгд, асуудлыг өөрийн сонирхолд нийцүүлэн зохицуулах, хуульчлахтай холбоотой санаачлах эрх (power of initiation), хоёрт, дээрээс даралт шахалт ирнэ гэж айхгүйгээр ажиллахтай холбоотой дархлаатай байх эрх(power of immunity) гэсэн хоёр эрхээр тодорхойлогдоно гэж үзжээ¹.

1 Gordon L. Clark. A Theory of Local Autonomy. Article published online: 23 FEB 2005 DOI: 10.1111/j.1467-8306.1984.tb01448.x

<Хүснэгт 1> Орон нутгийн бие даасан байдлын үндсэн шинжүүд

		Санаачлах эрх	
		бий	үгүй
Дархлааны эрх	бий	Хэв маяг 1	Хэв маяг 2
		“Бие даасан хот-улс”	Төвлөрөлгүй либерализм
		Эртний Венец, Флоренц	Тиеботын загвар дах өрсөлдөгч нэгжүүд
	үгүй	Хэв маяг 3	Хэв маяг 4
		Миллийн загвар	Хүнд сурталт аппарат
		АНУ –гийн муж улс ба төв засгийн газар хоорондын эсрэгцэл	Хуучин ЗХУ-ын орон нутгийн зөвлөл ба АНУ-ын муж улс төв засгийн газар хоорондын эсрэгцэл

Тед Роберт Гюрр, Десмонд Кинг нар хоёр хэв маяг бүхий загварыг санал болгосон байна.

Хэв маяг 1: Орон нутгийн засаг захиргаа эдийн засаг, нийгмийн нөхцлөөр хязгаарлагдахгүйгээр зорилгоо хэрэгжүүлж үйл ажиллагаа явуулах боломжтой (эрхтэй) байх. Ийм боломжийг хязгаарладаг эдийн засаг, нийгмийн хүчин зүйл гэвэл:

- Орон нутгийн засаг захиргааны орлого олох боломжийн хязгаар
- Орон нутгийн засаг захиргааны эрх, зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогыг нь гуйвуулах, саармагжуулах нөлөө бүхий орон нутгийн эдийн засгийн зохион байгуулалт бүхий сонирхол
- Орон нутгийн бодлогын агуулга болон хэрэгжүүлэлтэд нөлөөлдөг улстөрийн байгууллага, нийгмийн хөдөлгөөнүүд

Хэв маяг 2: Төв засгийн газраас айхтар оролцоно гэж болгоомжлохгүйгээр сонирхлоо хэрэгжүүлэх хэмжээ. Ийм оролцооны жишээ нь:

- Дээд шатны байгууллагаас илт хяналт тавьж оролцох
- Орон нутгийн шийдвэрийг шүүмжлэх
- Улсын хэмжээний улстөрийн байгууллагаас орон нутгийн

засаг захиргаанд дарамт шахалт үзүүлэх

- Дээрээс грант олгохдоо нөхцөл заах, янз бүрийн чиглэл өгөх гэх мэт болон бусад зүйлс орох ажээ.

Орон нутаг нэгдэх хэв маягтай байгаа тохиолдолд бие даасан байдалтай байх ба бие даах боломжийг хязгаарладаг хүчин зүйлсийн нөлөө ихсэх, жишээ нь орлого олох боломж муудвал орон нутаг дээд шатны байгууллагуудад хандах хэрэгтэй болно. Ийм нөхцөлд хэв маягийн хувьд нэгдэх хэв маягаас хоёр дахид шилжин өөрчлөгдөх ажээ.

Хал Уолман нар өөрсдөө орон нутгийн бие даасан байдлыг хэмжих арга зүй, аргачлалыг боловсруулан АНУ-ын муж улсууд дээр судалгаа хийж тэдгээрийг бие даасан байдлын үзүүлэлтээр нь жагсаасан байна. Тэд судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа юуны өмнө орон нутгийн төрийн байгууллагын бие даасан байдал хэмээх ойлголтыг үзэл баримтлалын төвшинд тодорхойлж, түүндээ тулгуурлан үзүүлэлтүүдийг гаргасан байна. Орон нутгийн бие даасан байдал гэдэг бол “орон нутгийн төрийн байгууллага эдийн засаг болон төрийн байгууллагын төвшин хоорондын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг, мөн тэд төрийн дээшээх төвшнөөс саад хязгаарлалтгүйгээр юу хийхээ тодорхойлох боломж, чадвартай байдаг орон нутгийн төрийн байгууллагуудын систем юм”. Хэрвээ энэхүү тодорхойлолтыг орон нутгийн бие даасан байдал гэдэг ойлголтыг ямар нэг хэмжээгээр илэрхийлж байгаа гэж үзвэл түүнд тулгуурлан дараах үзүүлэлтийг гаргаж болж байгаа аж.

1. Орон нутгийн төрийн (байгууллага байхын) ач холбогдол. Энэ үзүүлэлт нь орон нутгийн төр байхгүй бол орон нутгийн эдийн засагт ямар нөлөөтэй байх вэ, төрийн удирдлагын төвшин хоорондын харилцаанд ямар нөлөөтэй байх вэ гэдэг асуудлыг багтааж байгаа юм. Төв засгийн газар орон нутагтай холбоотой байж мэдээлэл авах, зорилгоо хэрэгжүүлэх бололцоо ямар байх вэ? Өөрөөр хэлбэл энэ нь манайх шиг нэгдмэл улсын хувьд төрийн удирдлагын ардчилал, үр нөлөөний тухай асуудал болж хувирна гэж болох юм.

2. Орон нутгийн төрийн шийдвэр гаргах боломжийн хязгаар. (discretion) Энэ нь орон нутгийн төрийн байгууллага

дээрээс тавьсан хязгаарлалт, даралт шахалтад өртөхгүйгээр шаардлагатай гэж үзсэн үйл ажиллагаагаа явуулах, шийдвэр гаргах боломж юм.

3. Орон нутгийн төрийн байгууллагын чадавх. Дээрх хоёр үзүүлэлт хангагдаж байлаа ч гэсэн орон нутгийн чадавх дутагдаж болно. Энэхүү чадавх нь нөөц, мэргэжлийн төвшин, менежментийн чадавх гэх мэт олон талтай.

Эдгээр гурван үзүүлэлтийн эхнийх нь яах аргагүй орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой үзүүлэлт юм. Эдгээр судлаачид орон нутгийн засаг захиргаа байснаар бодитой үр дүн гаргаж оршин суугчдын аж амьдралд тус болж чадаж байна уу гэдгийг чухал шалгуур гэж үзсэн байгаа юм.

Уолман нар эдгээр гурван ерөнхий үзүүлэлтийг хэмжиж болохуйц дэд үзүүлэлт, шалгуур болгон хувиргаж хэмжилт хийсэн байна.

Орон нутгийн бие даасан байдал гэдгийг дээр дурдсан шиг үйл ажиллагааны шинж байдал маягаар тодорхойлсон байх нь элбэг. Хамгийн ерөнхий байдлаар авч үзвэл энэ нь төв засгийн газрын илэрхийлж, хэрэгжүүлж байдаг бүх нийтийн сонирхол болон тухайн тодорхой орон нутгийн нийтлэгийн өвөрмөц сонирхолын харьцааны тухай асуудал юм. Бүх нийтийн сонирхолын хэрэгжилт нь орон нутгийн хэрэгцээ, сонирхлыг тэр бүр бүрэн дүүрэн хэрэгжүүлдэггүй. Зарим тохиолдолд зөрчилтэй байх нь ч элбэг байдаг.

Европын Холбооноос Орон нутгийн өөрөө удирдах ёсны Харти хэмээх баримт бичигтээ нутгийн өөрөө удирдах ёс гэдэг ойлголтыг тодорхойлсон байна. “Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь орон нутгийн олон түмэн хуулийн хүрээнд өөрийн хариуцлагад тулгуурлан нийтийн асуудлуудын дийлэнх хэсгийг оршин суугчдын сонирхолд нийцүүлэн удирдах, шийдвэрлэх эрх болон чадвар мөн” ажээ. Энэхүү тодорхойлолтыг үндсэндээ орон нутгийн бие даасан байдал хэмээх ойлголтын тодорхойлолт гэж үзэж бас болох юм.

Бид дээр дурдсан судалгаануудад болон бодрол эрэгцүүлэлдээ тулгуурлан орон нутгийн бие даасан байдал

хэмээх ойлголтын талаар ажлын тодорхойлолт гаргаж, түүнд суурилан шалгуур үзүүлэлтийг тогтоох оролдлого хийж байна.

СУДАЛГААНД АШИГЛАХ ТОДОРХОЙЛОЛТ

Орон нутгийн бие даасан байдал нь орон нутгийн засаг захиргаа нь дээд шатны байгууллагуудаас дарамт шахалтгүйгээр өөрийн эрх зүйн байдалд нийцүүлэн орон нутгийн оршин суугчдын сонирхлыг хангахад чиглэсэн үр нөлөө бүхий үйл ажиллагааг чөлөөтэй явуулж, хариуцлага хүлээх эрх болон чадвар мөн.

Иймээс орон нутгийн бие даасан байдлын шалгуурыг тогтоохдоо:

*Нэгд, эрх зүйн байдал нь ямар байгааг,
хоёрт, түүний хүрээнд үйл ажиллагаагаа чөлөөтэй
явуулах эрх бүрдсэн эсэхийг,
гуравт, чадавхийг /эдийн засаг -санхүү, менежментийн
г.м./
дөрөвт, хариуцлагын асуудлыг авч үзэх нь зүйтэй юм.*

Манай судлаачдын дотроос Б.Чимид засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүрдүүлбэр хэмээх ойлголтыг гаргаж таван гол зүйлээр тодорхойлсон байна. Үүнд нутаг дэвсгэрийн үндэс, хүн ам, нийгэмшлийн үндэс, эдийн засгийн үндэс, засаг захиргаа, удирдлага, эрх зүйн үндэс зэргийг оруулсан байна. Эдгээр нь чухамдаа бүрдүүлбэр гэдэг утгатаа зохицож байгаа бөгөөд хүмүүсийн аль нэг нийтлэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон төлөвшихөд эдгээр бүрдүүлбэр зайлшгүй юм. Гэвч эдгээр нь орон нутгийн бие даасан байдлын шалгуур хараахан биш. Ийм бүрдүүлбэрүүд бүрэн байгаа боловч орон нутгийн нэгжийн бие даасан байдал хангалтгүй байж болно.

Бидэнтэй адил нэгдмэл байгууламж бүхий улсын судлаачдын бүтээлийг судалж үзвэл ижилдүү хандлагатай байна. Унгар, Румыны судлаачид юуны өмнө санхүүгийн бие даасан байдалд гол анхаарлаа хандуулж байгаа юм. Тэд санхүүгийн бие даасан байдалд гол нь анхаарч, түүнээс ургуулан эрх зүйн асуудлыг зохицуулж болно гэж гол төлөв үзэж байна. Жнь: Румыны Петронела Захариа:

$$G_{al} = \frac{V_p}{V_t}$$

G_{al} – орон нутгийн санхүүгийн бие даасан байдлын төвшин

V_p – орон нутгийн нийт өөрийн орлого

V_t - орон нутгийн нийт орлого

Энэ томъёогоор бодож үзэхэд тус улсын 7 сумын санхүүгийн бие даасан байдал 25,63 – 40,54 байжээ².

Елена Чигу, Флорин Опра нар дээрх хандлагыг бүр дэлгэрүүлэн арван шалгуур үзүүлэлт (v) санал болгосонг бид арга зүйн хувьд ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

V1 – орон нутгийн төсвийн нийт орлогод өөрийн орлогын эзлэх хувь

V2 – орон нутгийн төсвийн нийт орлогод төрийн төсвөөс олгож буй шилжүүлгийн эзлэх хувь

V3 – төрийн төсөв болон улсын чанартай бусад төсвөөс орон нутгийн төсөвт олгож байгаа шилжүүлгийн хэв маяг (нөхцөл заасан эсэх)

V4 – Орон нутгийн байгууллагын санхүүгийн хараат байдал /Хантерийн коэффициентийг ашиглан 1–шилжүүлэг/ орон нутгийн төсвийн зарлага гэсэн томъёогоор бодно/

V5 – орон нутгийн засаг захиргааны орон нутгийн татвар тогтоох эрх

V6 – орон нутгийн засаг захиргааны татварын орлого цуглуулах эрх

V7 – орон нутгийн засаг захиргааны зээл авах эрх

V8 – нийт эрх мэдэлд зөвхөн орон нутагт олгосон эрх мэдлийн эзлэх хувь

V9 – орон нутгийн төсвийн үйл явцад мэдэх, хянах тавих эрх

² Petronela Zaharia. Public Administration and Local Autonomy – Public Management Theory Approaches. Petroleum-Gas University of Ploiesti Bulletin, Economic series. Vol. LX111 No 4/2011, p.120-123

V10 – төсвийн үйл явцад иргэдийн оролцоо

Судлаачид нэгд, шалгуур бүрт жин (w) тогтоосон, хоёрт, шалгуур бүрийг дотор нь зэрэглэж төвшингөөр нь оноо (s) өгсөн /80%-иас дээш бол 4 оноо, 50–79% бол 3 оноо гэх мэт/ байна. Ингээд орон нутгийн бие даасан байдлыг дундаж оноогоор нь үнэлжээ.

$$I_{ai} = \sum S_i W_i$$

I_{ai} - орон нутгийн бие даасан байдлын үзүүлэлт

S_i - хувьсагч бүрийн оноо

W_i - чухалчлалын коэффициент

Бид дээр орон нутгийн бие даасан байдлын тухай өөрсдийн тодорхойлолтоос үндэслэн дөрвөн багц үзүүлэлтийг авч үзэх нь зүйтэй болох тухай дурдсан билээ. Тиймээс Чигу нарын шалгуурт тэдгээр үзүүлэлт багтаж байгаа эсэх талаар нягтлая.

Нэгд, эрх зүйн байдал: V5, V6, V7, V8, V9, 10

Хоёрт, түүний хүрээнд үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах эрх бүрдсэн эсэх: V3, V4, V8

Гуравт, чадавхи: V1, V2, V4

Дөрөвт, хариуцлага хүлээх

Эндээс харахад бидний гаргасан тодорхойлолтын гол злетентүүдийг эдгээр үзүүлэлт багтааж байна гэж болох юм.

Одоо тэдний үзүүлэлтүүдээ хэмжиж орон нутгийн бие даасан байдлыг үнэлсэн байдлыг авч үзье.

<Хүснэгт 2> Орон нутгийн бие даасан байдлын үзүүлэлт

Ш№	Үзүүлэлтүүд	w _i	ОНОО			
			S=4	S=3	S=2	S=1
V1	Орон нутгийн төсвийн нийт орлогод өөрийн орлогын эзлэх хувь	0.15	≥80%	50-79	20-49	<20
V2	Орон нутгийн төсвийн нийт орлогод төрийн төсвөөс олгож буй шилжүүлгийн эзлэх хувь	0.15	≤20%	21-50	51-79	≥80
V3	Төрийн төсөв болон улсын чанартай бусад төсвөөс орон нутгийн төсөвт олгож байгаа шилжүүлгийн хэв маяг/болзолгүй шилжүүлгийн хувь/	0.05	≥80	50-79	20-49	>20
V4	Орон нутгийн байгууллагын санхүүгийн хараат байдал	0.15	0.7-1.0	0.5-0.69	0.2-0.49	0.0-0.19
V5	Орон нутгийн засаг захиргааны орон нутгийн татвар тогтоох эрх	0.10				
V6	Орон нутгийн засаг захиргааны татварын орлого цуглуулах эрх /хичнээн % ийг нь/	0.10	≥80	40-79	10-39	0
V7	Орон нутгийн засаг захиргааны зээл авах эрх	0.10				
V8	Нийт эрх мэдэлд зөвхөн орон нутагт олгосон эрх мэдлийн эзлэх хувь	0.10	>80%	50-79	20-49	<20
V9	Орон нутгийн төсвийн үйл явцад мэдэх, хянах тавих эрх	0.05				
V10	Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо	0.05				

<Хүснэгт 3> Чанарын/тоогоор хэмжиж болохгүй/
үзүүлэлтүүд


V5	0.10	Татвараа өөрөө тогтоодог	Дээрээс тогтоодог боловч орон нутаг татварын суурь юмуу тусгай татвар тогтоох эрхтэй	Дээрээс татварын төрлийг ч, суурийг тогтоох боловч орон нутагт тодорхой хязгаарын дотор өөрчлөх, тусгай татвар тогтоох эрхтэй	Бүгдийг нь дээрээс тогтоох
V7	0.10	Орон нутаг үндэсний болон гадаад валютаар гадаад, дотоод зээлийг чөлөөтэй авах эрх	Тодорхой зохицуулалтын хүрээнд дотоод зээлийг зөвшөөрөлгүй, гадаад зээлийг дээрээс зөвшөөрөлтэй авах эрх	Аль ч зээлийг хатуу зохицуулалтаар дээрээс зөвшөөрөлтэй авах	Ямар ч зээл авах эрхгүй
V9	0.05	Орон нутгийн шийдвэрт дотоод хяналт тавигддаг	Шийдвэрийг гарах, хэрэгжүүлэх, бүр эцэст нь дотоод хяналтын дараа гаднаас тусгай хяналтын байгууллагаас хяналт тавьж зөвлөмж өгдөг	Дотоод хяналтын зэрэгцээ төв байгууллага болон тусгай хяналтын байгууллагаас хяналт тавьдаг	Төв байгууллага болон тусгай хяналтын байгууллагууд шийдвэрийн бүх шатанд хяналт тавьдаг
V10	0.05	Иргэд бүлгээрээ төсвийн төсөлд болон хэрэгжүүлэхэд, хянаж шалгахад оролцдог	Иргэд бүлгээрээ дамжуулан төсвийн төсөлд санал өгч оролцдог	Иргэд төсөлд санал өгөх, гүйцэтгэлийн талаар мэдээлэл авах эрхтэй	Иргэд оролцдоггүй.

Үүний үндсэн дээр дээр дурдсан томъёогоор орон нутгийн нэгжүүдийн бие даасан байдлыг тодорхойлж 4 анги болгосон байна. Мөн түүнчлэн Европын орнуудын орон нутгийн бие даасан байдлыг тооцож ангилсан байна.

Румын:

D анги	1,0-1,74	Орон нутгийн байгууллагын бие даасан байдал хязгаарлагдмал
C анги	1,75-2,49	Орон нутгийн байгууллага төлөөллийн бие даасан байдалтай
B анги	2,50-3,24	Хэвийн бие дасан байдалтай
A анги	3,25-4,00	Бүрэн бие даасан байдалтай

Европын орнуудыг үнэлсэн байдал:



Дээр дурдсан үзүүлэлтүүд орон нутгийн бие даасан байдлыг тодорхойлоход үндсэндээ хангалттай боловч тэдгээрээс гадна харгалзвал зохих зарим үзүүлэлт бий. Үүнд:

- орон нутаг нэг бүхэл организм болон орших, үйл ажиллагаа явуулах боломж. Энэ нь гол төлөв орон нутаг дахь төрийн байгууллагууд яг орон нутгийн байгууллага уу, эсвэл дээд шатныхаа байгууллагын төлөөний байгууллага уу гэдгээр, түүнчлэн тэдгээрийн өдөр тутмын үйл ажиллагаанд дээд төвшний байгууллагаас хэр хутгалдан оролцдог, дарга удирдагчдыг нь хаанаас томилж, тэд хариуцлагаа хэний өмнө хүлээдэг вэ гэх зэрэг олон асуудлаас хамааралтай юм.
- Өөр нэг асуудал бол орон нутагт улстөрийн намуудаас үзүүлдэг нөлөөлөл
- Өмчийг захиран зарцуулах эрх. Орон нутгийн өмч хэний

мэдэлд байна вэ гэдэг нь бие даасан байдалд онцгой нөлөөтэй юм. Зарах, түрээслэх, зээлийн барьцаанд тавих, үйл ажиллагаанд ашигласанаас орлого олох гэх мэт олон талаар өмчийн эрх мэдэлтэй холбоотой асуудал үүсдэг.

- Ардчилал. Орон нутаг дахь ардчиллын асуудал нь нэгд, оролцооны боломж, хоёрт, хариуцлагын тайлагнал бодитой байх эсэхээр гол нь тодорхойлогдоно.

Эдгээрээс эхний гурван асуудлыг асуудлыг зайлшгүй анхааран үзүүштэй. Бид Чигу нарын гаргасан шалгуурууд дээр энэ хоёр үзүүлэлтийг нэмэн оруулбал уг аргачлалыг манай орны нөхцөлд ч ашиглаж болно гэж үзэж байна. Ингэснээр бид манай нөхцөлд 12 шалгуур үзүүлэлттэй болж байгаа юм. Харин үзүүлэлтүүдийн жинг орон нутгийн ажилтнууд болон мэргэжилтнүүдийн саналаар тогтоож болох юм.

Эдгээр арван хоёр үзүүлэлтийг шалгуур болгон ашиглаж сум бүрийн бие даасан байдлыг үнэлэх, улмаар үзүүлэлтүүдийн тоон утгыг ихэсгэх багасгах замаар бие даасан байдалтай гэж үнэлж болох үеийн утгыг олж болно. Тэгэхдээ орлого, зарлага гэх мэтээр хуваарь, хүртвэр хоёрыг зэрэг өөрчлөх шаардлагатай нь ойлгомжтой юм.

Дээр дурдсаныг анхааралдаа авч энэ аргачлалыг хэрэглэвэл орон нутгийн бие даасан байдлын шалгуур нь дор дурдсан байдалтай болох юм. Тухайлбал, тоон үзүүлэлт дээр орон нутаг дахь төрийн байгууллагуудын дарга эрхлэгч нарыг томилох эрх (V6), чанарын үзүүлэлт дээр өмчийг захиран зарцуулах эрх (V11) болон улстөрийн нөлөөлөл (V12) хоёрыг нэмэн оруулж байна.

Нэг. Тоон үзүүлэлтүүд

Ш№	Үзүүлэлтүүд	w_i	ОНОО			
			S=4	S=3	S=2	S=1
V1	Орон нутгийн төсвийн нийт орлогод өөрийн орлогын эзлэх хувь	0.15	$\geq 80\%$	50-79	20-49	< 20
V2	Орон нутгийн төсвийн нийт орлогод төрийн төсвөөс олгож буй шилжүүлгийн эзлэх хувь	0.10	$\leq 20\%$	21-50	51-79	≥ 80
V3	Төрийн төсөв болон улсын чанартай бусад төсвөөс орон нутгийн төсөвт олгож байгаа шилжүүлгийн хэв маяг/ болзолгүй шилжүүлгийн хувь/	0.05	≥ 80	50-79	20-49	> 20
V4	Орон нутгийн байгууллагын санхүүгийн хараат байдал	0.10	0.7 - 1.0	0.5-0.69	0.2-0.49	0.0-0.19
V5	Орон нутгийн засаг захиргааны орон нутгийн татвар тогтоох эрх	0.10				
V6	Төрийн байгууллагын дарга эрхлэгч нарыг томилох эрх	0,10	≥ 80	50-79	20-49	≥ 20
V7	Орон нутгийн засаг захиргааны зээл авах эрх	0.10				
V8	Нийт эрх мэдэлд зөвхөн орон нутагт олгосон эрх мэдлийн эзлэх хувь	0.05	$> 80\%$	50-79	20-49	< 20
V9	Орон нутгийн төсвийн үйл явцад мэдэх, хянах тавих эрх	0.05				
V10	Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо	0.05				
V11	Өмчийг захиран зарцуулах эрх	0,10				
V12	Улстөрийн нөлөөлөл	0,05				

Энэ хүснэгтэд чанарын үзүүлэлтийн үнэлгээг тавиагүй ба түүнийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хоёр. Чанарын үзүүлэлтүүд

V5	0.10	Татвараа өөрөө тогтоодог	Дээрээс тогтоодог боловч орон нутаг татварын суурь юмуу тусгай татвар тогтоох эрхтэй	Дээрээс татварын төрлийг ч, суурийг тогтоох боловч орон нутагт тодорхой хязгаарын дотор өөрчлөх, тусгай татвар тогтоох эрхтэй	Бүгдийг нь дээрээс тогтоох
V7	0.10	Орон нутаг үндэсний болон гадаад валютаар гадаад, дотоод зээлийг чөлөөтэй авах эрх	Тодорхой зохицуулалтын хүрээнд дотоод зээлийг зөвшөөрөлгүй, гадаад зээлийг дээрээс зөвшөөрөлтэй авах эрх	Аль ч зээлийг хатуу зохицуулалтаар дээрээс зөвшөөрөлтэй авах	Ямар ч зээл авах эрхгүй
V9	0.05	Орон нутгийн шийдвэрт зөвхөн орон нутгийнхаа хүрээнд дотоод хяналт тавигддаг	Шийдвэрийг гаргах, хэрэгжүүлэхэд дотоод хяналттай, үр дүнд нь гаднаас тусгай хяналтын байгууллагаас хяналт тавьж зөвлөмж өгдөг	Дотоод хяналтын зэрэгцээ төв байгууллага болон тусгай хяналтын байгууллагаас хяналт тавьдаг	Төв байгууллага болон тусгай хяналтын байгууллагууд шийдвэрийн бүх шатанд хяналт тавьдаг
V10	0.05	Иргэд төсвийн төсөлд болон хэрэгжүүлэхэд хяналт тавих, шалгахад оролцох эрхтэй	Иргэд хурлаараа төсвийн төсөлд санал өгч, хэрэгжилтийн талаар шүүн хэлэлцэх боломжтой	Иргэд зөвхөн төлөөлөгч-дөөрөө дамжуулан төсөлд санал өгөх, гүйцэтгэлийн талаар мэдээлэл авах эрхтэй	Иргэд оролцдоггүй.

V11	0.10	Орон нутаг өөрөө өмч худалдан авч, худалдах эрхтэй	Орон нутаг худалдах, худалдан авах талаар зөвхөн санаачлага гаргах, дээрээс гарсан санаачлагаас татгалзах эрхтэй	Орон нутаг зөвхөн түрээслэх эрхтэй	Түрээслэх эрхгүй
V12	0,05	Улстөрийн нөлөө бага	Улстөрийн нөлөөтэй	Улстөрийн дунд зэрэг нөлөөтэй	Улстөрийн хүчтэй нөлөөтэй

Үүний дараа бид шинээр нэмсэн үзүүлэлтүүдийн жинг тогтоож авбал зохих хамгийн их оноог тооцож орон нутгийн бие даасан байдлыг зэрэглэх хязгаарыг тогтоох хэрэгтэй. Ийнхүү бид шинэ үзүүлэлтүүдийг нэмж байгаа болохоор манай орны үзүүлэлтийг Европын орнуудынхтай харьцуулах боломжгүй. Харин Чигу нарын үзүүлэлтүүдийг хэрэглэсэн тохиолдолд Европын үзүүлэлттэй харьцуулах боломж гарна.

Чигу нарын аргачлалаар авбал зохих хамгийн дээд оноо 4 юм. Хэрвээ S нь дөрөв биш таван шатлалтай байх юм бол хамгийн их оноо 5 байна. Ийм тохиолдолд тоон үзүүлэлтийн интервалыг багасгах, чанарын үзүүлэлтийг илүү нарийвчлах хэрэгтэй юм. Үүнийг бид судлагааны явцад шийдвэрлэх болно. Харин жин 1 байх нь зохимжтой учраас түүнийг ямар ч тохиолдолд өөрчлөхгүй байх нь зүйтэй. Үзүүлэлт тус бүрийн жинг манай орны нөхцөлд нийцүүлэн тогтоосон болно.

Орон нутгийн бие даасан байдлын төвшинг ийм аргачлалаар тооцоолон харьцуулалт хийх, үзүүлэлтүүдийг ихэсгэж багасгах замаар засаг захиргааны нэгжийн хэмжээг тогтоох зэрэг оролдлогыг хийж болно.

Ийнхүү бид орон нутгийн бие даасан байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлохын хамт бие даасан байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай зарим нөхцлийг дурдах нь зүйтэй.

Орон нутгийн бие даасан байдал нь нутгийн өөрөө удирдах ёстой салшгүй холбоотой юм. Өөрөө удирдах ёс төрийн удирдлагын төвшин хоорондын харилцааны улмаас

юмуу, эсвэл орон нутагт чадавх бүрдээгүйгээс болоод зохих хэмжээнд хэрэгжихгүй байгаа нөхцөлд бие даасан байдлын талаар ярихад бодитой биш болно. Өөрөө удирдах ёс нь төвлөрөлийг сааруулах эрх зүйн талын арга хэмжээ, санхүүгийн боломж зэргээс гадна, соёлын, эдийн засаг, санхүүгийн гэх мэт зохистой нөхцлүүдийг шаардана.


Манай орны хувьд нутгийн удирдлагад өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослох зарчим тунхаглагдсан байдаг. Гэвч хэрэг дээрээ өөрөө удирдах ёс байна уу гэдэг асуудал туйлын эргэлзээтэй байгаа юм. Одоогийн байдлаар удирдлагын хоёр хэлбэрийг хослох бус нэг нь удирдаж нөгөө нь оролцох хэлбэр байгаа гэж болно. Нутгийн өөрөө удирдах ёсны хэрэгжилтэд учирч байгаа бэрхшээл юунаас болж байна вэ? Энэ асуудлын талаар их бодитой эрэгцүүлэх шаардлага байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны хамгийн чухал зүйл нь оршин суугчид өөрснөө гэвэл мэдээжийн хэрэг болохоор хэтэрхий болхи сонсогдож болох юм. Гэвч чухамхүү асуудлыг бид оршин суугчдаас л эхлэж тунгаах ёстой. Нутаг ба оршин суугч. Оршин суугч ба иргэн. Нутаг ба нутгийн эзэн. Орон нутгийн аливаа нэгжид оршин суугч бүр нутаг орондоо болж байгаа сайн муу үйл явдал, удирдлагын үйл ажиллагаа, түүний үр дүнг өөрийн гэрт болж байгаа үял явдал мэтээр үзэж, өөрөө идэвхтэй оролцож, сайныг нь дэлгэрүүлэх, хөгжүүлэх, саарыг нь засах арилгах гэж оролддог байх нь нутгийн өөрөө удирдах ёсны анхдагч бөгөөд зайлшгүй нөхцөл юм. Ийм биш байгаагаас ИТХ-д хэн сонгогдох нь хувь хүнд онцгой ач холбогдолтой биш, тиймээс ямар нэг (Ухуулга, жижигхэн “хахууль”) нөлөөлөлд автаж сонгоё гэж бодоогүй хүнийхээ төлөө санал өгөх, эсвэл өөрөө удирдах ёсны байгууллагаа бас л нэг дарга нарын байгууллага мэт үзэж хол хөндий байх, үйл ажиллагаанд нь оролцохгүй байх зэрэг үзэгдэл гардаг. Сумын иргэд сумын төсөв, түүний хэрэгжилтээс эхлээд сумын төв тохижилт хог хаягдал хүртэлх том жижиг аливаа асуудалд чин сэтгэлээсээ идэвхтэй оролцож, өөрсдөд нь үйлчилж байгаа сургууль эмнэлгийг өөд нь татдаг, зам харгуйгаа боломжийн хэрээр засдаг, ус билчээрээ хэрхэн ашиглахыг нийтээрээ хэлэлцэн оновчтой шийдвэр гаргаж хэрэгжүүлдэг байна гэвэл мөрөөдөл биш юм. Өөрөө удирдах ёсны агуулга, хамаг утга учир ерөөсөө

л ийм юм. Дээр үеийн Европын зарим тосгод, хотууд, Америк тивд шилжин суурьшигчдын суурин хотууд ийм байсан нь ном зохиолоос (жишээ нь А.Токвилийн бүтээл) харагддаг.


Орон нутагт засаг захиргааны нэгжийг хэрхэн байгуулсан нь тухайн газарт ийм “том гэр бүл” (Хүй элгэн) үүсэх эсэхэд маш их нөлөөтэй. Газар зүйн нөхцөл, олон зуун жил үргэлжилсэн уламжлал эсвэл угсаатны адилсал зэрэг нь ийм нягтарсан хүй элгэн буй болоход чухал нөлөөтэй гэдэг нь хүн төрлөхтөний түүхээс харагдаж байгаа юм. Харин засаг захиргааны нэгжийг зохиомлоор, огтчиж нийлүүлэх, салгах байдлаар зохион байгуулсан тохиолдолд ийм нөхцөл бүрдэхгүй, тухайн нэгж нэг бүхэл болохгүй уддаг байна.

Манай орны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн байдлыг авч үзвэл нэгд, хорьдугаар зуунд нэгжүүдийг нэлээд хэмжээгээр зохиомлоор буй болгосон, Хоёрт, дарангуйллын дэглэмтэй байсан нь өөрөө удирдах ёсны тухай асуудлыг тавих ч боломжгүй болгосон, гуравт, одоогийн байдлаар өөрөө удирдах ёс үр нөлөөтэй байх нөхцөл бүрдээгүй байна гэж болох юм. Энэ нь нутгийн удирдлага оршин суугчдын хооронд эсрэгцлийн юмуу, эсвэл эцэг-хүүгийн шинжтэй харилцаа буй болоход хүргэсэн байна. Үүнийг дараах байдлаар төсөөлж болох юм.



Нутгийн удирдлага болон оршин суугч хоёрын хоорондын ийм маягийн харилцаа нь тэгш хэмтэй биш бөгөөд оршин суугч идэвхгүй байх, улмаар удирдлагын талаасаа үйлчилгээг чанаргүй үзүүлэх, авилга, албан тушаалын зөрчил гаргах, дээшээ харах зэрэг олон сөрөг үзэгдлийг дагуулж байгаа юм.

Орчин үеийн нөхцөлд уг асуудлыг зохицуулах, улмаар өөрөө удирдах ёсыг төгөлдөр болгон хөгжүүлэх аргын нэг нь зах зээлийн механизмыг ашиглах байж болох юм. Үүнийг дараах бүдүүвчээр харуулж болно.



Ийм харилцаатай байгаа үед нутгийн захиргаа болон оршин суугчид харилцан бие биений өмнө үүрэг хүлээж хамтран ажиллах болно хэмээн төсөөлж болно. Оршин суугч зүгээр нэг оршин суугч биш, нутгийн эзэн, шийдвэр хамтран гаргах, хэрэгжүүлэхийг эрмэлзэгч болон хувирна. Тэрбээр түүнийг иргэн, социаль капитал хэмээх маш чухал нөөцийн эх булаг гэж үзэж болно. Хүн өөрийнхөө хөлс хүчээр олсон ашгаас татсан татварыг өөрт нь болон нутаг нугынханд нь ашигтай байдлаар зарцуулахыг эрмэлзэх нь зүй. Түүний нөгөө талаар дээр дүрсэлсэн харилцаанд орон нутгийнхаа төлөө хариуцлагыг орон нутаг өөрөө, оршин суугчдад ногдуулж байгаа болохоор хүмүүс орон нутгаа хөгжүүлэх, эмнэлэг сургуулиа зохистой авч явахын тулд сайн дураараа ажил хийх, нэмэр хандив өргөх болно. Ингэснээр тэд социаль капиталын эх булаг болж байгаа юм. Ийм байдал олон жил үргэлжилсний үр дүнд хөдөөгийн сургууль, эмнэлэг, соёлын төв, худаг гэх мэт зүйлс нь тухайн орон нутгийн оршин суугчдын дундын, өөрөөр хэлбэл олон нийтийн өмчийн шинжтэй болно.

Ер нь орон нутгийн хамтлаг болох тосгон суурин нь өөрөө ч, түүний өөрийн удирдлага ч тариаланд усыг ээлжээр, зохион байгуулалттай ашиглах, гал түймэртэй тэмцэх, хог хаягдлаа цэвэрлэх гэх мэтийн тэр нутгийн хүмүүст бүгдэд нь хамаатай асуудлыг өөрийн хүч хөрөнгөд тулгуурлан хамтран шийдвэрлэх шаардлагаар үүссэн байдаг. Асуудал нь өөр ч гэсэн нүүдлийн аж төрөх ёс бүхий манай оронд ч гэсэн ийм "нийтийн" асуудлууд байваас л өөрөө удирдах ёс төлөвших ёстой. Орон нутагт байгаа асуудлыг бүгдийг дээрээс зохицуулах, шийдвэрлэх гэж оролдвол орон нутгийн өөрөө удирдах ёс бодитой болохгүй. Үүнийг зөвхөн албан ёсны засаг захиргааны хуваариар шийдвэрлэж чадахгүй. Манай орны хувьд суурин

ард түмнийхтэй адил шинжтэй нийтээрээ оролцож шийдвэрлэх асуудал бол билчээр ашиглалт, малын өвчин эмгэгтэй тэмцэх, ган зудыг хамтын хүчин чармайлтаар эсэргүүцэх зэрэг байж болох юм. Иймэрхүү асуудлаар орон нутагт (тэгэхдээ зөвхөн дарга нарт нь биш) эрх мэдэл олгож чадавхжуулахад анхаарвал орон нутгийн өөрөө удирдах ёс алгуур боловч төлөвшиж болох талтай юм. Хоёр хүн билчээр ашиглалтын асуудлаар тохиролцохгүй, зодоо нүдээнд хүрч болох боловч баг сумаараа хэлэлцвэл асуудлыг зохистой шийдвэрлэх боломж бүрэн бий. Дээрх зурагт дүрсэлсэн харилцааг эрх зүйн орчноор баталгаажуулж эрх мэдлийн зохистой хуваарилалтыг буй болгож болох нь ойлгомжтой юм.

Нутгийн өөрөө удирдах ёс бүрэлдэн төлөвшөхөд институтацийн талын зохион байгуулалт нөлөөтэй юм. Уг асуудлыг энд дэлгэрэнгүй авч үзэх бололцоогүй учраас нутгийн өөрөө удирдах ёстой зэрэгцээ бүтцийг буй болгох, төрийн байгууллагын төвлөрөл, бүсчлэл зэрэг нь сайн болон саар нөлөөтэй гэдгийг л зөвхөн тэмдэглэе.

Ашигласан ном

1. Батболд Су. Орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх асуудал. Уб., 2010
2. Жаргал Г. Монгол сум. Уб., 2013
3. Gordon L. Clark. A Theory of Local Autonomy. Article published online: 23 FEB 2005 DOI: 10.1111/j.1467-8306.1984.tb01448.x
4. Hal Wolman, Robert McManmon, Michael Bell and david Brunori. Comparing Local Government Autonomy Across States. GWIPP working Paper. The George Washington University. <[http://www2.gwu.edu/~gwipp/Comparing Local Governments Across](http://www2.gwu.edu/~gwipp/Comparing_Local_Governments_Across) .
5. Ted R. Gurr and Desmond King. The State and the City. Univ of Chicago Press, 1987 European Charter of Local Autonomy
6. Petronela Zaharia. Public Administration and Local Autonomy – Public Management Theory Approaches. Petroleum-Gas University of Ploiesti Bulletin, Economic series. Vol. LX111 No 4/20



БАНКЫН МЯГМАРСҮРЭН

Орхон аймгийн ИТХ-ын дарга
Төрийн удирдлагын арга зүйч, зохион байгуулагч

НӨУБ-ЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ЧАНАР, ҮР НӨЛӨӨНД АНХААРАХ НЬ

Нутгийн өөрөө удирдах ёс хэмээх энэхүү ойлголт Монгол түмний амьдралын гүнд өөрийн биелэлээ олж бодитойгоор оршсоор ирсэн хэдий боловч, Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдөж, нутгийн удирдлагын зарчим болон засаглалын утга агуулгыг олж аваад дөнгөж хорь гаруйхан жил болж байна. Манай улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орж, энэхүү түүхэн сонголтоо шинэ Үндсэн хуулиар баталгаажуулсан бөгөөд нутгийн удирдлагын тогтолцоог зарчмын өөр байр сууринаас томъёолон “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэж хуульчилсан билээ. Монгол улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий

тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогод “Нутгийн өөрөө удирдах ёс нь ардчилсан нийгмийн гол үндэс мөн” хэмээн тодорхойлжээ. Ийнхүү НӨУЁ-ны зарчим нь эдүгээ манай улсад Үндсэн хуулиар баталгаажиж, практик амьдрал дээр түүний бүхэл бүтэн тогтолцоо бий болж бүрэн эрхээ хэрэгжүүлж байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг орон нутгийн бие даасан байдлын илэрхийлэл, тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэгч, нутаг дэвсгэртээ “эзэн” нь байхыг НӨУЁ-ыг хэрэгжүүлж байгаагийн шалгуур гэж үздэг. Аймгийн НӨУБ нь хүн амаа төлөөлөн орон нутгийн өмчийг өмчлөгч нь, газрын бодлого баталдаг газар нутгийн “эзэн” нь, нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэдэг, хөгжлийн бодлого барьдаг, шийдвэр гаргадаг байгууллага юм.

Нутаг дэвсгэрийн иргэдээс сонгогдсон Хурал нь тухайн нутгийн удирдлагыг хэрэгжүүлдэг институт нь, хүн ам нь түүгээр удирдуулах жолоодуулахыг хүлээн зөвшөөрсөн гэдэг утгаараа “дүрэм”-ийн засаг нь байдаг билээ. Монгол улсын үндсэн хуулиар нутаг дэвсгэрийн хамт олон нь өөрсдийн асуудлыг хуулийн хүрээнд өөрсдөө хэнээс ч хараат бусаар бие даан шийдвэрлэж, тэрхүү шийдвэр нь НӨУЁ хэрэгжиж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээнд заавал биелүүлэх хүчинтэй байхаар хуульчилсан юм.

Нутгийн удирдлага гэдэг бол төрийн удирдлагыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь байдаг. Өнөөдөр нутгийн удирдлагыг бүрдүүлж буй эрх тэгш хоёр субъект болох НӨУБ болох ИТХ, БИНХ, Засаг дарга гэсэн харилцан, тэнцвэр бүхий удирдлагын бие даасан хоёр субъект орон нутгийнхаа ажил амьдралыг удирдан зохион байгуулж байна. Хурал, Засаг дарга хоёр нь харилцан тэнцвэр бүхий нутгийн удирдлагын эрх тэгш хоёр субъект гэдэг хэдий боловч орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын эрх мэдлийн эх сурвалж нь Хуралд “хадгалагдаж” байдаг билээ. Өөрөөр хэлбэл дөрвөн жил тутам явагддаг орон нутгийн сонгуулийн үр дүнд бүрэлдэн бий болдог Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал, БИНХ нь Анхдугаар хуралдаанаараа зохион байгуулалтын асуудал буюу нутгийн удирдлагын шинэ

бүрэлдэхүүнийг бүрдүүлэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх мэдлийг баталгаажуулдаг. Түүний дотор тухайн шатны Засаг даргад нэр дэвшүүлэн томилуулах санал гаргаж дээд шатны засаг дарга болон Ерөнхий сайдад уламжлан томилуулдаг. Мөн түүнийг чөлөөлөх болон огцруулах талаар санал гаргаж уламжлах эрх нь тухайн шатны Хурлын бүрэн эрхийн асуудал юм. Энэ бүгдийг нэгтгээд дүгнэлт хийж үзвэл орон нутгийг удирдах “дээд” эрх мэдэл нь яах аргагүй НӨУБ-д байгаа юм. Тийм учраас НӨУБ-ын үйл ажиллагаа, түүний чанар үр ашгаас орон нутгийн хөгжил, хүн ардын амьжиргааны түвшин, амьдралын чанарын асуудал шууд хамааралтай юм.

Аливаа улс орон, бүс нутаг, орон нутгийн хөгжлийг тодорхойлогч үндсэн хүчин зүйл бол тэнд амьдарч буй хүмүүсийн хөгжлийн түвшин байдаг. Учир нь хүн гэдэг бол нийгмийн хамгийн үнэ цэнэтэй баялаг юм. Энэ нь төрийн үйлчилгээний хүртээмж чанар, түүнийг хүртэх боломж сонголттой шууд холбоотой. Түүний цаана ард иргэдийн амьдралын чанар өөрөөр хэлбэл орлого өндөр байх, эрүүл мэнд боловсролын болон бусад үйлчилгээг хүртэх өргөн боломжтой байх, үйлчилгээний чанар сайн байх зэрэг агуулга ойлгогдож байдаг бөгөөд энэ нь ерөнхий утгаараа тухайн орон нутгийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг байна..

Төрийн үйлчилгээ гэдэг бол Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд төрийн зорилт, чиг үүргийг ард иргэдэд бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжүүлж байгаа Засгийн газар, Нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудаас хариуцан гүйцэтгэх үйл ажиллагаа юм.

Мөн Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлж эхэлснээр бүсээс иргэдэд үйлчилгээ үзүүлэх гэдэг ойлголт бий болж, зарим эхлэл тавигдах болсон. Тухайлбал бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд “хүн амын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, соёл боловсролын үйлчилгээг тухайн бүс дотор нь аймаг, орон нутгийн чадавхид түшиглэн цогцолбороор шийдвэрлэх, үйлдвэрлэл үйлчилгээний тодорхой салбарыг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлсэн байх” зэрэг заалтууд орсон байгаа.

Түүнчлэн орон нутгийн өмчид тулгуурлан орон нутгийн хүн амын нийтийн үйлчилгээнд зориулсан үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрууд хэд хэдэн чиглэлээр ажиллаж байна. Орон нутаг хөгжиж, нутгийн өөрийн удирдлага бэхжиж төлөвших тутам ийм төрлийн үйлдвэр үйлчилгээний газрууд, орон нутгийн хөгжлийн сан, хувь нийлүүлсэн хэлбэрүүд бий болон нэмэгдэж, орон нутгаас үзүүлэх үйлчигээний төрөл хэлбэр улам өргөжиж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо олшрох болно гэж энэ талаар судалгаа хийж буй зарим судлаачид үзэж байна. Цаашдаа ч орон нутгийн өмчийн үйлдвэр, газрууд нь тухайн орон нутгийн өвөрмөц онцлог, хөгжлийн түвшин, төсөв хөрөнгө зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалан түлхүү хөгжүүлэх чиглэл, тоо хэмжээ янз бүр байх болон өсөх хандлага явах зүй тогтол харагдаж байна.

Төрийн удирдлага гэдэг бол нийгмийн нийт бүлэг, хэсгүүдийн хувьд хүний хөгжил, түүний бүхий л олон талт байдал илрэн цогцолж байх, төрийн үйлчилгээг хүн амд зохистой, чанартай үзүүлэх нийгмийн нөхцлийг бүрдүүлж чадахуйц төрийн байгууллагуудын үйл ажиллагааны сүлжээ, тэдгээрээс төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхэнтэй хууль, дүрмийн хүрээнд тогтоосон үр бүтээлтэй түншлэл юм. Төрийн үйлчилгээг төрийн албаны тогтолцоогоор дамжуулан хүргэдэг. Орон нутгийн түвшинд үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд бүх шатны Засаг даргын ажил албаны чадварыг дээшлүүлэх” гэж Монгол улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолд заасан байна.

НӨУБ –ын үйл ажиллагааны мөн чанарын цаана орон нутгийн хөгжлийн болон нутаг дэвсгэрийн хамт олны нийтлэг эрх ашгийн асуудал байдаг билээ. Нийтлэг эрх ашиг гэдэг бол нийгмийн харилцаанд оролцогчдын нийгмийн үйл хэрэгт хөтөлж байдаг эдийн засгийн утга агуулга бүхий ухамсарласан ашиг сонирхол байдаг. НӨУБ –ын үйл ажиллагаанаас ангид орон нутгийн амьдралын асуудал, түүнтэй холбоотой үйл ажиллагаа, ажил үйлчилгээ гэж байхгүй юм. Иймд нутгийн өөрийн удирдлагын байгууллага өөрийнхөө үйл ажиллагааны цар хүрээг бодитойгоор олж харж, түүний чанар хүртээмж, хэмжээсийн асуудал, үр дүн, гүйцэтгэлд анхаарах шаардлага

өдрөөс өдөрт улам нэмэгдэж байна. Энэ бүхэн хурлын байгууллагын өөрийнх нь үйл ажиллагааны чанар, далайц, үр нөлөөнөөс үндсэндээ хамаарах болно. Хурлын байгууллагын ажлын гүйцэтгэл, чанар, орон нутгийн амьдралд үзүүлж буй үр нөлөөний асуудлыг “чанарын нэгдсэн” нүдээр харах, нэгдсэн гараар зохицуулах, нийтлэг үнэлэмжээр үнэлэх, түүний амьдралд үзүүлж буй нөлөөг “чанар” талаас нь авч үзэх зайлшгүй шаардлага гарч байна. Энэ бүгд нь эргээд л хөгжил гэдэг томоохон нэр томъёонд зангидагдаж, түүгээр бид хийсэн ажлынхаа үр дүн, үр нөлөө, чанарыг олж харах ёстой юм.

Төрийн салбарын хүрээнд хийгдэж буй удирдлагын шинэчлэлийн гол зорилго нь зардлыг хэмнэх, төрөөс нийлүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, Засгийн газар болон төсвийн байгууллагуудыг илүү үр ашигтай ажиллуулах, тэдний баримталж буй бодлого, үйл ажиллагааг үр дүнд хүргэх зэрэг өргөн хүрээг хамарч байна. Эндээс бид үйлчилгээний чанарын асуудал түүний нэг чиглэл болж байгааг олж харна. Засгийн газрын зүгээс үзүүлж буй төрийн үйлчилгээний хувьд чанарын асуудал маш чухал байр суурь эзлэх шаардлага тавигдаж байгаа бөгөөд тухайлбал боловсрол олгох, эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх болон бодлогын зөвлөгөө зэрэг ажил үйлчилгээ, бүтээгдэхүүнүүд нь чанарын үзүүлэлттэй байх бөгөөд эдгээр нь бүгд үзүүлж буй үйлчилгээний чухал бүрдэл хэсэг нь байдаг. Бүтээгдэхүүний чанар түүний дотор төрийн үйлчилгээний чанарыг зарим тохиолдолд хэмжихэд хялбар байдаг бол бусад тохиолдолд бэрхшээлтэй байдаг.

Барааны чанар гэдэг нь тухайлбал бараа, бүтээгдэхүүнийг зориулалтаар нь ашиглахад хүний хэрэгцээг хангах эсэх чадварыг илэрхийлдэг шинж чанаруудын нийлбэр цогц байдаг. Эд юмс, бараа бүтээгдэхүүн бол маш олон бодит онцлогууд шинж чанарыг агуулдаг бөгөөд шинж чанарууд нь түүнийг бүтээж бий болгоход мөн эдэлж хэрэглэх явцад илэрч байдаг байна. Барааны чанарыг үнэлэхэд хүмүүсийн хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй буюу хэрэглээний шинж чанаруудыг сонгон авдаг байна. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах нь хэрэглэгчийн сонирхол төдийгүй үйлдвэрлэгч өөрийгөө найдвартай түнш гэдгийг харуулах, урт хугацааны ашигтай ажиллагаагаа хангахад чухал нөлөөтэй асуудал байдаг гэж

мэргэжлийн хүмүүс, судлаачид үздэг. Нийтлэг жишгээр авч үзвэл үйлдвэрлэгдэн гарч байгаа бараа бүтээгдэхүүн нь тодорхой шаардлага хангасан байх ёстой бөгөөд түүнийг зориулалтаар нь тодорхой хугацаанд эдэлж хэрэглэхэд тохиромжтой нөхцөл онцлогийг шаардлага гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл хэрэглэгчдийн хүлээгдэж буй хэрэгцээг хангах гэж тодорхойлж болох юм.

Тэгвэл НӨУБ-ын үйл ажиллагааны болон орон нутагт нийлүүлж буй төрийн үйлчилгээний чанар ямар байх ёстой вэ. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Монгол улсын Үндсэн хуульд заасан ёсоор нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх онцгой эрх хэмжээтэй. Энэхүү эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх тодорхой бүрэн эрхийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удилдлагын тухай хуулиар хуульчлан тогтоосон юм. Юуны өмнө НӨУБ-ын ажлын чанарын тухай авч үзэхийн тулд түүний гүйцэтгэлийн удирдлагын тухай цухас боловч авч үзэх нь зүйтэй юм.

Гүйцэтгэлийн удирдлага гэдэг нь үр дүнг голлон анхаардаг удирдлагын арга бөгөөд гүйцэтгэлийн зорилт дэвшүүлэх, гүйцэтгэлийг хэмжээсжүүлэх, гүйцэтгэлийн талаарх мэдээ баримт цуглуулах, явцыг хянах, тайлагнах, стратегийн зорилго, зорилтыг хангахын тулд гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор энэхүү мэдээ, мэдээллийг ашиглах зэрэг тасралтгүй үргэжлэх үйл явцын дүнд гүйцэтгэлийг сайжруулах тогтолцоо юм.

Гүйцэтгэлийн удирдлага гэдэг нь гүйцэтгэл хэмээх гол чухал ойлголтод үндэслэсэн, мөн түүнийг чухалчлан анхаардаг удирдлагын арга бөгөөд :

- Стратегийн зорилттой уялдуулж, хүсэн хүлээж буй гарц ба үр дагавар болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.

- Нөөцийн хувиарлалтыг гарц болон үр дагаврыг төлөвлөх үйл явцтай холбож, тэдгээрийн тэргүүлэх чиглэлийн дарааллыг тогтоох.

- Зорилгыг тодорхойлж, хэмжих шалгуур үзүүлэлтийг тогтоож, үр дүнг тайлагнах

- Гүйцэтгэлийг сайжруулахад чухал удирдлага болоод

суралцах үйл явцад анхаарах

- Хариуцлага ил тод байдлыг дээшлүүлэхэд тус тус үйлчилдэг байна.

Орхон аймгийн НӨУБ-ын гүйцэтгэлийн удирдлагын хүрээг тоймловол:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, жил бүр гүйцэтгэлийн явцад үнэлгээ дүгнэлт өгдөг.
2. Аймгийнхаа жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталж оны эцэст гүйцэтгэлийг нь хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгдөг.
3. Аймгийнхаа жил бүрийн орон нутгийн төсвийг хэлэлцэн баталж, явцад хяналт тавьж, гүйцэтгэлийг баталдаг.
4. Нутаг дэвсгэрийн хэмжээнд жил бүр оруулж буй улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төлөвлөгөөг баталж, ажлын явц, гүйцэтгэлд аудит хийлгэж, дүнг Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж дүгнэлт хийх, холбогдох арга хэмжээ авах
5. Нутаг дэвсгэрийн амьдрал, салбаруудын чиглэлээр хэрэгжүүлэх бүх чиглэлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл арга хэмжээг хэлэлцэн баталж, хэрэгжүүлэх талаар зохион байгуулж буй ажлын явц байдлын тайлан мэдээллийг сонсч, удирдамж чиглэлээр хангах
6. Монгол улсын хууль, төр засгийн бодлого, шийдвэр болон Нутгийн удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зохиож буй ажлыг нягтлан шалгах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх
7. Нутгийн удирдлагын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, түүний дүнг жил бүр хурлын хуралдаанаар хэлэлцэж үнэлж дүгнэх зэрэг үйл ажиллагаагаар дамжин бодлогын түвшинд гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна. Хурлын байгууллагын гүйцэтгэлийн удирдлагыг хурлын байгууллагын ажилд

тавигдах чанарын шаардлагатай нягт холбоотойгоор авч үзэх зайлшгүй шардлагатай юм. Хурлын байгууллагын ажлын чанарыг хэд хэдэн чиглэлээр тодруулж авч үзэж болох юм. Үүнд:

1. Хурлын байгууллагын батлан гаргаж буй шийдвэрт тавигдах чанарын шаардлага.
2. Хурлын байгууллагын төлөөллийн бүрэн эрхийг хангах үйл ажиллагаанд тавигдах чанарын шаардлага .
3. Хурлын байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тавигдах чанарын шаардлага.
4. Хурлын байгууллагын хяналт шалгалтын ажилд тавигдах чанарын шаардлага.
5. Хурлын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд тавигдах чанарын шаардлага зэргээр багцлан авч үзэж болох юм. Дээрх шаардлагуудыг тодруулж авч үзье. Үүнд:

1. Хурлын байгууллагын батлан гаргаж буй шийдвэрт тавигдах чанарын шаардлага нь бусад чанарын шаардлагуудын суурь шинжийг агуулна. Хурлын байгууллага бол нутаг дэвгэрийн хэмжээнд бүх нийтээр дагаж мөрдөх тогтоол шийдвэр гаргаж хэрэгжүүлдэг байгууллага. Өөрөөр хэлбэл НӨУБ-аас орон нутгийнхаа хэмжээнд засаглалыг хэрэгжүүлэх хүч чадал нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд заавал биелүүлэх “шийдвэр” гаргадаг оршино. НӨУБ нь хуулийн хүрээнд эрх зүйн акт гаргаж байгаа бөгөөд энэхүү эрхийг Монгол Улсын Үндсэн хууль , МУЗЗНДНТУТ хуулиар Хуралд олгосон байдаг. Гагцхүү хурлаас гаргах шийдвэр нь хууль зөрчөөгүй , хүний эрхийг хөндөөгүй, хэрэгжих баталгаатай, эцсийн үр дүнтэй, нийтээр хүлээн зөвшөөрөхүйц , түүнийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, үр нөлөө нь нүдэнд харагдаж , гарт баригдаж хэмжиж болохуйц байх явдал юм. Орон нутгийн хөгжлийн алс хэтийн, дунд хугацааны бодлогын болон цаг үеийн бүх бодлого, зорилт, ажил, үйлчилгээ нь НӨУБ-ын шийдвэрээр баталгаажиж хэрэгжиж байдаг оршино. Тийм учраас Хурлын байгууллагын шийдвэрийн чанар нь орон нутгийн ажил амьдрал, иргэдийн нийтлэг эрх ашигт шууд тусгалаа олж байдаг. Тухайлбал Орхон аймгийн ИТХ-аас 2002 оныг “Төрийн үйлчилгээний

шуурхай байдлыг хангах жил” болгон зарлаж, жилийн ажлын үр дүнг Аймгийн ИТХ-ын хуралдаанаар дүгнэж, жилийн турш хийсэн ажлынхаа үр дүнд суурилан 2003 онд “Орхон аймгийг Төрийн үйлчилгээний өндөр соёлтой загвар аймаг” болгох зорилт дэвшүүлж, уг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 жилийн үечлэлтэйгээр баталж биелэлтийг хангуулж байна. Мөн 2003 онд иргэдийн дунд өргөн хүрээтэй санал асуулгыг явуулж дээрх санал асуулгад үндэслэн Аймгийн ИТХ-ын хуралдаанаар Эрдэнэтчүүдийн эрмэлзэх үнэт зүйлийг “Хүний хөгжил-цэвэр хот” хэмээн томьёолон баталснаар улсын хэмжээнд анх удаа Эрдэнэт хот нь эрмэлзэх үнэт зүйлээ тунхаглан баталсан анхны хот болсон юм. Мөн Аймгийн ИТХ-ын Ээлжит хуралдаанаар 2014 онд “Мэдлэгт суурилсан Эрдэнэт” хөтөлбөрийг баталж, хотоо цаашид хүн ардынхаа мэдлэг оюунд тулгуурлан хөгжүүлнэ гэдгээ тунхаглан зарлалаа.

2. НӨУЁ-ын үндсэн субъект нь тухайн “нутаг дэвсгэрийн хамт олон” байдаг. Нутаг дэвсгэрийн хамт олноос сонгогдсон, тэднийг төлөөлж ажиллах үүрэгтэй Хурлын байгууллага нь орон нутгийнхаа ажил амьдралын гүнд байж, ард иргэдийнхээ хүсэл эрмэлзлэл, ашиг сонирхлыг мэдэрч, түүнд үндэслэн шийдвэрээ гаргаж байх ёстой. Энэ нь Хурал олон түмний холбоог бэхжүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцоог хангах, төлөөлөгчдөөс сонгогч түмэнтэй харилцах зэрэг үйл ажиллагаагаар дамжин хэрэгжинэ. Энэ чиглэлд тавигдах чанарын шаардлагад Хурлын байгууллагаас шийдвэр гаргахдаа эрх ашгийг нь хөндөнө үзэж буй хүн амынхаа хэсгийг оролцуулах, бие даан оролцож чадахгүй зорилтот бүлгүүдэд илүү чиглэгдсэн байх шаардлагатай. Манай аймгийн хувьд Аймгийн ИТХ-ын хуралдааныг 2 сард 1-ээс доошгүй удаа хуралдуулж, хуралдаан бүрийг орон нутгийн телевизээр шууд дамжуулж, хуралдааны зааланд иргэдтэй харилцах шууд утас ажиллуулж, иргэдээс ирүүлсэн шаардлагатай санал хүсэлтийг Хурлын шийдвэрт тусгах, холбогдох албан тушаалтнаар шууд хариу өгүүлэх, шилжүүлж ажил хэргийн шугамаар хариу өгүүлэх зэрэг ажлуудыг хэвшүүлсэн.

3. Хурлын байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, түүний амьдралд үзүүлсэн үр нөлөөнд тавигдах чанарын шаардлага бол орон нутгийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөгөөр

хэмжигдэх учиртай. Иймд хурлын байгууллагын тогтоол шийдвэр бүрийг хэрэгжүүлэхийн төлөө хяналтын тогтолцоог Хурал өөрөө бий болгох нь чухал. Шинэ бүрэн эрхийн эхнээс манай аймгийн Хурал энэ асуудалд онцгой ач холбогдол өгч багц шийдвэр гаргасны дотор “Хууль тогтоомж, аймгийн ИТХ-ын байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “Хурлын байгууллагын бодлого, шийдвэрийг хэрэгжилтийн хангах талаар авах арга хэмжээний тухай”, “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар асуудал хэлэлцүүлж буй байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам” зэрэг тогтоол шийдвэр багтаж байна. Харин Хурлын байгууллага гаргасан тогтоол шийдвэрийнхээ биелэлтийг хангуулах, төрийн үйлчилгээний чанар үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудаас үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, түүнийг боловсронгуй болгох, удирдлага, зохион байгуулалт болон төсөв санхүүгийн нөхцлийг бүрдүүлэхийг байнгын анхааралд байлгах нь чухал юм. Ингэж гэмээн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн асуудал бүрэн хэмжээгээр хангагдах ёстой. Энэ хүрээнд тавигдах чанарын шаардлагын бодит үр дүнг судалгааны бүх хэрэгсэл, хөндлөнгийн үнэлгээний гэх мэт арга хэрэгслүүдээр тооцох байх явдал юм.

4. Хурлын байгууллагын хяналт шалгалт, хяналт шинжилгээ үнэлгээний ажилд тавигдах чанарын шаардлага нь Хурлын шийдвэрийг чиглэсэн зорилго, бодит агуулгаар нь хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Хурал өөрөө гаргасан шийдвэртээ эзэн нь байж, түүний биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийж чаддаг байх ёстой. Ингэснээр түүнийг хэрэгжүүлэх явцад гарсан асуудал, хазайсан хазайлт, алдаа дутагдлыг нь залруулж хэвийн байдалд оруулах, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухай бүр мэдэрч мотиваци төрүүлэх зэрэг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах нөхцөл боломж бүрдэх юм. Аймгийн ИТХ-ын 2014 оны 12 дугаар сард хуралдсан Ээлжит хуралдаанаар 2015 оныг “Аймгийн ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, жилийн ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Тэргүүлэгчдийн хуралдаанаар

батлаж, хэрэгжүүлэх ажил зохион байгуулагдаж байгаагийн дотор Хурлын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтэд түвшин тогтоох хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг Хурлын төлөөлөгчдийн хүчээр аймаг даяар хийгдлээ.

5. Нутаг дэвсгэрийн хэмжээнд Нутгийн өөрийн удирдлагын байгууллага болон Засаг даргын үйл ажиллагааны үр дүнг амьдрал практик дээр ялган зааглах боломж бага. Энэ байгууллагын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр нэг, төлөөлдөг, үйлчилгээ үзүүлдэг хүн ам нэг, эцсийн зорилго эрх ашиг сонирхол нь нэгдмэл өөрөөр хэлбэл нэг зоосийн хоёр тал юм.

Иймд нутаг дэвсгэрийн хөгжил, хүн амын амьдралын чанарын өсөлтийг тусгасан нэгдмэл нэг үндсэн шаардлага тавих нь илүү зохимжтой юм. Тийм учраас манай Аймгийн ИТХ-ын 2014 оны 5 дугаар сард хуралдсан Ээлжит хуралдаанаар “Нутгийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүнийг тооцох аргачлал, тайлангийн загвар”-ыг баталсан. Энэхүү шалгуур үзүүлэлт нь 5 бүлэг 65 үзүүлэлтээс бүрдэж байгаа юм. Шалгуур үзүүлэлтийг 3 жилийн үзүүлэлтийг харьцуулах хэлбэрээр дүгнэх, суурь оныг 2012 он байхаар тооцсон бөгөөд жил бүрийн I улиралд багтаан Хурлын хуралдаанаар хэлэлцэж дүгнэж байхаар тогтоосон. Түүний дагуу 2015 оны 4 дүгээр сард хуралдсан аймгийн ИТХ-ын Ээлжит XXI хуралдаанаар дээрх үзүүлэлтийг анх удаа нэгтгэж дүгнэсэн байгаа. Нийт 65 үзүүлэлтээс 42 үзүүлэлт эерэг, 23 үзүүлэлт сөрөг байдлаар дүгнэгдлээ. Энэхүү үзүүлэлтийг нэгтгэн дүгнэснээр 3 жилийн динамикаар амжилт ололт, алдаа оноогоо олж харах нөхцлийг үндсэнд нь бүрдүүлж чадсан гэж үзэж байгаа бөгөөд үндсэндээ энд нутгийн удирдлагын үйл ажиллагааны чанар, үр дүн бодит утгаараа харагдаж байна гэсэн үг юм. Дээрх шалгуур үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлал нь аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, хүний амьдралын чанарын үндсэн үзүүлэлтийн динамик өөрчлөлт болон нутгийн удирдлагад илүү үр дүнтэй арга хэлбэр, зарчмыг нэвтрүүлсэн түвшинг тодорхойлоход оршиж байгаа бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээний анхаарал хандуулах гол талбар, түүний үр ашгийг дээшлүүлэх бодлогыг боловсруулах, түүнчлэн орон нутгийн иргэдэд үзүүлж буй үйлчилгээний

хүртээмж , чанарыг дээшлүүлэхэд дотоод нөөц боломжоо илүү үр ашигтай дайчлах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна. Энэхүү шалгуур үзүүлэлт нь үндсэндээ Орхон аймгийн Нутгийн удирдлагын үйл ажиллагааны чанарын түвшинг илтгэн харуулж байгаа юм. Бид гүйцэтгэлээ хэмжээсжүүлж чадахгүй юм бол гүйцэтгэлд хүрсэн эсэхээ мэдэх боломжгүй. Найдаж болохуйц хэмжээс үгүй бол зорилтоо хангаж байгаа эсэхээ, эсвэл бид үр ашигтай үр нөлөөтэй ажиллаж буй эсэхээ мэдэх ямарч арга байхгүй юм. Гүйцэтгэлийг хэмжээсжүүлэхийн нэг гол ач холбогдол нь асуудал дэвшүүлэх явдал бөгөөд энэ нь баримт нотолгоонд тулгуурласан менежментийн шийдвэр гаргах үндсэн нөхцөл болно.

Хаана чанарын асуудал яригдаж байна, тэнд чанарын удирдлагын асуудал давхар ойлгогдож яригдаж байх ёстой. Ийм учраас НӨУБ-уудаас цаашдынхаа үйл ажиллагаанд чанарын асуудлыг анхааралдаа байлгаж, ажил үйлчлилгээгээ чанартай байлгахын тулд чанарын тодорхой зарчмуудыг бий болгож баримтлах нь чухал юм. Үүнд:

1. Юуны өмнө нутаг дэвсгэрийнхээ хөгжлөөр баримжаалсан зарчим үйлчлэх ёстой. Хөгжил гэдэг нь олон хүчин зүйлээр тодорхойлогддог, өргөн хүрээтэй, нарийн нийлмэл үйл явц гэдгийг ойлгож батлан гаргаж буй алс хэтийн, дунд хугацааны болон цаг үеийн асуудлуудыг багтаасан шийдвэрт тусч буй эдийн засаг, нийгэм, соёлын зорилтуудыг нарийн уялдаа холбоотойгоор авч үзэх явдал чухал юм. Хөгжлийн үндсэн асуудлууд хүн амын орлогын өсөлт, чанарын шаардлага хангасан хоол хүнсний хангамж, боловсрол олох, эрүүл мэндийн сайн үйлчилгээ авах, эрүүл саруул амьдралын баталгаа зэрэг олон асуудал хамаарч байна. Энэ нь эргээд нутаг дэвсгэрийн хүн амын нийтлэг эрх ашигтай нягт холбоотой үндсэн асуудал болохын хувьд НӨУБ-ын ажлын чанарын суурь болох юм.

2. НӨУБ нь хүн амаасаа сонгогдсон төлөөллийн ардчилсан байгууллага учир түүний бүрэн эрх хууль ёсны лигитим шинжийг агуулдаг бөгөөд түүний гаргасан шийдвэр нутаг дэвсгэртээ нийтээр дагаж биелүүлэх хуулийн хүчин чадалтай юм. Энэ нь НӨУБ-ын эрх мэдлийн статус бөгөөд түүний зэрэгцээ өөрийн үлгэр дуурайллаар “нутаг дэвсгэрийнхээ хамт

олон”-ыг манлайлан удирдах чадвартай байх ёстой. Өөрөөр хэлбэл НӨУБ-ын үйл ажиллагаа өөрөө хууль дээдлэх зарчимд баттай суурилж, өөрийнх нь үйл ажиллагаа ёс суртахуун, ёс зүйн талаас эерэг хандлагатай байна гэсэн үг юм. Хүн амынхаа нийтлэг эрх ашгийн төлөө ажиллаж чадаж байна гэдгээ үйл ажиллагаараа харуулж ,алс хэтийнхээ хөгжлийн тавьсан зорилгодоо хүрэхийн тулд ингэж ажиллах ёстой юм гэдгийг хүн арддаа итгүүлэн үнэмшүүлж чадах нь НӨУБ манлайлан удирдах чадвартай гэдгээ харуулах гол үзүүлэлт болно.Тийм учраас НӨУБ –ын ажлын чанар нь манлайлах явдалтай салшгүй холбоотой юм.

3.НӨУБ нь өөрийн дотоод бүтцийг жигд ажиллуулж, түүнийг нэгдсэн үйл ажиллагаандаа татан оролцуулах нь ажлын чанарыг хангах гол хүчин зүйл байх болно.Өөрөөр хэлбэл Төлөөлөгчид, Тэргүүлэгчид, Хороо нь Хурлын байгууллагын дотоод бүтцийг бүрдүүлж байдаг бөгөөд тэднийг бүрэн хэмжээгээр татан оролцуулснаар тэдний чадварыг Хурлын байгууллагын ашиг тусын тулд ашиглах, нэгдсэн үр дүн, үр нөлөө бий болгох боломж бүрдэх юм.

4. НӨУБ нь орон нутгийн хөгжлийн бодлого барьдаг байгууллага юм. Тийм учраас өөрийн удирдах , зохицуулах, төлөвлөх, төсөвлөх, хянаж шалгах, нөөцийг удирдах бүх үйл ажиллагааг нэгдмэл үйл явц гэж үзэж, ойлгож, удирдлага зохицуулалтыг явуулах нь Хурлын байгууллагын ажил чанартай байх гол хөшүүрэг болно.

5.НӨУБ үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийж байх ёстой.Энэ нь НӨУБ –ын үйл ажиллагааны бүх чиглэлээр гаргаж болох гүйцэтгэлийг чанартай, шаардлагын түвшинд гаргаж чаддаг, тэр гүйцэтгэл дээрээ суурилан холбогдох үйл ажиллагааг сайжруулах байнгын арга хэмжээ авч чаддаг өөрөөр хэлбэл байнга сайжруулалт хийж байх чадвар нь НӨУБ –ын ажлын чанарыг сайжруулах гол арга хэлбэр байх юм гэж үзэж байна.

6.НӨУБ нь нутаг дэвсгэрийнхээ амьдралын асуудлаар бие даан шийдвэр гаргадаг байгууллага юм. Тийм учраас шийдвэр гаргахдаа асуудалд бодитойгоор хандах ёстой, бас шаардлагатай. Үндсэндээ хурлын байгууллагын шийдвэр нь орон нутгийн ажил амьдралын хөтөч нь, нутаг дэвсгэрийн

байгууллага, хүн амын үйл ажиллагааны эрх зүйн “үндэс” нь юм. Иймд НӨУБ –ын шийдвэр нийгмийн амьдралаас урган гарч буй шаардагыг зөв мэдэрсэн, зохицуулалтын арга хэлбэрийг оновчтой сонгосон, шийдвэр гаргахад үндэслэл болгосон өгөгдөл, мэдээллүүдийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэсэн, түүний үндсэн дээр гарсан байх зэрэг нь шийдвэрийн чанартай байх суурь нөхцлийг бүрдүүлэх болно.

7.НӨУБ-аас харилцаж буй бүх байгууллагатай үр нөлөө бүхий харилцаа тогтоох нь Хурлын байгууллагын ажлын чанар үр нөлөөг хангах чухал ач холбогдолтой. Хэдийгээр НӨУБ-ын бусад байгууллагуудтай харилцах харилцаа нь үндсэндээ захирах захирагдах харилцаа байх боловч НӨУБ болоод түүний харилцан ажиллаж буй байгууллагууд нь харилцан бие биенээсээ тухайн асуудлаар хамаарч, энэ харилцаа нь харилцан үр нөлөөтэй, үр ашигтай харилцаа байж, аль алиных нь тавьсан зорилгод хүрэх, үр ашиг бий болгох чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэж байх ёстой. Энэ нь эргээд Хурлын байгууллагын ажлын чанарт ихээхэн нөлөө үзүүлэх болно.

8.НӨУБ нь орон нутгийн иргэдээс сонгогдсон төлөөллийн ардчиллын байгууллага учраас түүний үйл ажиллагаанд оролцоог хангах нь ажлын чанар сайн байх үр нөлөөтэй хэрэгсэл юм. Хөгжлийн асуудлын гол нь зөвхөн материаллаг үйлдвэрлэлээр хязгаарлагдахгүй бөгөөд харин хөгжлийн үйл ажиллагаанд оролцогч хүмүүсийн нийгмийн чадавхийг улам сайжруулах явдал юм. Үүний тулд хөгжлийн үйл ажиллагаанд оролцогч хүмүүс нь зөвхөн түүний үр шимээс хүртэх биш, харин түүний хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад идэвхтэй байр сууринаас оролцох ёстой. Үүнд оролцооны жинхэнэ утга учир оршдог. Өнөөдөр дэлхий нийтээр оролцоог хангах хөгжлийн чиг хандлагад ихээхэн ач холбогдол өгч байгаа бөгөөд энэхүү чиг хандлага нь хүмүүсийн оролцоог чанарын хувьд дээшлүүлэх, өөрөө өөрийгөө тэтгэх, тогтвортой хөгжлийг хангах, нийгмийн шударга ёсыг тогтоох хөгжлийн хандлага гэж үзэх болжээ.Иймд оролцоог үр нөлөөтэй хангах, НӨУБ-ын ажлын чанарыг сайжруулах асуудал нь нягт холбоо бүхий үйл явц юм.

9. Ажил, үйлчилгээний чанарын асуудал бүх шатанд анхаарал татан яригдаж буй өнөөгийн нөхцөлд НӨУБ хэрэгжиж

байгаа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амд үйлчилгээ хүргэх зорилго бүхий бүх төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд чанарын удирдлагын ISO 9001:2008-ыг нэвтрүүлэх нь зүйтэй юм. Энэ хүрээнд юуны өмнө хүн амд үйлчилгээ үзүүлэх, харилцагчидтай гэрээ байгуулах, тендер шалгаруулах, шинээр ажил үйлчилгээ бий болгох, иргэдийн хяналт, зөвшөөрөл олгох зэрэг гол гол үйл ажиллагаа багтах боломжтой юм. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар 2011 онд улсын хэмжээнд анх удаа олон улсын ISO 2001:2008 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж баталгаажуулсан юм.

Энэхүү стандартыг нэвтрүүлснээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналт сайжирч хэрэглэгчдийг чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тогтмол хангах, байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй сайжрах бүх талын нөхцлийг бүрдүүлэх болон байгууллагын нэр хүнд өсөх, хэрэглэгчдийг татахад чухал ач холбогдолтой юм. Иймд НӨУБ-аас нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд засаг захиргааны бүх шатны болон төрийн үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх бодлого баримтлаж, бодлогоор дэмжих нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг тогтолцоогоор нь сайжруулах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.



ГАРАМЫН МАНАЛЖАВ

Монголын нутгийн удирдлагын холбооны дэд Тэргүүн
Багш, Удирдахуйн ухааны болон Боловсролын магистр

ТӨЛӨӨЛӨГЧ БҮРЭН ЭРХЭЭ ЗӨВ ОЙЛГОЖ ЧАНАРТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрх түүнийг хэрэгжүүлэх зарим арга барилыг ярихын өмнө Үндсэн хуулинд энэ чиглэлээр орсон үзэл баримтлал, түүний товч ухагдахууны талаар товч дурдъя.

Монгол улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн Төрийн үйл хэрэгт шууд оролцож мөн сонгож байгуулсан Төрийн эрх барих Төлөөлөгчдийн байгууллагуудаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэжээ.

Иргэн хүн, Төр нийгмийг удирдах эрхт оролцохдоо үйл ажиллагаанд нь хяналт шаардлага тавих, ажил үйлчилгээ сайжруулах чиглэлээр санал гомдлоо уламжлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх замаар шууд оролцох эрхтэй. Нөгөө талаар

өөрийгөө төлөөлсөн хүнийг Улсын Их Хурал, Аймаг, Нийслэл, Дүүрэг, Сумын ИТХ-д сонгох ажлыг өөрөө шууд оролцож саналаа нууцаар өгөх замаар хэрэгжүүлнэ. Сонгууль бол иргэн хүний Төр засгаа, Орон нутгийн удирдлагаа зөв байгуулахад ажил хэрэгч оролцох хамгийн чухал хэлбэр мөн. Бид хувь заяагаа хэнд даатгах вэ, тэр хүн бидний эрх ашиг, хүсэл бодлыг бүрэн илэрхийлж чадах уу? Шудрага, ажил хэрэгч зарчимч, хүн мөн үү, бидний ажил амьдралын зовлон бэрхшээлийг сайн мэдэж оновчтой шийдвэрлэж чадах эсэх зэрэг тодорхой асуудлаар нэр дэвшигчдээ сайтар судалж саналаа өгөх нь төр, нийгмийн удирдах хэрэгт иргэн хүн биеэрээ оролцож байгаа хамгийн чухал ажил билээ. Иргэн бидний хуулиар хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлж хийх ёстой чухал ажлын нэг нь сонгуульд өөрийгөө, гэр бүлээ, хамт олон, нөхдөө сайн бэлтгүүлэх, олон талаас нь бодож судалж, ярилцаж шийдвэрлэх хариуцлагатай ажил юм. Нэгэнт сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч нь Таны төлөө, Танай хамт олны ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл санал бодлын илэрхийлэл болж ажиллах учиртай тул уг хүмүүстэй захидал бичиг, утас, мессеж, И-майл зэрэг харилцах бүхийл боломжийг ашиглан санал бодлоо илэрхийлж хариу мэдээлэл авч амьд харилцаа тогтоох нь чухал. Ер нь нэр дэвшигчтэй эхнээс нь ажил хэргийн харилцаа тогтоон аймаг, сум, багийн хамт олны өмнөөс шийдвэрлүүлэх шаардлагатай тодорхой нэгээс хоёр асуудлыг судлан боловсруулж сонгогчдын өмнөөс захиа даалгавар болгон өгч биелэлт, үр дүнг байнга шаардаж ажиллах нь засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд биечлэн оролцож байгаа нэг арга болно. Энэ нь хуучирсан арга биш шинэчилж сонгогдсон хүндээ үүрэг хариуцлага үүрүүлэх нэг хэлбэр юм. Хууль батлах, бодлого шийдвэр хэлэлцэх үед иргэдийн санал бодлыг сайн тусгуулахад анхаарах нь чухал. Улсын Их Хурал бол төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага учраас улс орны хэмжээний бодлого шийдвэр гаргадаг. Иймээс улс орны хэмжээний болон тухайн аймаг сумын нийт хамт олны нийтлэг хэрэгцээ шаардлагыг илэрхийлсэн саналыг үндэслэл сайтай, баримт нотолгоотой гаргаж тавихад анхаарах нь уг санал бодол шийдвэрт тусаж хэрэгжих нэг нөхцөл болно. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч бол тухайн нутаг дэвсгэрт нийт иргэдийг, төлөөлсөн, иргэдээсээ сонгогдож Хурлаасаа баталгаажсан, иргэдээсээ сонгогдож иргэдийнхээ

төлөө үүрэг хариуцлага хүлээсэн хүн юм. Төлөөлөгч танаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэлдэнэ. Тэгэхээр тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч бол нутаг дэвсгэрийн хэмжээний асуудлыг хуулийн хүрээнд, иргэдийн нийтлэг ашиг сонирхолын дагуу хэлэлцэж шийдвэрлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг хянах томоохон үүрэг хүлээж байгаа болно. Энэ чанараараа Төлөөлөгч нь тухайн нутаг дэвсгэрийн нийт иргэдийг удирдан зохион байгуулагч, манлайлан хошуучлагч, үлгэрлэн дагуулагч мөн. Монгол улсын үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1-д “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...”¹ гэжээ. Энэ нь иргэн хүний ажил амьдралын хамгийн эгзэгтэй, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг олж хэлэлцүүлэх, батлах эрх, хариуцлагатай үүрэг хүлээж байгаа гэсэн хэрэг. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Монгол улсын үндсэн хуулиар баталгаажсан нутаг дэвсгэрийн хэмжээний бүх хүн амыг нэгтгэсэн эрх барих байгууллагын нийтлэг нэр юм. Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь “Ачааны хүндийг өөрөө үүрнэ” гэсэн латин үгнээс гаралтай утга юм.

“Нутгийн өөрөө удирдах ёсны эрх үндэс нь манай төрийн байгууламжийг бүрдүүлж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зөв зохистой хуваарь”² гэж доктор профессор Бираагийн Чимэд гуай бичжээ.

Монгол улсын үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 1-д дурьдсанаар “Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна”, “Монгол улсын нутаг дэвсгэр зөвхөн Засаг захиргааны нэгжид хуваагдана”³ гэсэн учраас Монгол улсын “Төрийн байгууламж”, “Засаг захиргааны нэгж” гэсэн хоёр утга бүхий үзэл баримтлалын шинжтэй утга санаа гарч байна. Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх нь төвлөрсөн төртэй, нэг бодлоготой нэгдмэл улсын шинж чанарыг илэрхийлэх бөгөөд нутаг дэвсгэр нь тодорхой нэгжүүдэд хуваагдах зарчим нь төрийн нэгдмэл бодлогод нутаг орныхоо онцлог, хэрэгцээ

1 Монгол улсын Үндсэн хуулийн 63, 64-р тал Улаанбаатар хот 1998 он.

2 Б.Чимид Үндсэн хуулийн үзэл баримтлал 177-р тал улаанбаатар хот 2002 он Улаанбаатар хот

3 Нутгийн удирдлагын өнөөгийн байдал, цаашдын зорилт 92, 93-р тал 2007 он Улаанбаатар хот

шаардлагад тулгуурлах, төрийн шийдвэрийг нэг мөр ойлгож жигд хэрэгжүүлэх утга юм. Бидний ярьж хэвшсэн “Орон нутаг” гэдгийг Үндсэн хуулиар “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж болгон өөрчилсөн нь төр, эрх зүйн шинжлэх ухааны шинэ түвшинд шилжиж хөгжлийн чиг хандлагыг илэрхийлсэн цогц асуудал болов”.

Судлаач асан З.Батцэнгэл бичихдээ “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж нь дараах шинжүүдээр тодорхойлогдох болох бөгөөд үүнийг ойлгож хэрэгжүүлэх явдал нь чухал юм. Үүнд:

- Өөрийн нутаг дэвсгэр
- Нутгийн иргэд
- Өөрийгөө тэтгэх чадвар бүхий аж ахуй
- Орон нутгийн өмч
- Орон нутгийн үйлчилгээ
- Орон нутгийн алба, албан хаагч
- Өөрийн удирдлага гэж додорхойлжээ”⁴.

Эдгээр шинжүүд дээр “өөрийн төсөв” гэж нэмэгдсэн байна. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлага нь энэ шинж чанаруудыг зөв төлөвшүүлж бий болгох, хэрэгжүүлэх асуудлаар бодлого чиглэл, хөтөлбөр зорилгоо тодорхойлж байх нь зүйн хэрэг юм аа. Монгол улсын үндсэн хуулийн Тавиндолдугаар зүйлийн 1-д “Монгол улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны хувьд аймаг нийслэлд, аймаг нь, суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдна”⁵ гэж заав. Энэ нь төрийн байгууламжийн тухай ойлголтыг лавшруулж Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай ойлголтыг тодорхой болгосон нь мэдээж Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалыг ул үндэстэй хэрэгжүүлж Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг шинхэнэ утгаар нь танин мэдэж ажиллах нь чухал. Үндсэн хуулийн Тавинесдүгээр зүйлийн 1-д “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжүүлнэ”⁵ мөн хуулийн 2-т “нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг нийслэл, сум дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг хороонд

4 Монгол улсын Үндсэн хууль 57-р тал 1998 он Улаанбаатар хот

5 Монгол улсын Үндсэн хууль 57-р тал 1998 он Улаанбаатар хот

иргэдийн Нийтийн Хурал, тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт түүний Тэргүүлэгчид мөн”¹ гэж тодорхойлсон.

“Нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн өөрөө удирдах байгууллага нь”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурал, Түүний Тэргүүлэгчид” гэсэн тодорхой бүтэц тогтолцоо бүхий байгууллага болов.

Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь өөрөө өөртөө эзэн болох, нутаг дэвсгэрийн эзэн нь болох, өөрсдийнхөө асуудлыг өөрсдөө шийдэж хэрэгжүүлэх тухай ойлголт юм. Монгол улсын Үндсэн хуулиар нутгийн өөрөө удирдах ёсыг тухайн нутаг дэвсгэрийн эрх барих байгууллага болгож иргэдийнхээ нийтлэг эрх ашигт захирагдаж төрийн удирдлагатай зөв хослох, асуудлуудыг гаргаж тавьжээ. Нутгийн өөрөө удирдах ёс нь монголчуудын ажил амьдралаа зохицуулж үе уламжлан авч ирсэн түүхэн харилцаанаас үүдэлтэй юм. Нутгийн өөрөө удирдах ёс нь “айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг” “Цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай хүчтэй” “Бүгдээрээ зөвлөлдвөл буруугүй” гэх зэрэг цэцэн мэргэн олон үгэнд утга санаа нь шингэж уламжилж ирсэн “Төрмөл” шинжтэй юм. Энэ ёс уламжлалыг нутгийн удирдлагын нэг субъект болгож баталгаажуулсанаар Үндсэн хуулийн үзэл баримтлалын нэг санаа илэрч байна. Өөрөө удирдах байгууллага нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мөн. Уг хурал нь Төлөөлөгчөөс бүрэлдэж иргэдийн ашиг сонирхолыг төрийн хууль тогтоомжийн хүрээнд зөв зохицуулж хэрэгжүүлдэг, хянаж шалгадаг, иргэдээсээ асууж дүнэдэг, тэдэндээ үйлчилдэг байгууллага болно. Аймаг сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн мэдлэг чадвар, ажил хэрэгч байдал, үүрэг хариуцлагаа ухамсарлах чадвар, иргэд олон нийттэйгээ “амьд” харилцаа холбоотой ажиллах арга барил нь тухайн шатны Хурлын чадамжийг илтгэнэ. Ийнхүү үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэнийг ИТХ-д Төлөөлөгчөөр сонгож ажиллуулах, өөрсдийгөө бүрэн төлөөлүүлэх, өөрсдийнхөө санал бодлыг байнга илэрхийлүүлж мэдлэг чадвартай ажиллуулах, өөрийн цаг хүчээ бусдын төлөө зориулан тулгамдсан асуудалд анхаарлаа төвлөрүүлэх, иргэн өрх айлд хүрч нөлөөлөх үр өгөөжийг илүү тусгах гэх мэт замаар чадвартай ажиллуулахад иргэд сонгогчид цаг ямагт анхаарч байх ёстой билээ. Эдүгээ “сонгосон” болоод мартдаг гажуудлыг бүрэн өөрчилж өөрсдийгөө идэвх санаачлагатай төлөөлүүлж

ажиллуулахад, иргэд өөрсдөө суралцах хэрэгцээ нэмэгдэж байна. Төлөөлөгч нь сонгогч иргэдийнхээ хүсэл сонирхол, санал бодол, эмзэглэл, бухимдал төрүүлсэн, тулгамдсан асуудал, хоцрогдож доголдсон үйлчилгээ, иргэн хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудал, байгаль орчин, нутаг усаа зөв зохистой ашиглаж хамгаалах хэрэгцээ, ядуурал ажлын байр, орлогын эх үүсвэртэй болгох шаардлага зэрэг нэн чухал асуудлыг иргэдээсээ мэдэрч ИТХ-ын Хуралдаанаар ярилцуулах, хэлэлцүүлэх, үүрэг хүлээдэг. Хэлэлцэж ярилцсан бол тухайн асуудлаар юу хийх, яаж ажиллах, хэн хийх, хэзээ бүрэн шийдэх, ямар хүч хөрөнгө шаардагдах, иргэн Дорж, Дулмаа нарт ямар үр нөлөө, өгөөж буян хүртээх зэрэг тов тодорхой асуултанд хариу өгөх замаар шийдвэр гаргах учиртай. Ардын зохиолч Ш.Сүрэнжав нэгэнтээ хэлснээр Төлөөлөгч нь олон нийтийн тусын тулд иргэдийнхээ ашиг сонирхолын төлөө “Асаж дүрэлзэж, хамтарч” байх хүн мөн. Шийдвэр бол хоцрогдсоныг ахиулах, дутууг гүйцээх, дундуурыг дүүргэх, ажил үйлчилгээ сайжруулах, дутагдал доголдлыг арилгахад чиглэдсэн, ажил хэргийн төлөвлөгөө, үүрэг албан баримт, баталгаа, юм. Шийдвэр бол бодлого юм. Бодлого гэдэг нь иргэдээсээ дахин дахин асууж судлах замаар зорилт зорилгоо зөв тодорхойлж, хүрэх үр дүнг урьдчдан тооцсоны үндсэн дээр хэрэгжүүлж хийх ёстой хөгжлийн бодлого, баримт бичиг, ажил хийх заавар шийд мөн. Аливаа шийдвэр, гарсан зорилго зорилтоо хүн бүртээ хүргэж, сурталчилж нэг мөр ойлгуулах, хэрэгжүүлэх ажлыг сайтар зохион байгуулах, явц үр дүнг тогтмол шалгаж дүгнэх, дахин дахин эрчимжүүлж ярилцах, иргэдээсээ санал асуух замаар дүгнэлт гаргуулах зэрэг тодорхой үе шатлалтайгаар ажиллаж хэвших, технологи бүхий дэс дараалалтай зарчим юм. Өдгөө цагт энэ технологи бүхий зарчим ихээхэн бүдгэрч хуралдах, хэлэлцэх, батлах гэсэн гуравхан дарааллаас хэтрэхгүй болжээ. Үүнээс үүдэн ИТХ-ын байгууллагын нэр хүнд, байр суурь ажил хэрэгч шинж чанар гажуудаж хэлбэрдэж загвардах, оронцоглож хийсвэрлэх, дутагдал түгээмэл гарах болов. Энэ дутагдлыг арилгаж ИТХ-ын байгууллагын үйл ажиллагааг дээшлүүлэхэд Төлөөлөгч нэг бүрийг чадваржуулах асуудал нэн чухал юм. ИТХ бол иргэдээ ээлж дараалалтайгаар өөрөө удирдах ёс, зарчимд сургах нэг ёсны сургууль мөн. Иргэдээ голох, нутгийн захиргааны мэргэшсэн ажилтнуудыг Хуралд сонгуулах тухай ярих нь энэ байгууллагын зарим нэг удирдлагын өөрийнх нь

чадвар санаачлагаас үүдэлтэй. Иргэдийн итгэл найдварыг авсан хэнийгч нутгийн өөрөө удирдах ёс зарчимд сайн сургах, сургалт семинарт дахин дахин оролцуулах, ном гарын авлага, мэдээллээр байнга хангах, сайн зааварлаж Хурлын ажил амьдралд орлцуулж мэдрүүлэх, иргэдийн санал бодлыг судлуулах замаар өөрөө биечлэн хөөцөлдөж ажиллаж сургахад цаг хугацааа, тэсвэр тэвчээр уйгагүй чармайлт шаардагдна. Төлөөлөгч хүнийг ингэж сургаж дадлагажуулахын оронд үл тоох, битүү муулах, зэргээр цөхрүүлж болохгүй. ИТХ-ын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн гэж хуульчилсан заалт байсаар байхад Төлөөлөгчдөө урьдчилж сайтар бэлтгүүлэхгүйгээр хуралдаан хийж оромддог гажуудал мэр сэр байсаар байна. Хуралдааныг хэзээ хийх, ямар асуудал хэлэлцэж, ямар шийдвэр гаргахыг нэг сараас доошгүй хугацааны өмнө Төлөөлөгчиддөө мэдэгдэж яаж бэлтгэх, юу уншиж судлах, орон нутгаас төрж гарсан эрдэмтэн судлаач, албан тушаалтан нартай хэн яаж холбогдож ямар зөвлөмж дэмжлэг авах, Засаг даргын тамгын газраас ямар мэдээлэл лавлагаа авах, аймаг, яам газартай урьдчилж юу ярих, хэн хөөцөлдөх, ямар асуудал шийдвэрлүүлэх гээд бэлтгэл ажлыг бүх шатанд сайн хангаж нэг ёсны “Уяа сойлго” нь таарсан нөхцөлд хуралдаанаа хийж хэвшмээр байна. Хуралдааны бэлтгэл ажлыг хангахад Хурлын хороодод тодорхой чиглэл зөвлөмж, өгч сайн ажиллуулах нь хуралдаанаа ажил хэрэгч болгох, Төлөөлөгчийг сайн бэлтгүүлж идэвхтэй оролцуулах олон талын ач холбогдолтой юм. ИТХ-ын үйл ажиллагааны чанар үр, өгөөж, хүнд хүрэх ач тус, гаргасан шийдвэр тавьсан зорилгоо хөөцөлдөж ажил болгох чадвар нь Төлөөлөгчийн мэдлэг мэргэжил, арга барил дадлага туршлага, ажилсаг чанараас ихээхэн хамаардаг. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүрэг нь Төлөөлөгч Таны сайн мэдэж, зөв ойлгож хэрэгжүүлэх учиртай хуулийн заалт, мөрдөж ажиллах жагсаалт мөн. Тиймээс энэ хуулийн 12 дугаар зүйлийн заалт бүрийг тайлбарлая.

Уг хуулийн 12 дугаар зүйл нь **“Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрх”** гэсэн гарчигтай. Өөрөөр хэлбэл Төлөөлөгч таны эрх, үүрэг, хариуцлагын нэгдлийг “Бүрэн эрх” гэсэн нэрээр илэрхийлж байна.

12 дугаар зүйлийн 1-1-д

“Асуудал хэлэлцэж шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцоно”

гэжээ. Таслах эрх гэдэг өндөр хариуцлага, өргөн ойлголт багтааж байна. Тухайн орон нутгийн хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд Та гар өргөж батлана гэдэг чинь Төлөөлөгч таны таслах эрх болно. Тиймээс ямар ч шийдвэрийг батлахаас өмнө урьдчилан юу хийх, яаж хийх, хэн хийх, хэзээ хийх, ямар хөрөнгө хүчээр шийдвэрлэх, энэ хэрэгжсэнээр иргэнд, хамт олонд ямар үр өгөөж өгөх зэргийг олон талаас нь эрэгцүүлэн бодож судалж байж, “таслах эрх”-ээ эдлэнэ шүү. “Би юун дээр дарчихваа” гэдэг шиг хэнд юунд ямар ашиг тустай шийдвэрийн төлөө гараа өргөв гэдэг чинь өөрөө өндөр хариуцлага, өргөн чадамж, өөрөө үүрч хийх асуудлыг багтаасан асуудал юм.

Шийдвэр батлахад өөрийгөө сайн бэлтгэж тухайн асуудалтай холбоотой мэдээллийг олж унших, иргэд сонгогчдын саналыг тандаж судлах, тэр чиглэлийн мэргэжлийн холбогдох хүмүүстэй уулзаж танин мэдэхүйн мэдээлэл авах, санал солилцож ойлголтоо нэгтгэх зэрэг өргөн цар хүрээтэй бэлтгэлд ажил хийж, өөрийгөө сайн бэлтгэсэний үндсэн дээр “Таслах эрх” ээ хэрэгжүүлэх учиртай. Хуулийн ганц үг ийнхүү өргөн агуулга, их ажил багтаадаг ажгуу. Үүний тулд хуулийнхаа үг утга бүрийг сайтар ойлгож ажиллах нь Төлөөлөгчийн таны чадвар болно.

12-р зүйлийн 1-2-д

“Хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавих, хариулт авах санал дүгнэлт гаргах, санал хураалгах” гэж бий. Энэ заалтанд Төлөөлөгч таны анхаарч өөрийгөө бэлтгэх дөрвөн “Том ажил” байна.

Тухайлбал:

1. Та хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хэнд ямар асуулт тавих вэ, гэдгээ бэлтгэх хэрэгтэй юм. Таны уншиж судалсан мэдээлэл, иргэдийн бодол санал зэргээс үүдэн уг асуудлаар таны тавих асуултууд урган гарах учиртай.

Асуулт нь танин мэдэх, ойлгох шинж чанартай байхын зэрэгцээ, хэлэцэж байгаа асуудлаар холобогдох хүмүүсийн анхаарал төвлөрүүлэх, шийдвэрлэж хийлгэх шаардлагаас үүдэн гарч болох юм.

2. Ямар асуултыг хэнд тавих, ямар түвшин хариулт авах нь мэдлэг, мэдээлэлтэй шууд холбогдоно. Нэг нь асуулт тавьж нөгөө нь хариу өгсөн болж энэ асуудлыг өнгөрүүлж боломгүй. Таны тавьсан асуултанд өгч байгаа хариу нь иргэд сонгогчдод болон тодорхой хүнд таны өгөх хариу болох учиртайг анхаарах хэрэгтэй. Тиймээс төлөөлөгч Та өөрийгөө сайн бэлтгэх хэрэгтэйгээс гадна шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн, дутагдал доголдлыг арилгахад чиглэсэн, ажил хэрэгч хариулт авах, үүний тулд дахин дахин лавлах замаар зөв, үр дүнтэй, шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн байхад чиглэгдэх хэрэгтэй.
3. Хэлэлцэж байгаа асуудлаар санал дүгнэлт гаргах гэдэг нь Таны хэлэх үг, шийдвэрт тулсгуулах асуудал болох ёстой. Тухайн орон нутгийн хэмжээнд нийт иргэдийн анхаарал төвлөрүүлэх дорвитой бүтээлч санал дүгнэлт хэлэх, тодорхой сонгогч иргэний ажил хэрэгч саналыг нэр хаягаар нь уламжилж тайлбарлах, Хуралдааны протоколд тэмдэглүүлэх, гаргах шийдвэрт тусгуулах нь Таны мэдлэг чадвар, бэлтгэл хэрхэн хангасанаас шалтгаална.
4. Тодорхой зарим асуудлаар горимын санал хураалгах замаар шийдвэрт тусгуулахыг хичээх нь Төлөөлөгч таны санал, санаачлагаас хамаарна. Тухайлбал: Сумын хүн эмнэлэгийн ажил үйлчилгээг хэлэлцэж байгаа бол, багийнхаа бага эмчийн ажиллах нөхцлийг сайжруулах, сумын эмнэлэгийн тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх зэрэг чухал асуудлыг онож санал хураалгах, хэрэгтэй. Энэ бол хуралдааны шийдвэрийг сайн болгох тодорхой иргэд хамт олны саналыг тусгуулахад үр өгөөжтэй юм. Энэ заалт нь бүхэлдээ Төлөөлөгч таны бэлтгэлээ базаах, өөрийгөө бэлтгэх, сонгогч иргэдээсээ санал судлах олон ажлыг сайн хийсэний үр дүн болдог.

12 дугаа зүйлийн 1-ийн 3-т

“Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах”

ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг сонгож төлөвлөхөд Төлөөлөгч Таны санал чухал. Та иргэд, сонгогчдоосоо сайн асууж тэднийхээ хүсэл сонирхолыг судалж чадсан бол зайлшгүй хэлэлцэж шийдвэрлэх үй түмэн том жижиг асуудал бий. Үүнийгээ зөв сонгох, хэлэлцэж шийдвэрлэх үндэслэл, нотолгоо баримтыг сайн гаргаж тавих нь чухал юм. Энэ заалтанд санаачлах, санал оруулах гэсэн хоёр асуудал байна. Санаачлах гэдэг бол аль шатны хурлаар ямар асуудал оруулах, юуг шийдвэрлүүлэх зэргийг сайн бодож судалгаа нотолгоо баримт жишээ хуулийн заалт зэргээ гаргаж албан ёсоор хандахыг хэлнэ. Харин санал оруулах гэдэг нь тодорхой иргэд, хамт олноос тавьсан саналыг үндэслэх буюу өөрөө санаачлан зайлшгүй хэлэлцүүлэх асуудлаар саналаа гаргахыг хэлнэ. Төлөөлөгч таны гаргасан саналыг Хурлын дарга судалж үзээд төлөвлөгөөнд тусгаж холбогдох бэлтгэлийг хангах үе шаттай аажлуудыг хийж хуралдаанаар хэлэлцүүлнэ. Санаачлага, санал гаргасан Төлөөлөгч уг асуудлаа хэлэлцүүлж нэг ч гэсэн тодорхой зүйлийг шийдвэрлүүлэхэд анхаарвал зохино. Үүний тулд бусад Төлөөлөгч, холбогдох мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж багагүй чармайлт гаргах учиртай. Хуралдаанд асуудал оруулах нэг субъект нь Хурлын Төлөөлөгч гэдгийг энэ хуулийн 24 дүгээр зүйлд тодорхой заасан байна. Тэгэхээр Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зөв сонгох, сайн бэлтгэх, Төлөөлөгч иргэн, хамт олны оролцоонд тулгуурлах замаар оновчтой зөв шийдлийг олох нь Төлөөлөгч хүний хуулиар хүлээсэн, сонгогч иргэдээс авсан үүрэг мөн.

12 дугаар зүйлийн 1-ийн 4-т

“Хурлын дарга Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Тэргүүлэгчийг сонгох, хороо байгуулах, тэдгээрт сонгогдох, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах тухай санал дүгнэлт гаргах”

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлийн 9-д сонгох сонгогдох эрх, эрх чөлөөг иргэний нэг чухал эрх болгож баталгаажуулсан билээ. Уг эрхийг зоригтой хэрэгжүүлж

Төлөөлөгчийн хувьд өөрийгөө нэр дэвшүүлэх, “ачааны хүндийг өөрөө үүрнэ” гэсэн өөрөө удирдах ёсны зарчмын дагуу үүрэг хүлээх, ажил хариуцах, орон нутаг, иргэдийнхээ төлөө хийж бүтээх зориг эрмэлзлэл дүүрэн хандах цаг болсон байна.

ИТХ-д Төлөөлөгчөөр сонгогдсон хүн сонгуульт тэр байгууллагынхаа дотоод зохион байгуулалтын бүтцэнд идэвхтэй оролцож, чанартай ажиллах нь тухайн хурлынхаа төлөө буюу нийт иргэдийнхээ төлөө зориг зүтгэл гаргаж байгаа хэрэг болно.

Нөгөө талаар нэрийг нь дэвшүүлсэн хамт олон ч, сонгосон сонгогчид тань хир чадвартай, санаачлагатай, мэдлэгтэй, нэр хүндтэй хүн бэ гэдэгт анхаарал төвлөрүүлж байгааг анхаарах хэрэгтэй. Энэ заалтанд өөрөө сонгогдох, бусдыг сонгох хоёр талын цогц асуудал багтаж байна.

12 дугаар зүйлийн 1-ийн 5-д

“Хурлаас байгуулсан байгууллага сонгосон буюу томилосон албан тушаалтны илтгэл сонсгол хэлэлцүүлэх санал гаргах”

Төлөөлөгч хүн сум, орон нутгийнхаа иргэдийг төлөөлж байгаагийн хувьд иргэдэд хүрэх ёстой үйлчилгээний чанар, хүртээмж, чирэгдэл доголдол, нутгийн захиргааны байгууллагаас иргэдийн санал хүсэлт гомдлыг шийдвэрлэж хариу мэдээлэл өгөх, төсөвт байгууллагаас хариуцсан үүрэг, иргэдэд үйлчлэх үйлчилгээгээ хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, тэдгээрийн дарга эрхлэгчдийн илтгэл сонсголыг Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаан, хорооны хурлаар хэлэлцүүлэх зэргээр санал санаачлага гаргаж ажиллах эрх үүргийг Танд өгсөн байна. Сургууль, эмнэлэг, соёл, Засаг даргын Тамгын газар зэрэг ард олны татварын мөнгөөр санхүүжиж иргэдэд үйлчлэх үүрэг хүлээсэн хүмүүсийн ажил үйлчилгээг сайжруулахад энэ заалтыг ашиглах нь чухал. Тухайн орон нутгийнхаа тулгамдсан асуудал, иргэд олон нийтийг хохироосон чирэгдүүлж байгаа асуудлыг сонгож тавих, нийтэд нэмэр нөөлөг болох, үр өгөөж үзүүлэх талаар илүү анхаарвал зохино. Энэ нь таны сонгуульт үүргээ нэр төртэй биелүүлж иргэд, сонгогчдоос итгэж хүлээлгэсэн итгэл найдварыг санаачлагатай хэрэгжүүлэх нэг арга болно. Энэ

заалтыг өргөн утгаар нь ойлгож хэрэгжүүлж сэдэж санаачилж гүйцэтгэх нь нутгийн өөрөө удирдах бйагууллагын байр суурь, нэр хүндийг дээшлүүлэх, иргэд сонгогчдынхоо захиа даалгаварыг биелүүлэх гол нөхцөл юм.

12 дугаар зүйлийн 1-ийн 6-д

“Хууль тогтоомж, хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах”

Гаргасан шийдвэр, тавьсан зорилтоо ажил хэрэг болгоход, хүн бүрийн хүчин зүтгэлийг төвлөрүүлэх олны хүчийг нэгтгэн зохицуулах, үр өгөөжийг дээшлүүлэх олон талын ач тустай чухал ажил юм. Шийдвэр гаргахын өмнө иргэдээс авсан саналаас хэний ямар санал хэрхэн тусгаж чадсанаа сайн тооцолж бодвол зохино. Иргэд сонгогчид танд янз бүрийн асуудлаар санал хүсэлт гаргаж байдаг. Ялангуяа хуралдааны өмнө хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төслийг иргэд, хамт олноор урьдчилан хэлэлцүүлж авсан саналыг нэг бүрчлэн анхааралтай судалж, шийдвэрт тусгаж байх нь чухал юм. Иргэдийн гаргасан санал бүрийн мөрөөр хийсэн ажил, шийдвэрлэсэн байдлыг тухайн иргэнд хариу мэдээлэл өгч Төлөөлөгч, сонгогчдын “амьд” бодитой харилцааг өөрчилж сайжруулах хэрэгтэй юм. Хуралдааны шийдвэр бол тодорхой нэг асуудлыг өөрчлөх, сайжруулах, ахиулах замаар хэрэгжүүлэх нэг ёсны бодлого юм. Бодлого, шийдвэрээ иргэдэд хүргэж ойлгуулах, сайн тайлбарлан таниулснаар уг шийдвэрийг бодитой ажил хэрэг болгоно. Шийдвэр гаргаад “далд хийчихдэг”, “мартдаг” буруу асуудлыг өөрчлөх нь ИТХ-ын байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, иргэд олон нийттэйгээ ойртож нягтрах олон талын ач тустайг анхаарч шинэчилж өөрчлөх, шийдэмгий ажиллах хэрэгтэй юм. Ховд аймгийн Үенч сумын ИТХ, өөрийн гаргасан шийдвэр, дүрэм, журам, иргэдийн гаргасан санал хүсэлтийн мөрөөр хийсэн ажлыг нэгтгэн тусгай хавтас болгон айл, өрх, баг, албан байгууллагаар аялуулж бодлого шийдвэрээ сурталчилдаг байна. Хүнд хууль тогтоомж, бодлого шийдвэрээ сурталчлан таниулахын тулд Та өөрөө сайн бэлтгэх, хууль тогтоомжоо мэдсэн байх нь чухал. Шийдвэрийнхээ утга санаа, зорилго чиглэлийг иргэдэд сайн таниулж түүнийг хэрэгжүүлэхэд ямар үүрэгтэй оролцох, юу хийх биелэлт үр дүнг хэдийд хянах, яаж

шалгах зэрэг иргэдийн оролцооны асуудлыг ягштал ойлгуулах нь шийдвэр хэрэгжих томоохон ажил болно. Ер нь иргэн хүн Төлөөлөгчтэйгөө нягт хамтран ажилласанаар үр дүнд хүрнэ. Мөн аймаг, УИХ-аар хэлэлцэж байгаа асуудал, хуулиудын талаар мэдээлэл авч батлагдахаас нь өмнө иргэдийнхээ өмнөөс тодорхой саналаа уламжилж тусгуулахад ч анхаарвал зохино.

12- дугаар зүйлийн 7-д

“Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах”

Энэ заалт бол Төлөөлөгч хүний сонгогчдынхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлж нутаг орны хэмжээний тулгамдсан иргэдийг хохироож байгаа, гол гол асуудлыг олж “АСУУЛГА” тавих нь ажил сайжруулах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг өөрчилж шинэчлэх чухал үүрэг юм. Энэ заалт нь төлөөлөгч нараас шийдвэрийнхээ биелэлт болон иргэдийн санал гомдлын мөрөөр хийх ажлыг хангуулах хяналтын нэг хэлбэр мөн. Гаргасан шийдвэр, тавьсан зорилт аль нэг албан тушаалтны хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэн тасрах, доголдох, түүнээс болж иргэд хохирох дутагдал газар сайгүй гардаг. Аль нэг ажлыг сайжруулах, дутагдал доголдлыг арилгах, иргэдийнхээ хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахын тулд хуралдаж хэлэлцэж шийдвэр гаргадаг учиртай. Иргэд хохирсон, гомдож чирэгдсэн, тийм нийтлэг дутагдлыг соргогоор мэдэрч, удирдах албан тушаалтанд нь “Асуулга” тавьж хариу мэдээллийг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгч иргэдээ сайн оролцуулж нийтэд өргөн мэдээлж ажиллах нь ИТХ-ын байгууллагын үйл ажиллагааг хүн рүү чиглүүлэх, байр суурыг дээшлүүлэх, чухал асуудал болно. Гэхдээ асуулга нь асуулт биш шүү.

Уг хуулийн заалтанд дурьдсан:

- a) Хууль тогтоомж, хурлын шийдвэр биелэхгүй байх.
- b) Иргэдийг хохироосон чирэгдүүлсэн, тэдний нийтлэг эрх ашгийг зөрчсөн.
- c) Тулгамдсан, доголдсон, иргэд эмзэглэсэн хурц чухал асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор.

Асуулга тавина.

Асуулгыг тухайн шатны

- o Засаг дарга
- o Түүний орлогч
- o Засаг даргын тамгын газар
- o Засаг даргын дэрэгдэх газар хэлтэс албадын дарга
- o Нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад тавина.

Асуулгыг Төлөөлөгч дангаараа буюу хэд хэдээрээ нийлж тавихаас гадна хороогоороо нэгтгэж тавьж болно. Юуны өмнө тавих асуулгаа сайн судалж онох, нотолгоо дутагдал, доголдлын талаар нотлох баримт, иргэд сонгогчдын санал бодлыг сайн тусгах нь зүйтэй. Төлөөлөгчдөөс асуулга тавих үед Хурлын дарга, нарийн бичгийн дарга нар мэдрэмжтэй хандаж уг асуулгын мөн чанар, хандлага ач холбогдлыг тодорхой болгож Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж хэнд тавих, хэзээ биелүүлэх, дүнг яаж хэлэлцэх, хурлын ямар хороо хяналт тавихыг зааж Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэж, тогтоол гаргана. Төлөөлөгчийн асуулга, Тэргүүлэгчдийн тогтоол, Хурлын даргын гарын үсэг бүхий албан бичиг зэргийг бэлтгэж асуулга тавих албан тушаалтанд гардуулж өгнө. Гардуулахдаа анхаарах асуудал, шийдвэрлэх зорилт, үр өгөөжийн талаар сайтар таниулж өгөх хэрэгтэй. Асуулгын мөрөөр хэрхэн ажиллаж байгааг Хурлын хороо, Төлөөлөгчдөөс хяналт тавьж, иргэдээс санал асуух замаар үнэлэлт дүгнэлт гаргуулна. Асуулгын мөрөөр хийсэн ажлын дүн мэдээллийг ИТХ-ын хуралдаанаар болон Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгч цаашид анхаарч хэрэгжүүлэх зорилтоо тодорхойлсон шийдвэр гаргана.

Хуралдаанаар хэлэлцүүлэх үед уг албан тушаалтны мэдээллийг сонсож Хурлын холбогдох хороодын санал

дүгнэлтийг хэлүүлнэ. Асуулга тавьсан Төлөөлөгч өөрийн санал дүгнэлтээ хэлнэ. Энэхүү хуралдаанд холбогдох хүмүүс, иргэдийн төлөөллийг аль болох өргөн хүрээтэй оролцуулж тэдний санал хүсэлтийг ч сонсох нь чухал юм. Ийнхүү асуулга бол шийдвэрлэх цар хүрээ, иргэдэд хүрэх үр өгөөж, дутагдал гомдлыг арилгах ач холбогдлоороо ИТХ-ын томоохон ажлын нэг, хяналт шалгалтын чухал хэлбэр болно. Асуулгын мөрөөр цаашид хийх ажлыг хэвшил болгон үргэлжлүүлж уг дутагдлыг дахин хөндөгдөж гаргахгүйгээр болтол нь нэг мөр шийдвэрлэхийн төлөө анхаарах хэрэгтэй. Энэ нь уг хуулийн заалтын мөн чанар болно.

12 дугаар зүйлийн 1-ийн 8-д

“Хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуй нэгж байгууллагад тэдгээрийн харъяалал, өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах шаардлага тавьж биелэлтийг хангуулах” гэжээ.

Мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 1-д

“Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр, тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан иргэд заавал биелүүлнэ” гэж заасан байгаа.

12 дугаар зүйлийн 1-ийн 8-д заасан Төлөөлөгч танд оногдуулсан чиг үүрэг нь энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 1-ээр ийнхүү баталгаажсан байна. Биелүүлэх ёстой, дагаж мөрдөх учиртай шийдвэрийнхээ биелэлтийг Та асуух шалгах, үзэж танилцах, эрхтэй байх нь

Энэхүү хуулийн заалтаар харъяалал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр шалгах, биелэлтийг хангуулах учиртай юм.

Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажсан ИТХ-ын шийдвэр нь тухайн нутаг дэвсгэрийн Төрийн хууль тогтоомжийн нэг адил хэрэгжих үндэслэлтэй байна. Таны хэлэлцэж ярилцаж “Гар өргөн” баталсан шийдвэр ажил хэрэг болж үр нөлөөгөө үзүүлж байх учиртай. Үүний тулд та шалгах, асууж танилцах, шаардах чиг үүрийг хуулиар авчээ. Гэхдээ байгууллагын

дотоод ажилд хэт хутгалдан орох, элдэв “Шантааж” үзүүлж болохгүйг анхаарах ёстой.

12 дугаар зүйлийн 1-ийн 9-т

“Сонгогчтойгоо тогтмол холбоотой ажиллаж тэднээс тавьсан өргөдөл, санал гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах” гэжээ.

Иргэд сонгогчид Танаар уламжлан ажил амьдралынхаа эмзэг, бэрхшээлтэй, чирэгдэж хохирсон гомдол, санал хүсэлтээ тавьж шийдвэрлүүлэх эрхтэй. Мөн орон нутгийнхаа хэмжээний томоохон асуудлаар, эсвэл тодорхой албан тушаалтны талаарч гомдол гаргаж болно. Төлөөлөгч Та иргэнээс тавьж байгаа асуудлыг анхааралтай сонсож, лавшруулж судалж өөрийн гэсэн ойлголт мэдээлэлтэй болох хэрэгтэй. Үүний дараа уг асуудлыг хаана хэнд хандахаа тодорхойлно. Иргэнээс тавьсан санал, гомдол, хүсэлтийн цар хүрээ шийдвэрлэх боломж, зэргийг судлан үзэж өөрөө шууд хандаж, эсвэл Хурлынхаа дарга, нарийн бичгийн даргадаа уламжилж тэднээс холбогдох хүмүүст албан бичгээр өгч болно. Иргэний өргөдөл гомдол саналыг хүлээж авах, шийдвэрлэх, хариу өгөх асуудлыг зохицуулсан хууль бий. Уг хуулийн дагуу Таны уламжилсан саналыг хүлээж аваад шийдвэрлэх цар хүрээгээр нь хэдэн хоногийн дотор шийдвэрлэх хариу өгөх хуулийн хугацааг мэдэж хандах хэрэгтэй. Уламжилсан санал гомдол хүсэлтийн мөрөөр хийж байгаа ажилд хяналт тавих өөрөө шаардах, хурлын удирдлагаас шаардуулах зэргээр иргэн хүний тавьсан санал хүсэлтийг шийдвэрлүүлэхийн төлөө “Та явах, хөөцөлдөх” үүрэг хүлээнэ.

Иргэдээс тавьсан санал хүсэлт гомдлыг бүрэн шийдвэрлүүлэх, өөрөөр хэлбэл хүсэл гомдол гаргасан иргэн хүн тэр хариунд сэтгэл ханамжийн зохих мэдрэмж авсан байхад оршино.

Өдгөө хариу өгсөн “дүр” эсгэх, анхаарна, хийнэ, судална гэсэн бөөрөнхий үгтэй хариу өгдөг аргаас аль болох зайлсхийх хэрэгтэй.

Энэ нь тухайн иргэнд тийм сэтгэгдэл төрүүлэх төдийгүй танд сонгогчдоос өгөх үнэлгээ тааруу болоход нөлөөлнө.

Иргэн хүнээс сонгогдсон Төлөөлөгч Та иргэнийхээ төлөө мятрашгүй зүтгэх, цуцашгүй тэвчээртэй хөөцөлдөж, цаг хүчээ зориулах үүрэгтэй. Тийм болохоор хүний санал хүсэлтэд гоомой хандах, хөнгөн хялбар ажиллах ёсгүй.

Төлөөлөгч Таны Хуралдаан дээр хэлэх үгэнд, тавих асуултанд энэ асуудал хөндөгдөж байх ёстой.

Төлөөлөгч танд шууд хамаарах нэг хуулийн ганцхан зүйл заалтаар хүлээсэн чиг үүргийг товч тайлбарлав.

Эдгээр үүргийг сайн ойлгож хэрэгжүүлэх цаашид улам боловсронгуй болгох хэрэгцээ улам өсөж байна.

ИТХ-ын Төлөөлөгчдөд тавигдах шаардлага хэрэгжүүлэх чиг үүрэг, хариуцах ажил харъяалах алба ажил улам нэмэгдэж байна. Үүнд:

Нэгдүгээрт

Төлөөлөгчөөр нэр дэвших хүнд тавигдах үнэлгээ, өгөх үүрэг, баримтлах зарчим, харгалзах үзүүлэлтийг улам боловсронгуй болгох хэрэгцээ гарч байна.

Юуны учир ямар хүн иргэдийг төлөөлж болох талаас нь ихээхэн анхаарах хэрэгтэй болжээ. Энэ нь сонгогч иргэдийн зүгээс анхаарах асуудал болно.

Нэрээ дэвшүүлдэг иргэн ч, улс төрийн нам ч, хамт олон нь ч хэнийг, юуны учир, яагаад дэвшүүлэх болсоноо урьдчилан сайн судалж нягтлах, сайн ойлголцох үүрэг зорилгыг нь мэдүүлэх шаардлагатай.

Хууль тогтоох дээд байгууллага, Улсын Их Хурал засгийн болон орон нутгийн эрхийг олж авах, намуудын ганц ашиг сонирхолд хэт хөтлөгдөж, нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн зарчмыг алдагдуулж байгааг нуух хэрэггүй.

Нутгийн өөрөө удирдах байгууллагад иргэд нь өөрсдөө нэрээ дэвшүүлж өөрсдийгөө төлөөлөх хүнээ өөрөө сонгох Үндсэн хуулийн үзэл баримтлалыг 1996 оноос эхлэн гажуудуулсаар байна. Улс төрийн намаас нэр дэвшүүлэх, 2012 оноос эхлэн намын жасгсаалтаар сонгодог сонгуулийн хууль

баталсан нь чухамдаа ИТХ-ын байгууллагыг улс төржүүлж, орон нутгийнхаа төлөө нэгэн зорилгоор идэвхтэй ажиллуулахын оронд, хагаралдуулах, өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг гажуудуулахад хүргэв.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийтийн хурал, Тэргүүлэгчид (Үндсэн хуулийн 59-р зүйлийн 2) Хороо, Түр хороо (ЗЗНДН түүний удирдлагын тухай хуулийн 21-р зүйл) гэсэн бүтэц тогтолцоог хуульчилсаар байтал намын бүлэг гэдэг сүрхий лут бүтэц бий болж өөрөө удирдах байгууллагыг иргэд нь Төлөөлөгч нь биш улс төрийн нам удирддаг болов.

Энэ гажуудлыг нэн даруй өөрчлөхгүй бол иргэдийн бие даасан бүтээлч санаачлага, идэвхтэй хандлага, иргэний нэр төдий оролцооноос болж өөрөө удирдах ёс уламжлалыг боомилсоор байна. Улс төрийн намын тухай, Сонгуулийн тухай хуулиудад энэ гажуудлыг нэг мөр ойлгож өөрчлөхгүй бол монгол хүний эв нэгдэл, хамтач зорилго, үе дамжсан нөхөрсөг уламжлал, “Цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай хүчтэй” мэргэн сургаал мартагдаж үгүй болох нь байна. Сумын Засаг дарга нь олон суудал авсан намын дарга болж байгаа нь Хурал Засаг даргын харилцаанд сөрөг үзэгдлийг бий болгож байгаа тул сумын хоёр даргыг улс төрийн намаас хол байлгамаар байна. Орон нутгийг улс төрийн намын нөлөөгүйгээр ажиллуулахгүй бол сумаараа, ИТХ нь, Төрийн бус байгууллага нь төрөл төрөгсөд, гэр бүл ч хагаралдаж хөгжлийн замд ч, аюулгүй байдалд ч сөрөг нөлөө үзүүлэхийг үгүйсгэх аргагүй боллоо.

Хоёрдугаарт

ИТХ-ын төлөөлөгч хүн бусдынхаа төлөө зүтгэх, бодлого тодорхойлох, санал санаачлага гаргах зэргээр иргэдийн төлөө оюун ухаан, мэдлэг чадвар цаг хүчээ зориулах үүрэг хариуцлага хүлээж байна. Эдүгээ манай улс чөлөөт зах зээлийн нийгэмд шилжиж байгаа атал Төлөөлөгч хүнийг “зардал”-гүй зүтгүүлэх гээд байдаг боллоо.

“Хөдөлбөл хөлс, зогсвол зоос” гэдэг үг чинь өдгөө цагийн зарчим биш үү. Бага цалин эсвэл хөлсгүйгээр хүнийг ажиллуулах гэдэг чинь үеэ өнгөрөөсөн асуудал шүү дээ. ИТХ-ын төлөөлөгчийг зөв сонгох, өндөр шаардлагатай ажиллуулах,

иргэд сонгогчдын дунд сайн явуулах хэрэгцээ бий. Тэр үүргээ биелүүлэх боломжийг нь санхүүгийн хувьд бүрдүүлж өгөх талаар төр засгийн зүгээс анхаарах цаг болжээ. Ингэж эс шийдвэл аппаратын хүчинд дулдуйдаж түүний тооны хойноос хөөцөлдөхөд хүргэж байна.

Өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах Үндсэн хуулийн зарчим үндсэндээ алдагдаад байна. Төр, Засаг дарга нараа баг хороо хүртэл түвшинд сайн анхаарч санхүүгийн боломжоор хангадаг болов. Өөрөө удирдах ёс төрийн удирдлагын хослол нь “Тунгалаг тамир” киноны Итгэлт баян, Эрдэнэ нарын орон гэр, эд хөрөнгийн байдал, харилцааны хэлбэртэй зүйрлэхээр болов.

Энэ гажуудлыг өөрчилж Хурлын Төлөөлөгчийн чиг үүрэг, хэрэгжүүлэх ажлыг тодорхой болгож хийсэн ажил, гаргасан үр дүнгээр нь урамшуулах эсвэл иргэдийн төлөө хөөцөлдөж бүтээсэн ажилд зарцуулсан цагаар нь үнэлдэг системд шилжих цаг болов.

Үндсэн Хуулийн “Хослуулах” зарчим алдагдаад байгаа нэг баримт бол засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 6-д “баг” хорооны хурлын даргад тухайн шатны Засаг даргын сарын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал сар дутам олгоно” гэж Төрийн удирдлагатай “Хослуулах” зарчмыг манай хууль тогтоогчид тогтоосноор илэрч байна. “Хүний алагаас адууны алаг дээр” гэсэн үг бий. Өөрөө удирдах ёсоо ийнхүү “алаг” үздэг байдлыг зогсоох цаг болов. Нутгийн өөрөө удирдах байгууллагад төр засгаас хандаж байгаа өдий төдий дутагдал гажуудлаас ганц хоёрхон баримт дурдлаа. Үүнээс үүдэн Хурал нь ч, Төлөөлөгч нь ч жинхэнэ утгаараа ажиллаж чадахгүй байна. “Хурал төсөвтэй байна” гэж хуульчилсан ч Засгийн газар, аймгаас үлдэгдлийн зарчмаар хувиарлагдсан хамгийн бага хувь оногдож байгааг өөрчлөх ёстой. Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байгаа бол хөгжлийн төвд хүнээ үнэнхүү тавьж байгаа бол, ардчлал, хүний эрхийг дээдэлж байгаа бол нутгийн өөрөө удирдах байгууллагаа Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу дэмжмээр, хөгжүүлмээр бэхжүүлмээр байна.

ИТХ хэрэггүй гэсэн “Хий үзэгдэл” газар авсаар л байна. Өөрөө удирдах ёсыг үе үеийн “Засаг Төрийнхөн боомилсоор

ялгаварласаар” нэг мөр “дарж” авахыг үгүйсгэх аргагүй. Ардчлалын нэг хэлбэр нь орон нутагт иймэрхүү төлөв, байдалтай хөгжиж байна.

Гуравдугаарт.

Сум бол нутгийн өөрөө удирдах ёс төлөвшиж хөгжих үндсэн өлгий гэж Бираагийн Чимид гуай нэг бус удаа тэмдэглэсэн. Өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь төлөвшүүлж Төлөөлөгчдийг сонгогдсон дөрвөн жилд нь зорилго чиглэлтэй, байнга тасралтгүй сургаж чадваржуулах цаг болов. Энэ нь төр засгийн бодлого чиглэл, дэмжлэгийн үр дүнд хэрэгжинэ.

Ингэвэл иргэн хүн, Төлөөлөгч хөгжлийг хөдөлгөгч хүч болно. Чадвартай Төлөөлөгч санаачлагатай ажиллана. Санаачлагатай, мэдлэг, туршлагатай, мэдрэмжтэй Төлөөлөгчөөс өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд үр өгөөж шалтгаална. Сум, дүүргийг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалын дагуу эдийн засаг, төсөв, санхүү, хүний нөөц, газар, байгаль орчноо өөрсдөө мэддэг, өөрсдөө хариуцдаг, өөрсдөө хянаж зохицуулдаг биеэ даасан нэгж болох цаг болжээ. Боловсрол, эрүүл мэнд, соёл, халамж зэрэг нийгмийн бүх төрлийн үйлчилгээг тухайн нэгжид нь, иргэнд нь мэдүүлж ажил үйл үйлчилгээгээ хэрхэн яаж чанаржуулахаа мэддэг болгомоор байна. Өмч хөрөнгө, төсөв, санхүү, хүний асуудлыг төрийн яамд тал талаас нь чангааж суудаг хуучин аргаа өөрчилж хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтаа төлөвлөж зохицуулж хэвшмээр байна.

Дөрөвдүгээрт

ИТХ-ын Төлөөлөгчийг сайн сонгож, өндөр шаардлагатай ажиллуулахад, үйл ажиллагааг нь дэмжиж үнэлж дүгнэхээс эхэлмээр байна. Тодорхой үзүүлэлтээр, хуульд заасан бүрэн эрхийн заалтуудын дагуу үнэлж дүгнэж үүргээ биелүүлж байгааг нь урамшуулах, сул ажиллаж байгааг нь чөлөөлөх, огцруулах хүртэл арга хэмжээ авдаг зарчмыг хуулинд суулгаж өгөх цаг болжээ. Учир нь сүр бадруулж сонгогдоод Хурал-аа тоодоггүй мартдаг, сонгогчдоо умартдаг, сонгуульт үүргээ хаядаг Төлөөлөгчид олшрох хандлагатай байна. 3000 хүртэлх хүн амтай сумын сонгуулийг нэг тойрог болгон сонгуулийг явуулж Төлөөлөгчийн тогтоосон тооны дараагийн хүн хуралд

орж ирдэг боломжийг хуульчлах хэрэгтэй юм. Тойрог болсон ч адил тогтоосон мандатын дарааллаар орж болно. Хуралд ёс зүйн хороог байгуулж ажиллуулах хэрэгтэй юм. Ёс зүйн хороо нь Төлөөлөгчийн хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн биелүүлж байгааг дүгнэдэг, сул, хангалтгүй нөхдөд хуралдааны үед сануулга өгөх улмаар огцруулах санал оруулж ирдэг байх нь Төлөөлөгчийн үүргээ биелүүлэх, хариуцлагыг жигд дээшлүүлэх олон талын ач холбогдолтой болно. Хариуцлага санаачлагыг өндөржүүлэх шаардлыг Төлөөлөгчөөс эхлэх цаг болов. Энэ асуудлыг сонгуулийн хуулиас нь эхлэн тусгаж өгөх хэрэгтэй байна. Ер нь Төлөөлөгч хүний манлайлах чадвар, өөрийн гэсэн “Имидж”-ийг төлөвшүүлж бий болгомоор байна. Ялангуяа сонгогч иргэдийн зүгээс тавих хяналт, шаардлагыг жигд өндөржүүлэх, үүний тулд иргэдээ сургаж бэлтгэхэд ихээхэн цаг, хүч зарцуулах шаардлага өгчээ.

Тавдугаарт

Монгол улсын Үндсэн хуулинд заасан шууд ардчлалыг Төлөөллийн ардчлалтай зөв хослуулах замаар нийт иргэдийнхээ улс төрийн ухамсар, чадварлаг санаачлага, бүтээлч хандлагыг өөрчлөх цаг боллоо. Сумын ИТХ-ын цөөн тооны Төлөөлөгчөө ийм зарчмаар ажиллуулж үүгээр дамжуулан иргэдийн оролцооны асуудлыг өрнүүлж дадлагажуулах шаардлага тулгарч байна. Мэдлэгтэй, чадвартай иргэн төр нийгмийн ажилд идэвхтэй оролцоно. Энэ оролцоо төлөвшиж хөгжихгүй байгаа нэг үндэс нь бүх шатны сонгууль билээ.

Сонгуулийн оролцоо, түүний үр дүнгээр иргэдийн оролцоо чадварыг дүгнэж болно. Сумын хэдэн удаагийн бүх шатны сонгуулийн ирц жил бүр буурч, сонгогчдын оролцооны идэвх дээшилж байна. Иргэдээ сургаж хөгжүүлэх, нийгмийн ажил амьдралд санаачлагатай хандах, өөрийнхөө төлөө нөхдийнхөө эрх ашгийн тулд иргэн бүрийг идэвхтэй оролцуулж сургахад төр засаг нь ч орон нутгийн бүх шатны байгууллагын дарга нар анхаарах хэрэгтэй болжээ. Төр засгийн эрх мэдэл, ард түмний гарт байгаа бол иргэдээ сургах, идэвхжүүлэх, тодорхой зорилгод нэгтгэх замаар төр, иргэний холбоог ойртуулах, нэр хүндийг нь дээшлүүлэх шаардлагатай байна.

Ер нь дуугүй томоотой байх, даргын хэлсэн үг, үүрэг даалгаврыг хүлцэнгүй хүлээн авах, хяналт шаардлагагүй

“даруухан амьдрах” тийм хуучны уламжлалдаа бат итгэсээр, түүнийг өөрчилөхөөс татгалздаг улс төрчид байгаа юм биш үү.

Шинэ хуучны зөрчил байгаа ч хуучин нь амь бөхтэй оршиж байна. Иргэдийн идэвхтэй оролцоо үгүйлэгдэж байгааг өөрчлөх, шинэчлэх, энэ талаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн дэвшүүлээд байгаа зорилтыг амьдралын хөрсөн дээр нь буулгах хууль эрх зүйн өөрчлөлт хийх, хэт туйлшрахаас болгоомжлох шаардлага байсаар байна. Энэ нь ИТХ-ын ажлыг чанаржуулахаас Төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэхээс, мэдлэг чадвартай, ажил хэрэгч оролцуулахаас шууд шалтгаална. ИТХ бол иргэдийг сургадаг нэг ёсны сургууль байх учиртай.

Өөрөө удирдах ёс нь хүний ажил амьдрал, өв заншилаас урган гарсан “төрмөл” уламжлал.

Энэхүү төрмөл, заяамал уламжлалаа Үндсэн Хуулынхаа үзэл баримтлалын дагуу хөгжүүлэх нь төр засаг, бүх шатны ИТХ-ын сонгуультай, иргэн бүрийн үндсэн үүрэг мөн.



ШААРИЙБУУГИЙН ГАНБАТ

Орхон аймгийн ИТХ-ын тэргүүлэгч
философич, философи-социологийн багш мэргэжилтэй
Удирдлагын академийн докторант

НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГА БА ИННОВАЦИ

Оршил

Манай улс 1992 оны шинэ үндсэн хуулиараа ардчилал иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулан, монголын төрийн тогтолцоог /гол нь эрх мэдлийн хуваарилалт/ өөрчилсөн юм. Шинэ үндсэн хуулиар нутгийн удирдлагын тогтолцоо шинэчлэгдэн нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлэх тухай зааснаар төрийн төвлөрсөн удирдлагыг “халж” нутгийн өөрөө удирдах байгууллагууд /Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Иргэдийн нийтийн хурал/ байгуулагдсан билээ. Өдгөө 2000 гаруй нутгийн өөрөө удирдах байгууллага ажиллаж иргэдийн өөрсдийнх нь хүсэл зориг, үйлдэл үйл ажиллагаа хэрэгжиж байна. Харин нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудыг иргэдийн эрх, эрх чөлөө, жам ёсны эрхийг хангах үүрэг бүхий институци талаас нь харвал

ихээхэн учир дутагдалтай байгаа болно. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд /НӨУБ/ нь үндсэн хуулийн статус бүхий байгууллага болсон хэдий ч бидний бодлоор 2 үндсэн шалтгаанаар хангалтгүй ажиллаж байгаа юм. Үүнд:

Нэгдүгээрт: Төрийн эрх бүхий байгууллагууд төвлөрлийг сааруулахад ихээхэн хойрго хандаж ирсэн нь нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд саад чөдөр тушаа болсон. Орон нутгийн төсвийн хэмжээ улсын төсвийн 10%-д хүрэхгүй байгааг дурьдахад л хангалттай. Тэр ч байтугай нэлээд хэдэн жилийн турш төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулиар төсвийн эрх мэдлийг Засгийн газар өөртөө авч төвлөрлийг сааруулж орон нутгийн бие дааж идэвхитэй ажиллах нөхцөлийг хааж ирсэн.

Хоёрдугаарт: НӨУБ-уудын чадамж сул, хуулиар олгосон үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлдэггүйтэй холбоотой юм. Энэ талаар УИХ-ын түвшинээс эхлээд иргэд хүртэл байр суурь, үзэл бодлоо илэрхийлдэг.

Энэ байдал нь хэргийн учир дээрээ ч, доороо ч байгаа гэсэн логик дүгнэлт хийхэд хүргэнэ.

Эл өгүүллийг бичигч миний бие НӨУБ-ууд үндсэн хуулиар баталгаажсан интитуцийн хувьд өөрсдөө өөрчлөгдөн шинэчлэгдэх нь төвлөрлийг сааруулаад зогсохгүй, нутгийн өөрийн удирдлагыг сайжруулах гол нөхцөл мөн хэмээн хэмээн үзэж НӨУБ-д мэдлэгийн менежмент, тэр дундаа инновацийн бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг хөндөж байна. Ингэж хандахдаа нутгийн өөрийн удирдлагын байгууллага нь:

1. Нийгмийн бие даасан институци мөн.
2. Ардчиллын эх сурвалж, үр дүн нь ард түмэн /иргэд/ мөн.
3. Үндсэн хуулиар баталгаажсан төлөөллийн ардчиллын үндсэн хэлбэр мөн гэсэн суурь ойлголтыг эш үндэс болгож байна.

НӨУБ-ын хүрээнд инновацийн бодлогыг хэрэгжүүлэх санааг энэ удаа хөндсөн болно. Ямартаа ч НӨУБ-д /2000 гаруй нэгжтэй/ инновацийн бодлого, инновацийн үйл ажиллагаа нэн шаардлагатай нь тодорхой юм.

Нутгийн өөрийн удирдлага ба инноваци

Нутгийн өөрийн удирдлагын инновацийн бодлогын асуудлыг ярихын тулд нутгийн өөрийн удирдлага гэж юу вэ? гэдгийг тодорхойлохоос эхлэх ёстой. Тэгвэл нутгийн өөрийн удирдлагын дор дурдсан үндсэн конвенциональ /зөвшилцсөн/ нийтлэг тодорхойлолтыг бий болгосон байна. Тухайлбал:

1. “Нутгийн өөрийн удирдлага гэдэг нь нутаг дэвсгэртээ хуулийн хүрээнд нийтийн үйл хэргийн ихээхэн хэсгийг өөрийн хариуцлага дор, оршин суугчдийн ашиг сонирхолд нийцүүлэн удирдан зохион байгуулах эрх, бодит чадвар юм” /Нутгийн өөрийн удирдлагын Европын Харти 3-р зүйлийн 1/
2. “Нутгийн өөрийн удирдлага нь нутаг дэвсгэрийн нэгжүүд өөрт хамаарах асуудлаа өөрсдийн үзэмж, санаачлага, хариуцлага дор тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид, иргэдийн сайн сайхны төлөө зохицуулах, хянах эрх мөн.” /Нутгийн өөрийн удирдлагын Торонтогийн тунхаг 2-р зүйлийн-а/

Дээрх тодорхойлолтууд нутгийн өөрийн удирдлагын зарчим, үйл ажиллагааны талбар, хараат бус байдал, хариуцлага хүлээх байдал зэрэг нутгийн өөрийн удирдлагын агуулга, мөн чанарыг бүрнээ илэрхийлнэ. Үүнтэй холбогдуулан НӨУ түүнийг хэрэгжүүлдэг байгууллагуудыг үндэсний хэмжээний институци гэж тодорхойлж болох юм. Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буйн хувьд нь инновацийн бодлогын салбар ч гэж үзэж болно. Энэхүү зураглалын үүднээс НӨУБ-ын салбарын инновацийн бодлого боловсруулах ёстой гэсэн байр суурь баримталж дор дурдсан дарааллаар санал бодлоо илэрхийлэв.

Нэг. Нутгийн өөрийн удирдлага ба инновацийн бодлогын үндсэн хүчин зүйлүүд тэдгээрийн онцлог

Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын инновацийн бодлого нь нь дараахь үндсэн хүчин зүйлээр нөхцөлдөнө.

Үйл ажиллагааны хүрээ. НӨУБ-ын үйл ажиллагааны хүрээ нь хоёрдмол утгатай бөгөөд нэг талаас улс орны

хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээний ерөнхий үзүүлэлт, хүрсэн түвшин, ард түмний амьдралын байдалтай, нөгөө талаас нутгийн өөрөө удирдах байгууллагын өөрийн үйл ажиллагаатай холбоотой.

НӨУБ-ын үйл ажиллагаа нь ижил төстэй байгууллагын дунд өрсөлдөөнт зах зээлийн өвөрмөц бүтцийг бий болгож нутгийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааны шинэчлэлийг шаардана. Энэ утгаараа нутгийн өөрийн удирлагын /салбарын/ инновацийн бодлого нь бусад салбарынхаас өвөрмөц онцлогтой байх агаад хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдоно. Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын инновацийн бодлогын чиглэл дараах суурь асуудлыг хамарна гэж үзэж болно. Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх асуудал
2. Тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах асуудал
3. Өмчлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх асуудал
4. Иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, шударга ёсыг бэхжүүлэх асуудал зэрэг суурь асуудлууд эн түрүүнд хамрагдана.

Үйл ажиллагааны динамик. Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын бүтээгдэхүүн нь иргэнд үйлчлэх үйлчилгээ бөгөөд үйлчилгээний чанар хүртээмжээр тодорхойлогдоно. Дашрамд тэмдэглэхэд нутгийн өөрийн болон нутгийн захиргааны байгууллагын ажил, үйлчилгээний чанар, хүртээмж бизнесийн байгууллагаас хоцорсон, төр захиргааны байгууллага бүгдийг нуруундаа үүрсэн нь бүтээмжийг нь бууруулсан нэг хүчин зүйл болсон. НӨУБ-ын ажил үйлчилгээний динамикийг хуулиар тогтоосон эрх үүрэг, үнэлэх шалгуур зэрэгтэй нь холбож тодорхойлох шаардлагатай. Үүнд:

А.Инновацийн эх сурвалж. НӨУБ-ын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлог нь инновацийн эх сурвалжийг илэрхийлнэ. Миний бодлоор НӨУБ-ын инновацийн эх сурвалж нь нутаг дэвсгэр түүн дээр үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага аж ахуйн нэгж иргэд юм. Асуудалд ингэж хандвал инновацийн эх сурвалжийг “бүрэн” ашиглаж чадна.

Б.Инновацийн эрэлт. Энэ нь танин мэдэхүйн хувьд инновацийн нийгмийн эрэлт, инновацийн НӨУБ-ын эрэлт хоёроор тодорхойлогдоно. Инноваци өөрөө эрэлт үүсгэж буйг арга зүй болгож нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд инновацийн эрэлтийн төрөл, хэлбэр чиглэлийг тодорхойлох нь суурь үндэслэл /концепци/ болно.

В.Технологийн горим. НӨУБ-ын технологийн горим нь 2 үндсэн онцлогтой гэж үзэж байна.

- **Хуулиар тогтоосон** /НӨУБ-ын үндсэн технологийг хуульчлан тогтоосон байдаг. Тухайлбал иргэдийн төлөөлөгчдийн хуралдаан, тэргүүлэгчдийн хуралдаан зэргийн үйл ажиллагааны горимыг хуульчилсан байдаг/

- **Өөрөө тогтоосон** /Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагууд бүрэн эрхийнхээ хүрээнд нутаг дэвсгэрийн хэмжээнд өөрийн үйл ажиллагааны горимыг тогтоож мөрдөх боломжтой. Харамсалтай нь энэ чиглэлээр ихэнх НӨУБ-ууд идэвхи муутай ажилладаг/

Үйл ажиллагааны орчин. НӨУБ-ын үйл ажиллагааны орчин нь нутаг дэвсгэрийн хэмжээг хамрах боловч нэн түрүүнд нутгийн өөрөө удирдах байгууллагын өөрийн орчин дахь мэдлэг бүтээх үйл явц, сургалт, судалгаа, хөгжлийн бодлогыг хамруулж ажиллах нь чухал юм. НӨУБ-ууд мэдлэг бүтээх үзэл баримтлалуудаас өөрийн онцлогт тохируулан сонголт хийж /К.Уйгийн мэдлэгийн менежментийн үе шат, Макэлройн мэдлэгийн менежментийн мөчлөг, Икишүри Нонака, Такэүчи нарын мэдлэгийн тойргоос сонголт хийх нь илүү тохиромжтой байж болно/ үйл ажиллагааныхаа орчинг өөрчлөх хэрэгтэй. Сургалтыг суралцах үйл явц болгон хувиргах үүний тулд хэлэлцүүлэг, маргаан өрнүүлэхэд НӨУБ-ууд анхаарах ёстой. Манай НӨУБ-ууд хуралдаж семинарддаг уламжлалт практикаасаа салах нь зүйтэй.

Дээр дурьдсан хүчин зүйлүүдийг уялдуулан зохицуулж инновацийн бодлогын концепцийн суурь болгож ажиллах нь НӨУБ-ын хөгжлийн эх сурвалж мөн. НӨУБ-ын инновацийн бодлого нь технологийн бус инновацид хамаарах бөгөөд ерөнхий утгаараа менежментийн инноваци юм.

Хоёр. НӨУБ-ын инновацийн бодлогын

бүрэлдэхүүн ба хэмжүүрүүд

НӨУБ-ын салбарын инновацийн бодлого нь салбарын инновацийн тогтолцоогоор тодорхойлсоны дагуу 3 үндсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд тэдгээрийг Европын холбооны 25 улсыг хамарч, 2005 оны 11-сараас эхлэн 9 салбар, 3 тусгай асуудлыг хамруулж 2,5 жилийн хугацаанд хийсэн судалгаагаар тогтоосон байна. Бүрэлдэхүүний 3 үндсэн элементийг тус бүрт нь товч тайлбарлая.

1.Мэдлэг ба технологийн суурь. Энэ нь НӨУБ-ын үйл ажиллагааг тодорхойлж байгаа мэдлэгийн бааз, технологийг хамарна. НӨУБ-ын тухай мэдлэг, НӨУБ-ын үйл ажиллагааны горим технологи нь нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти, Торонтогийн тунхаг зэрэг олон улсын баримт бичгүүд, тэрчлэн МУ-ын үндсэн хууль, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд томъёологдсон байдаг. Түүнчлэн нутгийн өөрийн удирдлагын тухай судлаачдын байр суурь, үнэлэлт дүгнэлтүүд НӨУБ-ын практик нь энэхүү салбарын мэлэгийн баазыг тодорхойлж байгаа юм. Энэ өнцгөөс нь үзэж НӨУБ-ын мэдлэг, технологийг баазыг инновацийн бодлого боловсруулах үндсэн хэмжигдэхүүн болгох ёстой.

2. Оролцогчид /тоглогчид/. Бүрэлдэхүүний энэ элементэд төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, бодлогын хүрээлэнгүүд, хувийн хэвшил, хэрэглэгчид /иргэд/ гэх мэт нийгмийн бараг бүх эд эс хамаарна. Тоглогчид нь ерөнхий сүлжээ үүсгэхээс гадна өөр өөрийн “автономи” сүлжээтэй байна.Тухайлбал 2013 оны хавар Хангайн бүсийн аймгуудын ИТХ-ын байгууллагын хамтын ажиллагаанй асуудлаар Орхон аймагт зөвлөгөөн зохион байгуулж, бүсийнхэмжээнд хэрэглэж болох “тэргүүн туршлага”-гаа солилцож хамтын ажиллагааны чиглэл гаргасан.

НӨУБ-ын өөрийн дотоод бүрэлдэхүүнд тухайн хурлын олонх цөөнхийг газар нутгийн, мэргэжлийн, хүн ам зүйн зэрэг параметрээр бий болгож ажил хэрэгч уур амьсгал бүрдүүлж үйл ажиллагааг өрнүүлэх нь НӨУБ-ын инновацийн

бодлогын хэмжигдэхүүний онцлог нь юм. Өнөөдөр нутгийн өөрийн удирдлагыг олон сонирхолын уулзвар дээр хөгжүүлэх шаардлага өндөр байгааг хаа хаанаа бодож ажиллах ёстой.

3. Институтууд. НӨУБ-ын үйл ажиллагааны хэм хэмжээ, процедур, тогтсон практик, дүрэм журам, стандарт нь энэ элементийн агуулгыг илэрхийлнэ. НӨУБ-ууд нь өөрийн соёл, үнэт зүйлсийг бий болгож ажиллах нь энд хамаарна. Харин энэ элемент нь орон нутгийн соёл, зан заншил, ёс суртахууны харилцааны онцлогийг агуулсан байдгаараа онцлог юм. Ийм учраас орон нутгийн онцлогтой уялдсан хэм хэмжээ, шалгуурыг баримтална гэсэн үг. 2014 оны намар Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал “Нутгийн удирдлагын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, түүнийг тооцох аргачлал”-ыг баталж гаргасан нь манай улсын нутгийн өөрөө удирдах байгууллагын хөгжлийн түүхэнд нэгэн шинэ үзэгдэл болсон. Мөн аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтны үйл ажиллагааны стандарт, ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон журам боловсруулж мөрдөж байгаа нь олзуурхуштай практик гэж үзэж байна. Дээр дурьдсан 3 элемент нь НӨУБ-ын инновацийн бодлогыг томъёолох эхлэлийн цэг мөн.

Инновацийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ буюу хэмжүүрийг Европын холбооны 25 улсыг хамарсан судалгаагаар нарийвчлан тогтоосон байна. Манай улсын НӨУБ-ын инновацийн бодлогод дор дурдсан хэмжүүрүүдийг хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

а/ Санаачлага. Инноваци нь процесс болохын хувьд үйл ажиллагааны бүх түвшин, хэлбэр бүтцэд санаачлагын ач холбогдол өндөр байдаг. Ер нь инноваци нь санааг хөгжүүлж тухайн салбарын хэмжээнд болон нийгэмд чиглүүлж бүтээгдэхүүн, үйлчилгээ болгож хувиргах үйл явц юм. Ийм ч учраас манай хуулинд “инновацийг мэдлэгийг баялаг болгож хувиргах үйл явц мөн” хэмээн тодорхойлсон. Санаачлагын багц, санаачлагын бүлэг гэх мэт өвөрмөц “бүтээгдэхүүн” үйлдвэрлэж ажиллах нь инновацийн хөрс үндэс нь юм. Иймд ийм арга хэмжээ инновацийн хэмжүүр нь болдог. Ажиглалтаар НӨУБ-уудад санаачлага ус агаар мэт шаардлагатай байна. Санаачлагаа хэмжилт шинжилгээ, судалгаатай холбохгүйгээр

амжилтад хүрэхгүй. Нягт нямбай, даацтай судалгаа үнэ цэнэтэй байх нь маргаангүй юм.

б/ Технологийн шинэчлэл. НӨУБ-ын үйл ажиллагааны технологийн өөрчлөлт, түүний зарчмыг тодорхойлох нь инновацийн бодлогын нэгэн хэмжүүр юм. Нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудад бодлого, үйл ажиллагааны уламжлалт технологигоос мэдээлэл харилцааны технологид шилжих алхам нэвтэрч байгаа нь НӨУБ-ын технологийн шинэчлэлийн нэг чухал хандлага юм. Технологийн шинэчлэлийн нэг хэсэг нь арга барилын өөрчлөлт юм. Шинэ зуунд хуучин аргаар ажиллаж болохгүй, товчоор хэлбэл ажлын арга барилаа байнга сайжруулж ажиллаж байж амжилтад хүрнэ. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд “Суралцагч байгууллага”, “Чанарын удирдлагын систем”, “Бэнчмаркинг” гэх зэрэг шинэ зууны үзэл баримтлалаас суралцах шаардлага өндөр байгааг ухаарч ажиллах хэрэгтэй.

в/ Инновацийн хөтөлбөр /төсөл/. НӨУБ-ын эрхэм зорилго, үнэт зүйл нь нийтийн эрх ашгийн үүднээс шинэ үр ашигтай зүйлийг нэвтрүүлэхэд орших учраас инновацийн хөтөлбөр /төсөл/-ийг бүсийн хэмжээнд, аймгийн түвшинд, тодорхой байгууллагын хувьд ч хэрэгжүүлэх шаардлага сүүлийн жилүүдэд хөгжлийн чиглэл, хандлагаас хамааран үүссэн. Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал 2014 онд “Мэдлэгт суурилсан Эрдэнэт” хөтөлбөр боловсруулан баталсан нь аймгийн түвшинд хэрэгжүүлж эхэлсэн инновацийн анхны хөтөлбөр гэж үзэх үндэстэй юм. Эрдэнэт хот нь Хангайн бүсийн тулгуур төвийн хувьд, дэлхийн аж ахуйн нэгж болох “Эрдэнэт үйлдвэр” ХХК, монголын хөнгөн үйлдвэрийн манлай “Эрдэнэт хивс” зэрэг жин дарах томоохон компаниудын өлгий нутгийн хувьд инновацийн төсөл хэрэгжүүлэх боломж хөрс суурь бүрдсэн гэж үзэж энэхүү хөтөлбөрийг эхлүүлсэн юм. НӨУБ-ууд инноваци нэвтрүүлэх объектоо тодорхойлж, инновацийн “гарааны талбай” байгуулж, инновацийн процессийг удирдах загвараа сонгож, идэвхижүүлэлтийн механизмаа тодорхойлж ажиллах хэрэгтэй. Энэ хүрээнд хувийн хэвшлийн туршлагаас суралцах шаардлагатай. Доктор А.Цанжид Өмнөд Солонгост төрийн инновацийн бодлого /инновацийн 5 зорилго бүхий/

амжилттай хэрэгжиж буйг тэмдэглэсэн байна. /Төрийн захиргаа сэтгүүл, 2010 оны №2 /

г/ Дүрэм журам. НӨУБ-ууд бүрэн эрхийнхээ дагуу нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд мөрдөх дүрэм журмыг батлан хэрэгжүүлэх нь шинэ зүйл санаачлах, үр дүнд хүргэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх ач холбогдолтой. Үүний хамт техникийн хэм хэмжээг /норматив/ тогтоож ажиллах ёстой. Уламжлагдсан буюу хуучин дүрэм журам, ерөнхий дүрэм журам, техникийн хэм хэмжээг хэрэгжүүлэх нь шинэ санаачлага шинэ зүйлд саад болно. Иймд энэ хэмжүүрт анхаарал тавьж өөрчлөх хэрэгтэй юм. Нутгийн удирдлагын “дүрмийн засаглал”-ыг нийтийн салбарын шинэ удирдлага \ New public management\ -ын үзэл баримтлалаас суралцах байдлаар тогтоох чиглэлийг урьтал болгох нь зүйтэй. Энд тэмдэглэх нэгэн зүйл нь дүрэм журмаар зохицуулах харилцааг хэт өргөтгөвөл “аргамжаатай морь” хол явах боломжгүйтэй адил болно.

д/ Санхүүгийн дэмжлэг. Инновацийн бодлого хөтөлбөр хэрэгжүүлж байгаа субъектүүдэд санхүүгийн дэмжлэг зайлшгүй юм. Санхүүгийн дэмжлэг дараахь хэв маягтай байж болохыг судлаачид тогтоосон. Үүнд:

1. Инновацийн элементүүдийг дэмжих үүднээс төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх /татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт гэх мэт /
2. Инновацийн үйлчилгээг холбогч /зуучлагч, туслагч/ байгууллагуудад санхүүгийн эх үүсвэр олгох. НӨУБ-ын инновацийн бодлогыг хэрэгжүүлэхэд иймэрхүү байгууллагууд шинээр үүсч ажиллах нь тодорхой юм.
3. Оролцогчид /тоглогчид/-ын дунд мэдлэг солилцох, дэлгэрүүлэх, зохицуулах асуудлыг удирдлагын системийг сайжруулах замаар шийдвэрлэх /санхүүгийн дэмжлэг олгох замаар шийдвэрлэх/
4. Инновацийн процесст нөлөөлөх шинэ байгууллага байгуулах, эрх зүйн акт гаргах гэх мэт. НӨУБ-ын инновацийн бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн шинэ байгууллага үүсэх

магадлал өндөр юм. Учир нь төвлөрлийг сааруулах үйл явц нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар гүнзгийрэх хандлагатай байна. Санхүүгийн механизмыг өргөн ашиглах нь инновацийн бодлого хэрэгжих урам бас үндэс нь юм.

НӨУБ-ын хэмжээнд инновацийн тогтолцоо бүрдүүлэх санал

НӨУБ-д инновацийг хэрэгжүүлэх нь монгол улсад хүнлэг ардчилсан иргэний нийгэм байгуулах үндсэн хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр болно гэж төсөөлж байна.



Тайлбар:

1. НӨУБ-ын инновацийн бодлого эрхэлсэн хороо нь УИХ-ын нутгийн удирдлагын дэд хорооны дэргэд байгуулагдан ажиллаж, бодлогын удирдлагаар хангаж ажиллана.

2. Монголын нутгийн удирдлагын холбоо /МНУХ/ нь инновацийн бодлогыг салбарын инновацийн тогтолцооны хувьд удирдаж ажиллана.
3. Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлууд МНУХ-ын удирдлага дор инновацийн бодлого, үйл ажиллагаа бодлого, үйл ажиллагаа боловсруулж ажиллана.
4. Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн байгууллагууд аймаг, нийслэлийн ИТХ-ын удирдлага дор өөрийн онцлогт тохирсон инновацийн бодлого, үйл ажиллагааны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
5. Баг, хорооны иргэдийн нийтийн хурал нь сум, дүүргийн ИТХ-ын байгууллагын мэргэжил- арга зүйн удирдлага дор инновацийн бодлого, үйлявцыг хэрэгжүүлнэ.
6. Энэхүү тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хяналт, үнэлгээг хийх, тайлагнах зэрэг процедурын асуудлыг тусгай журмаар зохицуулна.

Дүгнэлт

Шинэ санаа, шинэ зүйл бүхэн хэрэгжиж өөртөө шинэ зам татуулан зураих нь хөгжиж буй системийн дүр төрх гэлтэй. Хүн төрөлхтөн 20-р зууны сүүлч, 21-р зууны эхний жилүүдэд мэдлэгт түшиглэсэн нийгмийг бүтээхэд анхаарч тэргүүлэгч улс орнууд төдийгүй дэлхий нийтээрээ тэр зүгт тэмүүлж байгаа нь өнөө үеийнхний дүр зураг юм.

Байдал ийм байхад бидний монголчууд бас л мэдлэгтээ түшиглэсэн нийгэм бүтээхийн төлөө явах нь зайлшгүй юм. Эл байдлыг мэдэрсэн монголчууд инновацийг монголын хөгжлийн гарц болгох үүднээс зарим ахиц дэвшил хийж байна. Төр засаг, зарим судлаачид инновацийн утга учрыг ойлгуулахаас эхлээд гадаадын туршлагыг танилцуулж зарим байгууллагыг энэ чиглэлд хөтлөн суралцуулж байна.

Гэвч түүнийг бас л бүх түвшиндээ жигд ойлгоогүй байна. Инновацийн зүгт төр захиргааны байгууллагууд хошуучлан манлайлж байгаа нь харагдахгүй шахам байна.

Ийм нөхцөлд инновацийн бодлогыг иргэдийн өөрсдийнх

нь байгуулсан байгууллагаас эхэлж хэрэгжүүлэх нь нэн сонирхолтой юм. Инновацийн бодлогоор НӨУБ-уудын чадамжийг сайжруулах нь монголын төр иргэн 2-ын аль альных нь амин зорилго юм. Энэ утгаар НӨУБ-ын хэмжээнд инновацийн бодлого хэрэгжүүлэх асуудлаар санал бодлоо хуваалцлаа. Асуудал нь өөрөө маш өргөн далайцтай учраас цогц ойлголт бий болгоход бэрхшээлтэй байсаныг эцэст нь тэмдэглэе.

Ашигласан материал

1. НӨУБ-ны европын Харти
2. НӨУ-ын Торонтогийн тунхаг
3. Монгол улсын үндсэн хууль
4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
5. С.Нармандах – Нутгийн өөрийн удирдлагыг шинжихүй /УБ. 2010 он/
6. А.Рейд, В.Петер – Салбарын инновацийн тогтолцоо /бодлогын зураглал/ Брюсель 2008-2



Konrad
Adenauer
Stiftung

Хоёрдугаар бүлэг



**“НУТГИЙН УДИРДАЛАГЫН
ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ” сэдэвт
ЭССЭ, илтгэл бичих уралдааны
өндөр оноо авсан сэдвүүд**



Я.БЯМБАЯР

Удирдлагын академийн Төрийн удирдлагын
тэнхмийн эрхлэгч
доктор, дэд профессор

“ТЭРГҮҮЛЭГЧИД”: СОЦИАЛИЗМААС УЛАМЖИЛСАН ГАЖИГ УУ?

Оршлын оронд

“Тэргүүлэгчид” гэхээр бидний санаанд юуны өмнө “хурал цуглаан удирдах бүрэлдэхүүн” хэмээн буудаг. Уг нь “тэргүүлэх” гэсэн үйл үгийг нь бол “хошуучлах”, “манлайлах”, “толгойлох”, “түрүүлэх” гэсэн утгаар нь хэрэглэдэг билээ. “Тэргүүлэгчид” гэх “тэргүүлэх” гэсэн үгнээс үүсгэсэн үйлт нэрийг голчлон олон тоон дээр 1920-иод оны дунд үеэс үндсэн утгыг нь шилжүүлэн “хурал, цуглааны шийдвэр гаргах бүрэлдэхүүн”, мөн “төлөөллийн байгууллагын удирдах бүрэлдэхүүн” гэсэн утгаар хэрэглэх болжээ. Ийнхүү шилжсэн утга нь тухайн үеийн үзэл суртал, улс төрийн дэглэмийн албан ёсны нэр том ёёо учраас хүмүүсийн сэтгэлгээнд “хүчээр” нэвтэрч, загварчлагдсан бололтой.

Гэтэл өнөөдөр өр “Тэргүүлэгчид” нь зөвхөн орон нутгийн Хуралд л үлдэж хоцорсон байх бөгөөд Хурлын байнгын тасралтгүй ажиллагаа хангаж ажиллах үүрэг бүхий бүрэлдэхүүн байхаар Үндсэн хуулиар тогтоосон байна¹. Үүний зэрэгцээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тухайн нутаг дэвсгэрийн нэгжийг удирдах, төлөөлөх 14 бүрэн эрх олгосноос гадна Хурлын бүрэн эрхэд хамаарах 12 асуудлыг дараа Хуралд тайлагнахаар шийдвэрлэж байхаар заасан байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутгийн иргэдийг шууд төлөөлж буй нутгийн

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “ Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн ” гэж заажээ. Эх үүсвэр : Монгол Улсын Үндсэн Хууль. 1992.

өөрөө удирдах байгууллага билээ. Гэтэл иргэдийг төлөөлж буй байгууллага нь бус, түүн ий дотроос сонгогдсон, дам төлөөллийн этгээд болох Тэргүүлэгчид бодит байдал дээр удирдлагыг хэрэгжүүлж, орлон ажиллах эрхтэй болсон нь төлөөллийн ардчиллын зарчмыг зөрчсөн хэрэг болжээ.

Энэ илтгэлд “Тэргүүлэгчид” яагаад төлөөллийн ардчиллын зарчмыг зөрчи х болов, хэзээ ийм институци бий болов, бусад оронд ийм институци байгаа юу гэх зэрэг асуултад хариулж, уг ойлголтын мөн чанарыг тодорхойлж, цаашид Тэргүүлэгчдийг хэрхэх талаар саналаа дэвшүүлэх юм.

Гарал үүсэл

1921 онд Ардын Түр Засгийн газрыг байгуулахад Д.Чагдаржавыг “Засгийн газрын тэргүүлэгч дарга” хэмээх албан тушаалд сонгосон байна². Энд байгаа “тэргүүлэгч” хэмээх үг нь “толгойлох” гэсэн үндсэн утгаа агуулж байгаа гэж түүхчид үздэг болохоор Д.Чагдаржавыг Ардын Засгийн газрын анхны Ерөнхий сайд гэж нэрлэдэг бизээ. Харин 1923 онд МАХН-ын 2-р Их хурлаас Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийг 7 хүний бүрэлдэхүүнтэй сонгосон³ баримтаас харахад энэ үеэс л эхлэн Монголд “Тэргүүлэгчид” хэмээх ойлголт нь утгын хувьд өөрчлөгдсөн бололтой. 1924 оны Үндсэн хуулиар “үргэлж сууж”⁴ (байнга ажиллаж), Улсын Бага Хурлыг “жолоодох”⁵ түүний Тэргүүлэгчдийг сонгож байгуулахаар тогтоосон нь Зөвлөлт Орос Улсын 1918 оны Үндсэн хуулийн үзэл санаан дор төсөөтэй загвараар “улсын дээд эрхийг барих”⁶ газрыг бий болгосныг харуулна. Үүнээс хойш 1949 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хүртэл Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, дараа нь 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдтал Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нь төрийн эрх барих дээд байгууллага байжээ.

2 Б.Ширэндэв Монгол Ардын хувьсгалын түүх. УБ, 208 дахь талд үз.

3 МАХН-ын товч түүх. УБ, 1985, 100 дахь талд үз.

4 БНМАУ-ын Үндсэн хуулийн Арван тавдугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд. УБ, 1998, 8 дахь талд үз.

5 БНМАУ-ын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд. УБ, 1998, 9 дэх талд үз.

6 БНМАУ-ын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд. УБ, 1998, 6 дахь талд үз.

Харин орон нутгийн Хуралд Тэргүүлэгчид нь 1989 он хүртэл огт байгаагүй юм. Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргаа нь 5-11 хүний бүрэлдэхүүнтэй, хамтын шийдвэр гаргадаг, тухайн Хурлаасаа сонгогддог, Хурлын чуулганы чөлөө цагт бүрэн эрхийг нь хэрэгжүүлдэг (үнэн хэрэг дээрээ Тэргүүлэгчид гэсэн үг) этгээд байсан тул Тэргүүлэгчдийн хэрэгцээ байсангүй.

1988 онд МАХН-ын Төв Хорооны бүгд хурлаар орон нутгийн Хурлын ач холбогдлыг дээшлүүлэх асуудлыг хэлэлцсэний дараагаас орон нутгийн Ардын Депутатуудын Хурлын Тэргүүлэгчдийг бий болгожээ. Гэвч Хурлын чуулганы чөлөө цагт бүрэн эрхийг нь хэрэгжүүлэх эрхийг Гүйцэтгэх захиргаанаас Тэргүүлэгчдэд шилжүүлээгүй ажээ. Нэгэнт бүрэн эрх нь Гүйцэтгэх захиргаанд хэвээр үлдсэн учир АДХ-ын Тэргүүлэгчид нь хэрэг дээрээ нэрийн төдий байж, хийх ажилгүйгээрээ дуудуулж байв. Үүний зэрэгцээ АДХ -ын Гүйцэтгэх захиргааны дарга нь АДХ-ын Тэргүүлэгчдийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэж байсан тул Тэргүүлэгчид нь Хурлын ач холбогдлыг дээшлүүлэх, идэвхжүүлэх боломж ч тэр бүр гараагүй бололтой. Аймаг, хотуудын АДХ-ын Тэргүүлэгчдийн орлогч дарга нь зөвхөн орон тооны байсан ба сум, районы түвшинд Хурлын Тэргүүлэгч ид нь орон тооны байсангүй. Зарим аймагт (тухайлбал Хөвсгөлд) сумдын АДХ-ын Тэргүүлэгчдийн даргыг орон тооны болгох оролдлого хийж байсан авч статус, чиг үүрэг нь тодорхойгүй байсны зэрэгцээ бас ч үгүй олон ургальч үзэл дэлгэрч байсантай уялдан шүүмжлэлд өртөн Гүйцэтгэх захиргааны даргад хавсаргаж байсан баримт бий.

Гадаад улс оронд

Монгол хэлнээ “Тэргүүлэгчид” хэмээн нэрлэх болсон энэ ойлголтыг бид орос хэлнээс дам орчуулан хэрэглэж ирсэн билээ. Одоо ч монгол-орос толь бичигт энэ үгийг “президиум” гэж хөрвүүлсэн байдаг.

Харин оросууд анх латин хэлний “praesidēre” буюу “урд талд суух” гэсэн үгнээс гаралтай “praesidium” гэдэг үг ийг орос хэлээр “президиум” хэмээн герман дуудлагаар нь галиглан

хөрвүүлж хэрэглэжээ. Анх 1848 онд байгуулагдсан Пруссийн Ландтагийн доод танхим болох Төлөөлөгчдийн танхимд (*Preußische Abgeordnetenhaus*), дараа нь Германы эзэнт улсын Райхстагт парламентын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчдийг нийтэд нь “Präsidium” (герман дуудлагаар) гэж нэрлэх болжээ⁷. Одоо ч гэсэн ХБНГУ-ын Бундестагийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчдийг нэгтгэн “Präsidium”⁸ гэж нэрлэдэг байна. Хаант Орост анх орчин цагийн хууль тогтоох сонгуульт байгууллагыг 1905 оны хувьсгалын дараа байгуулахдаа доод танхим болох Улсын Думд мөн Германы адилаар удирдах бүрэлдэхүүнийг “Президиум” гэж нэрлэх болжээ. Эдгээр нь тухайн Хурлын хуралдааныг болон өдөр тутмын үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий албан тушаалтнууд бөгөөд ямар бие даасан үйл ажиллагаа явуулдаггүй, Хурлын өмнөөс бие даан шийдвэр гаргадаггүй юм.

Хожим нь Оросын 1917 оны Хоёрдугаар сарын хувьсгалын үеэр байгуулагдсан Петроградын ажилчин, цэргүүдийн депутатуудын зөвлөл нь Улсын Думын нэгэн адилаар зөвлөлийн удирдлагыг “президиум” гэж нэрлэх болжээ. Учир нь Улсын Думын депутатаар ажиллаж байсан эсер, меньшевик намын төлөөлөгчид уг зөвлөлд голлох байр суурьтай байх үеэс ийн хүү нэршсэн бололтой. Удалгүй ажилчин, цэргүүдийн шууд төлөөллөөс бүрддэг зэвсэгт тэмцлийн удирдах байгууллагад хувьсгалын дараа шорон, цөллөгөөс ирсэн мэргэжлийн хувьсгалчид (эхний саруудад эсер, меньшевикүүд, дараа нь 8-р сараас большевикууд) олноороо орж, удирдлагыг гартаа авсан байна⁹. Эндээс л “президиум” нь олон түмний өмнөөс нь удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргадаг институци болох эхлэлээ тавьсан бололтой.

7 Пруссийн Ландтагийн тухай ерөнхий мэдээлэл – http://de.wikipedia.org/wiki/Preu%C3%9Fischer_Landtag (2015.05.01-нд хандсан)

8 ХБНГУ-ын Бундестагийн албан ёсны сайт – <http://www.bundestag.de/bundestag/praesidium/> (2015.05.01-нд хандсан)

9 Тухайн үед Петроградын зөвлөлийн гүйцэтгэх хорооны бүрэлдэхүүнд орж байсан А.Г.Шляпниковын дурдатгалд “Ажилчин депутатуудын зөвлөл ийн нээлт болох гэж байсан ерөөнд ажилчдын төлөөлөгчид, сэхээтнүүд бага багаар цугларсаар байлаа. Зөвлөлд суух төлөөлөгчийн мандат хайсан сэхээтнүүд дүүрэн байв ... Энэ өдрийг хүртэл тэмцл ээс халуур явсан сэхээтнүүд ялсан ажилчид, цэргүүдэд наалдчихаад “жолоодогч” нь болох гэж уралдацгааж байв” гэсэн байдаг – В.А.Рачковский “Петроградский Совет рабочих и солдатских депутатов в феврале-марте 1917 г. в воспоминаниях социалистов (Часть I) өгүүллээс дам ишлэв. – “Новейшая история России” сэтгүүл, 2011, №2, 26 дахь талд үз. – <http://history.spbu.ru/journal-nir> (2015.05.01-нд хандсан)

Октябрийн хувьсгалын дараа боловсруулж мөрдөж эхэлсэн Зөвлөлт Орос Улсын Үндсэн хуульд Бүх Оросын Зөвлөлүүдийн Их Хурал (Всероссийский Съезд Советов), түүний чөлөө цагт Бүх Оросын Төвийн Гүйцэтгэх Хороо (Всероссийский Центральный Исполнительный Комитет), түүний чөлөө цагт Тэргүүлэгчид (Президиум) нь “хууль тогтоох, гүйцэтгэн захирамжлах, хяналт тавих дээд байгууллага”¹⁰ байхыг заажээ. Дараа нь 1924 оны Үндсэн хуульд¹¹ энэ чигээрээ байж байгаад “Сталины Үндсэн хууль” гэгддэг 1936 оны Үндсэн хуульд ЗСБНХУ-ын Дээд Зөвлөл (Верховный Совет СССР), түүний чөлөө цагт түүний Тэргүүлэгчид нь ЗСБНХУ -ын “хууль тогтоох дээд байгууллага” байхаар заасан байна. Түүгээр ч үл барам Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчид нь Дээд Зөвлөлийн чуулганы хуралдааныг удирдахгүй мөртөө тодорхой нөхцөлд Дээд Зөвлөлийг тараах эрх бүхий цорын ганц этгээд байхыг заасан байна¹². Өөрөөр хэлбэл, Тэргүүлэгчид нь хамтын шийдвэр гаргадаг төлөөллийн байгууллагын шийдвэрээ гаргах үйл явцыг удирдах үүрэг бүхий бүрэлдэхүүн байснаа тоталитар дэглэмийн үед олон түмний өмнөөс тэдний төлөөллийн байгууллагын нэр дор удирдлагыг хэрэгжүүлэх, шийдвэр гаргах бүрэлдэхүүн болж хувирчээ.

Тэргүүлэгчид нь 1990-ээд оны эх хүртэл хуучин социалист орнуудад нийтлэг хэрэглэгдэж байсан институци бөгөөд иргэдийн төлөөллийг хангасан ардчилсан хэв маяг мэт харагдах боловч хэрэг дээрээ цөөнх нь шийдвэр гаргадаг тоталитар дэглэмийн үндсэн загвар болон төлөвшсөн байна. Одоогоор институцийн хувьд манай ИТХ-ын Тэргүүлэгчдээс гадна дэлхий дээр БНХАУ, БНАСАУ-д л ийм “Тэргүүлэгчид” байна¹³. Бусад орнууд энэ институциэс аль хэдийн татгалзжээ!

Өөр нэг анхаарал татахуйц баримт бол англи хэлний тайлбар толь бичигт энэ “presidium” гэсэн үгийг зөвхөн “ЗХУ болон хуучин социалист орнуудад байсан төлөөллийн байгууллагын бүхий л эрхийг чөлөө цагт нь эдэлдэг байнгын

10 Зөвлөлт Орос Улсын 1918 оны Үндсэн хууль -- http://supol.narod.ru/archive/official_documents/const1918.htm (2015.05.01-нд хандсан)

11 ЗСБНХУ-ын 1924 оны Үндсэн хууль -- <http://www.tarasei.narod.ru/konst1924.htm> (2015.05.01-нд хандсан)

12 ЗСБНХУ-ын 1936 оны Үндсэн хууль -- <http://www.tarasei.narod.ru/konst1936.htm> (2015.05.01-нд хандсан)

13 БНХАУ-д “Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлын Байнгын Хороо”, БНАСАУ -д “Ардын Дээд Хурлын Тэргүүлэгчид” гэж нэрлэнэ.

ажиллагаатай этгээд”¹⁴ гэж тайлбарласан байх бөгөөд энэ нь англи хэлтэй орнуудад энэ үг угаасаа ямар нэгэн институцийн нэр болж ашиглагдаагүй болохыг илэрхийлнэ.

Өнөөгийн Тэргүүлэгчид буюу тулгамдсан асуудал

Дээр дурдсан түүхээс үзэхэд энэ үг нь монгол хэлнээ нэлээд үзэл сурталжсан утгатайгаар хэрэглэгдэж ирсэн байх юм. Бид өнөөг хүртэл ИТХ-ын Тэргүүлэгч ид нь иргэдийг дам төлөөлөн шийдвэр гаргах эрхтэй болж, Хурлыг идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хааж байгааг ч анзааралгүй явж ирлээ. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиудын хүрээнд авч үзвэл Тэргүүлэгчид нь хэд хэдэн нөхцөлийн улмаас нутгийн өөрөө удирдах байгууллагын голлох этгээд нь болон хувирч, төлөөллийн ардчиллын зарчим зөрчигдөж байгааг харж болно. Үүнд:

- 1) Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Хурлын Тэргүүлэгчдэд зөвхө н өөрт нь 14 бүрэн эрх, мөн дээр нь Хурлын онцгой бүрэн эрхээс 12 бүрэн эрхийг (ИТХ-д дараа тайлагнахаар) нэмж олгожээ. Эдгээр 12 бүрэн эрхийн хүрээнд өргөн мэдүүлсэн асуудлыг ИТХ-ын хуралдаанаар бус, ихэнх тохиолдолд Тэргүүлэгчид шийдвэрлэдэг болсон нь удаа дараагийн судалгаагаар харагдаж байгаа. Зарим Хурал жилийн эхэнд ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлынхаа төлөвлөгөөг урьдчилан баталдаг болсон нь үнэн хэрэгтээ хуралдаанаар хэлэлцэх асуудал нь хэт тогтмол, хэлбэр төдий зүйл болсоныг ч харуулна.
- 2) Тэргүүлэгчид нь тухайн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон зарладаг. Нэг үгээр хэлбэл, Тэргүүлэгчид нь Хурлыг хуралдуулах эсэхийг шийдвэрлэж, ямар асуудлыг хэлэлцэхийг тогтоодог.
- 3) Ихэнх Хурлууд жилд 2-3 удаа л хуралдаж байна. Хуулиар ИТХ нь жилд 2-оос доошгүй удаа, ИНХ нь жилд 3-аас доошгүй удаа хуралдах учиртай. Практикт төсөвт зардал, Хурлын төлөөлөгчдийн идэвх оролцоо, ИТХ-ын Тэргүүлэгчдийн санаачлаг а, ажлын албаны ажлын

14 <http://dictionary.reference.com/browse/presidium?s=t> – ээс үз (2015.05.01-нд хандсан)

хариуцлага, арга барил зэргээс шалтгаалан хуульд заасан тооноос олон удаа хуралдахгүй байна.

- 4) Хурлын ихэнх хуралдаан (ялангуяа сумдын ИТХ-ын хуралдаан) ажлын 1 өдөр үргэлжилдэг. Учир нь хэлэлцэх асуудал нь цөөн байхаас гадна нэг асуудлыг хэлэлцэх хугацаа мөн богино байгаа нь ажиглагдана. Асуудлыг урьдчилан ИТХ-ын хороод болон намын бүлгүүд бараг хэлэлцдэггүй, Тэргүүлэгчид ихэнхдээ өөрсдөө асуудлыг боловсруулан оруулдаг учир тусгайлан санал гардаггүй, цөөн тооны төлөөлөгчид саналаа хэлээд л уг асуудлын хэлэлцүүлэг дуусах нь элбэг байна. Хамгийн удаан үргэлжилдэг хуралдаан нь Анхдугаар хуралдаан – зохион байгуулалтын асуудалд хамаг анхаарлаа төвлөрүүл эн намаараа талцдаг учраас хуралдаан бусад хуралдааныг бодвол удаан үргэлжилнэ.
- 5) Төлөөлөгчид Хурлын хуралдаанд ирж суухаас өөрөөр Хурлын үйл ажиллагаанд бараг оролцдоггүй. Төлөөлөгчид нь идэвхгүй учраас хуралдаанаас өөр үйл ажиллагаа ч бараг байхгүй гэж хэлж болно. Ээлжит хуралдааны бэлтгэл ажлын хүрээнд цөөн тооны төлөөлөгчид ажлын хэсэгт орж ажиллана, өөр оролцоо үндсэндээ байхгүй. Хурлын төлөөлөгчид асуудал санаачилдаггүй, наад зах нь Засаг даргад асуулга ч тавихгүй тул ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлын дийлэнх олонхийг Засаг дарга санаачлан хэлэлцүүлдэг болжээ.
- 6) ИТХ-ын хороодын үйл ажиллагаа төлөвшөөгүй учраас Тэргүүлэгчдээс өөр Хурлын үйл ажиллагааг идэвхжүүлэх механизм одоогоор алга. Хэдийгээр төлөөлөгчид бүгд л аль нэг хороонд хуваарилагдах боловч ихэнх Хуралд хороодын ажиллах журам, арга барил, загвар төлөвшөөгүйгээс хороод нь огт ажиллахгүй байна. Эрхлэх асуудлаа хэт их өргөн хүрээтэй тодорхойлсон, хорооны бүрэлдэхүүнд орсон төлөөлөгчид нь ажиллах сонирхол сул, Хурлын ажлын албаны зүгээс дэмжлэг үзүүлдэггүй зэрэг ч мөн нөлөөлнө.

Шийдэл буюу төгсгөлийн оронд

ИТХ-ын Тэргүүлэгчид нь институцийн хувьд төлөөллийн ардчиллыг зөрчиж байгаа нь түүхэн утгаараа ч, өнөөгийн практикт үүсгээд байгаа асуудлаараа ч тодорхой байгаа юм. Түүнээс гадна ИТХ-ын идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хааж, улмаар нутгийн өөрөө удирдах ёс төлөвшихөд саад учруулж байгаа билээ. Иймээс ИТХ-ын Тэргүүлэгчдээс институцийнх нь хувьд татгалзах нь зүйд нийцнэ.

Ингэхийн тулд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулж, улмаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд холбогдох зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулах учиртай. Үүний зэрэг цээ салбарын бусад хуулиудын ИТХ-ын Тэргүүлэгчдэд бүрэн эрх олгосон зүйл заалтыг өөрчлөх нь дамжиггүй.

Гэхдээ Тэргүүлэгчдийг алга болгосноор дээр дурдсан асуудлууд шууд шийдэгдэхгүй нь мэдээж хэрэг. Иймээс Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа ИТХ-ыг байнгын ажиллагаатай болгох, хороод болон Хурлын бусад үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр судалгаа хийж, тодорхой үзэл баримтлалтайгаар асуудалд хандах нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Монгол Улсын Үндсэн хууль, УБ. 1992 -- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем -- www.legalinfo.mn (2015.05.01-нд хандсан)
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, -- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем -- www.legalinfo.mn (2015.05.01-нд хандсан)
3. Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх, УБ. 1985
4. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд, УБ. 1998
5. Ширэндэв Б., Монгол Ардын Хувьсгалын түүх, Засч залруулсан 2 дахь хэвлэл. УБ. 1999.

Орос хэлээр

6. Конституция Российской Советской Федеративной Социалистической Республики 1918 года - http://supol.narod.ru/archive/official_documents/const1918.htm (2015.05.01-нд хандсан)
7. Конституция Союза Советских Социалистических Республик 1924 года - <http://www.tarasei.narod.ru/konst1924.htm> (2015.05.01-нд хандсан)
8. Конституция Союза Советских Социалистических Республик 1936 года - <http://www.tarasei.narod.ru/konst1936.htm> (2015.05.01-нд хандсан)
9. Рачковский В.А., “Петроградский Совет рабочих и солдатских депутатов в феврале-марте 1917 г. в воспоминаниях социалистов (Часть I) – “Новейшая история России” сэтгүүл, 2011, №2, 22-34 дахь талууд --<http://history.spbu.ru/journal-nir> (2015.05.01-нд хандсан)

Англи хэлээр

10. Англи хэлний тайлбар толь бичгийн ерөнхий сайт --<http://dictionary.reference.com/browse/presidium?s=t> (2015.05.01-нд хандсан)

Герман хэлээр

11. Пруссын Ландтагийн тухай ерөнхий мэдээлэл -- http://de.wikipedia.org/wiki/Preu%C3%9Fischer_Landtag (2015.05.01-нд хандсан)
12. ХБНГУ-ын Бундестагийн албан ёсны сайт -- <http://www.bundestag.de/bundestag/praesidium/> (2015.05.01-нд хандсан)

А.ИДЭРПҮРЭВ

Төв аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
Удирдахуйн ухааны магистр

“НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ”

Монголын Нутгийн Удирдлагын Холбооноос эрхлэн гаргадаг “Нутгийн удирдлага” сэтгүүлийн захиалагч, байнгын уншигчийн хувьд тус Холбоо болон ХБНГУ-ын Конрад-Аденауэр сангаас хамтран сүүлийн жилүүдэд төр, засгийн түвшинд хамгийн эрчимтэй яригдаж байгаа сэдэв болох Төвлөрлийг сааруулах замаар орон нутгийн биеэ даасан байдлыг сайжруулж, НӨУБ буюу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын үйл ажиллагааг нь төгөлдөршүүлж боловсронгуй болгох арга замыг тодорхойлох, хууль эрх зүйн хүрээг шинэчлэх ямар боломж бололцоо байгааг харж дүгнэж байгааг нь тодруулж ухааныг нь уудлаж, санааг нь саах улсын уралдааныг эрдэмтэн, судлаачид, оюутан залуусын дунд зарласныг саяхны дугаараас олж уншив. Миний бие анх 10 гаруй жилийн өмнө төрийн албанд орохдоо ИТХ хэмээх байгууллагын үүдийг татан орсон, энэ байгууллагаараа олон жил овоглон дотор нь ажиллаж ирсний хувьд бусдын адил Нутгийн удирдлагын байгууллагуудын эдүгээ хийгээд ирээдүйн хувь заяанд нь хэрэндээ санаа тавьж явах ёстой хүмүүсийн нэг гэж бодож явдаг билээ. Тиймээс Хурлуудын маань чадамжийн өнөөгийн байдал, хууль эрх зүйн хүрээ, орон нутагт бидний өмнө тулгамдаж буй зарим бэрхшээлүүд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаарх санал бодлоо дараахь цөөхөн зүйлээр илэрхийлж байна.

Нэг. Орон нутгийн хөгжилд орон нутгийнх нь Удирдах байгууллагын бие даасан байдал, **асуудлаа өөрөө шийдэх эрх хэмжээ** хамгаас чухал:

Сүүлийн жилүүдэд Төв Засгийн газрын эрх хэмжээг багасгах, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх замаар төвлөрлийг сааруулах, орон нутгийн биеэ даасан байдлыг хангуулах, НӨУБ-ын эрх хэмжээг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх

гэж дээд доод шатандаа их ч ярилаа, эрдэмтэн судлаачид ч их судлалаа, дарга мяндагтнууд гадаад дотоодын арга барил туршлагыг бишгүй л судлаж энд тэнд Хурал зөвлөгөөн, бүсийн хэмжээний уулзалт ярилцлага гээд их л олон ярьсан, ярьж ч байгаа. Эдгээрээс өчнөөн төчнөөн үнэтэй, зөв, саналдүгнэлтүүд гардаг, тэрийг нь УИХ, Яам Тамгын газрынхан үг үсэггүй шахам бичиж тэмдэглэж аваад сайхан хуультай болохын ерөөл өргөөд явдаг хэдий ч харамсалтай нь түүнийг нь хүлээж авдаг, шийдвэрлэдэг, ажил хэрэг болгодог төр Засгийн байгууллага, албан тушаалтан гэж байна уу үгүй юу гэлтэй. Дөрвөн жилийн өмнө ярьсан зүйлүүд дөрвөн жилийн дараа бараг л хэвээрээ байгаад буйг бараг худлаа гэхгүй байх. Хамгийн гол нь эрх мэдэл хамгаас хүчтэй байдаг гэдгийг УИХ-ын гишүүд, сайд дарга нар маань хамгийн сайн ойлгодог бөгөөд аймаг, сумыг удирдаж яваа өөрсдөөсөө жижиг дарга нарт тэр эрх мэдлийг нь өгөхийг хүсдэггүйтэй шууд холбоотой. Харин үүнд хамгийн их сэтгэл санаа зовж амаа цангатал, хэлээ хөштөл ярьдаг хүмүүс нь өнөөх л НӨУБ-ын үндсэн албан хаагч /ИТХ-ын нарийн бичгийн дарга, Ажлын албаны ажилтнууд, Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга гээд цөөхөн дөө/ цөөхөн хүн байх шиг. Өөрөөр хэлбэл манай оронд хийгдэж байгаа төвлөрлийг сааруулах үйл явц үр дүн, амжилт ололт багатайхан шиг асар удаанаар урагшилж байна гэж дүгнэж болно.

Дэлхий нийтийн жишгээс харвал орон нутгийн удирдлагын бүрэн эрхийг тухайн улс Үндсэн хуулиараа, эсхүл Нутгийн удирдлагын бие даасан хуулиар л тогтоодог. Монгол улс 1990 онд Ардчилал руу шилжих шилжилтийг хийхдээ социализмын үеийн гэгддэг аж ахуйн зохион байгуулалтыг дагасан засаг захиргааны нэгжүүд бүхий Ардын Депутатуудын Хурал, түүний гүйцэтгэх захиргаа болон нэг намын удирдлага дор төвлөрсөн төвөөс бүрэн хараат, социалист ардчилсан төвлөн удирдах зарчимд тулгуурласан тогтолцоотой тулгарсан гэж судлаачид тодорхойлдог. Иймд манай улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүтэц зохион байгуулалт, түүний удирдлагыг боловсронгуй болгон шинэчлэх шаардлага зүй ёсоор тавигдсан юм. Нутгийн удирдлагын бие даасан байдлыг хангах оролдлогуудыг 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш бид /2002 онд “Төсвийн байгууллагын удирдлага,

санхүүжилтийн тухай” хууль, 2006 онд шинэчлэн найруулсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль, 2011 онд батлагдсан “Төсвийн тухай” хууль, “Орон нутгийн хөгжийн сан” гэх мэтийг нэрлэж болно/ хийж ирсэн хэдий ч бүрэн дүүрэн амжилт хараахан олоогүй л байна.

Монгол улсын “Үндсэн хууль”-ийн 58 дугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж заасан нь бий. Ухаж тунгаавал энэ заалт нь бидний яриад байгаа Нутгийн удирдлагыг бүрэн утгаар нь баталгаажуулсан Үндсэн хуулийн том заалт гэж ойлгож болно. Харин “эдийн засаг, нийгмийн цогцолбор” гэж юуг хэлж байгааг нарийн тодорхойлсон зүйл одоогоор алга байх шиг байна. Гэхдээ сонгодог утгаараа орон нутгийн Засгийн газар буюу орон нутгийн бие даасан засаг захиргааны шинжийг дараахь байдлаар тодорхойлсон¹ байдаг. Үүнд:

1. Үндсэн хуулийн дагуу тухайн нутаг дэвсгэртээ эрх барих чиг үүргийг хэрэгжүүлж, орон нутгийн үйлчилгээний талаар хариуцлага хүлээдэг.
2. Санхүү, төсвийн хувьд бие даасан, орлогоо өөрөө бүрдүүлэх эрх мэдэлтэй.
3. Боловсон хүчнийг томилох, ажлаас халах, албан тушаал дэвшүүлэх эрх мэдэлтэй.
4. Олонхийн намаас сонгогдсон Хурлын байгууллага орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, дотооддоо мөрдөх дүрэм, журам гаргадаг.
5. Төрийн захиргааны төв байгууллагуудын албан тушаалтнууд зөвхөн зөвлөгөө өгөх, мэргэжлийн хяналт хийх чиг үүрэгтэйгээс биш орон нутгийн бүрэн эрхэд хамаарах асуудалд оролцдоггүй байх. гэжээ. Эдгээрээс үзвэл манай Нутгийн удирдлагын байгууллагууд 2 ба, 3 дахь үзүүлэлтийн хувьд ямар ч эрх мэдэлгүй, 5 дахь үзүүлэлтийн хувьд хагас дутуу гэмээр эрх мэдэлтэй

1 Махвуд. П. “Засаглал, захиргаа ба хөгжил: Төрийг ажиллагаатай болгох нь”, Макмиллан пресс, 1997 он. тал-160.

байгаа дүр зураг нүдэнд бууж байна.

Орон нутгийн Удирдлагын байгууллагуудад яг ийм 5 эрх хэмжээ бүрэн олгогдсон цагт л бидний Нутгийн удирдлагын байгууллагуудын төгөлдөршил, Төвлөрлийг сааруулах гэсэн сайхан яриа биелэлээ олох юм. Төвлөрөл их байгаагийн хамгийн наад захын жишээ бол төр захиргааны ихэнх байгууллагуудын босоо тогтолцоо юм. Сумын удирдлагууддаа захирагдахаа байсан том толгойтой мэргэжилтнүүд цөөнгүй болжээ. Тухайлбал Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар. Тэднийг аймгийн МХГ-аас ерөнхий удирдлагаар хангаж томилох, чөлөөлөх эрхийг нээж өгсөн нь ихээхэн буруу юм. Бүр үр дүнгийн гэрээ байгуулах, ямар ажил үүргийг гүйцэтгэхийг нь бараг бүгдийг нь аймаг, сумаас хамаарахгүйгээр дээд байгууллагаас нь шийдвэрлэж байна.

Энэ мэтийн удирдлагын босоо тогтолцоо нь хүний нөөцийн асуудлаа, санхүүгийн асуудлаа, өөрөө бие даан хийх орон нутгийн эрх мэдлийг боомилж сулруулан төвлөрлийг дээш нь хүчтэй татаж байгаа юм. Өөрөөр хэлбэл нутаг орондоо үнэхээр эзэн нь л гэгдэж байгаа хуулиар олгогдсон эрх хэмжээтэй, түүнээ хэрэгжүүлснийхээ төлөө үүрэг бас хариуцлага хүлээдэг байгууллага болох нутгийн Удирдлагын байгууллагууд нь төсөв, санхүүгийн хувьд төвөөсөө бүрэн хараат бус, орлогоо өөрөө бүрдүүлж өөртөө зарцуулах эрх мэдэл нээлттэй, боловсон хүчнийг аливаа албан тушаалд томилох, чөлөөлөх, хариуцлага тооцох эрхтэй байж гэмээнэ орон нутаг өөрөө жинхэнэ утгаараа бие даан хөгжих “нутагтаа эзэн нь байж нутгаа өөрсдөө удирдах” бололцоо бүрэн бүрдэнэ. Төсөв, санхүүгийн хувьд манай орон нутгийн удирдах байгууллагууд үнэхээр хомс эрх мэдэлтэй юу гэвэл тиймээ. Үүнийг нэгэн судлаач тогоотой өрөм загсаасан сүүгээр жишээлсэн удаатай. Өөрөөр хэлбэл Төв Засгийн газраас орон нутгийн удирдлагуудыг шахаж шахаж цуглуулсан татварын хэдэн төгрөгийг /өрмийг нь Засгийн газар, сүүг нь дунд шатны захиргааны нэгж хамж аваад хусам нь суманд үлдэж байгаагаар жишээлсэн/ шат шатандаа танаж багасгасаар жинхэнэ хөрөнгө санхүү хэрэгтэй шаардлагатай нэгж дээр нь бараг юу ч үлдээхгүй хамдаг явдлыг бид олон ч жил ярилаа.

Хоёр. Нутгийн удирдлагууд давхардсан олон эрх мэдлээ алийг нь хэрэгжүүлэх вэ?

Дараагийн нэг зүйл бол яалт ч үгүй эрх мэдэл, чиг үүргийн давхардалгүй хуулиудтай болж түүнээ ягштал мөрдөх явдал чухал.

- Төрийн институцүүдийн эрх мэдэл, чиг үүрэг нь хоорондоо харилцан уялдаагүй зохион байгуулагдвал хариуцлагын тогтолцоо ихээхэн сулрах магадлалтай. Манай улсын “Үндсэн хууль”, ба “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д аймаг-нийслэл хоёр, сум-дүүрэг хоёр, баг-хороо хоёрыг хооронд нь гүйцэтгэх чиг үүрэг, эрх мэдлийнх нь хувьд төдийлэн нарийн зааж өгөөгүйгээс болоод чиг үүргийн давхардал их харагддаг. Өөрөөр хэлбэл аймаг, нийслэл, сумын Засаг дарга нар хоорондоо яг адилхан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг учраас шат шатандаа нэг адил асуудлаар өөр өөр шийдвэр гаргах магадлал байгааг орон нутгийнхан хэлдэг, хэлсээр л байгаа.

Иймд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29-ийн 1-д заасан “**Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх**”² гэснийг дотор нь хот хөдөөд хэрэгждэг хэрэгждэггүй ажил асуудал, хийгддэг хийгддэггүй ажил асуудал тус бүрээр нь ялган зааглаж эрх хэмжээг нь тус тусад нь зааж өгөх нь чухал байна. Эдгээр олон үүрэг бүхий заалтууд дотор сум, дүүргийн Засаг даргын эрх мэдэл дангаараа хүрч шийдэхээгүй асуудал ч бий. Цаг үе маань өдөр хоногоор шахуу шинэчлэгдэж өөрчлөгдсөөр байхад цаасан дээр бичсэн хууль маань хуучнаараа байсаар байхуу.

Мөн Үндсэн хуулийн “НӨУБ-ын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно”³ гэсэн НӨУБ-уудын эрх хэмжээг заасан том заалт бий. Энэ том заалт бол НӨУБ-д бараг бүх эрх мэдлийг л өгчихсөн утгатай заалт. Гэвч сайтар харвал аймаг, сумын ИТХ-ууд хоёулаа адилхан НӨУБ бөгөөд хоорондоо мөн л нэг асуудлаар өөр өөр байр суурьтай байвал /аймгийн ИТХ, сумын ИТХ-ууд нутаг дэвсгэр дээрээ нэг

2 “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт.

3 Монгол улсын “Үндсэн хууль”-ийн 62 дугаар зүйлийн 2 дахь заалт.

асуудлаар өөр өөр шийдвэр гаргасан байвал/ хэнийх нь зөв болох нь ихээхэн бүрхэг байгаа юм. Дээр нь энэ заалт өмнөх буюу 62-ын 1 дэх заалтаараа бүүр ч баталгаажихсан заалт. Гэвч бодит амьдралд огт хэрэглэгддэггүй шахам энэ заалтыг хэрэглэж үүнийг үндэслэж шийдвэр гаргаж байгаа Хурлууд хэр олон байгаа бол. Иймд эдгээр асуудлыг анхааралтай судлаж аймаг, сумын ИТХ-уудын хооронд ямар ч маргаан гаргахгүй байдлаар чиг үүрэг, эрх мэдлийг нь оновчтой хуваарилах шаардлагатай байгаа юм.

Нутгийн Өөрөө Удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно гэсэн том заалтыг барьж Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй шийдвэр гаргасан Булган аймгийн нэг сумын ИТХ-ынх шиг явдал бидэнд олон тохиолдвол хэрхэх вэ?.

Үүн дээр цаг үеийн нөхцөл байдал, хөгжил дэвшилд гарч буй өөрчлөлтүүдийг дагаад “хот” хэмээх засаг захиргааны нэгжийн асуудал хурцаар тавигдах боллоо. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт хийгдэх талаар хаа хаанаа ярьж /УИХ-ын гишүүд, улс төрийн намуудын шахалт, зөвшилцлийн үр дүнгээр/ зарим жижиг өөрчлөлтүүд орж байгаа хэдий ч “хот”-ын асуудлыг орхигдуулсаар /хотын асуудал зөвхөн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн цөөн заалт, Үндсэн хуулийн хавсралт хуулиар л зохицуулагдаж байна/ байгаа юм. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хот өөрөө нийслэлийн хэмжээний бүхий л ажил /автомашин дугаарлалтын хязгаар, тамхи татах цэг байгуулах, бүр реклам сурталчилгааны самбаруудыг хүртэл татан буулгах эсэхийг нийслэлийн ИТХ-аас шийддэг/ асуудлыг хэлэлцэн шийддэг мөртлөө Дүүрэг бүхэнд ИТХ ажиллаж байгаа, тэдгээрийн үйл ажиллагаа, зорилго, эрх хэмжээ нь бас л бүрхэг байна, давхардаад байна. Иймд нийслэл, дүүргүүдийн ИТХ-уудыг хооронд нь нэгтгэх нь зүйтэй юмуу, эсхүл алиныг нь татан буулгах эсэхийг шийдмээр цаг нь болсон.

Одоо хотын гадна байрлах дүүргүүд нь өөрсдөө “дагуул хот” болох асуудлаа санаачлан хэлэлцэн шийдвэрлээд эхэлж байгаа, залгуулаад үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын ажлыг дагаад суурьшлын шинэ шинэ

бүсүүд бий болж хотууд шинээр үүсэх /Хөшигийн хөндий дэх Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг дагасан “Шинэ Зуунмод хот”, Сэргэлэн сумын нутагт баригдаж буй Майдар бурханы цогцолборыг дагасан “Майдар сити” нэртэй хотууд байгуулагдвал тэндхийн засаг захиргаа, нутгийн удирдлагын байгууллагын асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь ойлгомжгүй байгаа/ явдал эхэлж байна. Дээр нь Төв засгийн газраас хийж буй хөрөнгө оруулалт, хүн амын шилжилт суурьшилтай холбогдоод аймгуудын төвийн сумдад ч хотын статус үүсээд байгаа нөхцөл байдлыг анхаарч Үндсэн хуулинд цогц байдлаар өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Гурав. ИТХ-ын Төлөөлөгчдөөс их юм шалтгаалдгийг хэлэх ёстой:

“Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна, Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ”⁴ гэж заасан. УИХ-ын гишүүнээр ч тэр аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр ч тэр жинхэнэ орон нутаг, ард иргэдээ боддог тэдний эрх ашгийн төлөө ажиллаж чадах хүнийг л сонгомоор. Ялангуяа төрийн албан хаагчдыг сонгуульд нэр дэвших өрсөлдөх, төрийн албан хаагчид ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдон ажиллахыг хуулиар хориглосноос хойш орон нутгийн Хурлуудын чадавх нилээдгүй суларсан. Өөрөөр хэлбэл Хурлуудын чадамж төлөөлөгчөөсөө бүрэн хамаарна гэдгийг сонгогч түмэн маань сайн мэдэж байх ёстой. Сонгуулиас сонгуульд төлөөлөгчдийн чадамж туршлага чанаржиж байгаа гэх боловч улс төрийн намаас нэр дэвшдэгийнхээ хувьд намын бодлогыг баримтлах, аливаа асуудалд улс төржих байр сууринаас хандах, хуралдаанд үг хэлж, санал бодлоо илэрхийлэхдээ намын юмуу эсхүл өөрийнхөө хувь хүний үзэл болдлоо түлхүү илэрхийлдэг төлөөлөгчид олширчээ. /Угтаа ИТХ-ын төлөөлөгч бол намайг сонгосон, манай тойргийн сонгогчид энэ асуудлаар ийм байр суурьтай байгаа, ийм саналтай байгаа гэдгийг хурал дээр хэлж илэрхийлэх, түүнийг Хурлын шийдвэр болгохын төлөө л ажиллах ёстой хүмүүс/

4 Монгол улсын “Үндсэн хууль”-ийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт.

Бидний гол баримтлан ажилладаг хууль болох “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”⁵-д төлөөлөгч хүн гэж хэнийг хэлэх, ямар үйл ажиллагаа явуулах ёстойг тодорхой зааж, тэдний бүрэн эрх, үйл ажиллагааны баталгааг нарийн зааж өгсөн хэрнээ хариуцлагын талыг сох орхигдуулсан гэж хэлж болно. Иймд Нэгжийн хуулинд хуулиар хүлээсэн үүрэг, бүрэн эрхээ хангалттай хэрэгжүүлээгүй, сонгогч олон түмнийхээ болон нутаг орныхоо эрх ашгийн эсрэг ажилласан намжсан, улс төржсөн, ашиг сонирхолд автсан төлөөлөгчийг эргүүлэн татах эрхийг нь сонгогч иргэдэд нь мөн өгөх хэрэгтэй. Ингэж төрийн хуулиар иргэнийхээ сонгох эрхийг нь илүү баталгаажуулж, тэр эрхийг нь бүрэн дүүрэн эдлүүлэх нь зүйтэй юм. Хийх ёстой ажлаа хийгээгүй буюу амласан амлалтаа биелүүлдэггүй, гүйцэтгэх ёстой үүргээ гүйцэтгээгүй улс төрийн намын утсан хүүхэлдэй болж ажилладаг иргэдийн төлөөлөгч нэртэй намуудын төлөөлөгчдийг сонгогч иргэд нь өөрсдөө саналаа өгөөд буцааж татдаг хуулийн хатуу заалттай болчихвол ИТХ-ын төлөөлөгчид эрх биш амласан амлалтаа хэрэгжүүлэхийн төлөө нутаг орноо бодож сайн ажиллах хөшүүрэг бий болох нь магад.

Ер нь тэгээд зөвхөн Засаг дарга л асуудал өргөн барьж хэлэлцүүлэхгүй бол дүлий юм шиг суугаад байдаг Хурлууд байх нь НӨУБ-ын нэр хүндэд ихээхэн халтай. Мөн ИТХ-ууд сонгуулиас сонгуулийн хооронд ард иргэдээ сонгууль өгөхөд нь бэлддэг, хүнээ танихад нь тусладаг, өмнөх бүрэн эрхийн хугацаанд сонгосон төлөөлөгч нь хэрхэн ажилласныг нь сонгуулийн өмнө сонгогчдод нь тайлагнадаг байвал бүр ч зүгээр мэт. Ийм зүйлийг бодож тооцоолж хийхгүй бол сонгуульд оролцох сонгогчдын ирц, идэвх сонгуулиас сонгуулийн хооронд буурсаар, төр засагтаа итгэх иргэдийн итгэл үнэмшлийг ч сулруулах сөрөг хандлага гаргах магадлал үүсэж байна. Үүнийг 1990-ээс 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн ирцийн дүн бүхий дор дурьдсан судалгаанаас тодорхой харж болохоор байна.

5 Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 12, 13, 14 дүгээр зүйлүүд.

Он	Бүртгэлтэй сонгогчийн тоонд эзлэх хувь	Сонгуулийн насны хүн амд эзлэх хувь
2012 он	65.24%	56.24%
2008 он	74.31%	60.47%
2004 он	81.84%	64.91%
2000 он	82.42%	70.96%
1996 он	88.39%	73.64%
1992 он	95.60%	86.11%
1990 он	98%	87.23%

Эх сурвалж: Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн, IDEA <http://www.idea.int/vt/countryview.cfm?CountryCode=MN>

Дөрөв. ИТХ-ын Тэргүүлэгчид гэсэн бүтэц хэрэгтэй юу?

Хурлын хуралдааны чөлөө цагт Тэргүүлэгчдийн эрх, үүрэг хэрэгжинэ. Харин хэрхэн юуг яаж шийдвэрлэж, ямар шийдвэр гаргаснаа тэд Хуралдаанд тайлагнах ёстой. Ингэж Хурал гэдэг субъектийн тасралтгүй үйл ажиллагаа амьдралд хэрэгжинэ. Тэргүүлэгчдийн үндсэн эрх үүрэг нь мөн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д суусан байдаг ч “**Тэргүүлэгч**” гэх нэр томъёог хэрэглэдэг орон дэлхийд Хятад манай хоёроос өөр байхгүй. Тэргүүлэгчид нь хуульд заасан ёсоор тухайн Хурлынхаа Анхдугаар хуралдаанаар ИТХ-ын даргыг оролцуулаад аймаг, нийслэлд долоогоос арван нэг, сум, дүүрэгт бол таваас долоон төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаатайгаар сонгогдох ёстой.

ИТХ-уудын үйл ажиллагаагаа явуулах дотоод зохион байгуулалтын нэг хэлбэр нь Хурлын Хороод бөгөөд Хороодыг нэг нэг Тэргүүлэгч ахлан ажиллаж байгаа. Хурлуудын чадамжийг дээшлүүлэх үүднээс мөн л нэгжийнхээ хуулинд өөрчлөлт оруулах замаар хийж үзэх нэг зүйл бол Тэргүүлэгчид нэртэй бүтцийг үгүй болгоод харин үүний оронд Хороодын мэргэшсэн байдал, Хороодын хуралдаанаар хурлын ажлын дийлэнхийг үр дүнтэй бөгөөд чанартай хийлгэх боломж байгаа юм. Тэргүүлэгчид бол ИТХ-д төлөөлөл болж сонгогдсон төлөөлөгчдийн төлөөлөл болж байгаа гэдэг утгаараа маш

их үүрэг, хариуцлага үүрсэн хүмүүс байх ёстой юм. Гэтэл бодит байдлаас харвал Тэргүүлэгчдийн хуралдаанаар ИТХ-д хандсан дийлэнх асуудал хэлэлцэгдэн шийдвэр болж гардаг, тэр хэрээрээ шийдвэрт нь улс төрийн нөлөөлөл орох, бас хариуцлагагүй шийдвэр гарах магадлал маш өндөр байна. Тухайлбал: нэг аймаг дунджаар 90 орчим мянган хүн амтай гэж үзвэл Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, аймаг, сум, дүүргийн ИТХ-ын Сонгуулийн тухай хуулиудын дагуу дөчин нэгэн төлөөлөгч сонгогдоно, тэдгээрээс арван нэгэн Тэргүүлэгч сонгогдон Хурлын чөлөө цагт бүрэн эрхийг нь хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэтэл арван нэгэн Тэргүүлэгчийн хуралдах ирцийн хүчинтэй хувь хамгийн доод тал нь зургаа. Зургаан Тэргүүлэгч хуралдаад, олонх буюу дөрвөн хүн гар өргөөд 90 мянган хүний эрх ашигтай холбоотой асуудлыг бүрэн утгаар нь хэлэлцэн шийдвэрлээд явах боломж бий юу гэвэл эргэлзээ бий. Үүний оронд ИТХ-ын Хороод асуудлыг олон талаас нь сайтар шүүн тунгааж Хурлын хэлэлцэх асуудалд гол үүрэг хүлээж нөлөө үзүүлдэг явдлыг хуулинд зааж өгөх нь Хурлуудын үйл ажиллагааны боловсронгуй байдал, гарах шийдвэрийн чанар чансаанд ихээхэн нөлөө үзүүлж болохоор байна. Товчоор хэлбэл хурлын Хороод бол асуудлыг хариуцсан салбарынхаа хүрээнд сайтар судлаж, судалгаа дүгнэлтэд тулгуурлан шийдвэрийн төслийн чанарыг аль болох дээшлүүлэхийн төлөө ажилладаг бол Тэргүүлэгчдийн хувьд зөвхөн тухайн өдрийн хуралдаанаар хувь хүн бүрийн гаргаж буй санал, дүгнэлт, магадгүй сэтгэл хөдлөлөөр асуудалд хандаж шийдвэр гаргах явдал түгээмэл маягтай ажиглагддаг.

Тав. ИТХ-ын даргаар томилогдох хүнд хуулийн шалгуур хэрэгтэй байна:

Өнөөгийн цаг үе шиг хувь хүний мэдлэг, боловсрол, чадвар чадавхийг эрхэмлэсэн нийгэмд ИТХ-ын даргаар тааруухан нэгэн томилогдон ажиллах нь орон нутгийн хөгжил дэвшил, Хурлын байгууллагын цаашдын хувь заяанд ихээхэн халгаатай. Ер нь ч тэгээд аливаа байгууллагын үйл ажиллагааны үр дүн сайн муу байх нь дарга, удирдлагаасаа ихээхэн шалтгаалдагийн адил ИТХ-ын даргын чадавхи, ёс зүй, эзэмшсэн боловсрол, мэргэжлээс ИТХ-уудын нэр хүнд, чадамж багагүй шалтгаалж

байх шиг санагддаг.

Харин Засаг дарга буюу ИТХ-ын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг албан тушаалтан нь “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулиар энгийн гэмээр таван зүйлийн шалгуураар тавигддаг. Гэтэл Засаг даргын дээдх гэж хэлж болох албан тушаалтан буюу орон нутгийн эрх барих дээд байгууллагын хамгийн том албан тушаалтан, Засаг даргыг үйл ажиллагааг нь удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилладаг байгууллагыг толгойлдог хүн нь ямар ч шалгуургүй хэтрүүлж хэлвэл бараг сургууль төгсөөгүй байсан ч хамаагүй этгээд намдаа өгсөн мөнгөнийхөө хэмжээгээр, эсхүл зохион байгуулалттай хуйвалдаанаар томилогдох явдал өнгөрсөн сонгуулийн үр дүнгээр олонтаа гарсан.

Ийм шалгуургүй Хурлын дарга нар олон томилогдоод байвал өндөр боловсрол эзэмшсэн, мэргэжил нь мэргэшил болж төлөвшсөн Засаг дарга нар өөрөөсөө мэдлэг чадвараар хол дутуу хүнээр үйл ажиллагаагаа удирдуулж чиглүүлгэж ажиллахгүй нь лав биш үү.

Ер нь төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид бүгд өөр өөрийн гүйцэтгэх чиг үүрэгтээ нийцсэн шалгуурыг хангасан тохиолдолд тухайн ажил албандаа томилогддог. Гэтэл хуулиар ИТХ-ын дарга хэмээх албан тушаалд тодорхой шалгуур тавиагүйгээс болоод ямар ч мэргэжил, мэргэшлийн чадавхгүй, дээр нь ёс зүйгүй, улс төрийн наймааны хор найруулгаар томилогдсон ИТХ-ын дарга нар орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлдог байгууллагыг чиглүүлж удирдах нь битгий хэл Хурлын хуралдаанаа ч нээж удирдаж чадахааргүй явдал гаргаж ард иргэддээ гологдон Хуралдааны танхимдаа эмгэнэлт-инээдмийн жүжгийн баатрын дүрд тоглох явдал цөөнгүй гарч байна. Ийм явдал 2012 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан сумдын ИТХ-уудад олон байгааг ард иргэд одоо ч ярьсаар байна.

Зургаа. Төгсгөл хэсэг буюу Хуулиар л зохицуулах шаардлагатай гээд Хурлууд гар амар суугаад байгаа юм биш байгаа?!

Монголчууд бид “Айлаас эрэхээр авдараа уудал” гэдэг дээ. Бусдын гар харж суухаар өөрт буй нөөц бололцоо давуу талаа

ашиглаад хийх ёстой, хиймээр байгаа ажлуудаа гүйцэлдүүлж л явах ёстой. Бүхнийг төр Засгаас шийдэж өгөх ёстой гэсэн гар, ам харсан байдлаар бид урагшаа ахихгүй нь тодорхой байна. Энд НӨУБ-уудын үйл ажиллагаатай холбоотой гол зүйлийн талаар дурьдахыг зорив. Өнөөдөр манай оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон арван хууль /500 орчим/ тогтоомж байна. Эдгээрээс 200 орчим хуулиар нь Хурлуудад эрх олгогдсон байдгийг судлаачид, НӨУБ-ынхан тодорхойлжээ. Харин энэ олон хуулиар олгогдсон эрх хэмжээгээ бид бүрэн эдлэж хэрэгжүүлж чадаж байгаадаа дүгнэлт хийж үзэх нь зүйтэй мэт. Өнгөрсөн онд хэрэгжсэн НӨУБ-уудын чадавхийг бэхжүүлэх төслийн сургалтын дараа нэг сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудад шинжилгээ хийж хичнээн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлснийг нь үзэхэд “Төсвийн тухай хууль”, “Байгаль орчны тухай багц хууль”, “Ашигт малтмалын тухай хууль”, “Нийгмийн салбарын зарим хуулиуд” гээд 40-өөс 50 орчим л хуулин дотор эргэлдсэн судалгаа гарсан. Гэтэл цаана нь их олон хуулиар хүлээсэн үүргээ Хурлууд хэрэгжүүлэхгүй орхигдуулаад байх шиг. Үүнээс үзвэл бид өөрийнхөө бүрэн хүчин чадлаар ажиллаж чадаж байгаа эсэхдээ эргэлзэж болохоор байна шүү дээ. Энэ судалгааг бусад аймаг, сумдын Хурлууд өөр өөр дээрээ бас хийж үзэх хэрэгтэй байх. төсөв санхүү, эдийн засаг хүндрэлтэй, боломж бололцоо хомс энэ цаг үед Хурлууд үнэт цаас хүртэл гаргах эрхтэй шүү дээ.

Төгсгөлд нь хэлэхэд Хурлууд маань шийдвэр гаргах чадамжаа маш сайн бодолцох учиртай. ИТХ-уудын шийдвэр гаргалтын үйл явц нь иргэд, олон нийтэд илүүтэй хандсан, тэдгээрт тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байдгаараа бусад удирдлагын түвшнийхээс онцлогтой. Өнөөгийн байдлаас ажиглавал Хурлын төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтнууд нь өдөр тутмын үйл ажиллагаагаа илүү үр дүнтэй эрхлэн явуулахдаа аливаа мэдээлэл цуглуулах үр дүнтэй хялбар арга замыг сонгох, судалгаа шинжилгээний энгийн арга зүйг эзэмших шаардлага зүй ёсоор тулгарч байгаа юм. Бүх шатны ИТХ-уудын гол үндсэн үүрэг бол тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлийн ойр болон алсыг харсан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, нөгөө талаар нутаг дэвсгэртээ дүрмийн засаглалыг хэрэгжүүлэх дүрэм,

журам боловсруулан батлах явдал юм. Эл хоёр үндсэн үүргийн аль алиныг төлөвлөх боловсруулахад судалгаа зайлшгүй хийх шаардлагатай. Судалгаагүй бодлого, шийдвэр гаргавал үнэн бодит байдалд тохирохгүй амьдралд нийцээгүй, үндэслэлгүй болно. Өөрөөр хэлбэл тийм бодлого, шийдвэр бодитой хэрэгжихгүй гэсэн үг.

Бодлого, шийдвэр маань аль болох үнэн бодит шинжлэх ухаанч судалгаанд үндэслэж чадвал шийдвэр нь төдий чинээ оновчтой, амьдралд үр ашигтай, хэрэгжих боломжтой болдог тул Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болгон орон нутгийнхаа хөгжлийн дүр төрхийн нарийн шинжээч, дүгнээч нь болж ажиллах ёстой гэсэн үгээр энэхүү эссэг өндөрлөж байна.

Орон нутгийн хөгжил ойрхон байгаа шүү Хурлынхаан!

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

1. Монгол улсын “Үндсэн хууль” 1992 он.
2. Монгол улсын Үндсэн хуулийн хавсралт хууль.
3. Монгол улсын “Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” 2006 он.
4. Монгол улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хууль.
5. Махвуд, П. “Засаглал, захиргаа ба хөгжил: Төрийг ажиллагаатай болгох нь”, М.пресс, 1997 он.
6. Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэнгээс явуулсан судлагааны тайлан.
7. А.Идэрпүрэв. “ИТХ-ын төлөөлөгчдөд судалгаа шинжилгээ хийх арга зүйг эзэмшүүлэх нь” ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалтын гарын авлага. 2015 он.
8. А.Идэрпүрэв. “Хяналт шинжилгээ, үнэлгээ буюу ИТХ-аас шийдвэрийн биелэлт тооцох нь” ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалтын гарын авлага. 2015 он.
9. А.Идэрпүрэв. “ИТХ-ын Хороодын үйл ажиллагаа Хурлын шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх нь” магистрын судалгааны ажил. 2015 он.
10. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх хэмжээг зохицуулж байгаа Монгол улсын хуулийн заалтуудын эмхэтгэл. Зуунмод. 2014 он.

ПҮРЭВИЙН БААСАНДУЛАМ

Хөгжлийн түүчээ сангийн санхүүч
Санхүү эдийн засагч

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭДИЙГ ОРОЛЦУУЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Төрийн байгууламжийн хувьд ямар ч хэлбэртэй байсан төв, орон нутаг гэсэн ойлголт аль ч улс оронд байдаг. Орон нутгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаа нь улсын болон орон нутгийн төсвийн бодлогоор дамжин хэрэгждэг бөгөөд орон нутгийн төсөв нь орон нутгийн санхүүгийн салшгүй хэсэг болж, орон нутгийн удирдлагын бүхий л үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг удирдах, зохицуулахад чиглэгддэг.

Төр болон орон нутгийн засаг захиргаанаас нийлүүлэх үйлчилгээний төрлийг хүн амын эрэлт, хэрэгцээг хангахуйцаар сайжруулан зохион байгуулах, орон нутгийн хүрээнд тухайн нутаг дэвсгэр дэх нөөцийг ашиглан эдийн засгийн бодлого, ажил эрхлэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, мөн ахуйн болон нийгмийн амьдралын түвшинг сайжруулах нь орон нутгийн төсвийн гол үүрэг бөгөөд үүнд орон нутгийн төсвийн орлого зонхилох байр суурийг эзлэх ёстой.

Зах зээлийн харилцаанд нийцүүлэх үүднээс татвар, төсвийн шинэчлэлийг манай улс хэрэгжүүлж эхэлснээр орон нутгийн төсвийн байдалд ихээхэн өөрчлөлт орж байна. Гэвч Монгол улс дахь энэхүү шинэтгэлийн үр дүн орон нутгийн түвшинд төдийлөн сайн гарч өгөхгүй байгаа нь улсын болон орон нутгийн төсвийн харилцаа зүй зохистой бус, ялангуяа орон нутгийн төсвийн биеэ даасан байдал сул байгаатай холбоотой гэж ойлгож байна. Төсвийн тухай хуулинд шинэчилсэн найруулга хийж татвар, төсвийн шинэчлэлийн хүрээнд төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн бие даасан байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг нь зүй ёсоор урган гарч байна.

Иймээс дээрх хосломол үйл ажиллагаануудыг хооронд нь уялдуулах, орон нутгийн төсөв бүрдүүлэхэд иргэдийн оролцооны талаар тулгамдаж буй асуудлыг тодорхой орон нутгийн жишээн дээр судалж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар өөрийн гэсэн саналыг гаргахыг оролдсонд шинэлэг тал, ач холбогдол тодорхойлогдно гэж үзэж байна.

Орон нутаг дахь иргэдийн оролцоо сул байгаагийн гол шалтгаан нь оролцоог хангахад чиглэсэн өнөөгийн эрх зүйн зохицуулалт, удирдлагын арга барил болон иргэдийн оролцооны талаарх иргэдийн хандлага, мэдлэг сөрөг үзүүлэлттэй байгаа гэсэн үндсэн таамаглал дэвшүүлж байна.

Орон нутгийн төсвийн үйл явцад иргэдийн оролцоо нэн чухал гэдгийг хүн бүр дэмждэг. Гэсэн хэдий ч орон нутгийн төсөвт иргэдийн оролцоо хамгийн доогуур түвшинд байна. Орон нутгийн төсвийн талаар багийн болон сум, дүүргийн, аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч, Засаг дарга нар мэдээлэл хийдэг боловч энэ нь иргэдэд тийм ч их хүртээлтэй биш хэвээр байгаа юм. Үүнийг дараах судалгааны үр дүнгээр тодорхой харуулж байна.


Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төв нь аймгийн төв Арвайхээрээс баруун тийш 135 км, нийслэл Улаанбаатараас 565 км зайд оршино. Засаг захиргааны дөрвөн багтай. “Орон нутгийн төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо” сэдвээр тус суманд хийсэн судалгааны үр дүнг нэгтгэн гаргав (Судалгааны асуулгыг хавсралт 1-д оруулав). Судалгааны объект, түүвэр: Судалгааг санамсаргүй түүврийн аргаар явуулж, судалгааны объектоор Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын дөрвөн багийг сонгож авсан. Түүврийн зохистой хэмжээг тогтоохдоо сонирхон тандаж буй асуудалд бодитой нөлөөлөх хүчин зүйлүүд болох оролцогчдын нас, хүйс, боловсрол, оршин суугаа газар зэрэг нийгэм, хүн амзүйн гол гол үзүүлэлтүүдийг ашиглан тогтоосон болно. Судалгаанд 4 багийг хамруулан нийт 160 нэгж өрх /өрх бүрээс 1 хүн/-ийг хамруулсан. Ингэхдээ 4-р баг, 3-р багийн хүн ам зүйн төвлөрлийг харгалзан түүврийн төлөөллийг нөгөө 2 багаас илүү авсан болно. Судалгааны арга зүй, аргачлал: Энэхүү судалгааг тоон судалгааны арга зүйд тулгуулан анкетын арга ашиглан явууллаа. Судалгааны

аргачлал: Тоон судалгааг урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу явуулж, мэдээллийг SPSS 16.0 багц программаар нэгтгэн мэдээллийн харьцаа, корреляци, дундаж бодох, хэв маягчлал үүсгэх, харьцуулах хүчин зүйлийн шинжилгээ хийх зэргээр анхдагч, хоёрдогч шинжилгээ хийсний үндсэн дээр дүнг нэгтгэн гаргав. Судалгаанд оролцогчдын хүн амзүйн бүтэц: Судалгаанд оролцогчдын 45.6 хувь нь эмэгтэй 54.4 хувь нь эрэгтэй, насны болон боловсрол, харьяалалын хувьд дараах байдлаар тодорхойлогдож байна.


Графикаас харахад 21-25, 26-30, 36-40, 31-35 иргэд нийгмийн идэвхитэй хэсгийг бүрдүүлж байгаа нь харагдаж байна. Мөн судалгаанд оролцогчдийн 34.3 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байгаа нь орон нутагт боловсролын түвшин харьцангуй өндөр үзүүлэлттэй байгааг илтгэж буй юм. Тус судалгаанд оролцогчдын 42 хувийг 4-р багийн иргэд эзэлж байгаа нь тус баг нь сумын төвийн баг учир хүн амын зүйн нягтаршил илүүтэй холбоотой болно.



Судалгаанд хамрагдсан иргэдийн насны бүтэц тухайн сумын иргэдийг төлөөлж чадахуйц болсон байна.




Асуулгын судалгаанд оролцогчдын 16 хувь нь 1-р баг, 19.5 хувь нь 2-р баг, 22.5 хувь нь 3-р баг, 42 хувь нь 4-р багийн иргэд байна. Боловсролын түвшингийн хувьд бүрэн дунд боловсролтой иргэд 34.3 хувь байгаа бол дээд боловсролтой иргэд 27.2 хувь, бага болон бүрэн бус дунд, тусгай боловсролтой иргэд 11.2-13.6 хувийг эзэлж байв. Судалгаанд оролцсон иргэд орон нутгийн төсвийн талаарх мэдээллийг хэрхэн авдгийг дараах зурагт нэгтгэн харууллаа.



“Та сумынхаа төсвийн талаарх мэдээллийг байнга авч чаддаг уу? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 17.20 хувь нь тийм, байнга авдаг гэж хариулсан нь хангалтгүй үзүүлэлт гэж судлаачийн хувиас дүгнэж байна. Учир нь судалгаанд оролцогчдын олонхи хувь нь бүрэн дунд боловсролтой, мөн


сумын төвд амьдардаг айл өрхүүд хамрагдсан байгаа. Гэтэл бараг авч чаддаггүй гэсэн хариултыг 22.5 хувь, түүнчлэн хааяа л авдаг гэсэн хариултыг 49.1 хувь нь сонгосон байгаа нь сумын удирдах ажлын баг болон иргэдийн хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгааг илтгэн харуулж байна гэж үзэж болох юм.



Дээрх зургаас харахад сумын иргэд мэдээллийг Багийн иргэдийн нийтийн хурал (21.2%) болон сумын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбараас (23.1%) олж авдаг гэсэн үзүүлэлт тэргүүлэх байр суурийг эзэлж байна. Энэ нь иргэдэд төсвийн талаарх мэдээллийг нутгийн удирдлага болон орон нутгийн төсвийн байгууллагууд хэвлэмэл байдлаар бэлтгэж тарааж чадахгүй байгааг харуулна. Эндээс иргэдийн зарим хэсэг бүлэг нь мэдээллийг зорьж авдаг бол зарим хэсэг нь зөвхөн орон нутгийн мэдээллийн хэрэгсэл болон хурлаас хамгийн хэрэгтэй мэдээллээ авдаг гэсэн нь хэрэв иргэд багийн иргэдийн нийтийн хуралдаа оролцох юм бол мэдээлэл сонсдог учир тэдний ИНХ-д оролцох оролцоог нэмэгдүүлэх нь чухлыг илтгэж байна.

Иргэдийн идэвх оролцоог хэрхэн нэмэгдүүлж хуралд илүү олон хүн хамруулан тэдний дуу хоолойг сонсож тэднээр дамжуулан төрийн бодлого шийдвэрийг хүргэх нь чухал гэж үзэж байна.

Зураг 9. Иргэд багийн иргэдийн нийтийн хуралдаа оролцдог байдал




Судалгаанд тус сумын иргэд, айл өрхийн 2 хувь нь хамрагдсан бөгөөд “Та багийн Иргэдийн нийтийн хуралдаа оролцдог уу?” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 46.40 хувь хуралдаа байнга оролцдог гэж хариулсан нь багийн ИНХ-д иргэдийн 50 хувь ч хүрэхгүй нь оролцож чаддаггүйг харуулж байгаа юм. Мөн бараг оролцдоггүй гэж судалгаанд оролцсон 3 хүн тутмын нэг нь буюу 30.4 хувь хариулсан нь анхаарал татах үзүүлэлт юм. Түүнчлэн мэддэггүй гэж 11.3 хувь нь, мэдсэн ч оролцдоггүй гэж 6.5 хувь нь хариулсан байгаа тул багийн ИНХ-аар хэлэлцэх асуудал, энэ талаарх мэдээллийг илүү хүртээмжтэй хүргэж болох бүхий л боломжийг бүрдүүлж ажиллах нь чухал гэдгийг харуулж байна.

Зураг 10. Та багийн иргэдийн хуралд оролцохдоо өөрийн амьдарч буй нутагт нэн тэргүүнд шаардлагатай байгаа бүтээн байгуулалтын талаар саналаа хэлдэг үү?




Дээрх зурагт тусгагдсан мэдээлэл нь хэрэв иргэд Багийн иргэдийн нийтийн хуралдаа оролцвол маш их идэвхи, оролцоотой байдгийг харуулж байна. Яагаад гэвэл хуралд суусан иргэд саналаа байнга хэлдэг, хэлж байсан гэсэн 2 хариултыг нэгтгэж үзвэл 51.6 хувьтай байгаа юм. Гэхдээ судалгаанд хамрагдсан иргэдийн 4 хүн тутмын нэг нь саналаа огт хэлдэггүй гэж хариулсныг анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Мөн хэлсэн ч шийдэгдэж байгаагүй, дарга нар мэдээд шийддэг гэсэн хариултыг нийт 22.4 хувь нь өгсөн нь багийн ИНХ-аар иргэдээс санал авах ажиллагаа нэр төдий явагдаж, иргэдийг үр дүнтэй оролцуулж, гаргасан саналыг нь хэрэгжүүлэх тал дээр нутгийн удирдлагын зүгээс анхаарах нь зүйтэйг харуулж байна.



Зураг 10-т харуулснаар Багийн иргэдийн нийтийн хурлаар орон нутгийн төсвийг хэрхэн хэлэлцдэг вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 59.8 хувь нь урьдчилан мэдээлэл тарааж, хурал дээр санал хурааж хэлэлцдэг, хурал дээр иргэдээс саналыг нь авч хэлэлцдэг гэж хариулсан нь Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төслийг боловсруулах явцад иргэдийг оролцуулж эхэлж байгааг харуулах сайн үзүүлэлт юм. Эндээс хуралд оролцсон иргэд саналаа хэлж, өөрийн оршин буй газарт юу хэрэгтэй байгаа тал дээр дуу хоолой, хүчээ нэгтгэн оролцож чадах болж байгаа тул иргэдийн идэвхи оролцоог цаашид нэмэгдүүлэн төсвийн үйл явцад үр дүнтэй оролцуулах боломж байгааг харуулж байна гэж ойлгож болно.

Зураг 12. Багийн иргэдийн нийтийн хурлаас төсөвтэй холбоотой гарсан иргэдийн санал ажил хэрэг болсон эсэх талаарх таны бодол?




Төсвийн тухай хуулинд өөрчлөлт орж орон нутгийн хөгжил сангийн хөрөнгийг багийн нийт иргэдээс бичгээр санал авч багийн иргэдийн нийтийн хурал дээр иргэдээр хэлэлцэн хамгийн олон санал авсан буюу тухайн нутагт нэн шаардлагатай ажлыг санхүүжүүлэх болсонтой уялдуулан 2013 оноос иргэдээс бичгээр санал авч эхэлсэн.

Энэ ажил эхний жилдээ хэрэгжиж эхэлж байхад иргэдээс саналаа цаасаар бичиж өгсөн гэсэн хариулт 40 хувьтай байгаа нь цаашид илүү үр дүнтэй ажил болох хандлага байгааг илтгэж байна. Мөн судалгаа хийх явцад иргэдийн саналыг цаасаар авах болсонд иргэд, хөдөлмөрчид, малчид сэтгэл хангалуун байгаа нь ажиглагдаж байсныг дурдья.

Гэсэн хэдий ч иргэдээс санал аваад түүнийг ажил хэрэг болсон болон болоогүй талаар нэгдсэн мэдээлэл өгөхгүй байгаа нь нутгийн удирдлага болон иргэдийн мэдээлэл солилцох суваг, уялдаа холбоо сул байгааг илтгэн харуулж байна.

Ингээд орон нутгийн төсвийг хэрхэн хэлэлцэн баталж байвал иргэдэд илүү ойлгомжтой, хүртээмжтэй байх болон түүнийг хэрхэн боловсруулах талаар нээлттэй санал асуулга авсан судалгааны дүнг нэгтгэж үзлээ.

Зураг 13. Танаас орон нутагт төсвийн хөрөнгөөр хийвэл зохих ажлын талаарх саналыг цаасаар авсан уу?



Зураг 14. Тухайн жилийн төсвийг иргэдээр хэрхэн хэлэлцүүлж, саналыг нь авч баталдаг байвал зохих талаарх иргэдийн санал



Судалгаанд оролцогчдын хамгийн их хувь эзэлсэн “Иргэдийн саналыг нэгтгэх, хэлэлцүүлэг хийдэг байх” гэсэн санал байгаа нь иргэд орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахад оролцох, өөрсдийн үүргийг тодорхой болгох, түүнийг хэрэгжүүлэн ажиллах сонирхолтойг илтгэж буй нь сайшаалтай.

Дээрх судалгаанаас харахад төсвийн үйл явцад иргэдийн оролцоо чухал ч үүнийг холбосон мэдээлэл, амьд харилцаа дутмаг байгаа нь харагдаж байна.

Мөн Нарийнтээл сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын талаар 2014 оны багуудын иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл, сумын иргэдийн хурлын тогтоолд харьцуулсан шинжилгээ хийхэд:

1 дүгээр баг буюу Шарга багийн Иргэдийн нийтийн хурлаас гаргасан тогтоолд эрэмбэлэгдсэн нийт 5 төслөөс 6; 2 дугаар баг буюу Баянтээг багаас эрэмбэлсэн нийт 10 төслөөс 7; 3 дугаар баг буюу Өндөрхөмөг багийн эрэмбэлсэн нийт 7 төслөөс 6; 4 дүгээр баг буюу Цагаан-Овоо багийн эрэмбэлсэн нийт 9 төслөөс 9 төслийг тус тус хэрэгжүүлэхээр Нарийнтээл сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоолоор шийдвэр гаргасан байна.

Гэвч Шарга багийн Иргэдийн нийтийн хурлаас гаргасан тогтоолд Цэцэрлэгт хүрээлэн байгуулах тухай болон Малчдын хужирын бүсд хороо барих талаар саналууд гарч ирээгүй, мөн Баянтээг багт “Ногооны зоорь барих” тухай санал гарч ирээгүй байхад сумын ИТХ-ийн төлөөлөгчдийн тогтоолд энэ тухай санал гарч ирсэн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл бүрэн утгаар хэрэгжихгүй байгааг харж болно.

Багуудын Иргэдийн нийтийн хурлаас гаргасан тогтоолд эрэмбэлэгдсэн саналууд яг тэрхүү эрэмбэлэгдсэн дарааллаар сумын төсөвт тусгагдаагүйг мөн анхааралдаа авах нь зүйтэй.

Иргэд зөвхөн төсөв, санхүүгийн асуудлын хувьд төдий бус, орон нутагт болон нийгэмд нийтлэг ач холбогдолтой ямарваа асуудалд оролцож байж гэмээнэ ард түмний засаглал жинхэнэ утгаараа хэрэгжих учиртай. Ардчилсан иргэний нийгмийн гол хөдөлгөгч хүч бол идэвхитэй оролцоо бүхий иргэд билээ.

Эцэст дүгнэхэд эдийн засгийн шинэ харилцаанд шилжсэнтэй уялдан манай улсын эдийн засгийн салбарт хийсэн өөрчлөлт шинэчлэлийн нэг гол хэсэг нь санхүү, төсвийн харилцааг шинэчлэн зах зээлийн эдийн засгийн нийтлэг жишигт зохицсон шинэ тогтолцоо, түүний эрхзүйг бүрдүүлэх асуудал байсан бөгөөд Монгол Улсын төсвийн

тухай хууль, татварын хууль батлагдан хэрэгжсэн нь дээрх асуудлын хүрээнд хийх шинэчлэлийн эхлэл нь болсон.

Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийг батлан мөрдсөн болон төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг 2003 оноос эхлэн мөрдөж эхэлсэн улмаар төсвийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжснээр төсвийн удирдлагын эрх зүйн болон иргэдийн оролцооны шинэ орчин, бүрдэж төрийн алба, төсвийн байгууллагын чадавхи сайжирсан нь дараагийн алхам юм. Гэсэн ч Төсвийн тухай хууль, Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журмын мэдээлэх оролцоотой холбоотой заалтуудын хэрэгжилт эхлэлийн шатандаа байна.

Зарим аймаг, сумд өөрийн цахим мэдээллийн сайт ажиллуулдаггүй харин ажиллуулж буй аймаг, нийслэл, сум, дүүргийн цахим хуудсанд байрлуулсан төсвийн мэдээлэл цаг хугацааны хувьд хуучирсан дутуу орсон, төсвийн байгууллагууд заавал байршуулах ёстой самбарыг хийгээгүй, самбар байгаа ч түүндээ төсвийн мэдээллээ байрлуулаагүй байх нь элбэг байна.

Үүнтэй нэгэн адил Нарийнтээл суманд төсвийн мэдээллээ байршуулах мэдээллийн самбар байгаа хэдий ч мэдээлэл нь 1 улирлын мэдээлэл байгаа харагдсан. Цахим сайт ажиллуулдаггүй.

Энэ нь төсвийн мэдээллийг цахим хуудсанд байрлуулах талаар хууль, журамд тусгасан хэдий ч хэрхэн, яаж зохион байгуулах, худалдан авах ажиллагааны явцыг ямар хугацаанд мэдээллэх зэрэг зохицуулалтуудыг оруулаагүй, хуулийн заалтуудыг зөрчин ил тод, нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр зарлан мэдээлэх үүргээ биелүүлээгүй байгууллага, ажилтанд тооцох хуулийн хариуцлага тодорхой бус, улсын болон орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, батлуулахаар өргөн барихаас эхлэн олон нийтэд ил тод болгох соёл дутагдаж байгаатай холбоотой.

Төсвийн тухай хуульд тусгагдсанаар орон нутгийн иргэд төсвийн үйл явцад оролцож саналаа илэрхийлэх эрх нь

нээгдэж байгаа ч иргэдээс гарсан санал, хамтаараа гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхгүй бол хуулийн заалтууд үнэ цэнэгүй болох юм.

Идэвхтэй оролцооны хувьд авч үзвэл бодит байдал дээр хамгийн чухал гэж үздэг улсын болон орон нутгийн төсвийг хэлэлцэж батлах, зарцуулах үйл явцад, түүнчлэн ИТХ-ын хуралдаанд иргэд биечлэн оролцох эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Иргэд өөрсдийн сонгосон УИХ-ын гишүүд, иргэдийн хурлын төлөөлөгчдөөр дамжуулах буюу төлөөллийн ардчиллын зарчмаар л төсвийг хэлэлцэн батлах үйл явцад оролцох боломжтой юм. Үүнийг цаашид иргэдийн шууд оролцооны хэлбэрээр өөрчлөх ажлыг орон нутагт эхлүүлүүлсэн байна. Төсвийн цаглабарын дагуу төсвийн үйл явц, худалдан авах ажиллагаанд оролцох боломжууд нь хэрэгжүүлэх механизм, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи талаасаа хязгаарлагдмал байна.

Иргэдийн хяналт, оролцоог хангахад чадавхижсан байгууллагуудыг илүүтэй ажиллуулах, төсвийг хянах үйл ажиллагаанд оролцох байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгдөг байх, судлаачид, шинжээчид, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг судалгаа, шинжилгээний ажилд өргөнөөр оролцуулах, худалдан авах ажиллагааны үйл явцад хяналт шинжилгээ, аудит хийх мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудыг чадавхижуулах ажлыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангахтай холбоотой батлан мөрдөж буй хууль, журмуудын хэрэгжилтийг хянах, үнэлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог нарийвчлан тодорхойлоогүй бөгөөд хуулиуд хоорондын уялдаа бүрэн хангагдаагүй байна. Төсвийн мэдээллийг ил тод болгосноор иргэдээс санал авах боломжийг олгох зарчмыг баримтлахаар хуульчилсан ч оролцоог хангах талаар төсвийн тухай хуульд зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зориулалтын талаар иргэдээс санал авч, иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж эрэмбэлэх зохицуулалт л тусгагджээ.

Иймээс иргэдээс авсан саналыг багийн иргэдийн нийтийн хурлаар нэгтгэн хэлэлцэн батлаж ажил хэрэг болгох нь чухал.

Судалгааны ажилд жишээ болгон авсан Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолыг харахад багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан саналыг 80 гаруй хувьтай оруулан баталсан нь сайшаалтай байна.

Цаашид төсвийн үйл явцад иргэдийн оролцоог үр дүнтэй хангахын тулд өмнө авч үзэж судалсан иргэдийн оролцооны 4 элементийг төсвийн болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох хууль тогтоомжид иж бүрнээр оруулж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг нарийн тодорхой хуульчилж өгөх шаардлагатай байна. Ялангуяа төсвийн асуудлаар шийдвэр гаргахад мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явц дахь олон нийтийн оролцоо, төсвийн үйл явцын ил тод байдлыг хангах ажлыг цогц байдлаар хоорондоо зөрчилгүйгээр зохион байгуулдаг болох нь чухал юм.

Санал зөвлөмж: Орон нутгийн төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын иргэдээс авсан судалгаанаас дүгнэн харахад дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

- Багийн иргэдийн нийтийн хурлын эрх хэмжээг нэмэгдүүлэх- эрх мэдлийн төвлөрлийг сааруулж орон нутагт эрх мэдэл шилжүүлэх явдал бөгөөд ялангуяа иргэдийн шууд оролцоогоор хэрэгжиж байдаг бие даасан байдлыг хангах
- Багийн иргэдийн нийтийн хурлын ирцийг сайжруулах – товлосон хугацаанд хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хуралдуулахгүй дахин хурал зарладаг байх. Энэ нь иргэдийн идэвхийг нэмэгдүүлж хүн нэг бүрийн оролцоо илүү чухал гэдгийг ойлгуулахад ач холбогдолтой.
- Хурлын тов мэдээллийг хүртээмжтэй болгох – зөвхөн багийн дарга хурлын талаар аман зар мэдээлэл хүргэхээс илүүтэй албан ёсны урилга хүргүүлэх, хувь хүн бүрийн утас руу мессеж илгээх маркетинг хэрэглэх
- Багийн иргэдийн хурал дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх - иргэдийн нийтийн хурал зохион байгуулж буй арга хэлбэр, мэдээлэл түгээлт, хэлэлцэх асуудлыг нарийн тодорхой болгох. Иргэдийн оролцоо нь тухайн

хурал төдийгүй нутаг орны хөгжилд ус, агаар мэт хэрэгтэй гэдгийг ухуулан ойлгуулах.

- Багийн иргэдийн нийтээр хэлэлцсэн санал ажил хэрэг болсныг эргэн мэдээллэдэг байх- хуралд оролцож хэлсэн болон олонхоор дэмжсэн саналууд ажил хэрэг болсон тухай мэдээллийг тогтмол иргэдэд хүргэснээр иргэд урамшин цаашид дараа дараагийн хуралд идэвхи санаачлагатай оролцох
- Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэх асуудал тодорхой, ил тод байх- хэлэлцэх асуудал тодорхойгүй байдаг учир иргэд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсохоос залхсан байдаг. Иймээс хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэлтэй бол хуралд оролцох болон асуудлыг тодорхойлох хандлага нэмэгдэх
- Төсвийн тухай мэдээллийг хүртээмжтэй болгох- багийн төв дээр мэдээллийн самбар ажиллуулах, зөвхөн хурал дээр биш иргэдийн саналыг тогтмол авч хариу өгдөг байх, иргэдэд төсвийн тухай мэдээлэл бүхий ном товхимол, материал хэвлэгдсэн тухай болон хэвлэмэл мэдээллийг байнга түгээдэг байх.

Дүгнэхэд, төсвийг бэлтгэн боловсруулж, хэлэлцэн батлан хэрэгжүүлэхэд улмаар хэрэгжиж буй үйл явцад үнэлэлт дүгнэлт өгч эргэх холбоотой ажиллаж амьдрах нь иргэн бүрийн эрх үүрэг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Мөн миний судалгааны ажилдаа дэвшүүлсэн орон нутгийн төсвийн үйл явцад дахь иргэдийн оролцоонд удирдлагын хэрэгжүүлж буй арга барил, иргэдийн мэдээллийн дутмаг байдал, сөрөг хандлага нөлөөлж байна гэсэн таамаглал судалгааны асуулгын үзүүлэлтүүдээр батлагдаж байна гэж дүгнэн үзлээ.

НОМ ЗҮЙ

Монгол улсын хуулиуд:

1. Төсвийн тухай /шинэчилсэн найруулга/. УБ., ТМ. 2012, №03
2. Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хууль. УБ., ТМ. 2002, №44
3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

хууль. УБ., 2007

4. Монгол улсын татварын ерөнхий хууль. УБ., 2006

Гарын авлага:

1. Б.Алтансүх, Ё.Энхбаяр. Орон нутгийн төсвийн үйл явц /Иргэдэд зориулсан гаын авлага/. Улс төрийн боловсролын академи, Монголын нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын Сан/
2. Д.Бямбажав, С.Түмэндэлгэр. Орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо /Судалгааны тайлан/. Мерси Кор ОУБ-ын ТАН төсөл. 2007 он
3. Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт /үндсэн баримт бичиг/. Нээлттэй нийгэм форум. УБ., 2013.03.20
4. Л.Анар-Эрдэнэ, Б.Батхүү, Л.Отгонтуяа, М.Энхбат нар. Иргэдийн оролцооны эрхзүйн орчин ба үнэлгээ /Судалгааны тайлан/. Улс төрийн боловсролын академи. УБ., 2013 он
5. Г.Жаргал. Орон нутаг бие даан хөгжих боломж, арга зам. Нээлттэй нийгэм форум. УБ., 2006 он
6. Г.Энхбаяр, Л.Отгонтуяа. Төрийн санхүүгийн удирдлага. УБ., 2009

Нийтлэл:

1. Д.Моломжамц. Улсын болон орон нутгийн төсвийн харилцааг боловсронгуй болгох зарим асуудал
Орон нутгаас авч ашигласан баримт бичиг:
 1. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол. Дугаар5/1., 2013.09.15 – Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлах тухай
 2. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Шарга багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол. Дугаар1., 2013.07.01
 3. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол. Дугаар03., 2013.06.29
 4. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 3-р багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол. Дугаар01., 2013.07.02
 5. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Цагаан-Овоо” багийн Иргэдийн Нийтийн тогтоол. Дугаар 2/3 .,2013.07.19

Вэб сайтууд:

1. www.legalinfo.mn
2. www.open-government.mn
3. www.iltod.gov.mn
4. www.tusuv.mn

**“Орон нутгийн төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо”
сэдэвт анкетын судалгаа**

Таны энэ өдрийн амгаланг айлтгая. Энэхүү судалгааг магистрын судалгааны ажлын хүрээнд авч байгаа бөгөөд та бидэнд үнэн зөв мэдээлэл өгнө гэдэгт итгэлтэй байна. Мэдээллийн нууцыг бид чандлан хадгалах болно.

Цаг зав гарган манай судалгаанд оролцсон танд баярлалаа.

Нэг. Ерөнхий мэдээлэл

- 1. Нас:** /бичнэ үү/
- 2. Хүйс:** а. Эрэгтэй б. Эмэгтэй
- 3. Та хэддүгээр багийн иргэн бэ?**
 - а. 1-р баг
 - б. 2-р баг
 - в. 3-р баг
 - г. 4-р баг
- 4. Боловсролын түвшин:**
 - а. Дээд боловсролтой
 - б. Тусгай дунд боловсролтой
 - в. Бүрэн дунд боловсролтой
 - г. Бүрэн бус дунд боловсролтой
 - д. Бага боловсролтой
 - е.

Хоёр. Орон нутгийн төсөв дэх иргэдийн оролцооны талаарх мэдээлэл

- 5. Та сумынхаа төсвийн талаарх мэдээллийг авч чаддаг уу?**
 - а. Тийм, байнга авдаг
 - б. Хааяа авдаг
 - в. Бараг авч чаддаггүй
 - г. Огт авдаггүй
 - д.

- 6. Та аймаг, сумынхаа төсвийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?**
- а. Сумын ЗДТГ-ын мэдээллийн самбараас
 - б. FM радио, телевизээс
 - в. Орон нутгийн сонингоос
 - г. Танилцуулга, товхимолоос
 - д. Номын сангаас
 - е. Сумын Засаг дарга, ажилтнуудаас
 - ё. Багийн Засаг даргаас
 - ж. Багийн иргэдийн нийтийн хурал дээр
 - з. Багийн өдөрлөгийн үеэр
- 7. Та багийн иргэдийн нийтийн хуралдаа оролцдог уу?**
- а. Байнга оролцдог
 - б. Бараг оролцдоггүй
 - в. Мэддэггүй
 - г. Мэдсэн ч оролцдоггүй
 - е.
- 8. Та багийн иргэдийн нийтийн хуралд оролцохдоо өөрийн амьдарч буй нутагт нэн тэргүүнд шаардлагатай байгаа бүтээн байгуулалтын талаар саналаа хэлдэг үү?**
- а. Байнга хэлдэг
 - б. Хэлж байсан
 - в. Хэлсэн ч шийдэгдэж байгаагүй
 - г. Огт үгүй
 - д. Дарга нар мэдээд шийддэг
- 9. Багийн иргэдийн нийтийн хурлаар орон нутгийн төсвийн асуудлыг хэрхэн хэлэлцдэг вэ?**
- а. Урьдчилан мэдээлэл тарааж хурал дээр санал хурааж, хэлэлцдэг
 - б. Хурал дээр иргэдээс саналыг нь авч хэлэлцдэг
 - в. Дарга өөрийн бичсэн саналаа хурал дээр шууд танилцуулан хэлэлцүүлдэг
 - г. Иргэдээр хэлэлцүүлэлгүй дарга нар өөрсдөө шийддэг
- 10. Багийн иргэдийн нийтийн хурлаас төсөвтэй холбоотой гарсан иргэдийн санал ажил хэрэг болсон эсэх талаарх таны бодол?**

- а. Энэ талаар эргэж мэдээлдэг
- б. Дам сонсдог
- в. Ажил хэрэг болдог нь харагддаг
- г. Энэ талаар мэдээлэл огт авч байгаагүй
- е.

11. Танаас орон нутагт төсвийн хөрөнгөөр хийвэл зохих ажлын талаарх саналыг цаасаар авсан уу? /2013 онд/

- а. Тийм, цаасан дээр бичүүлж санал авсан
- б. Үгүй, хурал дээр л санал авсан
- в. Үгүй, огт санал аваагүй
- г. Энэ талаар мэдэхгүй байна
- д.

12. Тухайн жилийн сумын төсвийг иргэдээр хэрхэн хэлэлцүүлж, саналыг нь авч батладаг байвал зохих талаар та саналаа бичнэ үү.

.....

.....

.....

Танд баярлалаа, амжилт хүсье.

М.БАТДОРЖ

Батлан Хамгаалах Их Сургуулийн багш

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦҮҮЛЭН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ НЬ

Зорилго: МУ-ын “Үндсэн хууль”-ийн үзэл баримтлалын хүрээнд төвлөрлийг сааруулах асуудлыг “Үндсэн хууль”-д хэрхэн тодорхойлсныг онол, арга зүйн талаас задлан шинжлэх тэгэхдээ зөвхөн нутгийн өөрийн удирдлагын байгууллагад эрх мэдэл шилжүүлэх замаар төвлөрлийг сааруулах биш, нутгийн удирдлагын 2 субъектын сумын НӨУБ, төрийн удирдлага харилцан шүтэлцээтэй хөгжүүлэх санааг авч үзэх зорилго тавьсан юм.

Монгол улс 1990-ээд он хүртэл гагцхүү:

- Төрийн болон төржсөн хоршооллын гэх нэг төрлийн өмчид үндэслэсэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай,
- Нэг нам дангаар ноёрхож төрийг орлосон захиргаадлын дэглэмтэй (Тоталитар)
- Хүн амыг анги ялгаварласан нийгэмшлийн үндэстэн, хатуу төвлөрсөн улс байв.

Ардчилсан хувьсгал ялж 1992 онд шинэ “Үндсэн хууль” баталсны дараахнаас төвлөрлийг задлах, улмаар сааруулах анхны хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх зарим алхам хийж зөв чиг зүгээ олж эхэлсэн юм.

1991 оноос өмч хувьчлал эхэлсэн, хувийн өмчийг хүлээн зөвшөөрснөөр хувийн аж ахуйн олон зуун аж ахуй нэгж үүсэж, иргэдийн өөрсдийн санаачилгад тулгуурлан нутгийн өөрөө удирдах ёс хэлбэрээ олж, аймаг, сумын харьцангуй биеэ даан хөгжих идэвх мэдэгдэн дээшилж, төрийн бус байгууллагуудын хөдөлгөөн үүсэж, өрнөж эхэлсэн зэрэг нааштай хандлагууд илт ажиглагдах болов.

Гэтэл улс төр, эдийн засгийн бодлогод хуучин хэв загвар, “Захиргаадах” хандлага зонхилох болж, дахин төвлөрөл 1996 оноос аажмаар, 2004 оноос эрчимтэйгээр газар авч төвлөрөл бараг дангаар ноёрхох болов. Энэ загвар гол төлөв төрийн бус байгууллагууд өөрсдийн санаачилгаар нийгмийн амьдралын (боловсрол, эрүүл мэнд зэрэг) зарим салбарт төвлөрлийг сааруулах талаар хэсэг бусаг ч гэсэн судалгаа эхэлсэн боловч төрийн зүгээс оновчтой дэмжихгүй явж ирсний улмаас үр дүн олигтой гараагүйн дээр цогц байдлаар хандан судлалгүй өдий хүрчээ.

Дахин төвлөрөл нь олон хүчин зүйлээс хамаарч байсан боловч Орон нутгийн сонгуулийг “Эрх барих” намууд төсвөөс удирдах, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилт”-ийн гаж тогтолцоо үүсгэн улсын санхүүгийн хэт төвлөрөл бий болгосон, нөгөө талаар өмнөх нийгэмд хэвшсэн удирдлагын хуучирсан (захиргаадлын) арга барил амь бөхтэй оршсоор ирсэн бөгөөд түүнтэй олигтой тэмцэл хийлгүй улс төрийн хүсэл зориг голлон дутсанаас шалтгаалжээ. Иймд уг шалтгааныг гүнзгий судлан илрүүлэх, төвлөрөл сааруулах арга замыг тодорхойлох оролдлого хийсэн болно.

Нэг. Төвлөрлийг сааруулах Үндсэн хуулийн үзэл баримтлал:

Одоо болон ирээдүйд төвлөрлийг эрс сааруулж, олон түмний идэвх, орон нутаг, бизнесийн хүрээний бие даасан санаачилга, бүтээлч хандлага, ил тод байдлыг тэргүүн зэрэгт тавьж, эдийн засагт төр, засгийн газрын олон талын оролцоог багасгаж, эс төвлөрхүйг зөв төлөвшүүлэх эрх зүйн бодлого, хууль зүйн үндэс Монгол улсад байна уу?

Үүнээс судалгааны үрдүн хамаарах тул эхлээд энэ асуудлыг авч үзэх нь зүйтэй. Шинэ Үндсэн хуулиар ардчилсан ёс, хууль дээдлэх, хүний эрхийг хангах үзэл зарчимд тулгуурласан Бүгд найрамдах төрийн тулгуур үндсийг бэхжүүлж, босоо хэвтээ хоёр чиглэлээр төвлөрлийг задалж, улмаар сааруулах эрх зүйн үндсийг тодорхойлсон гэж үзэж болно. Энэ тухайд Үндсэн хуулийн ямар үндэслэл байгааг тодорхой авч үзнэ.

1. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хуулиа дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан нь энэ талаар суурь үзэл баримтлал болно.

2. Мөн хуулийн 5.1, 5.4-т тус оронд “Нийтийн ба хувийн ашгийн” бүхий л хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчдийн эрхийг хуулиар хамгаална. “Монгол улс дэлхийн эдийн засгийн хөтөлбөрийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшмэл бүхий эдийн засагтай байна” гэж заасан нь төвлөрлийг задлах “Эдийн засгийн үндэс”-ийг илэрхийлжээ. Энэ нь бас төрийн төвлөрөл, оролцоог хязгаарласан хэрэг юм.

3. Улс төрийн эрх чөлөө тогтолцооны хувьд “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна”. “Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж Үндсэн хуулийн 3.1-д заасан нь төвлөрөл сааруулах улс төрийн механизмын үндэс болно.

4. Төвлөрөл сааруулах улс төр- нийгэмшлийн үндсийг Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт тусгасан байна. Жишээлбэл: Үндсэн хуулийн 16.9, 16.10-т **“Иргэд шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй”.**

Төрийн байгууллагад сонсох, сонгогдох эрхтэй. “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэжээ. Үүний нэг илрэл бол “Монголын нутгийн удирдлагын холбоо” байгуулагдаж 20 гаруй жилийн хугацаанд төвлөрлийг сааруулах, орон нутагт эрх мэдэл шилжүүлэх талаар олон удаа арга хэмжээ зохион байгуулж байгаа билээ.

5. Удирдлагын босоо тогтолцоог сааруулахын тулд “Улсын их хурал, засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн хурал, Засаг даргад шилжүүлж болно” (62.3) гэж заасан нь төв засгийн эрх мэдлийг

доош нь сааруулах үндэс болов.

Түүний дээр нутгийн удирдлага дахь урдын хатуу төвлөрлийг халж, өөрөө удирдах ёсыг голлон төлөвшүүлэх үзэл баримтлалыг Үндсэн хуульд тов тодорхой томъёолсон байдаг. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ. (59.1)

“Нутгийн өөрөө удирдах байгууллага (Иргэдийн хурлууд нь) тухайн аймаг, нийслэл сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх” бөгөөд дээд шатны байгууллага, түүний асуудлыг орлон шийдвэрлэж болохгүй (62.1) гэж тус тус заасан. Тухайлбал: “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн (58.1)” гэж Үндсэн хуульд заасан нь орон нутгийн бие даасан байдлыг хангах 5 үндсийг тавьсан гэж болно.

6. Иргэний нийгмийн болон бизнесийн орчны хүрээнд эрх мэдлийг шилжүүлэх талаар Үндсэн хуульд чухал санаа шингэсэн юм. Иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг Монголын ард түмний туйлын хүслэн болгов.

Эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байхын хамт төр нь зөвхөн:

- а) Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал
- б) Аж ахуйн бүх хэвшлийн хөгжил
- в) Хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна (Ү.Х.5) гэсэн нь түүний бүхнийг шийдэх гэсэн эрхийг хязгаарласан үндэслэл болов.

Засгийн газрын тухай хуулийн 19.1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн засгийн газарын шийдвэр гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад харьцуулан гүйцэтгүүлж холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн

санхүүжүүлж болно“ гэж заажээ. Энэ бүхэн иргэний нийгмийн дээр төр орших биш, төрийн дээр иргэний нийгэм орших зарчмыг тогтоосон гэсэн үг.

Монгол улсад иргэний нийгмийг төлөөлсөн олон мянган байгууллага бий болж бүтээн туурвих замд орсон билээ. Энэ бүхэн 1992 оны Үндсэн хууль улс орны хэмжээтэй төвлөрлийг сааруулах эрх зүйн гол үндэс болж чадна гэдгийг харуулж байгаа юм. Гэвч гол хуулийн заалтыг аятай механизм нэмэлт хэм хэмжээ, санхүүгийн нөхцөл бий болгох, төрийн алба, арга барилаа шинэчлэх тал дээр ноцтой гажуудал гарч цаашид яах вэ? гэсэн эргэлзээнд ороод байна.

Хоёр. Монгол улс дахь төвлөрөл, **эс төвлөрхүй хоёрын харьцааны** байдалд дүгнэлт хийх нь:

Зөв эхлээд гажуудалд орсны тодорхой шалтгаан, үр дагавар юу юм бэ гэдэг асуултыг авч үзье.

1. Монгол улс 1996 оноос хүчтэй төвлөрөлд автагдсаныг өмнө дурьдсан. Энэ талаар зарим түүхэн баримтыг тоймлон үгүйлвээс 1996 оноос орон нутгийн сонгуулийг Улсын Их Хурлын буюу төрийн сонгуулийг хуулбарласан ёс журамтай болгож өөрөө удирдах байгууллагаа иргэд өөрсдөө биш төвөөс улс төрийн намууд өрсөлдөн захиргаадаж, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг төр засгийн дээд эрхэнд байгаа буюу Улсын Их Хуралд суудалтай намуудын бүлэглэл болгосноор улс төрийн төвлөрөл газар авчээ. Хуульд орон нутгийн хуралд иргэн бие дааж нэр дэвших заалт байгаа¹.

Хэдий ч бодит байдал дээр аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль Улсын Их хурлын сонгуулийн дараах шат болон төвөөс зохион байгуулснаар орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад төвийн бодлогыг үг дуугүй хэрэгжүүлэгч болж хувирахад хүргэв.

Нам бус иргэн ИТХ-д сонгогдох боломжгүй болж ИТХ-ын төрийн байгууллага мэт болгон статусыг гажуудуулж байгаа нь Үдсэн хуулийн үзэл баримтлалд үл нийцсэн үйл явдал болов.

¹ . Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 7.2. Тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт байнга оршин суугч, сонгуулийн эрх бүхий Монгол улсын иргэн орон нутгийн Хурлын сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх эрхтэй.

Мөн намын жагсаалтаар нэр дэвшиж байгаа нь дээрхтэй утга нэг байна.

Хэдийгээр орон нутгийн хурал сонгуулийн тухай хуульд сонгуульд нэр дэвшигч нь хууль тогтоомжид заасны дагуу намын гишүүнээс түтгэлзсэн төрийн албан хаагч орон нутгийн хурлын сонгуулд нэр дэвшиж байгаа бол уг ажил албан тушаалаас чөлөөлөгдсөн байх шаардлагыг хангах тухай заасан хэдий ч байдал дээрдсэнгүй. Ингэснээр хүний нөөц бэлтгэж хуваарилах, иргэний алба зохион байгуулах эрх мэдлийг төвд төвлөрүүлж, орон нутгийн албыг бий болгож бэхжүүлж чадахгүй өдий хүрэв.

Үүнтэй холбоотойгоор нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг намын бүрэлдэхүүнтэй Засгийн газрын байгууллагуудад уусгах болсон байна. Өөрөөр хэлбэл хүний нөөцийн төвлөрөл аль хэдийнэ бий болчихжээ.

Олон хуульд орон нутгийн нийгэм, эдийн засаг гэх мэт удирдлагын эрх хэмжээг зөвхөн төр засгийг төлөөлсөн засаг даргаа шилжүүлсэн нь ИТХ-ын эрх хэмжээг хэрэг дээрээ хязгаарлав. Тухайлбал:

Сумын холбоотой 150 шахам хуулийн заалтыг судлахад ихэнх нь засаг даргын эрх хэмжээг нэмэгдүүлж Хурлынхыг орхигдуулсан байв.

Энэ бол эцсийн дүндээ хууль тогтоомжоор нутгийн удирдлагын шийдвэрлэгч эрх мэдлийг нутаг дэвсгэрийн хамтлаг, тэдний өөрөө удирдах байгууллагад биш, төрийн гүйцэтгэх эрх мэдэлд тэр тусмаа яам агентлагуудад олгон төвлөрүүлжээ².

2. Төвлөрөлд буцаж шилжих хандлага аажмаар лавширхын хамт “Төвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоо”-г Шинэ Зеландын туршлагыг авч хэрэгжүүлэхдээ хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаас нь бус мөнгийг засгийн хүчтэй болгохыг голчилсноос төвлөрөл улам хүчтэй болсон юм.

Төвлөрлийг сааруулж, эрх мэдэл олгодог Шведийн туршлагыг авч хэрэгжүүлэх гэтэл төвлөрүүлсэн өмнөд тив

2 . Б.Чимид “Хариуцлагатай төр”- Санхүүгийн төвлөрөл, НӨУБ форумын эмхтгэл

Шинэ Зеландийн жишигт төсөв санхүүдэд авчихлаар нэгдсэн бодлогод нийцэхгүй нь ойлгомжтой.

Энэ тогтолцоогоор аймаг, нийслэл, сум, дүүргийн орлого, зарлагын төсвийн эрхийн хэрэг дээр устгаж бүхнийг УИХ, ЗГ-ын мэдэлд төвлөрүүлэв. Ингэснээр аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт захиргааны аппаратын цалин зардал төдий үлджээ.

Төсвийн орлог, заралгын хуваарилалтад сум, аймгийн хүн амд үзүүлэх нийтлэг (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг) үйлчилгээний хүртээмж ажил тэгш байх зарчим алдагдсан гэж үзэж болно. Угтаа орон нутгийн төсөв бол дээрхээс гадна тухайн Засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж дэх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, соёлын болон түүнчлэн хүн амын нийгэм, соёлын бусад үйлчилгээг санхүүжүүлэх эх үүсвэрийг багтаасан байх ёстой.

Одоогийн бодит байдлаас харахад сумдын сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг зэрэг төсөвт байгууллага, үйлчилгээний бүхий л зардлыг төвд **“Сайдын багц”** нэртэй улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлж байна.

Үүнээс шалтгаалан **“Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх”** гэсэн Үндсэн хуулийн заалт хоосон лоозон болсоор буйг харуулж байна.

3. Монгол улсын үндсэн хуульд аймаг, сум нь “эдийн засаг, нийгмийн цогцолбор” байж хөгжих үндсийг өмнө тодорхойлсон. Энэ нь нутгийн өмчийн эрхийг хүлээн зөвшөөрсөн хэрэг. Гэтэл 1998 оноос хувьчлалаас үлдсэн сургууль, эмнэлэг төдийхнийг аймагт олгосон, нэр зүүв. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн суурь нэгж сум дүүрэгт өмчлөх эрхийг олголгүйг одоог хүрээд байна. Жишээ нь: ерөнхий боловсролын сургууль гэхэд хүүхэд нь сумынх, хөрөнгө нь аймгийнх, төсөв нь сайдынх байгаа нь үнэхээр гажиг тогтолцоо мөн. Сумын хуралд мэдэх юм даанч алга.

4. 2000 оноос УИХ ын гишүүн, ЗГ-ын гишүүнийг хавсран ажиллах болсноос төрийн байгууллагын эрх мэдлийн хуваарилалтын зохистой харилцаа эхнээсээ алдагдсан. 2004

оноос УИХ ын гишүүн бүр эхлээд 10, дараа нь 100, 250, 500 сая, 1 тэр бум төгрөгийн төсвийг тойрогтоо нэрээр өөрийн мэдэлд батлан авсан нь Үндсэн хуульд заасан Засгийн газрын бүрэн эрхэд халдсанаар үл барам орон нутгийн эрхийг булааж хийх ажлыг орлон ажилласан хэрэг болов. Эндээс харахад дээд түвшинд Үндсэн хууль дахь эрх мэдэл хуваарилах зарчим алдагдсан. Доод түвшинд салбарын хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийн бусад байгууллагын хоорондох эрх хэмжээ, чиг үүргийн хуваарилалт алдагдав.

Өнөөдөр Монгол улс засаг захиргааны хувьд 21 аймаг, нийслэл, 330 сум 1600-аад баг, 9 дүүрэг, 160-аад хорооноос тогтож байгаа бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх буюу орон нутагт төвийг төлөөлж суудаг 400 гаруй агентлаг ажиллаж байна. Үүнээс үзэхэд орон нутгийг УИХ-ын гишүүд, сайд нар тэр дундаа Сангийн яам удирдсан хатуу төвлөрөл болсон байна.

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллага өөрсдөө бүтэц, орон тоогоо батлах эртэй атал, Сангийн яам бүхнийг мэдэгч дүрд тоголж байна.

Үүнтэй холбогдуулан нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлын бодит нөхцөлийг сайжруулах, төвлөрлийг сааруулах чиглэлээр өмч, төсөв, татварын тогтолцоонд эрх шинэчлэл хийх цогц арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

Өнөөгийн хэт төвлөрөл хүчтэй болсныг Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, гишүүд болон Засаг даргын нэлээд гишүүд төвлөрлийг сааруулах, орон нутгийн бие даасан байдлыг хангах нь чухал гэдгийг хэлж байсан боловч харамсалтай нь түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж чадсангүй .

Миний сэдвийн гол агуулга нь төвлөрлийг сааруулах талаар Монгол улсын Үндсэн хуулийн зүйл заалтын хүрээнд задлан шинжилж өнөөгийн байдалд тодорхой дүгнэлт хийсэн болно.

Гурав. Төвлөрөл сааруулах талаар хийх үндсэн асуудлууд:

Төвлөрлийг сааруулах зорилтой төв, нутгийн удирдлагын эрх хэмжээг зааглан тодорхойлох чиглэлээр хууль тогтоомжид шинэтгэл хийх төдийгүй нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны хүрээнд ямар өөрчлөлт хийх талаар нэгдсэн бодлого хийх нэгдсэн бодлого гаргахаас эхлэх ёстой. Юуны өмнө хэт төвлөрлийн шалтгаанууд тэдгээрийг арилгах оновчтой арга замыг олж илрүүлэх, энэ талаархи олон улсын жишгийг судалж харгалзах хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

Уг асуудалд Засгийн газар, түүний хэрэг эрхлэх газар, ялангуяа орон нутагт хариуцсан хэлтэс, ажилтнуудын санал санаачилга чухал үүрэгтэй.

Санхүүгийн төвлөрлийг Улсын их хурлын зүгээс буруу шааж байвч Засгийн газрын байгууллагууд гажуудалтай тогтолцоог хадгалсаар байна.

ХЭТ ТӨВЛӨРЛӨӨС ЯМАР АРГА ЗАМААР ГАРЧ БОЛОХ ВЭ?

1. Эрх мэдлийн төвлөрлийг сааруулах эрх хэмжээний үндсийг Засгийн газар төвлөрүүлсэн олон хууль, Засгийн газар, яамдын дүрэм, зааврыг судалж, бодит эрх мэдлийг үүрэг хариуцлагын хамт доош доош нь орон, нутаг, бизнесийн байгууллагад боломжтойг нь иргэний нийгмийн байгууллагад Тухайлбал: Монголын нутгийн удирдлагын холбоонд шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх шаардлагатай.

2. Төвлөрөл сааруулах нь зөвхөн эрх хэмжээний асуудал биш юм. Эдийн засгийн үндэс болсон өмчийн харилцаанд хувийн хэвшилд төрийн оролцоог хязгаарлах боломж, төрийн болон орон нутгийн өмчийн зааг, ялгааг шинэчлэн тодорхойлох. Үүний тулд нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй байна. Шинэ нөхцөл өмчийн, өрх гэрийн өмчийн хэлбэр, гэр бүлийн үйлдвэр буюу өрхийн аж ахуй, бизнесийн бүтэц, тэдгээрийн ашгийн төлөө үйлдвэрлэл, ажил үйлчилгээний түвшин, ашигт чанар, хэтийн төлөв, төвийн болон нутгийн засаг захиргааны дэжлэг, зохицуулалт, бас хязгаарлалт, орон нутагт зах зээл хөгжих сум хоорондын түншлэл, сум нэг аймаг дамнасан зах зээлд

нэвтрэн гарах боломж, дэд бүтэцээрээ бум бие дааж хөгжиж чадах уу, гэх мэт нарийвчилсан судалгаа хийх шаардлага гарч байгаа юм.

3. Санхүүгийн хүчтэй төвлөрлийг түүний дотор, сайд бүр “Өөрийн багцад” бүхнийг төвлөрүүлж буй төсвийг задлах, орон нутгийн санхүү зээлийн эрхийг өргөтгөж хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй.

4. Улс төрийн төвлөрлийг нэн даруй сааруулах. Улс төрийн намууд, төрийг орлож, парламентийн хэлбэртэй болсныг орон нутагт өөрчлөх цаг болсон байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. “Нутгийн өөрөө удирдах ёсны тухай Европын Харти” 1985 он
2. “Нутгийн өөрөө удирдах ёсны олон улсын торонтогийн тунхаг” 1990 он
3. Б.Чимид “Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” 2004 он
4. Б.Чимид “Сумын судалгааны тайлан”

А.ЖАРГАЛДАВАА

*Төв, Алтанбулаг сумын ЗДТГ-ын
Нийгмийн бодлогын мэргэжилтэн*

“НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ” ЭССЭ

“Цаг хугацаа бол ..., улам боловсронгуй болохын тулд бидэнд өгсөн бэлэг аж”. /Томасс Манн/ Нэгэнт цаг хугацааны урсгал тасралтгүй, аливаа зүйлийн хөгжлийн дээд түвшин хязгааргүй тул түүний хэлсэнчлэн хөгжлийн асуудлыг цаг хугацаанаас хоцроолгүй авч явах ёстой ажээ.

МНУХ-ны дэд тэргүүн Г.Маналжав нэгэн нийтлэлдээ “Нэгжийн удирдлага нь “Өөрөө удирдах ёс”, “Төрийн удирдлага” гэсэн хоёр субъектээс бүрдэж байна...” хэмээн бичсэн ба энгийнээр авч үзвэл нутгийн удирдлага нь нэг талаас иргэдийг төлөөлөгч ИТХ, нөгөө талаас төрийг төлөөлөгч захиргааны байгууллагын хамтын үйл ажиллагаа гэсэн байдлаар ойлгогдож байна.

Зохиол бүтээлээс үзэхэд манай улс ч мөн адил 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хуулинд “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага” гэсэн зүйл, заалтаар орон нутаг, түүний удирдлагын тогтолцоо чиг үүргийг хуульчлан баталгаажуулж нутгийн өөрийн удирдлагын бүтэц тогтолцоо бий болсныг тэмдэглэсэн байна.

Нутгийн өөрөө удирдах ёсыг тодорхойлсон олон тодорхойлолт байдаг бөгөөд Европын Хартийн Здугаар зүйл буюу “Нутгийн өөрөө удирдах ёсны ойлголт” гэсэн хэсэгт “Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан хамтлагаас өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн орон нутагт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх эрх, бодит чадвар юм” хэмээн тодорхойлсон нь хамгийн оновчтой тодорхойлолт хэмээн тооцогддог ажээ.

Үүнээс авч үзвэл Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь энгийнээр иргэдээс сонгогдсон иргэдийн төлөө ажиллаж ажлаа тэдний өмнө тайлагнадаг иргэн төвтэй байгууллага бөгөөд энэ байгууллагын үйл ажиллагаа нь орон нутагт Засаг дарга, түүний Тамгын газраар дамжин хэрэгжиж байна.

Нутгийн удирдлагыг хэрэгжүүлэгч анхан шатны нэгж болох Багийн Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын үйл ажиллагаа хангалтгүй, хурлаар хэлэлцэх асуудлаа иргэддээ танилцуулдаггүй, хурлаас гаргасан шийдвэрээ сурталчлах, хэрэгжилт тооцох ажил дутмаг, хурлаас гарсан санал, шүүмжлэлийн мөрөөражил хэрэг болгож мэдээлэх зэрэг цогц үйл ажиллагаа дутмаг байгаа нь нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэхэд саад болж тулгамдаж буй гол асуудал болж байна.

Ингээд нутгийн удирдлагын эрх зүйн орчны хүрээнд тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар авч үзлээ.

- ИТХ-ын дарга, Засаг дарга нар бол нутгийн удирдлагын 2 субъект боловч ЗЗНДНТУТ хуулинд нэр дэвшигчдэд тавигдах шаардлага нь харилцан адилгүй байна. Тухайлбал ЗЗНДНТУТ хуулинд Засаг даргад нэр дэвшигч нь дээд боловсролтой, төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын ер төлбөргүй байх, ялгүй байх гэсэн 5 шаардлагыг хангасан байх ёстой байна. Харин ИТХ-ын даргад нэр дэвшигчид тавигдсан шаардлага гэсэн заалтыг тус хуулиас хайгаад би олсонгүй.

Иймд тухайн орон нутгийн удирдлагад нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг ижилхэн түвшинд авч үзэх хэрэгтэй.

- Мөн одоогийн хуулийн зохицуулалтаар Засаг дарга нь Засаг төрийн төлөөлөгч болохынхоо хувьд ИТХ-ын өмнө биш дээд шатны Засаг дарга, цаашлаад Ерөнхий сайдын өмнө хариуцлага хүлээдэг байгаа нь нутгийн өөрөө удирдах ёс нь бэлгэдлийн чанартай байгааг

харуулж байна. Засаг дарга нь дээд шатны Засаг даргын болон ерөнхий сайдын, нөгөө талаас иргэдийн төлөөлөл болох Хурлын өмнө хүлээх хариуцлагыг хуулинд тодорхой зааглан тусгаж өгмөөр байна.

Нутгийн өөрөө удирдах ёс сул сумын Засаг дарга ИТХ-ын өмнө хүлээх хариуцлага сул байгаагийн нэг үндэс нь тухайн хурлын төлөөлөгчдийн олонхи нь сонгогдсон намаас нэр дэвшсэн, эсвэл олонхитой үгсэн хуйвалдсан нь Засаг дарга болох боломж нээлттэй байгаа, үндсэндээ ийм байдлаар сонгогдож байгаагаас үүдэж байна.

Иймд орон нутагт төлөөллийн ардчиллаас илүү шууд ардчилалыг хэрэгжүүлэх асуудлыг судлан хуулинд тусгах.

- Анхан шатны нэгжийн удирдлага болох Засаг төрийн төлөөлөгч Багийн Засаг даргад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг харвал ЗЗНДНТУТ хуулийн 26.6-д Баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна гэжээ. Үүнд 26.6.1.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, 26.6.2.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх, 26.6.3.ялгүй байх гэсэн үндсэн 3 шаардлагыг хангасан байх ёстой гэжээ. Үүнээс үзэхэд боловсролын талаар тавигдсан шаардлага байхгүйгээс нутгийн удирдлагын анхан шатны сонгуульд олон танил, олон хамаатантай нь ялдаг гажуудал тогтсон байна.

Сумын 150 иргэнээс авсан судалгаагаар Баг, хорооны засаг дарга, ИНХ-ын даргад нэр дэвшигчдэд тавигдах шаардлагын талаархи асуусан асуултанд респондентийн 69,8% нь боловсролын шаардлагыг нэмж тусгах хэрэгтэй гэж хариулсан бол 8,4% нь үгүй, үлдсэн 21,6% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Анхан шатны нэгжийн үйлчилгээнд хамгийн ойр байдаг иргэдийн хариултаас харахад баг хорооны засаг даргын боловсролын асуудлыг ихэнх нь чухал шаардлагатай хэмээн үзсэн байна.

Энэ нь боловсролын асуудлыг нэн тэргүүнд тавих болсон өнөө үеийн чиг хандлагатай уялдахгүй байна. Тиймээс баг хорооны Засаг даргад нэр дэвшигчид боловсролын шаардлагыг нэмж тусгах хэрэгтэй байна.

- Иргэдийн нийгмийн идэвхи сул цуглахгүй, залуучууд оролцохгүй, тулгамдаж байгаа асуудлаа тодорхойлох чадамжгүй байгаа нь иргэдийн нийтийн хурлын даргатай холбоотой бөгөөд Баг хорооны ИНХ-ын даргын хувьд орон тооны бус байдаг нь ажлын идэвхийг сулруулж байна.

Техник технологи хурдацтай хөгжиж буй энэ зуунд төрөөс үзүүлэх үйлчилгээ иргэдэд улам ойртож цахим хэлбэрт шилжиж байгаа билээ. Цаашид улам боловсронгуй болж төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг оролцоо хөнгөрөх нь зөвхөн цаг хугацааны л асуудал болж байна.

Тиймээс дэлхийн олон улс орнууд “Нутгийн өөрөө удирдах ёс”-ыг үндсэн асуудал болгон хөгжүүлэх болсон өнөө үед нутгийн өөрөө удирдах ёсны анхан шатны төлөөлөгч ИНХ-ын даргын албан тушаал орон тооны болгох талаар ЗЗНДНТУТ хуулинд нэмж тусгах шаардлагатай байна.

- Боловсон хүчний дараагийн нэг чухал асуудал болох ИТХ-ын төлөөлөгчийн тухай авч үзье. Орон нутгийн сонгуулиар иргэд 4 жилд 1 удаа сонгох, сонгогдох эрхээ эдэлж өөрсдийн төлөөллийг сонгоод сумын ИТХ-ын төлөөлөгч гэх нэр төр, үүрэг хариуцлагыг үүрүүлдэг.

Сүүлийн үед дэлхий нийтийн хэмжээнд иргэдийн оролцооны хандлагад ихээхэн ач холбогдол өгч байна. Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд саад болж байгаа хүчин зүйлүүдийг иргэд өөрсдөө ярилцаж шийдлээ гаргаж ажиллуулахын тулд иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж идэвхижүүлэн ажиллах нь чухал болоод байгаа билээ.

Инээдтэй ч гэх юмуу, харамсалтай ч гэх юмуу нэгэн жишээ дурдахад багийн өдөрлөг, ИНХ хийе гээд зар тавьтал нэг ч хүн

ирдэггүй, тэгэхээр нь азтан шалгаруулна, сугалаатай гэхэд их олон хүн цуглаж тэр завшааныг ашиглаж багийн ИНХ-аа зохион байгууллаа хэмээн нэгэн Засаг дарга маань ярьж байсан юм. Энэ бол арга ядсан л хүний арга.

Мөн иргэдээс авсан судалгаанаас харахад судалгаанд оролцогчдын 15,3% нь л багийн ИНХ, өдөрлөгт тогтмол оролцдог хэмээн хариулсан бол ямар шалтгаанаар оролцдоггүй талаар асуусан асуултанд респондентийн 58,7% нь мэдэхгүй хэмээн бичсэн байна. Энэ асуудал нь тухайн тойргоос сонгогдсон иргэдийн төлөөлөгчийн хариуцлагатай холбогдох ёстой. Иргэдийг төлөөлж буйн хувьд тухайн ИТХ-ын төлөөлөгч нь иргэдийг мэдээллээр хангах, санал хүсэлтийг хүлээн авах, бодлого хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгуулан хэрэгжүүлэгчтэй хамтран ажиллах зэргээр иргэдтэй нүүр тулж тэдэнд хүрч ажиллах шаардлагатай байна.

Иргэн оролцохгүй бол нутгийн удирдлага түүн дундаа нутгийн өөрөө удирдах ёс ярих нь өрөөсгөл бөгөөд утгагүй.

Иймээс төлөөлөгчийг иргэд сонгогчидтой ажиллах нөхцлийг хурлын ажил үүргийн функцэд тодорхой суулгаж өгөх, эргэн татах зэргээр хариуцлага хүлээлгэх талаар хуульд тусгах, иргэдийн оролцоог сайжруулах, идэвхижүүлэх чиглэлээрх төсөл хөтөлбөрийг бодлогын түвшинд дэмжих талаарх хуулинд тодорхой тусгах хэрэгтэй. Тухайлбал: төлөөлөгчийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий ажилтны орон тоог ИТХ-ын бүтцэд бий болгох, төлөөлөгчийг намын бус иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих байдлыг хангаж өгөх, зэрэг асуудлыг шийдвэрлэх боломжийг нээж өгөх нь чухлаар тавигдаж байна.

- Дараагийн асуудал бол Нутгийн удирдлага, захиргааны байгууллага нь мэдлэг чадвартай боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар боловсон хүчний бодлого барьж ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдаг.

Төрийн албаны хуулиар баталгааждаг доорхи асуудлууд нутгийн захиргааны байгууллагын боловсон хүчний тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлдэг.

Тухайлбал: Орон нутгийн боловсрол, эрүүл мэнд, тусгайгийн салбарт ажиллагсдад хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл гэж 10-20% ийн цалингийн урамшууллыг сар бүр олгодог. Мөн ажилласан жилээс хамааран 3 болон 5 жил тутамд 6 сарын цалинтай тэнцэх тэтгэмжийг олгодог. Гэтэл энэ нийгмийн баталгаа нь ижилхэн “Төрийн жинхэнэ албан хаагч” нэрийн дор алба хаадаг захиргааны байгууллагын албан хаагчдад үйлчилдэггүй.

Төрийн албан хаагчдын цалингийн дундаж ижилхэн боловч урамшуулал нэмэгдэл харилцан адилгүй байдгаас Захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан хаагч нь Эрүүл мэнд, Боловсролын салбарын үйлчлэгчийн цалинтай ижил хэмжээний цалин авдаг.

Ийм нийгмийн баталгаа сул байдгаас орон нутгийн удирдлагын байгууллагад чадварлаг боловсон хүчнүүд тогтвор суурьшилтай ажилладаггүй.

Тиймээс төрийн жинхэнэ албан хаагчдын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх цалин, цалингийн сүлжээ, урамшуулал нэмэгдлийн талаар бодит харьцуулсан судалгааг хийх, нийгмийн баталгааг хангах талаар анхаарах хэрэгтэй байна.

- Өнөөгийн сум дүүргийн хурлын төлөөлөгчдийн тоог авч үзвэл 20000 хүртэл хүн амтай дүүргийн ИТХ-ын төлөөлөгч 17 байхад 2000 хүн амтай сумын хурлын төлөөлөгч 15 байна.

Иймд ЗДТГ-ын бүтэц орон тоо болон ИТХ-ын төлөөлөгчдийн тоог хүн амын тоо болон бусад хүчин зүйлсийг харгалзан өөрчлөх шаардлагатай байна.

- Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлын асуудал.

Нутгийн удирдлагын хөгжилд санхүүгийн асуудал чухал. Нутгийн өөрөө удирдах ёс хөгжсөнөөр ардчилал жинхэнэ утгаар хэрэгжинэ мөн төрийн ачаа хөнгөрөх, төрийн захиргааны байгууллага болон иргэдийн хоорондын харилцаа холбоо сайжрах, иргэдийн санаачилга дээшлэх, иргэд өөрсдийн амьдарч буй нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засаг,

соёлын үндсэн асуудлаар бие даан шийдвэр гаргах бололцоог олгох, иргэдийн эрх ашигт үл нийцэх асуудлыг хамгаалах, иргэдийн хяналт сайжрах зэрэг олон ач холбогдолтой ажээ. Иймээс нутгийн удирдлагын цаашдын чиг хандлага нь төрийн удирдлагаас илүүтэйгээр нутгийн өөрөө удирдах ёс руу чиглэх нь ойлгомжтой.

Засаг даргын дэргэдэх гэх боловч дээрээсээ удирдлагатай хэлтэс агентлагууд олширсоор.

Орон нутгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагын хувьд бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээгээ Засаг даргатай байгуулдаг боловч санхүүжилт нь харъяа яамнаас хийгддэг учир нутгийн удирдлагад хандах шаардлагагүй, мөн сумын боловсролын байгууллагын захирал, эрхлэгчийг харъяа газрын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга баталгаажуулдаг байсан бол 2014 оноос эхлэн дээд шатны буюу аймгийн Засаг дарга баталгаажуулдаг болсноор боловсон хүчний асуудалд ч орон нутгийн зүгээс оролцох боломжийг улам бүр багасгасан юм.

Иймээс орон нутгийн босоо удирдлагатай байгууллагуудын боловсон хүчний асуудал болон төсвийн эрх мэдлийг орон нутагт нь шилжүүлэх хэрэгтэй.

Ингээд “Миний нэр эцгийн минь нэр адил төрийн албан хаагч гэх нэр”-ээр овоглуулан явж байгаагийн хувьд нутгийн удирдлагын эрх зүйн шинэчлэл сэдвийн хүрээнд өөрийн өчүүхэн санал бодлоо нэмэрлэсэндээ маш их баяртай байна.

Ном зүй

1. Монгол улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, 1992
3. Төрийн албаны тухай хууль, 2002
4. Төсвийн тухай хууль, 2011
5. Г.Маналжав, Хурал, өөрөө удирдах ёс, 2000 он
6. О.Тунгалаг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал-түүнтэй холбоотой зарим асуудлууд, 2012 он

Ц.НОМИН

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын
ИТХ-ын нарийн бичгийн дарга

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА БАРИЛ, ҮР ӨГӨӨЖ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙГ ДАГУУЛЖ МАНЛАЙЛАХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ӨӨРЧЛӨХ АРГА

2015.04.21

Сэдвийг сонгосон үндэслэл:

Нэг. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн шинэчлэл зайлшгүй талаар үндэсний, аймгийн, сумын түвшинд хүчтэй яригдсаар нилээдгүй цаг хугацааг өнгөрлөө. Нутгийн өөрөө удирдах байгууллага хэмээх нэр томъёо 1992 оны Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 59 дүгээр зүйлийн 59.2-т зааснаар “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн” гэж хуульчилж өгснөөр иргэдээрээ овоглосон иргэдээ төлөөлсөн байгууллагын эх суурь тавигдсан түүхтэй. Ерөөс ардчилсан нийгмийн утга учир хүн өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, өмч хөрөнгийг шударга хөдөлмөрөөр хураан хуримтлуулж, төр захиргааны үйл ажиллагаанд үнэлэгээ дүгнэлт хийх, санал тавих, сайшаах, шүүмжлэх зэргээр идэвхтэйгээр оролцох бодит бололцоо үүссэн билээ.

Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэгч хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоох эрхэм зорилготой Үндсэн хуулиараа баталгаажсан байгууллагын гал тогоонд багтаж, төрийн албан хаагч нэрийн дор байгууллагын үнэт зүйлс, алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхээр өөрийн эрдэм, чадлыг зориулж, сайшаал зэмлэл, сайн муу үйл хэргийн эзэн болж яваагийн хувьд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны арга хэлбэр, үр нөлөөний хүрээнд иргэд

олон нийтээрээ хүрээлүүлэх үү? эс чадах уу? гэдэг дээр саналаа хуваалцах нь зүй ёсны үүрэг хариуцлага хүлээсэн албан тушаалтны хувьд болоод хөгжих дэвших нийгмийн эд эс болсон иргэний ёс зүйн асуудал хэмээн үзлээ.

Удиртгал. Ажиллах нөхцөл бололцоо хангагдсан түүхэн боломж.

Хууль эрх зүйн орчин.

1. Монгол улсын Үндсэн хууль ,1992
2. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 1992
3. Монгол улсын төсвийн тухай хууль, 1993
4. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль 1994
5. Төсвийн тухай хууль 2012

Хуулийн зүйл заалтуудаас онцлон дурдвал:

Жаран хоёрдугаар зүйл.

1.Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.

2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

ИТХ, Засаг даргын чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх эрх хэмжээ. ЗЗНДНТУТ хууль

Засаг даргын буюу төрийн төлөөлөгчийн эрх хэмжээ	ИТХ-ын буюу нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээ
<ul style="list-style-type: none"> o Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх o Хууль тогтоомж, Засгийн газар харъяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцана. o Хурлын шийдвэрт хориг тавина. o Тавьсан хоригийг ИТХ олонхийн саналаар няцаасан нөхцөлд уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно. o Засаг даргыг томилно. o Аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд томилно. 	<ul style="list-style-type: none"> o Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. o Нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэнэ. o Улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна. o Тухайн шатны Засаг даргад нэр дэвшүүлнэ.

Нэг. Тулгамдсан байдал:

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага сумын ИТХ-ын байгууллагыг иргэдийн олонх нь бие даасан бодлогын чиг үүрэг бүхий байгууллага гэхээс илүүтэйгээр ЗДТГ-ын бүтцэд хамааруулан ойлгодог.
- Үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох хуралдаан нь улс төрийн шийдэлтэй асуудлаас бусад асуудал хэлэлцэхэд ИТХ-ын төлөөлөгчдийн ажил хэрэгч оролцоонд тулгуурлаж бус албадлагын шинж чанартай ёсчлох чиг үүргийн дагуу хийгддэг.
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлага, сонгуультаан нь хуулийн хүрээнд тавигдах шалгуур нь тодорхой бус байдгаас хувь хүний чадамж тухайн шатны

Засаг даргаас боловсрол мэдлэг, ур чадварын түвшин дутмаг байдаг тул байгууллагын болон удирдлагын нэр хүндэд өгөх иргэдийн үнэлгээ, сэтгэл ханамж тааруу байдаг.

- Газар нутгийн хувьд хэтэрхий тархмал, мал аж ахуй эрхэлж амьдардаг тул цаг боломж хомс тааруу, хүрч үйлчлэх арга хэлбэрийг ихээр шаардаж байгаа
- Ард түмний өөрөө өөрийгөө удирдах эрхийн баталгааг хэрэгжүүлэх, иргэдийн оролцоог хангах асуудал тулгамдаж байна.

Тавьсан зорилго, зорилт: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг иргэдийн оролцоонд түшиглэн нутаг дэвсгэр, иргэдийн өмнө тулгамдаж буй асуудлыг бүрэн шийдвэрлэдэг эрх зүйн чадамж бүхий үйл ажиллагааг хэвшүүлэх зорилгын дор:

1. Иргэд оролцохын тулд мэдлэг мэдээлэлтэй байх хөрс суурь хэрхэн тавигдсан
2. Иргэд шийдвэр гаргах явцад оролцдог байдал хандлагын нөлөөлөл
3. Иргэдийн мэдээлэл авах хэрэгцээний бодит нөхцөл байдалд шинжилгээ хийх
4. Иргэдэд ямар мэдээ мэдээлэл юуны учир хэрэгтэй байгааг тодорхойлох зорилтуудыг дэвшүүлэн Хөвсгөл аймгийн 10 сумын ИНХ-ууд жилд хэдэн удаа хуралдаж, ямар шийдвэрүүдийг гаргаж буй талаар судалгаа хийж дүгнэлт гаргах

Энд дэвшүүлж байгаа зорилго зорилтыг тодорхойлох, цаашдын үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх бодит шаардлагыг эрдэмтэн судлаачид хэрхэн тодорхойлсон талаар онцлон дурдъя.

“Иргэний нийгэм нь өөрийн амьдралын ачааг дааж чадах, улмаар бусдын төлөө нийгмийн хариуцлага хүлээх чадвартай, ухаалаг мэдээлэлтэй иргэдтэй байж л бодитойгоор бий болно”¹

¹ Хишигдаваа А., Мягмарсүрэн С., Иргэдийн улс төрийн соёлын зарим асуудал, Нутгийн удирдлага сэтгүүл, МНУХ, 2012, №02, 24 дэх тал

“Орчин үеийн улс төрийн гүн ухааны онолын үндэслэгчид болох Макиавелли, Локк, Токвиль, Милль, Даль зэрэг томоохон сэтгэгчид иргэдийн улс төрийн оролцоог ардчилсан нийгмийн үнэт зүйлс, хүчирхэг хөдөлгүүр гэж үзэж байсан”.²

“Монгол улс дэлхий дээр хамгийн олон хүн амтай, хамгийн том газар нутагтай хоёр орноор хүрээлүүлсэн цорын ганц орон мөн. Тийм учраас ард иргэдээрээ асуудал шийдүүлнэ гээд Ерөнхийлөгчийн хэлээд байгаа, бидний яриад байгаа шууд ардчилал, иргэний оролцоо гэдэг чинь зөвхөн иргэний эрхээс гадна улс орны бүрэн эрхт байдлын асуудлыг шийдээд явах чадамжтай холбоотой юм”.³

“Сум орон нутгийн хурал, Засаг даргын харилцааны асуудлыг ч анхааран судлууштай болжээ. Сум, орон нутгийн хурал, Засаг дарга гэсэн хоёр өөр чиг үүрэгтэй нутгийн өөрөө удирдах тогтолцоог нутгийн өөрөө удирдах ёсонд нийцүүлэх үү? эсвэл төрийн тогтолцоонд нэгтгэх үү? гэдэг шиг ажил амьдралд оролцож байгаа сонгуультаан ажилтнууд, судлаач, эрдэмтэд, улс төрчид зориуд судалж үзэхээр болжээ”.⁴

Дэлхий дахины соёл иргэншлийг тодорхойлж байсан өвөг дээдсийн хойч үе бидэнд хүн төрөлхтөний дэвшилтэт ололт, ардчилал, иргэний нийгмийн зүй тогтлыг манай улс ардчилалд суралцаагүй, төрт ёсны уламжлалтай, иргэд боловсроогүй гэх мэт шалтгаанаар хойш тавих бус харин ч ардчиллын нийтлэг зарчимд улс орныхоо онцлогийг тусган бусдаас илүү зоримог, эрч хүчтэй, илүү чадварлаг зохион байгуулах оюун ухаан, хүч чадал та бидэнд байх учиртай.⁵

Тулгамдаад байгаа асуудлуудыг эрдэмтэн судлаачид, шат шатны нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтануудын хүрээнд дэвшүүлэн тавьж, байгууллагынхаа үйл ажиллагаа, арга барил, үр өгөөж, иргэд, олон нийтийг дагуулж манлайлах чадварыг хөгжүүлэх, арга замыг тодорхойлоход хувь нэмэр оруулахын тулд эрх зүйн орчны шинэчлэл, боловсон хүчний

2 Мөн тэнд 25 дахь тал

3 Элбэгдорж Ц., Шууд ардчилал-иргэний оролцоотой төсвийн менежмент үндэсний зөвлөгөөн, Төрийн ордон, 2013.


4 Маналжав Г., “Нутгийн захиргаанд нухацтай ярилцаж шийдэх асуудал байна”. Нутгийн удирдлага сэтгүүл, МНУХ, 2013, №4/96

5 Нармандах С., Иргэддээ тулгуурласан чадвартай, хариуцлагатай ИТХ-ыг төлөвшүүлэх арга зам зөвлөгөөн, Төрийн ордон, 2013.


эрдэм чадалд тулгуурлах менежментийн бодлого боловсруулах шаардлага байна.

Судалгааны объект: Сумын ИТХ, багийн ИНХ, иргэдийн хэрэгцээ сонирхол


Та мэдээллийг ямар арга замаар авч байна вэ?



2. ИТХ-аас 2013-2023 он хүртлэх хугацаагаар батлан гаргасан хөгжлийн төлөвлөгөөнд та саналаа өгсөн. Таны санал туссан эсэхийг эргэж хянасан уу?



3. Ямар мэдээлэл авахыг хүсч байна вэ?



Багийн ИНХ-ын хуралдаа нь дунджаар жилд 3-н удаа болж байна. 1 удаагийн хуралдаанаар 3-4 асуудал хэлэлцэж байгаа нь хүмүүсийн суух, мэдээлэл хүлээн авах, нэгэн зэрэг олон мэдээллийг боловсруулах зэрэг шинжлэх ухааны түвшинд хүний бие махбодь хүлээн авах боломжгүй гэж нотолсон хязгаарыг бүгдийг зөрчдөг хандлага байгаа нь тусгайлан судалж шийдэх арга замыг хайгууштай.

Хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзэх тоо хувь зааж өгсөн нь агуулга бус хэлбэр, чанар бус тоо, нэгжийг бус ерөнхийг эрхэмлэх хөрс болон тавигдаа юу даа гэсэн бодол эрхгүй төрж байна.

Судалгааны аргын сонголт: Санал асуулга, ажиглалт, туршилтын арга хэрэглэв. Сумынхаа 5 багийн нийт 100 иргэнээс нээлттэй болон хаалттай асуултаар санал асуулгын хуудас боловсруулан авлаа.

ИТХ, ИНХ-д ажиллаж байсан болон ажиллаж байгаа нийт 10 ажилтан сонгуультнуудтай ярилцаж санал сэтгэгдлийг сонслоо.

10 сумын багийн ИНХ-ын үйл ажиллагааг судлан дүгнэлт хийлээ.

Шинэлэг тал: Хөвсгөл аймгийн бусад сумдын ИНХ-уудын хуралдааны давтамж, хэлэлцсэн асуудлуудын чиглэлийг тодорхойлсноор өөрийн ажилд шинэлэг арга туршлага нэвтрүүлэх боломж үүслээ.

Өдөр тутмын ажлын явцдаа туршлагагаж байдаг боловч практикийг шинжлэх ухааны онолтой харьцуулан жиших замаар судалгаа хийх явцдаа мэдээлэлд боловсруулалт хийж, мэдлэг болгон ашиглах чадамжтай боллоо. Хувийн зүгээс цаашид судалгааны ажлыг гүнзгийрүүлэн судлах хүсэл зорилго төлөвшлөө.

Онол практикийн ач холбогдол: Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх хөгжүүлэх чиглэлээр улс орнуудын баримталж буй баримт бичгүүдийг дурдахад:

- Торонтогийн тунхаг
- Рио де Жанейрогийн тунхаг
- Дэлхийн болон Европын Харти
- МНУХ, КАС-ын 2001 оны тунхаглал

МНУХ-ноос нутгийн өөрөө удирдах байгууллагын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагад шинжилгээ судалгаа хийх зорилгоор эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлуудыг тогтмолжуулж байгаа. Я.Долгоржав, С.Нармандах, О.Тунгалаг, Б.Шарбанди, Я.Бямбаяр, Б.Баттүвшин, Г.Маналжав зэрэг олон эрдэмтэн судлаачид Монгол ахуй, Монгол сэтгэлгээнд тохирсон сонгодог онолыг боловсруулахын төлөө ажиллаж мэдлэг оюунаа дайчлан ололт амжилтыг батжуулан алдаа дутагдлыг сайжруулах арга замын хамтаар дэвшүүлэн тавьсаар ирсний бодит үр нөлөө болж жирийн нэг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга миний энэ асуудлыг сонирхох, судлах энэ талаар өөрийн бодлол санааг илэрхийлэх итгэлтөгс байх нөхцлийг бүрдүүлж чаджээ гэж бахархаж байна.

Дэвшүүлж байгаа санал:

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь татвараа бүрдүүлэх, хувиарлах эдийн засгийн эрх чадамжтай байх
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх хэмжээг Засаг

дарга бус ИТХ хэрэгжүүлэх

- Иргэдийн идэвх оролцоонд түшиглэсэн ардчилсан үнэт зүйлс бүхий засаглалыг төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай үр нөлөөтэйгээр хослуулах
- НӨУЁБ-ын алсын хараа, хэтийн зорилго, зорилтуудыг ханган биелүүлэх үйл ажиллагааны өдөр тутмын удирдлагын ханган ажиллагч ИНХ-ын дарга, шат шатны ИТХ-ын дарга нарын боловсрол, ажлын туршлагыг харгалзан сонгох нөхцлийг хуулиар бүрдүүлэх
- Иргэдийг төлөөлөхөөр гарч ирсэн төлөөлөгчид, шат шатны ИТХ, ИНХ-ын дарга, Тэргүүлэгчдэд цалин урамшуулал олгодог түүнийхээ хирээр хариуцлага тооцдог, хуралдаанаа шалтгаангүйгээр тасалдаг, сум, иргэдийн хөгжлийн бодлого, эрх ашгийн төлөө бус намчирхах үзэл гаргасан төлөөлөгчийн бүрэн эрхийг хөндөх хариуцлага, ёс зүйн чадамжийг илэрхийлэх хуулийн зүйл заалтыг тусган хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хэрэгжүүлэх арга зам:

- Бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагад иргэдийн санал бодлыг судладаг, шийдвэрт хяналт шинжилгээ хийдэг мэргэжилтэн ажиллуулах
- Төсвийн хөрөнгө, мөнгөний зарцуулалтад аудит хийдэгтэй адил төрийн үйлчилгээний чанарт үнэлгээ өгөх нийгмийн аудитын тогтолцоо бүрдүүлэх
- 4 жилийн хугацаанд сонгогдсон НӨУЁБ-ын ажилтан, сонгуультнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тусгай сертификатын сургалтанд үе шаттайгаар хамруулах
- ИНХ дарга, ИТХ-ын дарга нарын үр дүнгийн гэрээний үлгэрчилсэн загвар гарган мөрдүүлэх


ИНХ-ын хуралдаан, ИТХ-ын хуралдаан нь хэн нэгэн албан тушаалтны хүсэлтээр бус иргэдийн санаачлагаар амьдрал ахуйн хэрэгцээ шаардлагаар хэт олон биш цөөн асуудлыг нухацтайгаар хэлэлцэж хэвших

-Бүх шатны нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын дарга нарт тавигдах шаардлагыг тусгаж өгөх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, арга барил, нэр хүндийг сайжруулан иргэдийн итгэлийг хүлээсэн, хүрээлүүлсэн иргэдийн гэсэн овогтой байгууллага байх боломж бодит байдалд нийцэн төлөвшинө гэж үзэж өөрийн саналыг дэвшүүллээ.


Ном зүй

1. Үндсэн хууль, Улаанбаатар, 1992.
2. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Улаанбаатар, 1992.
3. Төсвийн тухай хууль, Улаанбаатар, 2012.
4. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Улаанбаатар, 1994.
5. Бямбаяр Я., Нутгийн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал илтгэл, Удирдлагын академи, Улаанбаатар, 2006.
6. Лувсанжамц Л., Пүрэвтогтох Г., Норовсамбуу Д. нар, Орон нутгийн засаглалд иргэдийн оролцоог хангах нь гарын авлага, “Орон нутгийн Засаглалыг дэмжих хөтөлбөр” төсөл, Улаанбаатар, 2011.
7. Нутгийн удирдлага сэтгүүл, МНУХ., 2009-2015.
8. Тунгалаг О., Үлгэрчилсэн журам, дүрмүүд, Улаанбаатар, 2015.


№	Асуулт	хариулт	1-р баг	2-р баг	3-р баг	4-р баг	5-р баг	Нийт дүн
1	Та мэдээллийг ямар арга замаар авч байна вэ?	мэдээллийн самбараас	2	1	3	5	4	15
		багийн удирдлагуудаас	9	5	8	5	11	38
		сумын вэб сайтаас	2		1	3		6
		хурал, цуглаанаас	5	12	6	5	3	31



№	Асуулт	хариулт	1-р баг	2-р баг	3-р баг	4-р баг	5-р баг	Нийт дүн
2	“Чандмань-Өндөр сумын хөгжлийн төлөвлөгөө 2013-2023”-г боловсруулахад таны саналыг авсан. Таны санал туссан эсэхийг эргэж хянасан уу?	тийм	4	4	4	6	3	21
		үгүй	14	11	10	12	14	61



№	Асуулт	хариулт	1-р баг	2-р баг	3-р баг	4-р баг	5-р баг	Нийт дүн
3	Ямар мэдээлэл авахыг хүсч байна вэ?	Хуулийн сургалт, сурталчилгаа					1	1
		Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр	7	5			1	13
		халамжийн үйлчилгээ		3			1	4
		ОНХС-гийн талаар		1		1	1	3
		СХС-гийн төслийн биелэлтийг хянаж шалгадаг эсэх		1				1
		Байгаль орчны талаарх асуудал	1	4				5
		Хүний хөгжлийн талаар	2	1				3
		багийн иргэдийн тухай	1	1				2
		Шинэ мэдээ мэдээлэл	2	1		2		5
		Төрөөс малчдын талаар баримталж буй бодлого	4					4
		ИТХ-ын гаргасан шийдвэр				1		1
Сумын хөгжлийн төлөвлөгөө хэрэгжиж буй эсэх				3		3		



БАГИЙН ИНХ-УУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИНЖИЛСЭН СУДАЛГАА

2015.05.15

№	Сумын нэр	Багийн тоо	2014 онд ИНХ-ын хуралдаан хийсэн тоо	ИНХ-ын хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо	Үүнээс иргэдийн санал, хүсэлтийн дагуу хэлэлцсэн
1	Арбулаг	6	17	58	3
2	Бүрэнтогтох	6	16	25	3
3	Галт	5	20	82	5
4	Рашаант	5	13	41	4
5	Төмөрбулаг	5	16	48	-
6	Түнэл	6	24	86	-
7	Улаан-Уул	5	11	25	-
8	Чандмань-Өндөр	5	12	43	2
9	Эрдэнэбулган	5	15	45	3
10	Мөрөн	13	39	162	45
	Нийт	61	183	615	65

**НАМСРАЙДОРЖИЙН БАТЧИМЭГ
БАЯРААГИЙН БАЯЛАГМАА**

*Монгол Улсын Их сургууль-Хууль зүйн сургуулийн
Эрх зүйн V курсын оюутан*

**ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА УЛС
ТӨРИЙН НАМ**

Удиртгал

- Сэдэв сонгосон үндэслэл
- Шинэлэг санаа
- Судалгааны ач холбогдол

Нэг. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ба улс төрийн нам

1.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай ойлголт, сонгуулийн тогтолцоо

1.2. Улс төрийн намын талаархи онолын ойлголт, нутгийн өөрөө удирдах байгууллагад оролцох оролцоо

Хоёр. Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулинд сонгуулийн тогтолцоог тусгасан байдал

Гурав. Харьцуулсан судалгаа (Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтанд орон нутгийн сонгуулийн тогтолцоог тусгасан байдал)

Дүгнэлт, Санал

Ашигласан эх сурвалж

УДИРТГАЛ

Сэдэв сонгосон үндэслэл

Нутгийн өөрөө удирдах ёс бол Үндсэн хуулинд тусгагдсан Монголын ардчилсан төрийн салшгүй хэсэг юм.¹ Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэж заасан байдаг. Нутгийн өөрөө удирдах ёсны талаарх олон онолын урсгал чиглэлүүдтэй² бөгөөд “Өөрөө удирдах ёс” гэж тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил хэргийг тэндхийн иргэд, хамт олон шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан бие даан шийдвэрлэхийг хэлнэ.³ Дээрхээс үзвэл нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Иргэдийн нийтийн хурал, тухайн хурлын чөлөө цагт түүний Тэргүүлэгчид нь тухайн орон нутгийн иргэдийн төлөөлөл юм. Гэвч тухайн иргэдийн төлөөллийг сонгохдоо сонгуулийн холимог тогтолцоогоор буюу нэг талаас пропорциональ тогтолцоогоор шууд намыг сонгож байгаа нь нутгийн өөрөө удирдах ёсонд

1 Л.Золзаяа, Л.Лувсанжамц “Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал” УБ., 2003, 14 дэх тал

2 Эрх зүй сэтгүүл- 2000 он, № 1, А.Эрдэнэцогт “Нутгийн өөрөө удирдах ёсны гол чиглэл”, 52-55 дах тал

- Чөлөөт хүй элгэн /обшина/-ийн онол : Энэхүү онолын гол онцлог нь “хүй элгэн” өөрийн ажил хэргээ эрхлэн мэдэх эрх нь хүний эрх, эрх чөлөөтэй адил жам ёсны бөгөөд салгаж үл болох шинжтэй.

- Нийгмийн онол: Дээрх онолын дараа үүссэн нийгмийн онолоор өөрөө удирдах ёсны мөн чанар бол нутаг дэвсгэрийн бие даасан хамтлагууд өөрийн зорилтоо хэрэгжүүлэх нь зөвхөн тэдгээрийн эрхийн асуудал байдаг. Учир нь өөрөө удирдах байгууллагыг төрийн байгууллага гэж үздэггүйд оршино.

- Төрийн онол: Өөрөө удирдах ёс нь төрийн удирдлагын орон нутгийн зохион байгуулалтын нэг хэлбэр бөгөөд нутгийн өөрөө удирдах ёсны хүрзэн дэх бүхий л бүрэн эрх төрөөс өгөгдсөн, төрийн засаглалаас эх сурвалжтай.Төрийн удирдлагаас ялгаатай нь нутгийн өөрөө удирдлагыг Засгийн газрын түшмэдүүд (төрийн албан хаагч) хэрэгжүүлж болохгүй.

- Дуализмын онол: Өөрөө удирдах ёсны төрийн онолын дараагаар ХХ зууны эхэн үеэр гарч ирсэн бөгөөд төрийн болон нийгмийн онолыг хослуулах зорилт тавьсан болно.

- Нийгмийн үйлчилгээний онол: Өөрийн оршин суугчдад үйлчилгээ үзүүлж, зохион байгуулах нь нутгийн өөрийн удирдлагын онцолж хийх үндсэн ажил нь байна.

3 Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал:Нутгийн удирдлага”, УБ, 2004, 13 дах тал
Мөн Өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн нэгжийн хүн ам, суурин газрын оршин суугчдын ба олон нийтийн байгууллагын гишүүд гэх мэт, хүмүүсийн нэгдлийн дотоод зохион байгуулалт бөгөөд үндсэн утга учир нь иргэд хамтарч ерөнхий хэрэг явдлаа удирдан хөтлөх, амин чухал асуудлаа шийдвэрлэхэд оршино.Д.Солонго “Төрийн эрх зүйн тайлбар толь” УБ., 2003., 76 дах тал

нийцэж байгаа юу?, нам нь иргэдийн төлөөлөл мөн үү?, Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн **3.1-т** “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан ёсоор иргэд “Нутгийн өөрөө удирдах байгууллага”-ын төлөөлөгчдийг сонгохдоо шууд оролцож чадаж байгаа эсэх гэсэн асуудлууд гарч ирж байгаа тул энэхүү сэдвийг судлах болсон билээ.

Шинэлэг санаа : Нутгийн өөрөө удирдах байгууллага дах намын оролцоо гэсэн сэдвээр судалсан бүтээлүүд нилээдгүй байдаг. Харин судлаач окутан бидний зүгээс энэхүү сэдвийг хязгаарлаж 2012 оны нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн тогтолцоо нь холимог тогтолцоогоор явагдаж, пропорциональ тогтолцоогоор намыг сонгож байгаа нь нутгийн өөрөө удирдах байгууллага дах намын оролцоог улам ихэсгэсэн, үүнээс үүдэх сөрөг үр дагавар бий болгосон тухай судалсан нь энэхүү илтгэлийн шинэлэг тал болно.

Судалгааны ач холбогдол: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын мөн чанарыг алдагдуулж байгаа үндсэн нэг шалтгаан нь улс төрийн намын давамгайлсан оролцоо юм. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төлөөллийг сонгох сонгуулийн тогтолцоог судалснаар тухайн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намын оролцоог багасгах үндсэн шийдлийг бий болгох ач холбогдолтой гэж үзэж байна.

НЭГ. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ба улс төрийн нам

0.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай ойлголт, сонгуулийн тогтолцоо.

Иргэншиж тогтсон нийгэмд нутгийн өөрөө удирдах ёс нь ардчиллын үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан хангаж буй хэмжүүр, эрх зүйт төрийн нэг чухал шинж юм.⁴

4 А.Эрдэнэцогт “Нутгийн өөрөө удирдах ёсны Олон Улсын хөгжлийн чиг хандлага”, Эрх зүй сэтгүүл 2003 № 10-11 , 71 дэх тал

Олон улсын баримт бичгүүдэд⁵ Өөрөө удирдах ёсны талаар тодорхойлохдоо **“Тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид ардчилсан, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр өөрсдийн төлөөллийн байгууллагаа бүрдүүлнэ” гэсэн агуулгыг тусгасан байна.**⁶ Өөрөөр хэлбэл, тухайн нутгийн иргэд, эсвэл тэднээс ардчилсан, чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр сонгогдсон төлөөлөгчид хэрэгжүүлэх ба үйл ажиллагаандаа ардчилалын үнэт зүйлсийг мөрдлөг болгоно.⁷ Ийнхүү сонгуулийн явуулах, дүнг яаж нэгтгэх арга хэлбэрийг сонгуулийн тогтолцоо гэж ойлгоно. Сонгуулийн холимог тогтолцоо гэдэг нь мажоритар буюу олонх дийлэнх, пропорциональ буюу хувь тэнцүүлэн сонгох тогтолцоог хослуулсан аргыг хэлдэг. Хувь тэнцүүлэх /пропорциональ/ тогтолцоо гэж нэг тойрогт өрсөлдсөн нам, бүлэг, нэрд эвшигчдийн хооронд авсан саналын хувь хэмжээгээр нь гишүүний мандатыг буюу суудал хуваарилах аргыг хэлнэ. Энэ тогтолцооны үед сонгогч голчлон тодорхой нам, эвслийн төлөө саналаа өгдөг.⁸ Нутгийн өөрөө удирдах байгууллагад намын нөлөөлөл ихсэж байгаа нь нутгийн өөрөө удирдах ёсны шинжийг алдагдуулж, нутгийн иргэдийн эрх ашиг гэхээсээ илүүтэй намын эрх ашгийг дээгүүр авч үздэг сөрөг нөлөөтэй.⁹ Гэтэл Монгол Улсад сонгуулийн холимог тогтолцоогоор (нэг талаас мажоритар, нөгөө талаас пропорциональ тогтолцоогоор намыг сонгож) нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчийг сонгож байна. Нутгийн захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын зохимжтой харьцаа алдагдвал улс төрийн байгууллага мэт болох¹⁰ нутгийн өөрөө удирдах байгууллагын шинж нь алдагдах юм. Өнөөгийн байдлаар Монгол Улсад¹¹: Иргэдийн төлөөлөгчдийн хуралд намууд бүлэг байгуулан асуудал бүрийг хэлэлцээд талцаад байгаа нь дээр дурьдсан орон нутгийн эрх ашгийг

5 Торонто хотноо 1993 онд Хуралдсан нутаг дэвсгэрийн нэгжийн Олон Улсын холбооны 31-р бага хурлаас “Нутгийн өөрөө удирдах ёсны Олон улсын тунхаг” бичиг болон Нутгийн удирдлагын тухай 1985 оны Европын Хартид ардчилсан улсууд нийтээр хүлээн зөвшөөрсөн нутгийн өөрөө удирдах ёсны талаар нийтлэг байдлаар тодорхойлсон.

6 Д.Дондог, О.Тунгалаг “Нутгийн удирдлага-Эрх зүйн шинэчлэл” УБ, 2007, 3 дах тал

7 “Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр” сэдэвт бага хурлын баримт материалын эмхэтгэл, УБ, 2004, 192 дэх тал

8 Б.Нармандах “Үндсэн хуулийн эрх зүй” ., УБ., 2011, 143 дах тал

9 Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал” Гуравдугаар дэвтэр, ., УБ., 2004, 39 дэх тал

10 Ш.Цогтоо “Засаг захиргаа” онол, арга зүйн асуудал, УБ., 2007, 192 дэх тал

11 “Газар, удирдлагаарх зүй”. УБ, 2005., Я.Бямбабаяр “ Нутгийн өөрөө удирдах ёсны тухай эргэцүүлэл ” 195-197 дахь тал

үгүйсгэхэд хүргэж байна. Тухайлбал, Засаг Даргыг томилоход намаар талцах. Жишээ нь: Баянхонгор аймгийн Заг сумын 1 дүгээр /Баянбулаг/ багийн Засаг даргыг сонгох сонгуульд Монгол Ардын намаас нэр дэвшигч 50,4 хувийн саналаар ялсан. Гэтэл сумын Засаг дарга Э.Мөнхбаяр “Дээд, доодгүй Ардчилсан нам ялсан энэ үед багийн дарга ч Ардчилсан намын хүн байх шаардлагатай, би бүрэн эрхийнхээ дагуу Монгол Ардын намаас ялалт байгуулсан хүнийг батламжлахгүй” гэсэн шалтгаанаар томилоогүй.¹² Ийнхүү судлах явцад 2012 оны байдлаар сонгуультай холбоотой маргаан 120 хэлэлцэж¹³, 2013 оны шүүхийн шийдвэрийн нилээдгүй байр суурийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль болон Засаг даргыг томилохтой холбоотой маргаан эзэлж байна.

0.2. Улс төрийн намын талаархи онолын ойлголт, нутгийн өөрөө удирдах байгууллагад оролцох оролцоо

Улс төрийн “Нам” гэдэг бол нийтлэг сонирхол, үзэл баримтлалтай хүмүүсийг нэгтгэж, үйл ажиллагаа нь төр, засгийн эрхийг авах буюу түүний хэрэгжилтэд оролцоход чиглэсэн сайн дурын улс төрийн байгууллага юм.¹⁴ Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр 4.1-т “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.” Дээрхээс үзвэл нам нь нутгийн иргэдийг төлөөлөх зорилгогүй харин засгийн эрхийг гартаа авах зорилго бүхий байгууллага бөгөөд аливаа улс төрийн намын үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг нь сонгуулийн компанийг амжилттай явуулж ялалт байгуулах явдал байдаг билээ¹⁵. Иймээс Нутгийн өөрөө удирдах байгууллагад намын эзлэх байр суурь ихсэх тусам нутгийн өөрөө удирдах байгууллагад шийдвэр гаргалтын түвшинд бие даасан байдал алдагдана.

12 Баянхонгор аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2013.03.22-ны дугаар-6 шүүхийн шийдвэр, 2013-04-12-нд www.shuukh.mn сайтаастатажаава. Хуудас: 2/9

13 http://www.supremecourt.mn/index.php?option=com_content&view=article&id=1293%3A2013-02-15-07-17-55&catid=26%3A2010-11-10-08-10-56&Itemid=153, 2013.04.24-нд авав.

14 МУИС-НШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн бэлтгэсэн “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2010., 322 дэхь тал

15 Ц.Мөнхцэцэг “Политайнмент буюу цэнгээнт улс төр”, УБ., 2010., 152 дахь тал

* Үндэсний статистикийн хорооны цахим хуудаснаас 2013.04.10-ны өдөр авав.

Улс төрийн намын нэр	Орон нутгийн хуралд сонгогдсон гишүүдийн тоо /2008 онд/*	Орон нутгийн хуралд сонгогдсон гишүүдийн тоо /2012 онд, албан бус тоо,/
Бүгд	698	738
МАХН	434	20
Ардчилсан Нам	242	379
Иргэний эвсэл	0	0
Иргэний Зориг Нам	0	3
Эх орон нам	3	0
БНН	2	0
Биедааннэрдэвшигч	17	5
Монгол ардын нам	-	334

Дээрх 2008 болон 2012 оны орон нутгийн хурлын сонгуулийн дүнг харвал намын эзлэх байр суурь нэмэгдсээр байгааг харж болно. Гэхдээ намыг орон нутгийн сонгуулийн байгууллагад огт оролцох ёсгүй гэж үзэж болохгүй бөгөөд гагцхүү Аймаг, нийлэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль нь холимог тогтолцоотой болсноор иргэд Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өөрсдийн төлөөлөгчөө сонгохдоо нэг талаас намаас нэр дэвшүүлсэн намын төлөөлөгчийг өөрсдийн ашиг сонирхлоос үл хамааран сонгоход хүрч байгаа бөгөөд нөгөө талаас Иргэдийн төлөөлөгчдийн хуралд бие даан нэр дэвшигчийн хувьд эзлэх байр суурь нь улам багасах үндэс болж байна.

ХОЁР. Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулинд сонгуулийн тогтолцоог тусгасан байдал

2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр шинээр батлагдсан Аймаг, Сум, Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 9-д “Сонгуулийг холимог хэлбэрээр буюу хувь тэнцүүлэх болон нэг буюу олон мандаттай олонх (мажоритар)-ын хэлбэрээр явуулна.” гэж өөрчилсөн. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн /цаашид МУЗЗНДНТУ

тухай хууль гэх/ 10 дугаар зүйлийн 3-т “Сумын хурлын төлөөлөгчдийн тоог хүн амын нягтрал байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дараах байдлаар тогтооно. МУЗЗНДНТУ тухай хуулийн 10.3.1-т “Сумын хүн амын тоо нь 2000 хүртэл бол 15; 10.3.2. сумын хүн амын тоо нь 2000-5000 хүртэл бол 21; 10.3.3. сумын хүн амын тоо нь 5000-9000 хүртэл бол 27; 10.3.4. сумын хүн амын тоо нь 9000 ба түүнээс дээш бол 31.” гэж заасны дагуу Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 4.11.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хувь тэнцүүлэх хэлбэрээр сонгогдох төлөөлөгчдийн тоог Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10.3-т заасан сумын Хурлын төлөөлөгчдийн тоог гуравт хувааж тогтоох бөгөөд хэрэв ийнхүү хуваахад бутархай тоог ердийн ойролцоо бүхэл тоогоор тогтоох” гэж заасан бөгөөд үүнээс дүгнэвэл МУЗЗНДНТУ-ын тухай хуулийн 10.3.1-т заасны дагуу 2000-н хүн амтай сумын хуралд 15 төлөөлөгч байх ёстой гэж үзвэл 5 төлөөлөгч нь хувь тэнцүүлэх буюу намын нэрээр сонгогдох¹⁶ болж байна. Дээрхээс үзвэл 2000-н хүн амтай суманд намаас хамгийн багадаа 5 төлөөлөгч сонгогдохоор байгаа нь намын байр суурь орон нутагт илт давамгайлах байр суурийг эзлүүлэхээр хуульчилсан байна.

ГУРАВ. Харьцуулсан судалгаа

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар 2.1-т “Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.”, 2.2-т “Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана” гэж заасан байдаг. Иймээс харьцуулах улсаа сонгохдоо дараах шалгуурыг тавьсан болно.

1. Улс нь төрийн байгууламжийн¹⁷ хувьд нэгдмэл¹⁸ байх,

16 Сонгуулийн холимог тогтолцоотой холбоотойгоор Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т Нам, эвсэл нь сонгуульд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн 10.2-10.4-т заасан тухайн аймаг, сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тооноос илүүгүй хүнийг нэгдсэн нэг жагсаалтаар нэр дэвшүүлнэ.”

17 Н.Лүндэндорж “Төрийн онол” УБ., 2008, 161 дэх тал
Төрийн байгууламж бол улсын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хуваарилалт, төрийн төв орон нутгийн байгууллагын хороондын харилцааны эрх зүйн байдлыг илэрхийлсэн ойлголт юм. Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжид эсвэл муж улс, субъектын нутаг дэвсгэрт хуваагдаж байна уу гэдгээс хамааран нэгдмэл хийгээд холбооны улс гэсэн төрийн байгууламжийн хэлбэрт хуваагдана.

18 Б.Чимид “Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй”, УБ, 2002, 19 дэх тал

2. Эрх зүйн тогтолцооны хувьд Ром-Германы тогтолцоотой эсхүл Постсоциалист орнуудыг сонгож авсан билээ.

Нидерланд Улсын нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний сонгуулийн тогтолцоотой харьцуулан судлах нь: Ром-Германы эрх зүйн бүлд Герман, Франц, Итали, Португаль, Нидерланд зэрэг улсууд багтана.¹⁹ Итали, Нидерланд, Япон, Испани зэрэг улсын Үндсэн хуулиар нутгийн удирдлагын эрх зүйн үндсийг нарийвчилж зохицуулсан байдаг.²⁰ Нидерланд²¹-ын орон нутгийн Зөвлөлийн төлөөлөгчид нь тухайн нэгжид харьяалагдах иргэдээс дөрвөн жилийн хугацаагаар пропорциональ системээр сонгогддог. Нидерланд улсын Үндсэн хуулийн²² **129** дүгээр зүйлийн 1-т Нутгийн өөрөө удирдах байгууллага болох орон нутгийн зөвлөлийн төлөөлөгчид нь тухайн орон нутгийн нэгжид харьяалагдах иргэдээс 4-н жилийн хугацаагаар сонгоно. Тус хуулийн **129 дүгээр** зүйлийн 2-т “Парламентаас баталсан сонгуулийн журмын дагуу пропорциональ системийг хэрэглэж сонгуулийг явуулна. Дээрх үндсэн хуулийн заалтуудыг үндэслэвэл пропорциональ тогтолцоогоор нэгжид харьяалагдах иргэдээс сонгодог байна. Пропорциональ тогтолцоог²³ зөвхөн намыг сонгоход ашигладаггүй гэсэн агуулгыг илэрхийлж байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгохдоо намыг сонгож хувь тэнцүүлэн хувиарлах бус харин тухайн орон нутагт харьяалалтай иргэдийн хооронд (Иргэн эсвэл “*Бие даасан хамтлаг*” гэж Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрийн нийт иргэн буюу нутаг дэвсгэрийн хамт олныг хэлнэ.) авсан саналыг хувь тэнцүүлэн хувиарлаж, нутгийн

Нэгдмэл улс – нутаг дэвсгэр нь зөвхөн төр засгаас тогтоосон статустай засаг захиргааны нэгжүүдэд хуваагдсан байна.

19 С.Нарангэрэл “Монголын ба дэлхий эрх зүйн тогтолцоо”, УБ., 2001, 240 дэх тал

20 “Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр” сэдэвт бага баримт материалын эмхтгэл, УБ, 2004, 167 дох тал

21 Т.Доохүү, Ч.Энхбаатар “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй: Тусгай анги”, УБ, 2009, 152 дахь тал

1983 оны Үндсэн хууль нь үндсэн хуульт байгууллын үндсийг бүрдүүлсэн байна. Нидерланд нь нэгдмэл улс мөн. Төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Нидерланд нь үндсэн хуульт парламентын хаант засаглалтай улс. Орон нутгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хувьд Нидерланд нь 12 мужид, харин мужууд нь нутгийн өөрөө удирдах 62 байгууллагад хуваагддаг, мужууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөллийн байгууллага нь тэдгээрийн зөвлөлүүд байдаг.

22 Constitution of Netherlands ., 1983., орчуулав.

23 Хувь тэнцүүлэх /пропорциональ/ тогтолцоо гэж нэг тойрогт өрсөлдсөн ам, бүлэг, нэр дэвшигчдийн хооронд авсан саналын хувь хэмжээгээр нь гишүүний мандатыг буюу суудал хуваарилах аргыг хэлнэ.

өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчдийг сонгодог байна.

Бүгд найрамдах Польш Улсын нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний сонгуулийн тогтолцоотой харьцуулан судлах нь:

Хуучин социалист орнуудын хүрээнд хэт төвлөрлөөс ангид орон нутгийн бие даасан хараат бус байх зарчмыг шинэ Польшийн 1997 оны Үндсэн хуулийн VII хэсэгт зохицуулсан байна.²⁴ Польш Улсын Үндсэн хуулийн 3 дугаар 3.1-т “Бүгд найрамдах Польш улс бол нэгдмэл улс мөн” гэж заажээ. Польшийн Үндсэн хуулийн²⁵ 169 дүгээр зүйлийн 169.1-т “Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгжүүд өөрийн зорилтыг шийдвэр гаргагч, гүйцэтгэгч байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлнэ.” 169.2-т “Шийдвэр гаргагч байгууллагын сонгуулийг нийтээрээ, шууд, тэгш эрхтэй нууцаар санал хурааж явуулна. Нэр дэвшигчид нэрээ дэвшүүлэх, сонгууль явуулах зарчим, журам болон сонгууль хүчинтэй байх нөхцлийг хуулиар тодорхойлно. Бүгд найрамдах Польш Улсын Сонгуулийн тухай²⁶ төрөлжсөн хуулийн (2011он) 7 дугаар бүлэгт Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн эрх зүйн харилцааг зохицуулсан байна.²⁷ Тухайн хуулийн 6.2-т “Орон нутгийн өөрөө удирдах байгууллага гэдэг” нь Өөрөө удирдах зөвлөл (засаг захиргааны анхан шатны нэгж), Орон нутгийн зөвлөл, Бүсийн зөвлөл зэргээс бүрдэнэ. Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн нутаг дэвсгэрийн харьяалалтай байна. Тухайн хуулийн 489.2-т “...Хотын захирагч болон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгохдоо хуулийн дагуу дийлэнхи олонхиор /мажоритар/ нууц санал хураалтын үндсэн дээр сонгоно.” Польш улсад нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчдийг сонгохдоо сонгуулийн мажоритар тогтолцоог хэрэглэдэг байна.

24 “Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр” сэдэвт бага баримт материалын эмхэтгэл, УБ, 2004, 167 дах тал

25 Бүгд найрамдах Польш Улсын Үндсэн хууль., Польш хэлнээс орчуулсан: Б.Лхагважав, Ж.Алтангэрэл

26 <http://www.legislationline.org>, Election Code Of Poland, орчуулав.

27 7-р бүлэг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль. 369-469-р зүйлүүдэд дараах харилцаануудыг зохицуулсан байна. Сонгуулийн Ерөнхий зарчмууд, Оршин байгаа газрын шилжих хөдөлгөөний асуудал, Сонгуулийн дүнг зарлах тухай, Нэр дэвшигчдэд мандат олгох, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлттэй холбоотой асуудлууд, Сонгууль хүчин төгөлдөр болох тухай, Нэр дэвшигчдийг зарлах зэрэг асуудлуудыг зохицуулсан байна.

ДҮГНЭЛТ

Дүгнэлт 1. Аймаг, нийлэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль нь холимог тогтолцоотой болсноор иргэд Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өөрсдийн төлөөлөгчөө сонгохдоо нэг талаас намаас нэр дэвшүүлсэн намын төлөөлөгчийг өөрсдийн ашиг сонирхлоос үл хамааран сонгоход хүрч байгаа нь Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн **3.1-т** “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэсэн суурь зарчим бодит байдал дээр хэрэгжихгүйд байна.

Дүгнэлт 2. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь иргэдийн төлөөллийн байгууллага гэсэн ойлголтын онолын болон эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзлээ. Сонгуулийн тогтолцоогоор нэг талаас намыг сонгож байгаа нь нутгийн өөрөө удирдах байгууллагын мөн чанарыг алдагдуулж, нутгийн өөрөө удирдах байгууллагад намын нөлөөлөлийг ихэсгэж байна. Иймээс Орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь улс төрийн шинжтэй байгууллага болгон хувиргасан байна гэж үзэж болохоор байна.

Санал

1-рт: Нутгийн өөрөө удирдах байгууллага дах төвлөрлийг сааруулж, намын нөлөөллийг байх ёстой мэтээр ихэсгэхгүйн тулд Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн явуулахдаа пропорциональ тогтолцоогоор намын сонгох зүйл, заалтыг хасаж, цаашид дахин хэрэглэхгүй, намд давуу эрхийг өгөхгүй байхыг анхаарах нь зүйтэй.

2-рт: Гадаад улс орнуудтай харьцуулсан судалгаанд тулгуурлан Нидерланд Улсын Үндсэн хуулинд заасан нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчийг сонгохдоо пропорциональ тогтолцоог хэрхэн хэрэглэж байгааг анхааралдаа авах нь зүйтэй. Монгол Улс пропорциональ системээр иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг явуулах шаардлагатай бол Нидерланд улстай адил жишгээр улс төрийн намыг сонгох биш, харин тухай орон нутгийн харьяаллалтай

иргэдээс нэр дэвшүүлж хувь тэнцүүлэх байдлаар хуульчилж болох юм. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөллийн байгууллага тул нэр дэвшигчид тухай нутгийн харьяат, нутгийн иргэдийн эрх ашгийг төлөөлж чадах иргэн байх нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг хөгжүүлэхэд чухал нөлөөтэйг анхаарч үзүүштэй.

Ашигласан материал

Хууль тогтоомж

1. Үндсэн хууль., УБ, 2002
2. Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль., УБ., 2012
3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвгэр түүний нэгжийн удирдлагын тухай хууль., УБ., 2006
4. Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль , УБ., 2007
5. Улс төрийн намын тухай хууль, УБ, 2005

Ном, сэтгүүл

1. Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал:Нутгийн удирдлага”, УБ, 2004
2. Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг”УБ, 2008
3. Б.Чимид “Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал”., УБ., 2008
4. Б.Чимид “Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй”, УБ, 2002
5. Д.Солонго “Төрийн эрх зүйн тайлбар толь” УБ., 2003
6. Ш.Цогтоо “Засаг захиргаа-онол арга зүйн асуудал” УБ., 2007, 192-р тал
7. Л.Золзаяа, Л. Лувсанжамц “Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал” УБ., 2003
8. Н.Лүндэндорж “Төрийн онол” УБ., 2008
9. Д.Дондог, О.Тунгалаг “Нутгийн удирдлага-Эрх зүйн шинэчлэл” УБ, 2007
10. Удирдлагын академи “Сумын судалгаа:онол арга зүйн асуудал” УБ., 2004
11. Б.Нармандах “Үндсэн хуулийн эрх зүй” ., УБ., 2011
12. С.Нарангэрэл “Монголын ба дэлхий эрх зүйн тогтолцоо”, УБ., 2001

13. МУИС-НШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн бэлтгэсэн “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2010
14. Ц.Мөнхцэцэг “Политаймент буюу цэнгээнт улс төр”, УБ., 2010
15. “Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр” сэдэвт бага хурлын баримт материалын эмхтгэл, УБ., 2004
16. “Газар, удирдлагаэрх зүй”. УБ, 2005., Я.Бямбабаяр “Нутгийн өөрөө удирдах ёсны тухай эргэцүүлэл”
17. Эрх зүй сэтгүүл- 2000 он, № 1, А.Эрдэнэцогт “Нутгийн өөрөө удирдах ёсны гол чиглэл”,
18. Эрх зүй сэтгүүл 2003 он № 10-11 А.Эрдэнэцогт “Нутгийн өөрөө удирдах ёсны олон улсын хөгжлийн чиг хандлага “ 71 дэх тал
19. Т.Доохүү, Ч.Энхбаатар “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй: Тусгай анги”, УБ, 2009
20. Constitution of Netherlands ., 1983.,
21. Election Code of Poland., 2011,
22. Бүгд найрамдах Польш Улсын Үндсэн хууль.,

Г.АМАРЖАРГАЛ

Москва хотын Санхүү, эдийн засгийн их сургуулийн оюутан

НУТГИЙН УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛД ИРГЭН МИНИЙ ҮЗҮҮЛЭХ ХУВЬ НЭМЭР

Намайг Амаржаргал гэдэг. Энэ жил миний хувьд 12-р ангиа төгсөж амьдралынхаа чухал алхамыг хийх үе ирээд байгаа билээ. Би өөрийн үе тэнгийнхнийгээ төлөөлж Энэхүү үндэсний уралдаанд оролцож, Нутгийн удирдлагын талаарх үзэл бодол шинэлэг санааг та бүхэнд хүргэхээр зорьж байна.

Миний ээж Орчуулагч мэргэжилтэй, би чөлөөт цагаараа ээжийнхээ ажилд байнга тусалдаг бөгөөд 2013 онд ээжийнхээ ажилд тусалж байх үедээ анх “Нутгийн удирдлага, нутгийн удирдлах ёс” гэдэг үгтэй анх таарч байсан. Үнэндээ би энэ үгийг сайн ойлгохгүй байсан учир юу гэсэн үг болох талаар ээжээсээ асуусан юм. Тэгэхэд ээж минь “Нутгийн удирдлага ба удирдах ёс гэдэг нь *Ачааны хүндийг өөрөө үүрье* гэсэн латин үгнээс гаралтай, хүн төрөлтхний амьдрал, түүхтэй салшгүй холбоотой зүйл юм. Өөрөөр хэлбэл бидний өдөр тутмын амьдрал ч үүнтэй салшгүй холбоотой” гэж товчхон тайлбарласан юм. Үүний дараа 2014 оны зун бид гэр бүлээрээ хөдөө явж Миний өвөөгийн нутаг нэгэн суманд очсон билээ. Энэ сум бидний өмнө очиж байсан аймаг сумдаас харьцангуй хөгжил муутай санагдсан. Тэгээд би ээжээсээ “миний өвөөгийн нутаг яагаад ийм муу хөгжсөн юм бэ гэж асуухад “Яагаад гэвэл энд аймаг орон нутгийн засаг, захиргаа муу ажилладаг байх” гэж хариулж билээ. Би дахиад л “Яагаад” гэдэг асуултаа тавихад ээж минь “Аймаг орон нутгийн засаг, захиргаа нь тухайн нутаг дэвсгэрийн хамт олны нийгмийн асуудал болон тэдний эрх ашгийг хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэж чаддаг, өөрөө хариуцлагаа үүрэх чадвартай, өөрийн гэсэн өмчтэй, иргэдийн төлөөллийн, нөгөө талаас төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага байдаг. Энэ байгууллага хэдий сайн ажиллана, тэнд амьдарч байгаа хүмүүс төдий чинээ жаргалтай байдаг.” гэж хэлсэн. Энэ л үед би нутгийн удирдлага гэдэг үгний утгийг

ойлгож энэ талын мэдээ мэдээлэл сонирхон уншиж, “Нутгийн удирдлага” гэдэг үгний утгыг ойлгож мөн иргэн би ямар хувь нэмэр оруулж болох талаар бодож, сонирхож эхэлсэн.

Ингээд ном, хэвлэлээс ойлгосон зүйлээ багцлан дурдахад Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь ер нь хүн трөлөхтөн энэ дэлхийд амьдарч эхэлсэн тэр цагаас үүдэлтэй бөгөөд энэ нь хүй нэгдэлийн үеэс авахуулаад суурин болон нүүдоийн соёл иргэншил оршин тогтнох үе гэх мэтчилэн хүн төрөлхтний хөгжлийн үе шатуудад янз бүрийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн нь одоогийн хөгжлийн түвшинд хүрчээ.

Бид Нудгийн өөрөө удирдах ёсыг улс орныхоо хөгжилд амжилттай хэрэгжүүлж чадсан Герман, Канад, Швед, Сингапур зэрэг улсын туршлагыг судалж, өөрийн орны онцлогт нийцүүлэн нутагшуулах нь чухал. Өнөөгийн нөхцөлд Манай оронд нутгийн удирдах ёсны хөгжил төдийлөн сайн биш байгаа нь дөнгөж шинээр үүсэж байгаа зүйл бус харин өөрчлөлтийн шинэчлэлтийн арга нь ард түмний ёс заншил, ахуй амьдралын онцлогт төдийлөн тохиромжтой биш байж болох талтай юм. Жишээ нь

Монгол улсад Ардын хувьсал ялсанаас хойш нутгийн удирдлагын хуучин тогтолцоог халж, засаг захиргааны байгууллагын шинэ систем үүсэн хөгжсөөр ардчилсан хувьсгалтай золгожээ. Үүний дараа Манай орон зах зээлийн харилцаанд шилжиснээр нутгийн удирдлагын тогтолцоонд өөрчлөлт орж, 1992 оны шинэ Үндсэн Хуулиар баталгаажсан нутгийн удирдлагын цоо шинэ тогтолцоо хуульчилан батласан. Энэ хуулинд

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь **нутгийн өөрөө удирдах ёсыг** төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.” гэж тунхагласан байдаг. Тэгвэл нутгийн удирдлагын сул байдал нь нөгөө талаас энэ нь манай төр засгийн үйл ажиллагааны гажуудал, мөн ард түмний мэдлэг мэдээлэлгүй байдал, албан тушаалтнуудын хариуцлагагүй байдал зэрэг нь нутгийн удирдлагын салбарын хөгжилд саад болж байгаа бас нэгэн хүчин зүйл байж болох юм.

Иргэд тэтгэвэр тэтгэмж авах, шилжилт хөдөлгөөн хийлгэх, төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний талаарх санал гомдолоо шийдвэрлүүлэх гэх мэт өөрт тулгамдсан ямар нэг асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд харьяа нутгийн өөрөө удирдах байгууллагатайгаа харьцдаг. Энэхүү уралдаанд оролцохоор энэ сэдвээр мэдээ, мэдээлэл судалж байхад зарим нэг нэр томъёог, ойлгохгүй байх явдал их байлаа. Мөн төрийн байгууллага нь нутгийн удирдлагын байгууллага яг мөн үү гэдгийг ялгаж ойлгоход хүндрэлтэй байсан. Энэ бэрхшээлээс шалтгаалан энэхүү эссэг бичих явцад үг хэллэгийн алдаа гарсан байх магадлалтай юм.

Миний хувьд анх 2013 онд 16 нас хүрээд иргэний үнэмлэх авах зорилгоор өөрийнхөө харьяа хороон дээр мэдээлэл авахаар очсон. Сургуулийнхаа багш нар, гэр бүлийнхэн, ангийн найз нараас өөр олон хүнтэй харьцаж үзээгүй шахуу байсан надад хороон дээр очиход яагаад ч юм маш хэцүү байсан. Учир нь тус байранд ил тод хадсан мэдээлэл байхгүй, шаардлагатай байгаа мэдээлэлээ хэнээс авах нь тодорхойгүй байлаа. Тэгээд хорооны нарийн бичиг гэх эмэгтэйд ирсэн зорилгоо хэлэхэд Нийслэлийн иргэний бүртгэлийн газар бичиг баримтаа бүрдүүлж очно гэхээс өөр мэдээлэл авч чадсангүй. НИБГ-т би ганцаараа очихоос эмээгээд ээжтэйгээ хамт очсон. Тэнд мөн л мэдээлэл байхгүй 7 номерийн өрөөнд оч гэлээ. Гэвч тэр өрөө цоожтой, ямар хувиараар ажиллах нь тодорхойгүй, ийм хаалга биднийг угтлаа. Ээж бид 2 хэн нэгэн ирж магад гээд хэсэг хүлээж байтал хажуугийн өрөөний ажилтан ирэхээр нь учир байдлаа хэлтэл тэр хүн бидний яриаг дутуу хагас сонсоод маргааш үдээс хойш ир гэсэн үг сонслоо. Ингээд маргааш нь ирж ямар баримт бүрдүүлж, хэзээ ирж болох талаар мэдээлэлд хүрсэн юм. Зөвхөн шинээр иргэний үнэмлэх авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалт авахын тулд би 3 өдөр зарцуулсан юм. Энэ байдал надад үнэндээ бэрхшээлтэй санагдаж байсан. Уг нь би хороон дээрээс бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, НИБГ-ын ажилтны ажиллах цагийн хувиарыг аваад очих боломжтой байсан гэж боддог.

Уг нь манай улс 1992 онд батласан шинэ үндсэн хуулиараа “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагань **нутгийн өөрөө удирдах ёсыг** төрийн удирдлагатай

хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.” гэж тунхагласан байдаг. Албан ёсны мэдээгээр Үндсэн хуулийн тунхаглал их сайхнаар биелэгдэж байгаа мэт боловч агуулгаараа бодит байдал дээр огт өөр байгааг надад тохиолдсон явдал харуулж байна.

Миний **судалж уншснаар** нутгийн өөрөө удирдах ёсны ач холбогдол нь доорхь байдлаар илэрхийлэгддэг байна.

- а. Ардчиллыг хөгжүүлэх
- б. Төрийн зүгээс орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх зарим чиг үүргээсээ чөлөөлөгдөх
- в. Төр, захиргаа, иргэдийн холбоо бэхжүүлэх
- г. Орон нутгийн онцлогийг харгалзах үзэх
- д. Иргэдийн хяналт, хувийн санаачлага дээшлүүлэх

Ийм ач холбогдол бүхий байгууллага манай оронд яагаад үндсэн чиг үүргийнхээ дагуу ажиллаж чадахгүй байна вэ. Энд зөвхөн тухайн байгууллага, тэнд ажиллаж буй хүмүүсийг буруутгаж болохгүй. Харин иргэд өөрсдөө үүргээ ухамсарлаж, хуулинд заасны дагуу нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулахгүй байна. .

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэдгүйгээр төсөөлөхийн аргагүй бөгөөд энэ байгууллагын хөдөлгөгч хүч нь иргэд юм. Нутгийн өөрөө удирдах байгууллага иргэд, хоёрын хамтын үйл ажиллагааны үр дүнд энэ байгууллага үйл ажиллагаа улам боловсронгуй болж хөгжсөөр иржээ. Иргэд өөрийн төлөөллийн хүнийг нутгийн өөрийн удирдлагын байгууллагад сонгох мөн өөрөө сонгогдох эрхтэй байдаг. Ингэснээр иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шийдвэр гаргалтанд нөлөөлөх зэрэг боломжуудыг олж авдаг. Энэ нь орон нутгийн түвшинд шударга ардчиллыг хөгжүүлэх, иргэд өөрсдийн сонгосон байгууллага, төлөөлөгчөөрөө дамжуулан өөрийн амьдралд туслгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх, эрх ашиг нь ямар нэг байдлаар зөрчигдсэн тохиолдолд харьяа нутгийн өөрөө удирдах байгууллагатаа шууд хандах боломжууд бий болно.

Учир нь нутгийн өөрөө удирдах байгууллага нь төрийн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэгтэй байдаг ба **нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн чиг үүргүүд нь:**

1. Орон **нутгийн хэргийг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог хангаж өгөх**
2. Орон **нутгийн өмч болон санхүүгийн нөөцийг удирдах**
3. Тухайн **нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах**
4. Нутаг дэвсгэрийннийгэм ахуйн, соёлын болон иргэдийн өдөр тумын амьдралд зайлшгүй шаардлагатай бусад нөхцөлийг хангах
5. Харьяалах **нутаг дэвсгэртээ хууль тогтоомж болон нийгмийн дэг журмыг сахиулах**
6. Хууль болон бусад эрх зүйгээр баталгаажсан нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх ашиг, сонирхолыг хамгаалах

Ер нь нутгийн удирдлагын байгууллага нь төр иргэн 2-ыг холбогч гүүр болон ажилладаг. Иймээс нутгийн өөрөө удирдах байгууллага дээр дурдсан үндсэн чиг үүргийнхээ дагуу ажиллаж, хуулиар олгогдсон эрх хэмжээг иргэдийнхээ эрх ашиг, сонирхолд нийцүүлэн аливаа, улс төрийн хүчин, эрх мэдэлтэй, бизнесийн салбараас ангид хэрэгжүүлж, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг өөрөө бүрэн хариуцах чадавхтайгаар ажиллах нь хамгийн чухал гэж ойлгож байна.

Харин ийм чадварлаг нутгийн өөрийн удирдлагыг бэхжүүлэхэд иргэн миний оролцоо юу байх вэ. Тэгвэл иргэн хүн идэвх санаачлагатай ажиллаж, тухайн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай цаг үед өөрөө санал бодлоо дэвшүүлж байх нь чухал.

Миний ард түмний шашин шүтлэг, зан заншлийнхаа онцлогоос шалтгаалан бие биедээ шаардлага тавихыг хэл ам хийж бусдын ажилд саад болж байна гэсэн ташаа хандлага бидний дунд урт удаан хугацааны турш оршин тогтносоор ирсэн. Иймээс шинэ үеийн залуус бид энэ сэтгэлгээний гажуудлыг өөрчилж хариуцлагагүй ажилтныг хариуцлагатай болгох, ажлын байрны ёс зүйг эрхэмлэдэг

болгох, хуулинд заасан чиг үүргийнхээ дагуу ажиллаж чадахгүй байгаа нутгийн удирдлагын байгууллагын ажлыг сайжруулахын тулд мэтгэлцээн, санал асуулга явуулах, ярилцлага зохион байгуулах зэрэг ажлын зохион байгуулж, залуусыг идэвхтэй болгох ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Бидний үеийн залуус нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд маш хойрог ханддаг. Учир нь тэдэнд нутгийн удирдлагын байгууллага болон төрийн үйлчилгээний байгууллагатай холбоотой асуудлыг төдийлөн сайн ойлгогддоггүй, асуудал гарвал эцэг эх нь очоод шийдвэрлэхдэг. Мэдээж ээж аав нь хүнд сурталтай ажилтнуудын царайчлах ч юм уу, асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд тэдний гаргаж буй зохисгүй занг хүлцэн өнгөрөөж, өнөөдөр миний ирсэн хэрэг бүтэж л байвал болоо гэсэн байдлаар хандана. Гэвч би нутгийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёсны талаар уншиж судалснаар энэ нь байж болшгүй шудрага бус, ёс зүйгүй, өөрсдийг нь сонгон ажилуулж байгаа иргэдийг дорд үзэж, үл томсорлосон явдал юм гэдгийг ойлгосон. Тэгвэл шинэ үеийн залуус бид энэ хүмүүст цаг тухайд нь шаардлага тавиад, тэднийг үүрэг хариуцлагаа ухамсарлахад нь нөлөөлөөд, хуулинд заасны дагуу асуудлаа шийдвэрлүүлээд байвал ийм байдал давтагдахгүй байх боломжтой. Энэ л миний болон залуус бидний нутгийн удирдлагын байгууллагын хөгжилд оруулах хамгийн том хэвч нэмэр гэж үзэж байна.

Хэдийгээр ээж минь анх надад Нутгийн удирдлага гэдэг юу болох талаар анхны мэдэгдэхүүн өгч байсан хүн боловч бодит амьдрал дээрээ энэ байгууллагын ажилд ер оролцдоггүй идэвхүй нэгэн болохыг нь ойлгосон. Учир нь би ээжээсээ “өөрийн амьдарч буй газрын нутгийн удирдлагын үйл ажиллагааг хэр мэддэг, тус байгууллагын удирдлагыг сонгох үед ээжийгээ оролцсон уу” гэж асуухад шууд “үгүй” гэж хариулсан. Би учрыг нь лавлахад “Манайд нутгийн удирдлага жинхэнэ утгаараа ажилладаггүй, би тэдэнтэй аль болох харьцахгүй байхыг хичээдэг” гэж хариуллаа. Тэгээд би ээжээсээ “Та тэгвэл энэ байдлыг өөрчилж сайжруулах ямар нэгэн оролдлого хийсэн үү.” гэж асуухад “Манайхан санал бодлоо илэрхийлж, шаардлага тавьсан хүнд дургүй, түүнийг хавьчин гадуурхдаг.

Би өрх толгойлосон эмэгтэй. Тиймээс би өөртөө төвөг удахгүйн тулд юу ч хийгээгүй” гэсэн хариулт сонслоо.

Ер нь манай оронд нутгийн удирдлагын байгууллага, нутгийн удирдах ёсыг хөгжүүлэх эрх зүйн орчин нэгэнт бүрдсэн, эрдэмтэн судлаачид маань тус байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, ач холбогдлыг нь тодорхойлсон олон баримт бичгүүдийг боловсруулан гаргасан, төр засаг болон төрийн бус байгууллагаас дэмжлэг авах бүрэн боломтой ардчилсан улс юм.

Тэгвэл юу болохгүй байна вэ. Нутгийн удирдлагын байгууллагад ажиллаж буй удирдах албан тушаалтан, гүйцэтгэх ажилтнууд, мөн тус байгууллагаар үйлчлүүлж байгаа хүмүүс бүгд Монгол улсын иргэн юм. Тэгэхээр Монгол улсын иргэн бид бүгдээрээ иргэний үүргээ ухамсарлан, нийгэмдээ хариуцлагатай байж чадвал бид энэ байгууллагыг ямар ч бэрхшээлгүйгээр чадавхжуулж чадна. Иймээс би шинэ үеийн залуусаа, иргэн таныг, нийт монгол улсын иргэдийгээ нийгэмдээ хариуцлагатай, идэвхтэй амьдарцгаая гэж уриалж байна.

Эцэст нь хэлэхэд Нутгийн удирдлагын байгууллагын чадавхийг дээшлүүлэхд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага бидний өмнө тулгараад байна. Учир нь миний, бидний төлөөлөл болон сонгогдсон хүмүүс сонгосон иргэдийнхээ эрх ашгийн төлөө ажиллаж чадахгүй бол илүү чадварлаг, үүргээ ойлгодог хүмүүсээр солих эрх надад, танд, миний гэр бүлд байна.

Г.БУЛГАНТАМИР, Б.СҮХБАЯР

Батлан хамгаалахын Их сургуулийн оюутан

“ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ”

Түлхүүр үг: Улсын салбарын шинэ удирдлага, Монгол улсын төсөв, вестминстер, төсвийн зарчим, төсвийн шинж, төсвийн үйл ажиллагаа, ил тод байдал, иргэдийн оролцоо, төсвийн үйл ажиллагаанд оролцоог хангах.

НЭГ. Оршил

Улсын хөгжлийн шалгуур үзүүлэлт нь төрийн бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх арга ажиллагаа байдаг. Монгол улсын төрийн бодлогын шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа олон арга ажиллагааны нэг нь төсвийн шинэчлэлийн тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл төсвийн шинэчлэлийг хийх нь төлөөллийн ардчиллаас шууд ардчилалын хэлбэрээр, ил тод байдал, иргэд, хэрэглэгчдийн оролцоонд тулгуурласан үр дүнтэй, хамгийн сайн төсвийн тогтолцоог бүрдүүлэх явдал.

2003 оноос Монгол улсад хэрэгжүүлж байгаа төсвийн шинэчлэл, түүний зүй тогтол эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж, судалгааны чиглэл болсоор байгаа өнөө үед Менежмент, Төрийн Захиргааны мэргэжлээр суралцаж буй оюутан бид “Төрийн захиргааны онол удирдлага, Төрийн санхүү удирдлага, Нутгийн удирдлага, ”зэрэг хичээлийг судалсан нь орон нутгийн төсвийн ил тод байдлыг судалж илтгэл бичих үндэслэл болсон. Яагаад гэвэл: Төсөв өөрөө “нийтийн шинж”-ийг агуулдаг. Нийтийн шинжийгоролцоогоор ил тод байлгах ёстой.

Зорилго: Монгол улсын төрийн бодлогын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй төсвийн шинэчлэлийн асуудлуудаас төсвийн ил тод байдал, оролцоог төсвийн байгууллагын жишээн дээр судалж, санал дүгнэлт гаргахад оршино.

Зорилт:

- Монгол улсын төсвийн шинэчлэлийн **зорилго, хүрээ, чиглэлийг** судлах

- Төсвийн ил тод байдал, оролцоог Төсвийн байгууллагын жишээн дээр судлах
- Санал, дүгнэлт гаргаж зөвлөмж боловсруулах

Судалгааны арга зүй:


- Баримт бичиг судлах арга
- Асуулгын арга
- Нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглалаа.

ХОЁР. Үндсэн хэсэг.

1. Монгол улсын төсвийн шинэчлэлийн зорилго, хүрээ, чиглэл


Монгол улсын төсвийн шинэчлэлийн зорилго, хүрээ, чиглэлийг ярихын тулд Монгол улсын төсвийн болон төсвийн удирдлагын тухай ойлголтыг авч үзье.

Төсөв нь нэгэн зэрэг улс төр, санхүү, эдийн засгийн ойлголт, ухагдахууныг агуулсан нарийн ойлголт юм. Монгол улсын төсөв гэдэг нь: Төсвийн тухай хууль /2011.12.23./-ийн 4.1.5-д зааснаар “Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр юм. Монгол улсын төсвийг чиг үүрэг, шинж болон олон талт талаас нь тодорхойлбол: /зураг 2.1/



Зураг 2.1. Монгол улсын төсвийг чиг үүрэг, шинж болон олон талт байдал

Төсвийн удирдлага гэдэг нь: Санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, мөнгөн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, мөнгөн хөрөнгийн үүрэг, амлалт авах, хариуцлага хүлээх, мөнгөн хөрөнгөөр үр дүнг бий болгох нэгдмэл иж бүрэн ажиллагааг хэлдэг. Төсвийн удирдлагын тухай ойлголтыг нэгтгэж зураг 2.2-т харуулав.



Зураг 2.2.Төсвийн удирдлага

Дээрх ойлголтоос үзэхэд төсөв, төсвийн удирдлагын тухай ойлголт нь дараах арга хэрэгсэл байдлаар хөгжиж байна.Үүнд:

- **Төлөвлөлтийн арга хэрэгсэл.** Төсвийн хүрээнд улсын салбар /төсөв/-ын байгууллагын стратеги чиглэл, зорилго тодорхойлогдож төсвийн жилд ямар хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжих, тэдгээр нь ямар уялдаа холбоотой байхыг тогтоож өгдөг.
- **Улс төрийн арга хэрэгсэл.** Улс төрийн бүлэглэл, намуудын сонирхол төсөвт тусгалаа олж, засгийн газрын үйл ажиллагаагаар дамжин хэрэгжиж сонгогчид, хэрэглэгчдэд нөлөөлөх боломжийг бүрдүүлдэг.
- **Нийгмийн арга хэрэгсэл.** Иргэд, хэрэглэгчид, хувийн хэвшилд төрөөс үзүүлэх дэмжлэг болон тэднээс улсад оруулах хувь нэмэр , нийгмийн эмзэг бүлэг, төрөөс анхаарал халамж шаардлагатай бүлэгт үзүүлэх дэмжлэгийг баталгаажуулдаг.
- **Эдийн засгийн арга хэрэгсэл.** Эдийн засгийн өсөлт болон иргэд хэрэглэгчдийн хөдөлмөрийн бүтээмж, орлогыг нэмэгдүүлдэг.

- **Хууль эрх зүйн арга хэрэгсэл.** Төсөвлөх арга, хугацааны үечлэл, төсвийн хязгаар, үйл явцаар дамжуулан төсвийн харилцаанд оролцогчдын бүрэн эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлж байдаг.

Иймд төсвийн удирдлагын зорилт нь:

- 1) Санхүүгийн нэгдсэн сахилга батыг хангах /зардлыг хянах/
- 2) Тэргүүлэх чиглэлд нөөцийг хуваарилах/стратегийн шинжтэй үйл ажиллагаанд хөрөнгө хуваарилах/
- 3) Үйл ажиллагааны удирдлагыг сайжруулах /Үр дүнг чухалчлах/

Төсвийн шинэчлэл: Дэлхийн улс оронд сүүлийн 100 гаруй жил үргэлжилж байгаа тасралтгүй шинжтэй үйл явц. Улсын салбарт гарч байгаа хурдацтай өөрчлөлтийн хүрээнд төсвийн шинэчлэл сүүлийн 30-аад жил эрчимтэй хийгдэж байна.

Төсвийн шинэчлэлийн тухай ойлголтыг зураг 2.3-аар үзүүлбэл:



Зураг 2.3.Төсвийн шинэчлэл

Төсвийн шинэчлэлийн зорилго: Төсвийг дунд хугацаагаар төсөвлөх, төсвийн зарцуулалтыг ил тод болгох, төсөв захирагчдын төсвийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын үр дүнд тулгуурласан хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх, төрийн санхүүгийн хяналтын үр дүнг , дээшлүүлэх, төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тод болгоход чиглэгдэнэ./Хамгийн сайн төсвийн тогтолцоог хөгжүүлэхэд/

Төсвийн шинэчлэлийн хамрах хүрээ /Юуг шинэчлэх ?/

- **Төсвийн үүрэг**

- Төсвийн хэм хэмжээ
- Төсөвлөх арга
- Төсвийн орчил /төсвийн үйл явц/
- Төсвийн хариуцлага
- Төсвийн ил тод байдал
- Оролцоо

Төсвийн удирдлагад гарч байгаа /парадигм/ буюу хандлагын өөрчлөлтүүд

- Гүйцэтгэлд суурилсан төлөвлөлт
- Төлөвлөлтийн арга ажиллагаа
- Макро эдийн засгийн бодлого
- Бизнесийн салбарын санхүүгийн салбарыг нэвтрүүлэх
- Засаглалыг бэхжүүлэх /Ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшдүүлэх, ёс зүйг баримтлах г.мэт/

Төсвийн удирдлагад гарч байгаа өөрчлөлтүүдээс үзэхэд төсвийн шинэчлэлийн гол асуудал нь ил тод байдал, иргэдийн оролцооны тухай асуудал болж байна.

Төсвийн ил тод байдал. Төсвийн нийтийн шинж болон төсвийн зарчим бөгөөд төсвийн үйл ажиллагаа, төсөвт тусгагдсан орлого, зарлага ямар ч нууцлалгүй, учир битүүлэг тодорхойлолтгүй байх асуудал юм. Судлаач Ф.Нитти төсвийн ил тод байдлыг шударга ёс гэж тэмдэглэсэн байдаг.

Оролцоо /Төсвийн үйл ажиллагаанд оролцоог хангах/. Ардчилсан засаглалын гол хэмжүүр бөгөөд дэлхий дахины засаглалын багц шалгуур үзүүлэлтэнд төсвийн үйл ажиллагаанд оролцогчдын санаа бодлыг сонсох, хариуцлага хүлээх нь оролцоог хангах явдал хэмээн тэмдэглэсэн байна. Мөн Шууд ардчилал, иргэдийн оролцоотой төсвийн менежмент үндэсний сургалт"-ын хаалтын ажиллагаан дээр Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн үгэндээ ... Иргэдийн оролцоо гэж чухам юуг хэлээд байгаа юм, цуглараад асуудлаа ярихыг хэлж байна... , ... иргэдийн оролцоо гэдэг бол явж явж санхүүгийн тухай, санхүүгийн эрхийн тухай, тэр эрхийг иргэд болон оролцогчдод шилжүүлэх тухай асуудал юм гэж онцлон тэмдэглэсэн. Монгол улсын төсвийн шинэчлэл нь эрх зүйн хувьд:

- **Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /3.2.3. Төсөв санхүүгийн салбарын аюулгүй байдал/**
- **Монгол улсын Төсвийн тухай хууль /2011.12.23. 63 дугаар зүйл /Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах/**
- **Шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /Засгийн газрын 2012.09.18. 37 дугаар тогтоол/**
- **Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт /Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогоол 3 дугаар зүйл Төсөв санхүүгийн ил тод байдал/**
- **Шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг /Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 176 дугаар зарлигын хавсралт/**

Тухайлбал, Монгол улсын төсөв санхүүгийн ил тод байдал:

1. Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлтэй уялдуулах.
2. ҮАБ болон Төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсаар, бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн байх.
3. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар мэдээллэх, иргэд, хэрэглэгч, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтанд хяналт тавих боломжийг хангах
4. Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээллэх.
5. Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт өөрчлөлт

оруулсан тохиолдолд цахим хуудас болон бусад хэлбэрээр мэдээллэх.

6. Зөвхөн хууль тогтоомжинд заасан төлбөр хураамжийг үйлчлүүлэгчээс авч түүний хэмжээний тухай цахим хуудас болон бусад хэлбэрээр мэдээллэх.
7. Үйлчилгээний хөлс болон төлбөр хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох /чирэгдэлгүй болгох/.
8. Төрийн өмчийн /төсвийн/хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа тус бүр нь ил тод байх.

Оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын стратеги:

1. Нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлыг иргэдийн оролцоотойгоор шийддэг болох.
2. Иргэдийн оролцоонд тулгуурласан үйл ажиллагааг төлөвшүүлэх болон авилга хүнд суртлаас ангид, үр ашигтай бүтээлч орчин бүрдүүлэх.
3. Иргэдийн оролцооны албан болон албан бус боловсролыг дэмжих /стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэглэгчийн хэрэгцээ нийгмийн шинэчлэлтийн шаардлагатай уялдуулах /
4. Иргэний оролцоог хөгжүүлэх/дан ганц шүүмжлэхээс илүүтэй бүтээлчээр оролцдог тогтолцоог бүрдүүлэх /
5. Нийгмийн удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг бүхэлд нь иргэдийн оролцоо, хяналтад оруулах / бүтэц, бүрэлдэхүүний нэгж хэсгүүдийн гүйцэтгэх үүрэг функцийг үр ашигтай тодорхой хувиарлалт бий болгох/
6. Төсөв санхүүгийн хэт төвлөрлийг сааруулах.
7. Иргэдийн оролцооны загварыг дэлгэрүүлэх.
8. Бодлогын салбаруудад иргэний оролцооны бүлэг буюу мэргэжлийн эвсэл холбоод, нийгэмд танигдсан өндөр мэдлэг боловсролтой эрдэмтэд, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн иргэний нийгмийн байгууллагын саналыг төрийн бодлогод тусгуулах гэх мэт.

ГУРАВ. Судалгааны хэсэг.

Монгол улсын төрийн бодлогын шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа төсвийн шинэчлэлийн гол элемент төсвийн ил тод байдал, оролцоог хангах тухай асуудал Баянзүрх дүүрэг дээр ямар түвшинд байгааг тодорхойлохыг илтгэлийн зорилт болгосон тул дараах судалгаа хийсэн.

Баянзүрх дүүрэг нь төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээ явуулсны төлөө төсвөөс санхүүжилт авч байгаа учир төсвийн байгууллага мөн. Иймд төсвийн хөрөнгөөр явуулж буй үйл ажиллагаа нь төсвийн шинэчлэл, шинэчлэлийн Засгийн газрын бодлого бусад баримт бичигт тусгагдсан санхүү, төсвийн ил тод байдал, оролцооны тухай асуудлыг хангах учиртай.

Баянзүрх дүүрэг дээр мэргэжлийн дадлагаа хийх явцдаа бид санхүү, төсвийн ил тод байдал, иргэдийн оролцооны талаар дараах мэдээллүүдийг иргэдэд нээлтэй байлган ажиллаж байна.





Судалгаа: Төсвийн ил тод байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд оролцоог хангах шаардлагатайг дараах судалгаагаар харуулахыг зорилоо. Судалгааг БЗД-ийн ЗДТГ-ын нийт 95 ажилтны 30% буюу 31 ажилтнаас асуухаргаар авсан /Хавсралт 1/

Асуулт 1: Та БЗД-ийн төсвийн зарцуулалтыг мэддэг үү гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 11% тийм, 89% Үгүй /зураг 3.1./



Зураг 3.1. БЗД-ийн төсвийн зарцуулалтыг мэддэг эсэх

Асуултанд хариулсан хувиас үзэхэд төсвийн ил тод байдал, оролцооны тухай асуудал хангалтгүй байгаа бөгөөд төсвийн хөрөнгийн үр өгөөжийг сайжруулахын тулд БЗД-ийн түвшинд төсвийн төлөвлөлтийн чадавхийг дээшлүүлж, тайлагналтын

оновчтой тогтолцоог чанд дагаж мөрдөх шаардлагатайг харуулж байна.

Асуулт 2:Та БЗД-ийнхээ төсвийн зарцуулалтыг үр дүнд чиглэгдсэн гэж үздэг үү?гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 8% тийм, 26% үгүй, 66% мэдэхгүй



Зураг 3.2. БЗД-ийн төсвийн зарцуулалт үр дүнд чиглэгддэг эсэх

Судалгаанаас дүгнэхэд төсвийн зардалд өртөг тооцох механизм байхгүй, төсвийн хөрөнгийг үйл ажиллагаа, үр дүнтэй холбож төсөвлөх зарчим жинхэнэ утгаараа хэрэгжихгүй, өөрөөр хэлбэл төсвийн үйл ажиллагаа хөгжилд буюу оролцоонд тулгуурлахгүй байна.

Асуулт 3:Та БЗД-ийнхээ санхүү, төсвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх шаардлагатай гэж үздэг үү гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 3% үгүй,97% тийм гэж хариулсан байна. /зураг 3.3/



Зураг 3.3. БЗД-ийн санхүү төсвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх шаардлагатай эсэх.

Судалгаанаас үзэхэд БЗД-ийн төсвийн зарцуулалтыг үр дүнд чиглүүлэхийн тулд үр дүнг үнэлэх үүрэг бүхий дотоод хяналтын тогтолцоог сайжруулж ажиллах шаардлагатай байна.

ДӨРӨВ. Дүгнэлт, санал

Төсвийн шинэчлэл үр дүнг чухалчилдаг тул төсвийн хөрөнгийн зарцуулалт бүрийн цаана үр дүн байх шаардлагатай. Төсвийн хөрөнгийн үр дүн үр өгөөж нь төсвийн байгууллагын ил тод байдал, оролцооны тухай асуудал юм. Төсвийн ил тод байдал, оролцооны тухай асуудал нь огт хэрэгжих боломжгүй зүйл биш. Өөрөөр хэлбэл хөрөнгө зарцуулах эрх бүхий менежер, мэргэжилтэний мэдлэг, чадвар, чадамж, сэтгэлгээнээс хамаарах асуудал.

Судалгаанаас үзэхэд БЗД-ийн санхүү төсвийн үйл ажиллагаанд төсвийн ил тод байдал, оролцооны тухай асуудлыг сайжруулах хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Иймд төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь төсвийн үр дүнд суурилсан үйл ажиллагаа явуулахын тулд төсвийн зарлагын уламжлалт аргаас татгалзаж, төсвийн орчны өөрчлөлтөнд зохицож уялдсан, төсвийн ил тод байдал, оролцоог боловсронгуй болгож ажиллах шаардлагатай байна.

Санал

1. Зардлыг шууд бууруулах бус нийтийн салбарын бүтээмжийг дээшлүүлэхийг зорих
2. Хөрөнгийн зардал гаргахдаа ажиллагсад болон хэрэглэгчдийн саналыг тусгадаг тогтолцоог бий болгох.
3. Байгууллагын төсвийн зарцуулалтыг мэдээллэх мэдээллийн системийг боловсронгуй болгох. / тогтмолжуулах/
4. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл хэрэгжилт, тайлагналтанд оролцооны чухлыг ажиллагсад болон хэрэглэгчдэд ойлгуулах.
5. БЗД-ийн бүтэц, үйл ажиллагааны онцлогт тохирсон өртөг тооцох аргачлалыг сайжруулж, түүний дагуу өртгийн болон үйл ажиллагааны мэдээллийн уялдааг хангахуйц төсөвлөлт, тайлагналтын системийг хөгжүүлэх
6. Санхүүгийн ажилтнуудын төсөв санхүүгийн хувьд хүлээх хариуцлагыг тодорхой болгох

Хавсралт 1.

Асуулгын хуудас

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Та дараах асуултанд хариулт өгч туслана уу?

Сонгосон асуултын өмнөх үсгийг дугуйлна уу?

• **Та БЗД-ийнхээ төсвийн зарцуулалтыг мэддэг үү?**

А.Тийм

Б.Үгүй

• **Та БЗД-ийнхээ төсвийн зарцуулалтыг үр дүнд чиглэгдсэн гэж үздэг үү?**

А.Тийм

Б.Үгүй

В.Мэдэхгүй

• **Та БЗД-ийнхээ санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх шаардлагатай гэж үздэг үү?**

А.Тийм

Б.Үгүй

Ашигласан материал

1. Шууд ардчилал-иргэдийн оролцоо. УБ., 2014
2. Монгол улсын төсвийн тухай хууль. УБ., 2011
3. Монгол улсын төсвийн тогтвортой байдлын тухай хууль. УБ., 2010
4. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам
/Сангийн сайдын тушаал/
5. Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын зарчим
6. Нийслэлийн Засаг даргын 2013 оны 11 сарын 06 өдрийн А/984 дүгээр захирамж
7. Сарангэрэл Д., Төрийн санхүү. УБ., 2012



Konrad
Adenauer
Stiftung

Гуравдугаар бүлэг



**“ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ
ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН
ТУХАЙ, ХУУЛИНД ОРУУЛАХ
ШИНЭЧЛЭЛ”-ийн тухай
МНУХ-оос боловсруулсан
ТӨСӨЛ**



**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ**

**Шинээр тод хар
Өөрчлөн найруулсан тод хар доогуур зурсан
Хасагдсан дээгүүр дарсан**

№	Одоо мөрдөгдөж байгаа НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл	Өөрчлөх санал
1	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зохицуулалт</p> <p>1.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.</p>	
2	<p>2 дугаар зүйл. Хууль тогтоомж</p> <p>2.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p>	
3	<p>3 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж</p> <p>3.1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.</p> <p>3.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан</p>	

<p>олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p> <p>3.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулна.</p> <p>3.4.Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.</p>	<p>3.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх <u>нийслэлийн хаяа, дагуул хот, аймаг дахь улсын зэрэглэлтэй болон орон нутгийн хот, сум, дүүрэг дэх тосгоны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулна.</u></p> <p>3.4.Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргаа, <u>иргэдийн шууд оролцооны</u> нэгж мөн.</p>
<p>4</p> <p>4 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах</p> <p>4.1.Аймаг, сум, дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан саналыг үндэслэн хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.</p>	<p>4.1.Аймаг, сум, дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан саналыг үндэслэн хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлийг үндэслэн харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ</p>
<p>4.2.Баг, хороо байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг энэ хуулийн 4.1-д заасан үндэслэлийг баримтлан тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.</p> <p>4.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг батлах, өөрчлөх асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.</p>	<p>4.2.Баг, хороо байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг энэ хуулийн 4.1-д заасан үндэслэлийг баримтлан тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.</p> <p>4.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг батлах, өөрчлөх асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.</p>

	<p>4.4.Хилийн цэсийн асуудлаар аймаг, нийслэл харилцан адилгүй саналтай байсан нь уг асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахад саад болохгүй.</p> <p>4.5.Ээлжит сонгуулийн жил шинээр баг, хороо, сум, дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгахыг хориглоно./Энэ хэсгийг 2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/</p>	
5	<p>5 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс</p> <p>5.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс нь түүнд хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлий, байгалийн нөөц баялаг, орон нутгийн өмч, бүх төрлийн өмчийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос бий болсон хуримтлал, албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.</p>	
6	<p>6 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв</p> <p>6.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг төсөвтэй байна.</p> <p>6.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.</p>	<p>6.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг төсөвтэй байна. Баг, хорооны удирдлагын үйл ажиллагааны зардлыг сум, дүүргийн төсөвт тусгайлан тусгаж, батална.</p>

7	<p>ХОЁРДУГААР БҮЛЭГ</p> <p>Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо</p> <p>7 дугаар зүйл. Удирдлагын тогтолцоо</p> <p>7.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна:</p> <p>7.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;</p> <p>7.1.2.баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал;</p> <p>7.1.3.энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан Хурлын хуралдааны чөлөө цагт тэдгээрийн Тэргүүлэгчид;</p> <p>7.1.4.аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга.</p>	
8	<p>8 дугаар зүйл. Удирдлагын үндсэн зарчим</p> <p>8.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална.</p> <p>8.2.Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн.</p>	<p>8.2.Нутгийн өөрөө удирдах ёс нь иргэд ШУУД, мөн чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн.</p>

<p>9</p>	<p>9 дүгээр зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага</p> <p>9.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь дараахь тогтолцоотой байна:</p> <p>9.1.1. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал; 9.1.2. сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал; 9.1.3. баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал.</p> <p>9.2. Энэ хуулийн 9.1.1-9.1.3-т заасан Хурлын хуралдааны чөлөө цагт бүрэн эрхийг нь тэдгээрийн Тэргүүлэгчид хэрэгжүүлнэ.</p> <p>9.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид “Хурал” гэх/-ын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд ээлжит бус сонгуулиар байгуулагдсан Хуралд энэ хугацаа хамаарахгүй.</p> <p>9.4. Аймаг, нийслэл, сумын Хурлын төлөөлөгч нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугч байна.</p> <p>9.5. Дүүргийн Хурлын төлөөлөгч нь тухайн дүүрэгт байнга оршин суугч, эсхүл уг дүүргийн нутаг дэвсгэр дэх байгууллага, аж ахуйн нэгжид ажил, хөдөлмөр эрхлэгч байна.</p> <p>9.6. /Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p> <p>9.7. /Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p> <p>9.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ын Хурлын төлөөлөгч нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид 3-аас доошгүй жил байнга амьдарч байгаа, оршин суугч байна.</p> <p>9.5. Дүүргийн Хурлын төлөөлөгч нь тухайн дүүрэгт байнга оршин суугч, эсхүл уг дүүргийн нутаг дэвсгэр дэх байгууллага, аж ахуйн нэгжид ажил, хөдөлмөр эрхлэгч байна.</p>
----------	---

<p>9.8. Хурлын төлөөлөгчдийн бүрэн Хурлын шинээр сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрснөөр дуусгавар болно.</p>	<p>9.8.Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн хугацаа шинээр сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрх <u>Хурлын тогтоол гаргаж</u>, хүлээн зөвшөөрснөөр <u>эхэлнэ</u>. <u>дуусгавар болно</u>.</p> <p>9.9.Хурлын Төлөөлөгчөөр нөхөн сонгогдсон иргэний асуудлыг сонгуулийн хорооны саналыг үндэслэн тухайн хурал 15 хоногийн дотор хэлэлцэж баталгаажуулна.</p> <p>9.10.Хурлын төлөөлөгч нь <u>үйл ажиллагаандаа баримтлах</u> Ёс зүйн дүрэмтэй байна. Ёс зүйн дүрмийг Хурлын хуралдаанаараа батална.</p>
<p>10</p> <p>10 дугаар зүйл.Хурлын төлөөлөгчдийн тоо</p> <p>10.1.Нийслэлийн Хурлын төлөөлөгчдийн тоо нь 45 байна.</p> <p>10.2.Аймгийн Хурлын төлөөлөгчдийн тоо N-ийг хүн амын нягтрал байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дараах томъёогоор тодорхойлогдох n гэсэн тоонд үндэслэн $n < 17$ бол $N = 17$, $n > 41$ бол $N = 41$, бусад тохиолдолд $N = n$ гэж тогтооно:</p> $n = a + b \left(\frac{a+b+c}{2} \right) + d$ <p>Үүнд:</p> <p>a нь аймгийн төвийн сумын багийн тоо; b нь аймгийн төвийн сумаас бусад сумын тоо; c нь a+b сондгой бол 1, тэгш бол 0-тэй тэнцүү;</p>	<p>10.2 Аймгийн Хурлын төлөөлөгчдийн тоо N-ийг хүн амын нягтрал байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дараах томъёогоор тодорхойлогдох n гэсэн тоонд үндэслэн $n < 17$ бол $N = 17$, $n > 41$ бол $N = 41$, бусад тохиолдолд $N = n$ гэж тогтооно.</p>

<p>d нь $a + b \left(\frac{a+b+c}{2} \right)$ сондгой бол 0, тэгш бол 1-тэй тэнцүү.</p> <p>10.3.Сумын Хурлын төлөөлөгчдийн тоог хүн амын нягтрал байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дараах байдлаар тогтооно:</p> <p>10.3.1. сумын хүн амын тоо нь 2000 хүртэл бол 15;</p> <p>10.3.2. сумын хүн амын тоо нь 2000-5000 хүртэл бол 21;</p> <p>10.3.3. сумын хүн амын тоо нь 5000-9000 хүртэл бол 27;</p> <p>10.3.4. сумын хүн амын тоо нь 9000 ба түүнээс дээш бол 31.</p> <p>10.4. Дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоог хүн амын нягтрал байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дараах байдлаар тогтооно:</p> <p>10.4.1. дүүргийн хүн амын тоо нь 20000 хүртэл бол 17;</p> <p>10.4.2. дүүргийн хүн амын тоо нь 20000-80000 хүртэл бол 25;</p> <p>10.4.3. дүүргийн хүн амын тоо нь 80000-180000 хүртэл бол 35;</p> <p>10.4.4. дүүргийн хүн амын тоо нь 180000 ба түүнээс дээш бол 41."Энэ зүйлийг 2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p>	<p>10.2.1. хүн ам 50000 хүртэл бол 21</p> <p>10.2.2. хүн ам 50000-100000 хүртэл бол 31</p> <p>10.2.3. хүн ам 100000-аас дээш бол 35 байна.</p> <p>10.3. сумын Хурлын төлөөлөгчдийн тоо хүн амын нягтрал байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дараах байдлаар тогтооно:—</p> <p>10.3.1. хүн ам 3000 хүртэл бол 21;</p> <p>10.3.2. хүн ам 3000-9000 хүртэл бол 25;</p> <p>10.3.4 хүн ам 9000-дээш бол 31 байна.</p>
--	--

<p>11</p>	<p>11 дүгээр зүйл. Хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах</p> <p>11.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн дүнгээр байгуулагдсан Хурлын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.</p> <p>11.2.Сонгуулийн дүнгээр тухайн Хуралд хамгийн олон суудал авсан нам, эвсэл Хурлын даргад эхэлж нэр дэвшүүлэх эрхтэй.</p> <p>11.2. Хурлын даргад дээд боловсролтой, ял шийтгэлгүй, нэр хүндтэй, улсад 5-аас доошгүй жил ажилласан хүний нэрийг дэвшүүлнэ.</p> <p>11.4.Хурлын даргад нэг хүний нэр дэвшсэн бол илээр, хоёр ба түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн ын буюу 50-иас дээш хувийн санал авсан төлөөлөгчийг Хурлын даргаар сонгогдсонд тооцно.</p>	<p>11 дүгээр зүйл. Хурлын даргыг сонгох</p> <p>11.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Хурлын анхдугаар хуралдаанаар Хурлын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.</p> <p>11.2.Сонгуулийн дүнгээр тухайн Хуралд хамгийн олон суудал авсан нам, эвсэл Хурлын даргад эхэлж нэр дэвшүүлэх эрхтэй.</p> <p>11.3.Тухайн Хурлын төлөөлөгчид Хурлын даргад өөрийн болон бусад төлөөлөгчийн нэрийг дэвшүүлж болно.</p> <p>11.4.Хурлын даргад нэг хүний нэр дэвшсэн бол илээр, хоёр ба түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан төлөөлөгчийг Хурлын даргаар сонгогдсонд тооцно.</p> <p>11.5.Энэ хуулийн 11.4-т заасан нэр дэвшигчдийн аль нь ч олонхийн санал аваагүй бол санал тэнцсэн буюу хамгийн олон санал авсан хоёр төлөөлөгчийг хоёр дахь санал хураалтад оруулах бөгөөд тэдгээрийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол энэ зүйлд заасан журмаар Хурлын даргад дахин нэр дэвшүүлнэ.</p> <p>11.6.Хурлын төлөөлөгчид санал хураалтад оролцохдоо зөвхөн нэг хүний төлөө санал өгөх бөгөөд нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхтэй.</p>
-----------	--	--

<p>11.7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Хурлын даргыг дараах тохиолдолд чөлөөлж, огцруулж болно:</p> <p>11.7.1.Төрийн жинхэнэ сэхиргөөнт бөмөн төрийн тусгай албан тушаалд томилогдсон;</p> <p>11.7.2.нэг жилээс дээш хугацаагаар сургуульд суралцах болсон;</p> <p>11.7.3.хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;</p> <p>11.7.4.хүндээр өвчилсний улмаас эмнэлгийн дүгнэлт гарсан;</p> <p>11.7.5.тухайн орон нутгаас шилжсэн эсхүл хаягийн бүртгэлээ өөрчлөөгүй боловч байнга оршин суухгүй байгаа;</p> <p>44.7.6.Хурлын үйл-ажиллагааны тайланг хэлэлцээд хангалтгүй гэсэн үнэлгээ авсан;</p> <p>11.7.6.нас барсан;</p> <p>11.7.7.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан.</p>	
---	--

	<p>11.8.Хурлын даргыг энэ хуулийн 11.7.1-11.7.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 11.7.6, 11.7.8-д заасан тохиолдолд огцорсонд тооцож, тогтоол гаргах бөгөөд 11.7.7-д заасан тохиолдолд шууд орон гарсан гэж үзэж шийдвэрийг батлагаажуулна.</p>
<p>12</p> <p>12 дугаар зүйл. Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх</p> <p>12.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын төлөөлөгч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.1.асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;</p> <p>12.1.2.хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал дүгнэлт гаргах, санал хураалгах;</p> <p>12.1.3.Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;</p> <p>12.1.4.Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Тэргүүлэгчдийг сонгох, хороо байгуулах, тэдгээрт сонгогдох, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргах;</p> <p>12.1.5.Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонстол хэлэлцүүлэх санал гаргах;</p>	<p>12 дугаар зүйл. Хурлын төлөөлөгчийн эрх, үүрэг.</p> <p>12.1.4.Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга; Тэргүүлэгчдийг сонгох, хороо байгуулах, тэдгээрт сонгогдох, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргах;</p> <p>12.1.5.Хууль, тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага болон Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонстолыг хэлэлцүүлэх санал гаргах;</p>

<p>12.1.6.хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах;</p> <p>12.1.7.хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авч Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх;</p> <p>12.1.8.хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах, шаардлага тавьж биелэлтийг хангуулах;</p> <p>12.1.9.сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах.</p>	<p>12.1.10.Төлөөлөгч нь хуралдаандаа сайн бэлтгэлтэй, бүрэн оролцож, энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1-2 дахь заалтыг хэрэгжүүлж, тухайн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалын үр дүнг сайтар тооцож ажиллах.</p> <p>12.1.11.Төлөөлөгч нь хуралдааны чөлөөт цагт Хурлын хорооны үйл ажиллагаанд оролцож, төлөөлөгчийн хувьд хийсэн ажлын талаарх мэдээллийг Хурлын цахим хуудас болон бусад хэлбэрээр мэдээлнэ.</p>
--	--

<p>13</p>	<p>13 дугаар зүйл. Хурлын төлөөлөгчийг чөлөөлөх, огцруулах</p> <p>13.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дараахь тохиолдолд хугацаанаас өмнө дуусгавар болно:</p> <p>13.1.1. нас барсан;</p> <p>13.1.2. хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;</p> <p>13.1.3. хүндээр өвчилсний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;</p> <p>13.1.4. гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан;</p> <p>13.1.5. тухайн орон нутгаас шилжсэн.</p>	<p>13 дугаар зүйл. Хурлын төлөөлөгчийг чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах</p> <p>13.1.3. хүндээр өвчилсний улмаас эмнэлгийн дүгнэлт гарсан:</p> <p>13.1.5. тухайн орон нутгаас шилжсэн эсхүл хаягийн бүртгэлээ өөрчлөөгүй боловч байнга оршин суухгүй байгаа;</p> <p>13.1.6. Төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалд томилогдсон;</p> <p>13.1.7. нэг жилээс дээш хугацаагаар сургуульд суралцах болсон;</p> <p>13.1.8. ёс зүйн дүрмээ удаа дараа зөрчсөн.</p> <p>13.2. Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 13.1.2, 13.1.3, 13.1.5 - 13.1.7-д заасан тохиолдолд чөлөөлөх. 13.1.4, 13.1.8-т заасан тохиолдолд өгцрүүлэх тухай огцорсонд тооцож, тогтоол гаргах бөгөөд 13.1.1-д заасан тохиолдолд шууд орон гарсан гэж үзэж шийдвэр гаргахгүй.</p>
-----------	---	--

<p>13.3.Нөхөн сонгогдсон Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан төлөөлөгчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.</p>	<p>13.4.Тухайн тойргийн сонгогчдын олонх нь Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал гаргасан тохиолдолд хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>
<p>14</p>	<p>14 дүгээр зүйл. Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа</p> <p>14.1.Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална.</p> <p>14.2.Төлөөлөгчдийн Хурлын ажилд оролцсон байдлыг харгалзан тэдгээрт Тэргүүлэгчид урамшуулал олгож болох бөгөөд хэмжээ, олгох журмыг нь аймаг, нийслэлийн Хурал баталж шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгана.</p> <p>14.3.Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтан бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй.</p> <p>14.4.Засаг дарга, эрх бүхий бусад албан тушаалтан Хурлын төлөөлөгчийг ажлаас халах, чөлөөлөх, шилжүүлэх, өөрчлөх тохиолдолд саналаа тухайн шатны Хурлын Тэргүүлэгчдэд урьдчилан танилцуулж зөвшилцсөн байна.</p> <p>14.2.Төлөөлөгч үйл ажиллагааны зардалтай, Тэргүүлэгчид урамшуулалтай байна. Төлөөлөгчдийн Хурлын ажилд оролцсон байдлыг цагаар тооцож хэргэжсэн өддөөрт—Тэргүүлэгчид урамшуулал олгож болох бөгөөд хэмжээ, олгох журмыг нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал баталж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгана.</p> <p>14.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд улс төрийн нам бусад байгууллагаас оролцох, нөлөөлөхийг хориглоно.</p>

<p>15</p>	<p>15 дугаар зүйл. Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох</p> <p>15.1.Дор дурдсан тохиолдолд аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын бүрэн эрх энэ хуулийн 9.3-т заасан хугацаанаас өмнө дуусгавар болно:</p> <p>15.1.1.Хурлын нийт төлөөлөгчийн гуравны хоёроос доошгүй нь тухайн Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж хугацаанаас нь өмнө тараах тухай санал гаргасан;</p> <p>15.1.2.тухайн нутаг дэвсгэрийн нийт сонгогчийн дийлэнх олонхи нь Хурлын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нь зүйтэй гэж санал гаргасан;</p> <p>15.1.3.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх, татан буулгах тухай Улсын Их Хурлын шийдвэр гарсан.</p> <p>15.2.Энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан тохиолдолд Хурал өөрөө тарах тухай тогтоол гаргаснаар тухайн Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.</p> <p>15.3.Хурал өөрөө тарах тухай тогтоолын төслийг илээр санал хурааж шийдвэрлэнэ.</p> <p>15.4.Багийн Хурлаар энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан асуудлыг хэлэлцэхээр бол тухайн багийн нийт өрхийн гуравны хоёроос доошгүйн төлөөлөл оролцсон тохиолдолд Хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.</p>	<p>15.1.2.тухайн нутаг дэвсгэрийн нийт сонгогчийн дийлэнх олонх нь Хурлын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нь зүйтэй гэж санал гаргасан;</p> <p>15.1.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жилд гурваас доошгүй удаа хуралдаанаа хийгээгүй тохиолдолд;</p> <p>15.4.Баг. хорооны Хурлаар энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан асуудлыг хэлэлцэхээр бол тухайн хуралдаанд оролцсон иргэдийн нийт өрхийн гуравны хоёроос доошгүйн саналаар төлөөлөл өрөлцөөн төхмөлдөлд Хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.</p>
-----------	--	---

	<p>15.5.Энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т зааснаар Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан бол 30 хоногийн дотор сонгууль зарлана. <u>45-6./Энэ хэсгийг 2009 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u></p>	
16	<p>16 дугаар зүйл. Хурлын төсөв, тамга, тэмдэг</p> <p>16.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал төсөвтэй байх бөгөөд түүнийг Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна.</p> <p><u>/Энэ хэсэгт 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p>	<p>16.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал төсөвтэй байна. Хурлын төсөв нь Төлөөлөгч, Тэргүүлэгчид, хороод, ажлын албаны үйл ажиллагааны зардлаас бүрднэ. Тухайн хурлын төсвийн шүүд захирагч нь Хурлын нарийн бичгийн дарга байна. Ажлын албаны төсвийг Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн нарийн бичгийн дарга захиран зарцуулна. Сум, дүүргийн Хурлын төсөвт баг, хорооны ИНХ-ын үйл ажиллагааны зардлыг төлөвлөж хэрэгжүүлнэ.</p>
	<p>16.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал нь эрх бүхий байгууллагаас тогтоосон журамд нийцсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p>	

17

ГУРАВДАГУУР БҮЛЭГ

Нутгий удирдлагын шат шатны байгууллагуудын нийтлэг бүрэн эрх

17.1 Баг, хороо нь Монгол улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арванхоёрдугаар зүйлд заасан иргэний Үндсэн ба журамт үүргийг байнга таниулж биелэлтэнд нь иргэдийн өмнөөс хяналт тавих.

17.1.1 Иргэдтэйгээ ажиллах, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй хүрэх асуудлаар хурлаар хэлэлцүүлэх, сум, дүүрэгт уламжилж шийдвэрлүүлэх.

17.1.2 иргэд, айл өрхөөр дагаж мөрдөх журам, тогтоолыг хэлэлцүүлж батлах.

17.1.3 дэвшүүлсэн зорилт, гаргасан шийдвэр, Засаг даргын хөтөлбөрийн биелэлтийг иргэдийн хяналтын оролцоотойгоор хянан шалгах.

17.1.4 Иргэдээс гаргасан санал хүсэлт шүүмжлэлийн мөрөөр зохиосон ажлын Үр дүнг тухай бүр нь иргэдэд мэдээлж байх. Сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сан, амжиргаа дээшлүүлэх сангийн хөрөнгөөр иргэн, өрх айлын саналыг тусгаж шийдвэрлүүлэх.

<p>17.2 Сум дүүргийн удирдлагын нийтлэг бүрэн эрх</p> <p>17.2.1 Тухайн нутаг дэвсгэртээ байгаа боловсрол, эрүүл мэнд, соёл, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, халамж, зам, талбай, тохижилт, цэцэрлэгжүүлэлт, гэрэлтүүлэг хог хаягдал, ахуйн ба нийтийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өргөтгөх, хүртээмжтэй болгох жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг хариуцан зохион байгуулна. Хүн амын хэрэглээг жигд хангах эдэлбэр газрын ашиглалт хамгаалалт малчдын өвөлжөө хаваржааг тодорхой болгож зохион байгуулах.</p> <p>17.2.2 Мал аж ахуйн үйлдэрлэл, газар тариалан эрхлэлтийг боловсронгуй болгох тэнцвэртэй хөгжүүлэх байгаль эзлтэй шинэ технологи нэвтрүүлэх, бэлчээрийн зөв менежмент хийх</p> <p>17.2.3 Гэмт хэрэг зөрчлөөл урьчдан сэргийлэх ажил, хүний эрхийг хамгаалах</p> <p>17.2.4 Сум дундын аж ахуйн нэгдсэн үйлчилгээ байгуулах хамтын чармайлтыг нэгтгэх, малчин иргэдийг малжуулах, үүлдэр угсааг нь сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх</p>	
--	--

<p>17.2.5 Орон сууц барих, цэвэр бохир усны хангамж үйлчилгээ</p> <p>17.3 Аймаг, нийслэл, орон нутгийн хотын удирдлагын бүрэн эрх</p> <p>17.3.1 Төлөвлөлт, санхүү ерөнхий боловсрол коллеж, нэгдсэн эмнэлэг, биеийн тамир спортын арга хэмжээ, соёл зэрэг нийгэм соёлын үйлчилгээ, газар зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, өмчийн харилцаа, онцгой байдал цагдаа, хөдөлмөр эрхлэлт халамж, нийгэм хамгаалалын хөгжлийн асуудлаар бодлого журам гаргаж зохион байгуулах.</p> <p>17.3.2 Шинжлэх ухаан, технологи иновацийн ололтыг нэвтрүүлэх, шинэ бүтээл гаргах.</p> <p>17.3.3 Сум, дүүргийн ажлыг зохицуулж зохион байгуулах, чиглүүлэх</p> <p>17.3.4 Бус нутгийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг ИТХ-д танилцуулах</p> <p>17.3.5 Малчин иргэдийг малжуулах</p> <p>17.3.6 Нутаг дэвсгэртээ байгаа өндөр хүчдлийн цахилгааны шугам сүлжээний засвар арчилгааг хийж хэвийн ажиллагааг хангах.</p>	
--	--

<p>17.3.7 Нийтийн тээврийн үйлчилгээ</p> <p>17.3.8 Орон сууц, нийгэм соёл үйлчилгээний барилга байгууламжийн бүтээн байгуулалт</p> <p>17.3.9 Нэгдсэн ариутгал, хоргүйжилт хортон шавьжийн устгалт, гамшгийн хор хөнөөлийг арилгах ажлыг зохион байгуулах.</p>	<p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ</p> <p>Хурал, Тэргүүлэгчид, Хурлын дарга, тэдгээрийн бүрэн эрх</p> <p>18 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх</p> <p>18.1.Баг, хорооны Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>18.1.1.Хурлын хуралдааны дарга, Хурлын Тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх;</p> <p>18.1.2.баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах санал болон Засаг даргын огцрох тухай хүсэлтийг хүлээж авах эсэхтэй холбогдсон саналыг хэлэлцэн сум, дүүргийн Засаг даргад уламжлах;</p> <p>18.1.3.Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;</p>
<p>17.3.7 Нийтийн тээврийн үйлчилгээ</p> <p>17.3.8 Орон сууц, нийгэм соёл үйлчилгээний барилга байгууламжийн бүтээн байгуулалт</p> <p>17.3.9 Нэгдсэн ариутгал, хоргүйжилт хортон шавьжийн устгалт, гамшгийн хор хөнөөлийг арилгах ажлыг зохион байгуулах.</p>	<p>18.1.2.баг, хорооны Засаг даргыг томилуулах, чөлөөлөх, огцруулах санал болон Засаг даргын огцрох тухай хүсэлтийг хүлээж авах эсэхтэй холбогдсон саналыг хэлэлцэн шийдвэрлэж сум, дүүргийн Засаг даргад уламжлах;</p> <p>18.1.4.баг, хорооны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэж батлах, хууль, тогтоомж, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн</p>

<p>18.1.6.баг, хорооны иргэдийг шагнаж урамшуулах, дэмжлэг, тусламж үзүүлэх саналыг сум, дүүргийн Хурал, Засаг даргад уламжлах;</p> <p>18.1.7. өрхийг албан татвар, бусад ногдол үүргээс түр чөлөөлөх буюу хөнгөлөлт үзүүлэх тухай саналыг сум, дүүргийн Хурал, Засаг даргад оруулах;</p> <p>18.1.7.8.харьяалах баг, хорооны иргэний үндсэн ба журамт үүргийн биелэлтийг хангуулах;</p> <p>18.1.8.9.иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах;</p> <p>18.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>	<p>биелэлтийг хангах ажлыг зохион байгуулсан үр дүн, тайланг хэлэлцэж ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх, баг, хорооны төсвийн гүйцэтгэлийн тайлан үр дүн хэлэлцэх;</p> <p>18.1.9.сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлэх санал гаргах;</p> <p>18.1.10.баг, хорооны удирдлагын үйл ажиллагааны зардал, түүний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах;</p> <p>18.1.11.баг, хорооны иргэдийн эрх ашгийг хөндсөн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг авах, ач холбогдлоор нь эрэмблэх, холбогдох байгууллагад уламжлах;</p>
---	--

	<p>18.1.12.Баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэр хууль, тогтоомжид нийцээгүй бол хүчингүй болгох;</p> <p>18.1.13.Баг, хорооны хөгжлийн ойрын болон дунд хугацааны хөтөлбөр зорилтыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, гарсан шийдвэрийг хангуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>18.1.14.Баг, хорооны иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах асуудлаар холбогдох байгууллагад уламжлах, нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан байгууллагын удирдлагын сонголт, мэдээллийг хэлэлцүүлэх;</p> <p>18.1.15.газар, бэлчээрийг зүй зохистой ашиглах, эзэмших, үржил шимийг нэмэгдүүлэх тухай асуудлыг хэлэлцэж саналаа сүм, дүүргийн Хуралд уламжлах.</p> <p>18.1.16.</p> <p>18.2.Баг, хорооны Хурлын энэ хуулийн 18.1.1-18.1.1.4, 18.1.6,—18.1.10, 18.1.11, 18.1.15, -д зааснаас бусад бүрэн эрхийг уг Хурлын хуралдааны чөлөө цаг тухайн Хурлын Тэргүүлэгчид хэрэгжүүлнэ.</p>
<p>18.2.Баг, хорооны Хурлын энэ хуулийн 18.1.1-17.1.1.3, 18.1.8 -д зааснаас бусад бүрэн эрхийг уг Хурлын хуралдааны чөлөө цаг тухайн Хурлын Тэргүүлэгчид хэрэгжүүлнэ.</p>	

	<p>18.3.Баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын тэргүүлэгчдийн даргыг Хурлын тэргүүлэгчдээс сонгож, чөлөөлнө. Үйлчилгээний чанарыг сайжруулах, өргөтгөх, хүртээмжтэй болгох жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг хариуцан зохион байгуулна. Хүн амын хэрэглээг жигд хангах эдэлбэр газрын ашиглалт хамгаалалт малчдын өвөлжөө хаваржааг тодорхой болгож зохион байгуулах.</p>
<p>18</p> <p>19 дугаар зүйл. Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх</p> <p>19.1.Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ:</p> <p>19.1.1.Хурлын зохион байгуулалт, хяналт шалгалтын талаар: а/Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай асуудал; б/Хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгох, өөрчлөх; в/тухайн Хурлын хороо, түр хороо байгуулах, түр хороог татан буулгах, хорооны дарга, бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөх, ажлынх нь тайланг хэлэлцэх;</p> <p>г/Засаг даргыг томилуулах, чөлөөлөх болон огцруулах санал гаргаж аймаг нийслэлийн Засаг даргад уламжлах;</p>	<p>19.1.1.б/ Хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгох, еэпгэх, чөлөөлөх огцруулах;</p>

<p>д/сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>е /тухайн Хурлын төлөөлөгчөөс Засаг даргад тавьсан асуулгын хариуг хэлэлцэж, шаардлагатай бол зохих шийдвэр гаргах;</p> <p>ж/тухайн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй бол хүчингүй болгох;</p> <p>з/хууль тогтоомж, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг Засаг дарга хэрхэн зохион байгуулж байгааг шалгах, үнэлгээ өгөх;</p> <p>к/хууль тогтоомжийн хүрээнд Хурлын төсвийг батлах.</p>	<p>19.1.2. нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар:</p> <p>а/ нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;</p> <p>б/ Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах;</p> <p>в/ орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн сан байгуулах, уг сангийн эх үүсвэр, зориулалтыг тогтоох, сангийн хөрөнгийн зарцуулалтын журам, тайланг батлах;</p> <p>г/ тухайн орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээний үнэ тариф үндэслэлтэй эсэхийг хянах, журам тогтоох;</p>
<p>19.1.1.к/ Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог тогтоох;</p>	<p>к-и</p> <p>б/ Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн төсвийн боловсруулалт талаар санал дүгнэлт өгөх төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг хянаж батлах;</p>

<p>д/ хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох; е/ бүсчилсэн хөгжлийн стратегитэй нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжил, хэтийн төлөвийг уялдуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх; ж/бүс нутгийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй хамтран ажиллах тухай гэрээ, хөтөлбөр, бусад баримт бичгийг батлах;</p>	<p>з/нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг батлах; к/нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай Засаг даргын саналыг хэлэлцэн шийдвэрлэх; л/тухайн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээ нь хүн ам, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээр бол энэ тухай Засаг даргын мэдээллийг хэлэлцэж шийдвэр гаргах, шаардлагатай бол хууль тогтоомжид нийцүүлэн журам тогтоож мөрдүүлэх;</p>	<p>м/Тухайн нутгийн дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар санал гаргах; н/орон нутгийн давсан орлогыг хуваарилах асуудлыг хэлэлцэж, зарцуулах шийдвэр гаргах; о/нутаг дэвсгэртээ бичил уурхай ажиллуулах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих.</p>
--	--	---

19	<p>19.1.3.орон нутгийн өмчийн талаар:</p> <p>а/орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;</p> <p>б/орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалтыг батлах, хууль тогтоомжид заасан журмын дагуу түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;</p> <p>в/орон нутгийн нийтийн зориулалттай өмчлөлийн хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/, орон нутгийн бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах;</p> <p>г/орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг Иргэний хуульд нийцүүлэн тогтоох;</p> <p>д/орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид, эсхүл өөр өмчид шилжүүлэх журмыг-тогтоох;</p> <p>е/орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн эд хөрөнгө, хувьцааны өөрт ногдох хувийг тодорхойлох, түүнчлэн тухайн орон нутгийн төсвийн хөрөнгө, бэлтгэл нөөц, бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох;</p>	<p>а/орон нутгийн өмчийн зүйлсийг <u>актлах, худалдах, захиран зарцуулах</u> өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;</p> <p>б/орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийг <u>бүртгэх, тоолох</u>, жагсаалтыг батлах, хууль тогтоомжид заасан журмын дагуу түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;</p> <p>в/орон нутгийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/, орон нутгийн бусад өмчийн хуулийн этгээдэд <u>гэрээгээр</u> эзэмшүүлэх, ашиглуулах, <u>түрээслэх</u>;</p> <p>г/орон нутгийн өмчийн эд хөрөнгийг <u>түрээслүүлэх</u> журмыг <u>Иргэний хуульд</u> нийцүүлэн тогтоох;</p> <p>д/орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид, эсхүл өөр өмчид <u>шилжүүлэх</u> журмыг <u>тогтоох</u>;</p>
----	---	---

<p>ж/орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах;</p> <p>з/орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;</p> <p>к/орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх журам, төлөвлөлт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох;</p> <p>л/орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;</p> <p>м/орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бий болгох талаар тухайн Хурлаас Засаг даргад олгох эрх хэмжээг тогтоох, хяналт тавих;</p> <p>н/орон нутгийн өмчийн төлөөлөгчийн эрх хэмжээ, ажиллах журмыг тогтоох.</p>	<p>е/орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн эд хөрөнгө, хувьцааны өөрт ногдох хувийг тодорхойлох, түүнчлэн тухайн орон нутгийн төсвийн хөрөнгө, бэлтгэл нөөц, бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох;</p> <p>ж/орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах;</p> <p>з/орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;</p> <p>к/орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх журам, төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох;</p> <p>Г л/орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;</p> <p>Д.м/орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бий болгох талаар тухайн Хурлаас Засаг даргад олгох эрх хэмжээг тогтоох, хяналт тавих;</p> <p>н/орон нутгийн өмчийн төлөөлөгчийн эрх хэмжээ, ажиллах журмыг тогтоох.</p>
---	--

<p>19.2.Сум, дүүргийн Хурал нь хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>20 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх</p> <p>20.1.Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>20.1.1. үнэт цаас гаргах тухай аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцэж шийдвэрлэх;</p> <p>20.1.2.орон нутгийн буюу тухайн аймаг, нийслэлийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх талаар Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцэж шийдвэрлэх;</p> <p>20.1.3.орон нутгийн өмчийг хувьчлах бодлого, чиглэл, хувьчилж үл болох орон нутгийн өмчийн жагсаалтыг Засаг даргын өргөн мэдүүлснээр хэлэлцэж батлах, түүнд өөрчлөлт оруулах;</p> <p>20.1.4-хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>	<p><u>20.1.Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.2-г зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</u></p> <p><u>20.1.4.орон нутгийн өмчийн зүйлсийг актлах, худалдах, захиран зарцуулах өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;</u></p> <p><u>20.1.5.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг Иргэний хуульд нийцүүлэн тогтоох;</u></p> <p><u>20.1.6.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид, эсхүл өөр өмчид шилжүүлэх журмыг тогтоох.</u></p>

<p><u>20.1.7.орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн эд хөрөнгө, хувьцааны өөрт ногдох хувийг тодорхойлох, түүнчлэн тухайн орон нутгийн төсвийн хөрөнгө, бэлтгэл нөөц, бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох.</u></p> <p><u>20.1.8.орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, үл хөдлөх болон эргэлтийн хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гаргах, дүрмийг батлах.</u></p> <p><u>20.1.9.орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.</u></p> <p><u>20.1.10.орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх журам, төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох.</u></p> <p><u>20.1.11.орон нутгийн өмчийн төлөөлөгчийн эрх хэмжээ, ажиллах журмыг тогтоох.</u></p>	
---	--

<p><u>20.1.12.Засаг даргын өргөн мэдүүлсэн орон нутгийн буюу тухайн аймаг, нийслэлийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хувындлаас гадуур худалдах, шилжүүлэхдээ сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авсан байх.</u></p> <p>20.1.4-13.</p> <p>20-2.Хууль тогтоомжид зөвхөн сум, дүүргийн Хуралд өлгөсөн бүрэн эрхийг аймаг, нийслэлийн Хурал тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хориглоно.</p>	<p>20.2.Хууль тогтоомжид зөвхөн сум, дүүргийн Хуралд өлгөсөн бүрэн эрхийг аймаг, нийслэлийн Хурал тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хориглоно.</p> <p>21 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх</p> <p>21.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хуралд энэ хуулийн 19.1.1."е", 19.1.1."ж", 19.1.2."г", 19.1.2."ж", 19.1.2."з", 19.1.3."в", 19.1.3."г", 19.1.3."ж", 19.1.3."з", 19.1.3."к", 19.1.3."л", 19.1.3."н"-д заасан Хурлын бүрэн эрхийг Хуралд дараа тайлагнахаар Хурлын чөлөө цаг хэрэгжүүлж болохоос гадна дараах асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ:</p> <p>21.1.1.Хурлын хуралдааныг товлон зарлах, түүний бэлтгэлийг хангах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон санал, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх;</p>	<p>21</p>
<p><u>20.1.12.Засаг даргын өргөн мэдүүлсэн орон нутгийн буюу тухайн аймаг, нийслэлийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хувындлаас гадуур худалдах, шилжүүлэхдээ сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авсан байх.</u></p> <p>20.1.4-13.</p> <p>20-2.Хууль тогтоомжид зөвхөн сум, дүүргийн Хуралд өлгөсөн бүрэн эрхийг аймаг, нийслэлийн Хурал тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хориглоно.</p>	<p>21.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид энэ хуулийн 19.1.1."е", 19.1.1."ж", 19.1.2."г", 19.1.2."ж", 19.1.2."з", 19.1.3."в", 19.1.3."г", 19.1.3."ж", 19.1.3."з", 19.1.3."к", 19.1.3."л", 19.1.3."н"-д заасан Хурлын бүрэн эрхийг Хуралд дараа тайлагнахаар Хурлын чөлөө цаг хэрэгжүүлж болохоос гадна дараах асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ:</p> <p>21.1.1.Хурлын хуралдааныг товлон зарлах, түүний бэлтгэлийг хангах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон санал, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх;</p>	<p>21</p>
<p><u>20.1.12.Засаг даргын өргөн мэдүүлсэн орон нутгийн буюу тухайн аймаг, нийслэлийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хувындлаас гадуур худалдах, шилжүүлэхдээ сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авсан байх.</u></p> <p>20.1.4-13.</p> <p>20-2.Хууль тогтоомжид зөвхөн сум, дүүргийн Хуралд өлгөсөн бүрэн эрхийг аймаг, нийслэлийн Хурал тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хориглоно.</p>	<p>21.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид энэ хуулийн 19.1.1."е", 19.1.1."ж", 19.1.2."г", 19.1.2."ж", 19.1.2."з", 19.1.3."в", 19.1.3."г", 19.1.3."ж", 19.1.3."з", 19.1.3."к", 19.1.3."л", 19.1.3."н"-д заасан Хурлын бүрэн эрхийг Хуралд дараа тайлагнахаар Хурлын чөлөө цаг хэрэгжүүлж болохоос гадна дараах асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ:</p> <p>21.1.1.Хурлын хуралдааныг товлон зарлах, түүний бэлтгэлийг хангах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон санал, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх;</p>	<p>21</p>

<p>21.1.2.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, дээд тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах, үүнтэй холбогдох асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын илтгэл, саналыг хэлэлцэх;</p> <p>21.1.3.нутаг дэвсгэртээ сахилга, дэг журмыг бэхжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>21.1.4.иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу судлан шийдвэрлэх;</p> <p>21.1.5.Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын сонгууль явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх;</p> <p>21.1.6.эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>21.1.7.хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;</p> <p>21.1.8.төрийн дээд шагналд тодорхойлох;</p> <p>21.1.9.иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулж, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах;</p>	<p>21.1.2.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах, үүнтэй иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт хяналт тавих, холбогдох дээд шатны байгууллагад уламжлах, тухайн нутаг дэвсгэрт дэх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын илтгэл, саналыг хэлэлцэх;</p>
--	--

<p>21.1.10. олон нийтийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэр дэх төрийн бус байгууллага, сүм хийдтэй харилцах;</p> <p>21.1.11. Хурлын хороо болон түр хорооны ажлыг зохицуулан зохион байгуулах, өөрийн дэргэдэх байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн удирдах;</p> <p>21.1.12. гудамж талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, дурсгалын цогцолбор байгуулах, түүх, соёлын дурсгалт, үнэт зүйлсийг тогтоож хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, энэ талаар нутаг мөрдөх журам тогтоох;</p> <p>21.1.13. нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн болон иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбогдсон асуудлаар Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, төсвийн байгууллагын удирдлагад асуулга тавих, түүний хариуг хэлэлцэж санал, дүгнэлт өгөх;</p> <p>21.1.14. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>21.2. Аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчид нь сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үйл ажиллагаанд нь дэмжлэг тусалцаа үзүүлнэ.</p>	<p>21.1.12. гудамж талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, хөшөө дурсгалын цогцолбор байгуулах, нуулгэн шилжүүлэх, буулах, нэрэмжит шатнал бий болгох, түүх, соёлын дурсгалт, үнэт зүйлсийг тогтоож хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, энэ талаар нутаг дэвсгэртээ дагаж мөрдөх журам тогтоох;</p> <p>21.1.13. нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн болон иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах хууль, тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, төсвийн байгууллагын удирдлагад асуулга тавих, түүний хариуг хэлэлцэж санал, дүгнэлт өгөх;</p> <p>21.2. Аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгч, Ажлын алба нь сум, дүүрэг, баг, хорооны Хурал, Тэргүүлэгчид, Ажлын албыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үйл ажиллагаанд нь дэмжлэг тусалцаа үзүүлнэ.</p>
--	---

<p>21.3.Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Төсвийн тухай хуулийн 10.1.2-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан Тэргүүлэгчид өөрөө тогтооно.</p> <p>21.4.Ажлын албаны дарга нь тухайн Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга байна.</p> <p>21.5.Хурлын Тэргүүлэгчид үйл ажиллагаагаа тухайн Хуралд жилд 1-гээс доошгүй удаа тайлагнана.</p>	<p>21.3.Хурал ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Хурал өөрөө тогтооно.Төсвийн тухай хуулийн 10.1.2-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан Тэргүүлэгчид өөрөө тогтооно.</p> <p>21.4.Ажлын албаны дарга нь тухайн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга байна.</p>
<p>22</p> <p>22 дүгээр зүйл. Хурлын хороо болон түр хороо</p> <p>22.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хороог байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана.</p> <p>22.2.Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаагаар төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос сонгоно.</p> <p>22.3.Хороо тухайн Хуралд ажлаа хариуцан тайлагнана.</p> <p>22.4.Хурал нь цаг үеийн асуудлыг судлах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.</p> <p>22.5.Хорооны тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн Хороо болон түр хороо, ажлын хэсэг байгуулах, түр хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг Хурал өөрөө тогтооно.</p>	<p>22.2.Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаагаар төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос сонгоно. Хорооны дарга нь тэргүүлэгч байна.</p> <p>22.4.Хурал нь цаг үеийн асуудлыг судлах, санал, дүгнэлт боловсруулах, хянан шалгах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.</p>

23	<p>23 дугаар зүйл. Хурлын даргын нийтлэг бүрэн эрх</p> <p>23.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>23.1.1.тухайн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангах саналыг Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>23.1.2.тухайн Хурлын хуралдааныг даргалах, гарсан шийдвэрийг ёсчилж баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>23.1.3.Тэргүүлэгчид, хороо, түр хороо, төлөөлөгчдөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, мэдээлэл гарын авлагаар хангах нөхцөл бололцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулалтын удирдлагаар хангах;</p> <p>23.1.4.эрх бүхий этгээдээс Хурал, Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхээр тавьсан санал асуулгын биелэлтийг хүлээн авах, гарах шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>23.1.5.Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;</p> <p>23.1.6.Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг томилуулах саналыг Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;</p>	<p>23.1.6.Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг томилуулах тухай Төрийн албаны зөвлөлийн саналыг Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж өрүүлж шийдвэрлүүлэх, энэ нь сонгуулийн нэгэн бүрэн эрхийн хугацаанд хамаарахгүй;</p>
----	---	--

<p>23.1.7.Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;</p> <p>23.1.8.тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах, Засаг даргын огцрох тухай хүсэлтийг хүлээж авах эсэх саналыг Хуралд оруулах;</p> <p>23.1.9.нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих;</p> <p>23.1.10.тухайн орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>23.1.11.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн жилийн зорилтын биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;</p> <p>23.1.12.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар сум, дүүргийн Хурлын саналыг авч Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрээ Засаг даргад уламжлах;</p> <p>23.1.13.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>23.1.7.Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан, Хурлын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;</p> <p>23.1.10.тухайн орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хуваарилалт, ажлын гүйцэтгэлд хяналт тавих; ажлыг зохион байгуулах;</p> <p>23.1.11.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, иргэдийн ашиг сонирхолыг хамгаалах, эдийн засаг, нийгмийн жилийн зорилтын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулж, ажлыг зохион байгуулж биелэлтийг хангуулах арга хэмжээ авах; дүгнэх</p> <p>23.1.12.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар баг, хороо, сум, дүүргийн Хурлын саналыг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрээ Засаг даргад уламжлах;</p>
--	---

	<p>23.1.14_тухайн Хурлыг дотоод, гадаадад төлөөлөх; 23.1.15.төрийн дээд болон бусад шагналаар шагнуулах саналыг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж зохих дээд байгууллагад уламжлах; 23.1.16.иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцээд гаргасан баг, хорооны Хурлын санал, сум, дүүргийн Хурлын шийдвэрийг Засаг даргад хүргүүлэх; 23.1.17.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. 23.2.Аймаг, нийслэлийн Хурлын дарга нь сум, дүүргийн Хурлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй. 23.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга нь орон тооны байна./Энэ хэсгийг 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p>	<p>23.2.Аймаг, нийслэлийн Хурлын дарга нь сум, дүүргийн Хурлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг удирдана.өөхөн байгуулах үүрэгтэй- Сум дүүргийн Хурлын дарга нь баг, хорооны Хуралд арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлнэ.</p>
<p>24</p>	<p>24 дүгээр зүйл. Хурлын хуралдаан 24.1.Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын Үндсэн хэлбэр нь хуралдаан байна. 24.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын элжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа, баг, хорооны Хурлын хуралдааныг жилд 3-аас доошгүй удаа тус тус хуралдуулна.</p>	<p>24.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын элжит хуралдааныг жилд 3-аас доошгүй удаа, баг, хорооны Хурлын хуралдааныг жилд 4-өөс доошгүй удаа тус тус хуралдуулна.</p>

<p>24.3.Төлөөлөгчдийн гуравны хоёроос шаардсанаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ээлжит бус хуралдаан хуралдуулж болно.</p> <p>24.4.Анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй Хурлын Тэргүүлэгчид, бусад хуралдааныг тухайн Хурлын Тэргүүлэгчид хуралдаан эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна.</p> <p>24.5.Анхдугаар хуралдаанаар тухайн даргыг оролцуулан аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийг 7-11, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийг 5-7, баг, хорооны Хурлын Тэргүүлэгчдийг 3-5 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.</p>	<p>24.3.Төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй шаардсанаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баг, хорооны иргэдийн гуравны нэгээс доошгүйн шаардсанаар баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно.</p> <p>24.4.Анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 15 хоногийн дотор бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй Хурлын Тэргүүлэгчид, бусад хуралдааныг тухайн Хурлын Тэргүүлэгчид хуралдаан эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна.</p> <p>24.5.Анхдугаар хуралдаанаар тухайн шатны Хурлын даргыг оролцуулан аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийг 7-9, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийг 9-11, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийг 5-7, баг, хорооны Хурлын Тэргүүлэгчдийг 3-5 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Тэргүүлэгчийг төлөөлөгчдийн дотроос сэлгүүлэн ажиллуулж болно.</p>
---	---

<p>24.6. Анхдугаар хуралдааныг шинээр төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь, бусад хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон төлөөлөгчдийн аль нэг нь нээж удирдана.</p> <p>24.7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын хуралдаанд тухайн Хурлын нийт төлөөлөгчийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.</p> <p>24.8. Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно.</p> <p>24.9. Хуралдаанд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.</p> <p>24.10. Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.</p> <p>24.11. Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах буюу огцрох тухай хүсэлтийг нь хэлэлцэх тохиолдолд аймгийн төвийнхөөс бусад сумын багийн Хуралд багийн нийт өрхийн 50-нас доошгүй хувийн төлөөлөл оролцсон бол хүчинтэйд тооцно.</p>	<p><u>24.6. Анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь шинээр Хурлын даргыг сонгох хүртэл удирдана. Хамгийн ахмад төлөөлөгч нь хуралдааныг удирдах боломжгүй болсон тохиолдолд дараагийн ахмад настай нь удирдана. Бусад хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон төлөөлөгчийн аль нэг, эсхүл Тэргүүлэгчдээс санал болгосон төлөөлөгч нээж удирдана.</u></p>	<p>24.10. Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 3 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.</p>
---	---	---

	<p>24.12.Баг, хорооны Хурлын хуралдааныг хэсэгчлэн зохион байгуулж болно.</p> <p>24.13.Ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 50 хоногийн дотор анхдугаар хуралдаан хуралдуулж Хурлын дарга сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол тухайн Хурлыг тарсанд тооцож дахин сонгууль явуулна.</p> <p>24.14.Хуралдааныхаа дэгийг тухайн Хурал өөрөө тогтоож тогтоолоор батална.</p>	
<p>25.3.Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан саналд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө Хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.</p>	<p>25 дугаар зүйл. Хуралд асуудал оруулах эрх</p> <p>25.1.Хурлын Тэргүүлэгчид, хороо, түүнчлэн төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.</p> <p>25.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хуралд зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.</p> <p>25.3.Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан саналд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 1 хоногийн өмнө Хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.</p>	

<p>26</p>	<p>26 дугаар зүйл. Хурлын тогтоол</p> <p>26.1.Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална.</p> <p>26.2.Хурлын болон Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолд Хурлын дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдаан даргалагч тус тус гарын үсэг зурна.</p> <p>26.3.Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга захирамж гаргах эрхтэй.</p> <p>26.4.Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн эрх зүйн дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно. <u>“Энэ хэсгийн “... , эсхүл дээд шатны” гэсэн хэсгийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцгийн 2009 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/ 25.5 Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй. /Энэ хэсгийн “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэсэн хэсгийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцгийн 2009 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/</u></p>	<p>26.3.Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга захирамж гаргах эрхтэй.</p>
-----------	--	--

<p>26 дугаар зүйл Хурлын хяналтын чиг үүрэг</p> <p>26.1 Хурал нь өөрийн гаргасан шийдвэр, тавьсан зорилт, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, төсвийн зориулалт түүний үр дүнд хяналт шинжилгээ хийж дүгнэнэ.</p> <p>26.1.1 Хурал нь Төлөөлөгч, Тэргүүлэгч, ажлын хороо, Иргэдийн оролцоотойгоор хяналт шалгалт хийж, дүнг хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн болон Хорооны хурлаар хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгнө.</p> <p>26.1.2 Гаргасан шийдвэр тулгамдсан асуудлын чиглэлээр нээлттэй сонсгол хийх, нэрэмжит өдөрлөг үзлэг шалгалт явуулах</p> <p>26.1.3 Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1-ийн 7-д заасан Асуулгын үр дүнг дээшлүүлж түүний мөрөөр хийсэн ажил, үр дүнгийн талаар хэлэлцэж дүгнэлт өгнө.</p> <p>26.1.4 Хурлын хяналтын ажил бүрийг удирдамжтайгаар хийж үр нөлөө, өгөөжийг дээшлүүлнэ.</p>	
--	--

27	<p>ТАВДУГААР БҮЛЭГ</p> <p>Засаг дарга, түүний бүрэн эрх</p> <p>27 дугаар зүйл. Засаг дарга, түүнийг томилох</p> <p>27.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн.</p> <p>27.2. Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож байгаа иргэд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно.</p>	<p>27.2. Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож байгаа иргэд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно.</p> <p>27.3. Энэ хуулийн 27.2-т зааснаар нэр дэвшүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргыг Монгол Улсын Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг дарга тус тус 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд нөхөн томилогдсон Засаг даргад энэ хугацаа хамаарахгүй.</p>
----	---	--

<p>27.4. Энэ хуулийн 27.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 27.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй.</p>	<p>27.4. Энэ хуулийн 27.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 27.3-т заасан, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшигчийг эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 27.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлнэ, бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Монгол Улсын Ерөнхий сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй.</p>
<p>27.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>27.5.1. дээд боловсролтой;</p> <p>27.5.2. төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан;</p> <p>27.5.3. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;</p> <p>27.5.4. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;</p> <p>27.5.5. ялгүй байх.</p> <p>27.6. Баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>27.6.1. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;</p>	<p>27.5.2. төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан, удирдах ажлын туршлагатай;</p>

<p>27.6.2. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх; 27.6.3.ялгүй байх.</p> <p>27.7. Засаг даргыг өөр ажилд томилох шаардлага гарвал томилох эрх бүхий албан тушаалтан зохих шатны Хурлын Тэргүүлэгчидтэй урьдчилан зөвшилцөнө.</p> <p>27.8 Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тухайн Хурлын болон дээд шатны Засаг даргын өмнө, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн Хурлын болон Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцна.</p> <p>27.9.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ажлаа тухайн Хуралд, баг, хорооны Засаг дарга иргэдэд тус тус жил бүр тайлагнана.</p>	<p>27.6.4.дээд боловсролтой;</p> <p>27.9.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ажлаа тухайн Хурал, иргэдэд, баг, хорооны Засаг дарга иргэдэд тус тус жил бүр тайлагнана.</p>
<p>28</p> <p>28 дугаар зүйл. Хурлын шийдвэрт хориг тавих</p> <p>28.1.Тухайн Хурал Үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн, эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.</p> <p>28.2.Хоригийг тухайн шийдвэр батлагдсан өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан бичгээр тавих бөгөөд хориг тавих болсон үндэслэлийг нь тодорхой заана.</p> <p>28.3.Хурал хоригийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хуралдаанаар хэлэлцэх бөгөөд түүнийг нийт төлөөлөгчийн олонхи нь хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн шийдвэр, тэдгээрийн холбогдох хэсгийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдөнө.</p>	

	<p>28.4.Хурлын шийдвэрт бүхэлд нь хориг тавьсан бол үйлчлэлийг бүрэн хэмжээгээр, хэсэгчлэн хориг тавьсан бол холбогдох зүйл, заалтын үйлчлэлийг уг шийдвэрийг Хурлын дарга хүлээн авснаас хойш хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзсэнд тооцно.</p> <p>28.5.Засаг даргыг чөлөөлөх, огцруулах асуудлаар гаргасан тухайн Хурлын шийдвэрт Засаг дарга хориг тавих эрхгүй.</p> <p>28.6.Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.</p>
<p>29</p>	<p>29 дүгээр зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p> <p>29.1.Баг, хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>29.1.1.төр, засгийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>29.1.2.хадлан, тэжээл бэлтгэх, отор нүүдэл, малын урьдчилан сэргийлэх угаалга, тарилга хийх, ноос ноолуур авах, хашаа саравч барих, худаг ус гаргах, тариа ногоо тарих, хураах, өвөлжилтийн бэлтгэл хангах, мал тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах зэрэг цаг үеийн ажлыг хугацаанд нь гүйцэтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>29.1.3.хүн амын эрүүл мэндийн байдалд ажиглалт хийж, өвчтэй хүмүүсийг эмчлүүлэх, сувилуулах, эмнэлгийн яаралтай тусламжийг цаг тухайд нь үзүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;</p>

<p>29.1.4.хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад орон нутгийн нөөц бололцоог илрүүлж ашиглах ажлыг зохион байгуулах, энэ талаар иргэдээс гаргасан санаачилгыг дэмжих;</p> <p>29.1.5.хүн амын боловсролын түвшинг судлах, сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;</p> <p>29.1.6.шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>29.1.7.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судлах;</p> <p>29.1.8.хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах;</p> <p>29.1.9.ган, зуд зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, энэ хуулийн 29.1.6."б"-д заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p>	<p>29.1.8.хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах;</p> <p>29.1.9.ган, зуд, гал түймэр зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, энэ хуулийн 29.1.6."б"-д заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p>
<p>29.1.10.статистикийн мэдээллийг зохих журмын дагуу гаргах;</p> <p>29.1.11.хүн ам, түүний шилжилт хөдөлгөөнийг зохих журмын дагуу бүртгэх;</p>	

<p>29.1.12.захиргааны журмын биелэлтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;</p> <p>29.1.13.байгалийн баялгийг ашиглах, <u>байгаль орчныг хамгаалах хууль</u> тогтоомжийн биелэлтэд олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавих;</p> <p>29.1.14.гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>29.1.15.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулга явуулах, түүнчлэн эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хуулийн төсөл, төр нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>29.1.16.иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;</p> <p>29.1.17.нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагын тайланг иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>29.1.18.нутаг дэвсгэрт нь байнга буюу түр оршин суугч иргэд иргэний үндсэн ба журамт үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;</p> <p>29.1.19.нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, албан газар, байгууллага, түүнчлэн байнга буюу түр оршин суугч иргэдэд захиргааны журам, дээд шатны болон иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг, чиглэл өгч биелэлтийг нь хангуулах, тэдгээрээс дэмжлэг тусалцаа авах;</p>	<p>29.1.14-гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;</p>
---	---

<p>29.1.20.иргэнийг шагнаж урамшуулах, гачигдалтай иргэнд тусламж дэмжлэг үзүүлэх тухай саналыг сум, дүүргийн Хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; 29.1.21.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. 29.2.Баг, хорооны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана. 29.3.Баг, хорооны Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл сум, дүүргийн Засаг дарга өөрчлөх буюу хүчингүй болгоно. 29.4.Баг, хорооны Засаг даргыг энэ хуулийн 33.1, 33.2-т заасан үндэслэл, журмаар ажлаас нь чөлөөлөх буюу огцруулна. 29.5.Баг, хорооны Засаг даргыг чөлөөлөх, огцруулах асуудлыг тухайн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ. 29.6.Баг, хорооны Засаг дарга тогтоосон журмаар үйлдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. 29.7.Баг, хорооны Засаг даргын цалин, ажлаа явуулахтай холбогдсон бусад зардлыг сум, дүүргийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ. 29.8.Баг, хорооны Засаг дарга иргэдэд урамшил, дэмжлэг тусламж үзүүлэх, ажлаа хэвийн явуулах нөхцлийг хангах зориулалт бүхий мөнгөн хөрөнгийн сантай байж болох бөгөөд зарцуулалтынх нь дүнг сум, дүүргийн Засаг дарга болон иргэдийн Нийтийн Хуралд тайлагнана.</p>	<p>29.5.Баг, хорооны Засаг даргыг чөлөөлөх, огцруулах асуудлыг тухайн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэх үүрэгтэй.</p>
--	---

30	<p>30 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх</p> <p>30.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>30.1.1. төлөвлөлт, төсөв, санхүү, бүртгэл тооцооны талаар:</p> <p>а/нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>б/харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>в/харьяалах нутаг дэвсгэрийнхээ санхүүгийн байдал, хүн амын орлого, хөдөлмөрийн нөөц, газрын төлөв байдлын удирдлага, төлөвлөлтийг хангахад шаардагдах тайлан тэнцэл гаргах;</p> <p>г/харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан тайлан мэдээг хугацаанд нь хариуцан гаргуулж, хяналт тавих, хүн ам, орон сууц, газар, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>д/орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн санг бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах;</p>
----	--

<p>е/нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>30.1.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар:</p> <p>а/төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаархи төрийн бодлоо, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>б/тухайн орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах эд хөрөнгийн жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийн тухай санал боловсруулж Хурал, түүний Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>в/тухайн орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах санал боловсруулж Хурал, түүний Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>г/орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг тогтоох;</p> <p>д/орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого явуулж, дүнг Хуралд танилцуулах, шаардлагатай бол зохих шийдвэр гаргуулж хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>е/орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан ажлын дүнг Хуралд тайлагнах.</p>	<p>30.1.1.ё.орон нутгийн давсан орлогыг зарцуулсан гүйцэтгэлийн тайланг Хурлаар хэлэлцүүлэх;</p>
--	---

30.1.3. хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, газар, байгалийн бусад баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах талаар:/Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

а/Төрийн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;/Энэ дэд заалтад 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

б/Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; в/хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай шийдвэр гаргах;

г/Газар, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, тэдгээрийн биелэлтийг хангах чиглэлээр Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж биелэлтийг нь хангуулах;

д/Газрын нэгдмэл сангийн данс бүртгэлийг хөтлөх, тайлан гаргах, нутаг дэвсгэртээ газар зохион байгуулалт хийх тухай шийдвэр гаргаж, Засгийн газраас тогтоосон журмын дагуу хэрэгжүүлэх;

	<p>е/нутаг дэвсгэрт нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хууль тогтоомжид заасны дагуу санал өгөх;</p> <p>ж/Газар эзэмших, ашиглахтай холбогдсон маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;</p> <p>з/Газар нутгийнхаа тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах санал боловсруулж Хуралд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>к/хуульд заасан зориулалтаар тухайн орон нутгийн чанартай барилга байгууламжийг газар дор барих, ашиглахад зориулан газрын хэвлийг олгох;</p> <p>л/цэцэрлэгт хүрээлэн, зүлэгжүүлсэн талбай байгуулах, мод, бут сөөг тарьж ургуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>м/нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн талаар гаргасан сум, дүүргийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>н/нутаг дэвсгэрт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах.</p>
--	--

31	<p>а/харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бус нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах;</p> <p>б/өмчийн бүх төрөл, хэлбэрт тулгуурлан харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амын тээврийн үйлчилгээний хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулах, уг үйлчилгээнд дагаж мөрдөх журам, стандартын биелэлтийг хангуулах;</p> <p>в/орон нутгийн чанартай зам, гүүр, үер усны хамгаалалт, далан суваг барих, засварлах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>г/нутаг дэвсгэртээ харилцаа холбоог хөгжүүлэх, харилцаа холбооны үйлчилгээгээр хүн амыг хангах, шуудан солилцох, хүргэх хуваарь, чиглэлийг батлах;</p> <p>д/нутаг дэвсгэртээ эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, худалдаа, ахуйн үйлчилгээ, хот тосгоны орон сууц, нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>30.1.5.хүн амын нийгэм-соёлын үйлчилгээ, нийгмийн хамгааллын талаар:</p> <p>а/нутаг дэвсгэртээ боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын талаархи төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;</p>
----	---

	<p>30.1.4-дэд бүтцийн талаар:</p> <p>б/хуульд өөрөөр заагаагүй бол Хурлын шийдвэрийг үндэслэн тухайн орон нутгийн өмчит ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургууль, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах;</p> <p>в/нутаг дэвсгэрийн ариун цэвэр-халдваргүйжилтийн байдалд хяналт тавьж, хүн амыг гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, уг өвчин гарч болох нөхцөл бүрдсэн буюу гарсан тохиолдолд нутаг дэвсгэртээ бүхэлд нь буюу хэсэгчлэн онцгой дэглэм тогтоох;</p> <p>г/хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;</p> <p>д/нутаг дэвсгэрийнхээ хүн амын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулж Хурлаар шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн зэрэг хууль тогтоомжид заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах ажлыг ерөнхий удирдлагаар хангах;</p> <p>е/нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн ариун цэвэр, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга технологи, шаардлагыг хэрхэн сахиж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулах.</p>
--	---

32	<p>30.1.6.хууль ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар:</p> <p>а/хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах;</p> <p>б/байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хүн, мал амьтныг аврах, нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, гэнэтийн аюулын бусад үр дагаврыг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, хүнс тэжээлийн нөөцийг дайчилж нөхөх олговор, үнийг төлөх;</p> <p>в/тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг хууль тогтоомжийн хүрээнд удирдах;</p> <p>г/иргэдийг хүлээж авах ажлыг зохион байгуулж, тэднээс гаргасан өргөдөл, санал, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэхийн дээртухайн Хурлын Төлөөлөгчөөс тавсан өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж хариу өгөх</p> <p>д/тухайн нутаг дэвсгэр дэх шүүх, прокурорын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>е/нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын үйл ажиллагааны талаар хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах; ж/худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг баталж, мөрдүүлэх;</p> <p>з/дотоод, гадаадад тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;</p>
----	--

<p>к/Засгийн газраас аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг даргаас сум, дүүргийн Засаг даргад хууль тогтоомжид заасны дагуу шилжүүлсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;</p> <p>л/нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад орон нутаг, ард иргэдийн эрх ашигтай холбоотой асуудлаар хууль тогтоомжид заасан хэмжээ, хязгаарын дотор үүрэг, чиглэл өгч, биелэлтийг нь хангуулах.</p>	<p>м/Тухайн нутгийн дэвсгэр нутаг үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдах зөвлөлийг батлуулах, төсвийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөхдөө Хурлын саналыг харгалзах.</p>
<p>30.2. Засаг дарга эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.</p> <p>30.3. Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл сум, дүүргийн Засаг даргын захирамжийг аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжийг Ерөнхий сайд тус тус өөрчлөх буюу хүчингүй болгоно.</p> <p>30.4. Засаг дарга нь бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй.</p> <p>30.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p>	

33	<p>31 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>31.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>31.1.1. сум, дүүргийн Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах;</p> <p>31.1.2. аймгийн Засаг дарга нэгээс илүүгүй, нийслэлийн Засаг дарга хоёроос илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх./<u>Энэ заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан!</u></p> <p>31.1.3. харьяалах нутаг дэвсгэрийнхээ дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх бодлого боловсруулж Хурлаар батлуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>31.1.4. Хурлын шийдвэрийн үндсэн дээр орон нутгийн өмчийн оролцоотой гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэр байгуулах, тэдгээрт газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах;</p> <p>31.1.5. газрын эзэмшил тогтоох, эдэлбэр газар олгох, байгалийн баялаг, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>31.1.6. нутаг дэвсгэртээ батлан хамгаалах, гамшгаас хамгаалах, нийгмийн хэв журам хамгаалах ажлыг удирдах, цэргийн анги, салбар, улсын аюулгүй байдлыг хангах болон хууль хяналтын бусад байгууллагатай харилцан ажиллах;</p>
----	--

	<p>31.1.7.иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх, хяналт тавих;</p> <p>31.1.8.Засаг даргын зөвлөл байгуулж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг нь батлах;</p> <p>31.1.9.сум, дүүргийн Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих;</p> <p>31.1.10.хууль тогтоомжид заасан бол нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллагын удирдлагыг аймаг, нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх; <u>Энэ заалтад 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан!</u></p>
	<p>31.1.11.хууль тогтоомжид заасан бол орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагыг Хуралтай зөвшилцөн томилох, чөлөөлөх;</p> <p>31.1.12.нутаг, дэвсгэртээ тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай саналыг боловсруулж, Хуралд оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>31.1.13.харьяалах нутаг дэвсгэрт нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход тухайн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн санал өгөх;</p> <p>31.1.14.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон аргачлалын дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг тус бүрээр нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тогтоож мөрдүүлэх;</p>

	<p>31.1.15.шаардлагатай тохиолдолд тухайн орон нутагт хуульд заасан үүргээ хэрэгжүүлж байгаа тахарын албанд шаардагдах хүн хүч, автомашин, техник, шатахуун, орон байр болон бусад хэрэгслээр туслах; <u>/Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/</u> 31.1.16.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. <u>/Энэ заалтын дугаарт 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p>
	<p>34 32 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх 32.1.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 32.1.1.баг, хорооны Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах; 32.1.2.сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;/Энэ заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ 32.1.3.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх; 32.1.4.эрх бүхий байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасны дагуу эдэлбэр газар олгох; 32.1.5.албан татвар, төлбөр, хураамж хураах, зохих төсөвт шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээ авах;</p>

	<p>32.1.6. нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, ариун цэврийн байдалд хяналт тавьж, үйлчилгээний цагийн хуваарь тогтоох;</p> <p>32.1.7. хот, тосгоны иргэдийг цэвэр усаар хангах, хог хаягдал, бохир ус зайлуулах, цэвэрлэх, мод, бут, сөөг, жимсний мод тарьж ургуулах, тохижуулах, гудамж талбайг гэрэлтүүлэх, үер усны хамгаалалт, далан суваг барих арга хэмжээ авах, түүнчлэн харьяалах нутаг дэвсгэрт нь барилга байгууламж барих, зам, холбооны шугам өөрчлөхөд оршин суугчдын санал авч шийдвэрлэх;</p> <p>32.1.8. хууль тогтоомжид заасан бол тухайн нутаг дэвсгэр дэх төсвийн байгууллагын ажилтанг холбогдох дээд байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;</p> <p>32.1.9. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
35	<p>33 дугаар зүйл. Засаг даргтыг чөлөөлөх, огцруулах,</p> <p>Засаг дарга огцрох</p> <p>33.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан бол дээд шатны Засаг дарга буюу Ерөнхий сайд түүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.</p> <p>33.2. Засаг дарга гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон, түүнчлэн хууль тогтоомж зөрчсөн буюу чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй бол тухайн шатны Хурал түүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө огцруулах саналыг дээд шатны Засаг дарга буюу Ерөнхий сайдад хүргүүлнэ.</p>

	<p>33.3.Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 32.2-т заасан саналыг ажлын 5 хоногт хянаж огцруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>33.4.Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 32.2-т заасан үндэслэлээр Засаг даргыг огцруулах бол саналаа зохих шатны Хуралд хүргүүлэх бөгөөд Хурал 15 хоногийн дотор хэлэлцэж санал хураалт явуулж хариу өгнө.</p> <p>33.5.Засаг дарга огцрох тухай хүсэлтээ бичгээр гаргаж болно.</p> <p>33.6.Хурлын төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүй нь Засаг даргыг огцруулах саналд гарын үсэг зурж Хурлын даргад өргөн мэдүүлсэн бол Хурал 15 хоногийн дотор уг саналыг хуралдаанаараа хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ.</p> <p>33.7.Засаг даргыг чөлөөлсөн, огцруулсан бол Засаг даргыг шинээр томилох хүртэлх хугацаанд түүний бүрэн эрхийг нь Засаг даргын орлогч хэрэгжүүлж хариуцлагыг нь бүрэн хүлээнэ.</p> <p>33.8.Ерөнхий сайд, дээд шатны Засаг дарга, Хурал энэ хуулийн 33.4, 33.6-д заасан саналыг хүлээж аваагүй бол Засаг даргыг огцруулах саналыг нэг жилийн дотор дахин тавихгүй бөгөөд энэ заалт Засаг дарга гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон бол хамаарахгүй.</p>
--	---

<p>36</p>	<p style="text-align: center;">ЗУРГААДУГААР БҮЛЭГ</p> <p>Ажлын алба, Засаг даргаас бусад байгууллагатай харилцах</p> <p>34 дүгээр зүйл. Засаг даргын ажлын алба</p> <p>34.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>34.1.1.харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах;</p> <p>34.1.2.Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах;</p> <p>34.1.3.Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;</p> <p>34.1.4.хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;</p> <p>34.1.5.Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>34.1.6.төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;</p> <p style="text-align: right;">34.1.4.хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох, тайлагнах;</p>
-----------	---

	<p>34.1.7. тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх.</p> <p>34.2. Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас тогтоох бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хэлтэс, тасагтай байна.</p> <p>34.3. Тамгын газрын даргыг хуулийн дагуу нэр дэвшүүлсэн иргэдээс сонголт хийж Засаг дарга томилно.</p> <p>34.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн Засгийн газраас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарт багтаан Тамгын газрын орон тоо, цалингийн санг тогтоож, ажилтнуудыг томилж, чөлөөлнө.</p> <p>34.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p>
	<p>35 Дугаар зүйл. Засгийн газартай харилцах</p> <p>35.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газартай дор дурдсан журмаар харилцана:</p> <p>35.1.1. жил бүр үйл ажиллагааныхаа тайланг Засгийн газарт хүргүүлэх бөгөөд Засгийн газар уг тайланг хуралдаанаараа хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>35.1.2. нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх, эс дэмжвэл өөрийн саналыг Ерөнхий сайдад уламжлах;</p>
37	

	<p>35.1.3.нутаг дэвсгэрийнхээ болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн асуудлыг цогцолбороор хөгжүүлэх бодлого боловсруулахад Засгийн газраас зөвлөлтөө, дэмжлэг авах;</p> <p>35.1.4.нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг хэлэлцэхэд Засгийн газрын хуралдаанд оролцож санал, байр сууриа илэрхийлэх.</p> <p>35.2.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсвийг бүрдүүлэх, захиран зарцуулах, бүс нутгийн хөгжлийг төлөвлөх зэрэг асуудлаар Засгийн газар аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад зарим эрх, чиг үүргээ шилжүүлж болно.</p>	
	<p>36 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах</p> <p>36.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга төрийн захиргааны төв байгууллагатай дор дурдсан журмаар харилцана:</p> <p>36.1.1.төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах;</p> <p>36.1.2.харьяалах нутаг дэвсгэрийн салбарын болон салбар хоорондын бодлогыг хэрэгжүүлэхдээ харьяалах нутаг дэвсгэртээ төрийн захиргааны төв байгууллагатай хамтарсан шийдвэр гаргаж биелэлтийг зохион байгуулах;</p> <p>36.1.3.нутаг дэвсгэрийнхээ хэтийн хөгжлийн асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх нэгдсэн бодлогын талаар Ерөнхий сайдтай шууд харилцах;</p>	<p>38</p>

<p>36.1.4.орон нутгийн хүч, хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагад саналаа уламжлах;</p> <p>36.1.5.эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн буй орчныг хамгаалах, төрөөс хүн амд үзүүлэх үйлчилгээтэй холбогдсон асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх.</p>	<p>36.1.5.эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн буй орчныг хамгаалах, төрөөс хүн амд үзүүлэх үйлчилгээнд үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд иргэдийн нийтлэг эрх ашгийн үүднээс төрийн захиргааны төв байгууллагад санал, шаардлага тавих, хариуг авч иргэдэд мэдээллэх хэлбэрээр харилцаж ажиллах тавьж шийдвэрлүүлэх.:-</p> <p>36.1.6.Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газарт санал тавих, хариуг авах.</p>
<p>36.2.Эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага саад учруулахыг хориглоно.</p> <p>36.3.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн удирдлагын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p>36.4.Сум, дүүргийн Хурал, Засаг дарга энэ хуулийн 36.1.3, 36.1.4-т заасан асуудлыг аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлнэ.</p>	

39	<p>37 дугаар зүйл. Хурал, Тэргүүлэгчидтэй харилцах</p> <p>36.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ Хурал, түүний Тэргүүлэгчидтэй дор дурдсан журмаар харилцана:</p> <p>37.1.1.Хурал, түүний Тэргүүлэгчдээс хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж дүнг тайлагнах;</p> <p>37.1.2.хууль тогтоомж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, түүний үр дүнг жил тутам Хуралд тайлагнах;</p> <p>37.2.Сум, дүүргийн Хурал, Засаг даргын хооронд үүссэн маргааныг аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргатай зөвшилцөн, аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргын хооронд үүссэн маргааныг нутгийн удирдлагын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус шийдвэрлэнэ.</p> <p>37.3.Засаг дарга хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад нь Хурал, Тэргүүлэгчид саад учруулж үл болно.</p>
40	<p>38 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын хамтын ажиллагаа</p> <p>38.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийг цогцолбороор хөгжүүлэх, хөрөнгө хүч төвлөрүүлэх томоохон асуудлыг Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга нар хамтран хэлэлцэж шийдвэрлэх буюу саналаа холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.</p>

	<p>38.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааны явцад сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын хооронд үүссэн маргааныг харьяалах дээд шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Ерөнхий сайд тус тус шийдвэрлэнэ.</p>	
<p>41</p>	<p>ДОЛООДУГААР БҮЛЭГ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааны баталгаа 39 дүгээр зүйл. Хурлын болон Засаг даргын бүрэн эрхийн баталгаа</p> <p>39.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.</p> <p>39.2. Төрийн албанд 25-аас дээш жил ажилласан аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга тэтгэвэр тогтоолгох бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 12 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно.</p> <p>39.3. Хурал, Тэргүүлэгчид, Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь тухайн нутаг дэвсгэр дэх байгууллага, албан тушаалтан бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.</p> <p>39.4. Хурал, Тэргүүлэгчид, Засаг дарга, тэдгээрийн ажлын албадын ажиллах нөхцөл бололцоог хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээр баталгаажуулна.</p>	<p>39.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно. Энэ тэтгэмж нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан тушаалтанд хамаарахгүй болно.</p>

	<p>39.5.Тухайн нутаг дэвсгэрт захиргааны журам зөрчсөн иргэд, байгууллага, албан тушаалтанд Засаг дарга зохиц хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх, эсхүл тийм хариуцлагыг хүлээлгэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавина.</p> <p>39.6.Баг, хорооны Хурлын даргад тухайн шатны Засаг даргын сарын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал сар тутам олгоно.</p>	<p>39.6.Баг, хорооны Хурлын Тэргүүлэгчдийн даргад тухайн шатны Засаг даргын сарын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хөдөлмөрийн хөлсний нэг сарын доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшуулал сар тутам олгоно.</p>
42	<p>40 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын шийдвэрийг биелүүлэх</p> <p>40.1.Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ.</p> <p>40.2.Хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.</p>	
43	<p>41 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгжийн удирдлага хууль ёсыг сахих</p> <p>41.1.Хурал, Засаг даргаас хурал, жагсаал, цуглаан, санал асуулагуу явуулах талаар гаргасан шийдвэр зөвхөн хууль тогтоомжид нийцсэн байвал зохино.</p> <p>41.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан шийдвэр хууль тогтоомж, Хурал, Засаг даргын шийдвэрт харшилсан бол Засаг дарга уг шийдвэрийг хүчингүй болгоно.</p>	

	<p>41.3.Засаг захиргааны тухайн нэгжид үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дээд шатны байгууллагад харьяалагддаг аж хууль нэгж, албан газар, байгууллагын гаргасан шийдвэр хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрт харшилбал Засаг дарга түүнийг өөрчлөх буюу хүчингүй болгуулах саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах бөгөөд энэхүү саналыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлнэ.</p>	
44	<p>42 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хүлээх хариуцлага</p> <p>42.1.Хурал, Засаг даргын хууль бус шийдвэрийн улмаас иргэд, байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.</p> <p>42.2.Хурал, Засаг дарга гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэл, хариуцлагыг бүрэн хүлээнэ.</p>	
45	<p>43 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох</p> <p>43.1.Энэ хуулийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд албан ёсоор нийтэлснээс хойш арав хоногийн дараа дагаж мөрдөнө.</p> <p>43.2.Энэ хуулийн 27.5.1, 27.5.2 дахь заалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008 оны ээлжит сонгууль явуулж шинээр сонгогдсон төлөөлөгчид бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн үеэс эхлэн дагаж мөрдөнө.-</p>	<p>43.1.Энэ хуулийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд албан ёсоор нийтэлснээс хойш арав хоногийн дараа дагаж мөрдөнө.</p> <p>43.2.Энэ хуулийн 27.5.1, 27.5.2 дахь заалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008 оны ээлжит сонгууль явуулж шинээр сонгогдсон төлөөлөгчид бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн үеэс эхлэн дагаж мөрдөнө.-</p>

1 Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

ТЭМДЭГЛЭЛ